



Эрмэр

МОНГОЛ

Эртэч монгол
Зохиолч: А.Шагдарсүрэн
Эрхлэн гаргасан: Монгол тэмүүлэл-Сайхан Монгол орон ТББ-ын

ISBN: 978-99929-64-20-0

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Энэхүү ном нь Монгол тэмүүлэл-Сайхан Монгол орон ТББ-ын өмч бөгөөд түүнийг зөвшөөрөлгүйгээр хувилах, нийтлэх, микрофильм хийх, электрон системд оруулах болон бусад хэлбэрээр олшруулан ашиглахыг хориглоно.

Монгол тэмүүлэл-сайхан монгол орон ТББ-ын тухай

Монгол ухаанаар дархлаажсан, дэлхийд байр сууриа эзэлсэн, үлгэр жишээ, манлайлагч иргэн болох нь МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ юм.

Алсын хараа

Монгол тэмүүлэл нь шинэ мянганд Монгол Улс “ХҮНИЙ ХӨГЖИЛ”-өөрөө дэлхийд манлайлах үндэстэн болоход чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийг хамарсан үндэсний хөдөлгөөн болно.

Эрхэм зорилго

Монгол хүнийг мөнх тэнгэрийн үзлээ дээдлэн, эх байгальтайгаа шүтэлцэн амьдрах монгол ухаанд суралцсан дархлаатай; түүх, соёл, уламжлал, заншилаа өвлөсөн үндэсний бахархалтай, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн соёл боловсролтой, эх оронч, ёс суртахуунлаг, ирээдүйдээ итгэлтэй, бүтээлч иргэн болгон хөгжүүлнэ.

Энэ эрхэм зорилгод нам эвсэл, шашин шүтлэг, үзэл бодлоос үл хамааран монгол хүн бүр, байгууллага хамт олон бүр нэгдэхийг уриалж байна.

2008 оны 4 дүгээр сард “Монгол Тэмүүлэл-Сайхан Монгол Орон” ТББ байгуулагдсанаас хойш монгол хүний эх орноо хайрлах сэтгэл, ёс суртахуунлаг харилцаа, бүтээлч оролцоог идэвхжүүлэн хөгжүүлэх чиглэлд олон ажил зохион байгуулж байна. Үүний нэг нь “Эртэч Монгол” өглөөний ажил хэрэгч уулзалт юм.

2010 оны 1-р сарын 25-31-ний өдрүүдэд болсон “Иргэний нийгмийн нөлөөллийн 7 хоног”-оор Монгол

тэмүүлэл-Сайхан Монгол орон ТББ-аас санаачилж 2010.01.28-ны Пүрэв гарагийн өглөө 7.00 цагт “Эртэч Монгол” ажил хэрэгч уулзалтыг анх удаа зохион байгуулсан.

Хөгжилтэй орны нийгмийн хурд иргэдээ эрт босч ажлаа амжуулахыг шаарддаг. Ихэнх орнуудад өглөө 5 цаг гэхэд метро, автобус зэрэг нийтийн тээвэр ажил албандаа яарсан зорчигчдоор дүүрч, хотын гудамж аль хэдийн хөл хөдөлгөөнд орж, дуу шуугианд автсан байдаг. Гэтэл манай Монголд 5 цаг байтугай 7 цаг гэхэд нам гүм байж байгаад 8 цаг гэхэд сая л хөдөлгөөнд орж эхэлдэг. Ийм нөхцөл байдлыг өөрчлөх нэг алхам нь “Эртэч Монгол” уулзалт байх юм.

Ер нь монголчууд эрт босч ажил үйлсээ төлөвлөн, амжуулж ирсэн бүтээлч, хурдтай ард түмэн. Чингис хааны үед дэлхийг төвхнүүлэх их үйлийг бүтээхдээ үүрийн таван жингээр (4-

5 цагийн үед) өрлөг жанжид, хүлэг баатруудтайгаа уулзан, ажил хэргээ төлөвлөн ярилцдаг байж. Өглөө эрт хүний оюун сийрэг, сэтгэл амгалан, бие эрч хүчтэй байдаг биологийн идэвхтэй энэ үеийг ийнхүү монголчууд ажил хэрэгчээр бүтээлч ашигладаг байсан байна. Энэ тэнгэрлэг уламжлалыг “Эртэч Монгол” уулзалт сэргээж байна.

“Эртэч монгол” уулзалтын агуулга:

Гэгээрлийн цаг – “Эх оронч үзэлтэй, ёс суртахуунлаг байж манлайлан оролцох нь” гэсэн агуулгаар ажил амьдрал, хийсэн бүтээсэн үйлээрээ олон түмэнд хүлээн зөвшөөрөгдөн, хайр, хүндэтгэлийг нь хүлээсэн хүндтэй зочид уригдан илтгэл тавина.

Мэдээлэл солилцох цаг – илтгэлтэй холбоотой асуулт асууж, ярилцах

Илтгэлийн гол агуулгыг амьдралдаа хэрэгжүүлэх уриалга гаргах

Энэхүү уулзалтыг 14 хоногт нэг удаа өглөө 07.00-08.30 цагт тогтмол зохион байгуулж байна. Нийгмийн салбар бүрийн удирдагчид, манлайлагчид, идэвхтнүүдийг өргөнөөр оролцуулдаг бөгөөд тэдний нийгмийн сайн сайхны төлөөх идэвхтэй оролцоог дэмжин, салбар бүртээ хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах талаар мэдээлэл, туршлага солилцох, бие биенээсээ суралцах чиглэлд явагддаг.

Энэ удаад бид уулзалтанд уригдсан 24 хүндтэй зочны олон түмэнд толилуулсан илтгэлүүдийг эмхэтгэж агуулгаар нь эрэмбэлэн “Эртэч Монгол” өврийн ном болгон ард түмнийхээ гэгээрлийн санд нэмэрлэн хүргэж байна. Энэхүү номны хэвлэлтийн зардал “Эртэч Монгол” уулзалтанд оролцогчдын хандиваар бүтсэн болохыг тэмдэглэхэд таатай байна. Монгол ажил хэрэгч хүн Та “Эртэч Монгол” номоо амтархан уншиж, өврийн дэвтэр, ширээний ном болгон үргэлж ажил амьдралдаа хэрэгжүүлэн, ард түмнээ манлайлан дагуулахыг хүсье. Номын цагаан буян арвижин дэлгэрэх болтугай.

Монгол тэмүүлэл-Сайхан Монгол орон” ТББ Утас/факс: 70127080 Цахим хуудас:
www.mongoliandream.mn



Монгол Улсын гавьяат эмч М.ШАГДАРСҮРЭН:

Сэтгэл гэгээрээсэй

Өглөө эрт босохын учир

Нар битүү эрт босох сайн гэж би олонтоо сонссон. Чухам яагаад гэдэг нь төдийлөн тодорхой бус байлаа. Өглөө эрт боссон хүн нэгийг үзэж, үдэш орой унтсан хүн нэгийг сонсоно гэсэн үг байдаг. Эртний сургаалд “Шувуу мэт эрт босч, адуу мэт орой унтаж бай” хэмээн айлдсан байдаг. Бас нэгэн сударт, “Нар мандаж байхад унтаж буй хүний ухаан балартдаг” хэмээн бичсэн буй.

Бурхан номын бясалгал үйлдэж буй хүнийг өглөө эрт 4-6 цагийн хооронд босч ухаанаа төвлөрүүлбэл сайн гэдэг нь учиртай байх. Хүн дундажаар 70 насалдаг гэвэл нилээд олон жилийг унтаж өнгөрөөдөг гэсэн тооцоо гарна.

Нэгэн номонд: “Хүмүүний нас хаврын яргуй шиг даанч богино, шөнийн цагийг үхдэл мэт унтаж өнгөрүүлдэг ” гэж бичсэн байх юм. Ухаант мэргэдийн унтаж, идэх нь бага байсан болов уу.

“Номноос өөр нөхөр үгүй

Нойрноос өөр дайсан үгүй” гэсэн сургаал байдаг билээ.

“Нойрноос морио

Чөмөгнөөс хутгаа” гэсэн үг надад тохиолдсон удаатай. Би 15 настайдаа морь уяна хэмээн хүн дуурайн адуунаас морь бариулж, чөдөрлөж хоноод нам унтаж, морио алдаж хөгөө тарьсан юм.

Миний нэг найз “Өглөө унтаад босч өгөхгүй байгаа хүүхдүүдээ харахаар урам хугардаг” гэж билээ. Миний номын анд, хятад хэлний орчуулагч Х.Цагаанхүү гуай: “Нар ургахаас өмнө босч байгаарай гэж хүүхдүүддээ ямагт захидаг” гэсэнсэн.

85 нас сүүдэр зооглоод бурхан болсон ээж минь тун эртэч хүн байлаа. Тавхан минут дугхийгээд бие амарлаа сайхан болчихлоо гэдэгсэн.

Бясалгалын багш нар унтаж байгаа хүний дэргэд амьсгалын дасгал хийж болдоггүй, яагаад

гэвэл хор ялгаруулдаг, сөрөг энергитэй байдаг гэж ярьдаг.

Бар цагт босохгүй бол өдрийн явдал хоцорно

Бага залуудаа эрдэм сурахгүй бол насны явдал хоцорно гэдэг ээ.

Одоо сэтгэлээ гэгээрүүлэх, ариусгах номхроох талаар ярья.

Хүмүүс бидний сэтгэлд бурхан, буг хоёулаа зэрэгцэн оршдог гэнэм. Хүн бүхний сэтгэлд орших бурханлиг чанарыг шунал хэмээх шулам саатуулж байдаг аж. Шунал бол зовлонгийн эх үндэс юм. Зовлонгийн гол шалтгаан нь харанхуй бүдүүлэг тэнэг мунхаг атаархуу хомхой сэтгэл юм. Тэнэг мунхаг гэдэг бол үнэнийг үл мэдэгч харанхуй бүдүүлгийг хэлнэ. Таван махбодь бүгд огторгуйн махбодид хурна, таван хор бүгд мунхаг сэтгэлд хурна хэмээжээ. Бусдын сайн сайхныг хараад

хий хоосон атаархахын оронд өөрийн бие сэтгэлээ засаж залруулах ёстойг тэр болгон бид ухаарахгүй байгаа нь мөнөөх мунхаг харанхуйгаас үүдэлтэй.

Шунал гэгч нь аливаа нэг юмыг ганцаар эзэгнэх гэсэн бачимдал өдөж хатгасан туйлын хүчтэй хүсэл юм. Нүдэнд үзэгдэх чихэнд сонсогдох бүхнийг хүснэ, бүр амиа егүүтгэх хүсэл ч төрөх нь буй. Харанхуй мунхаг шуналаас хомхой уур хилэн мунхаг буруу үзэл гомдол, тэмцэл, атаа хорсол, зусар бялдуучлал, дээрэнгүй омог, үзэн ядалт, ертөнцийн муу муухай бүхэн үүсч гардаг гэж бурхан багш сургасан нь юутай үнэн бэ? Зовлонгийн эх үүсвэр болсон шунал хүсэл, тэнэглэл, уур омог, бардам зангаа хязгаарлаж чадваас хүн жаргалын хутгийг олно.

Шунал нь хүн өөртөө таалагдсан шохоорхсон юмаа хармагц хүслээ гүйцээх юмсан, эдлэх юмсан гэсэн хүсэл дотроос хатган даамжирахад үүсдэг. Шуналт сэтгэлийг хатуу тэвчээрээр барихаас өөр аргагүй билээ. Халуун хүйтэн өлсөж цангах, өвдөж зовох түүнчлэн доромжлол гүтгэлгийг ч тэвчин хүлцэж сурах хэрэгтэй юм байна. Таван мэдэрхүйгээр үүсэх шуналыг эрүүл ухаанаар намжааж дарах нь юунаас ч чухал. Хичээл сэрэмж хэрсүү ухаан хэрэгтэй. Уур хилэн гэдэг бол өөрийн санаанд таалагдаагүй юмаа хараад өөрийн дур хүсэлд таацуулан захирах гэсэн буруу сэтгэлд автаснаас үүсдэг. Гэгээрэхийг хүсч буй хүн бүхэн юуны өмнө өөрийгөө бүхий л шуналын галаас зайлуулах хэрэгтэй. Хүн нэг удаа уурлахад урьд үйлдсэн буянаа баллан арчдаг байна. Иймд уур омогоо тэсвэрлэн барьж сурах хэрэгтэй. Үлгэрлэвэл ороо морийг оосорлон тогтоохтой адил зүйл юм.

Тавдугаар ноён хутагт бээр “Хийсэн жаахан буянаа хэт магад барахдагаа хэмээн айлдсан буй” мөн “Ус хэдий тунгалагч хөлдөхөөрөө мөс болдог. Ухаантан хэдий мэргэн ч уурлахаараа мунхаг болдог” хэмээжээ.

Урьд намайг жаахан хүүхэд байхад эмэг ээж маань цээжин дотор чинь гал ассан ч хамрынхаа нүхээр утаа бүү гарга гэж ноён гэгээний сургаалд айлдсан байдаг хэмээн ярьдагсан.

Мунхаглал гэдэг бол хүн өөрийн харанхуй цээжнээс юуг хийвэл зохистой, юуг хийхгүй бол дээр вэ гэдгийг мэддэггүйгээс, мэддэг ч ухан ойлгоогүйгээс үүсдэг. Аливаа муу муухай юм бүхний эх үүсвэр эндээс үүсч байна. Шунал, уур, мунхаг гурвыг энэ ертөнцийн гурван хор

хэмээжээ. Шунал бол өөрийгөө цэнгүүлэх мэдрэмжээс үүсдэг. Уур бол сэтгэл тааламжгүйн мэдрэмжээс үүснэ. Мунхаг бол буртаг санаанаас үүснэ гэжээ.

“Шуналын сэтгэл барагдахгүй. Түүнийг зайлуулах туйлын хэцүү. Уур хилэн их боловч түүнээс зайлах нь хялбар. Харин харанхуй мунхагийн хилэн туйлын их бөгөөд түүнээс хагацах маш бэрх болой” хэмээн эртний сударт сургажээ. Шунал тачаал, уур омог, харанхуй мунхаг бол энэ ертөнц дээрх зовлон гамшгийн гол шалтгаан юм. Сэрэмж бол шуналаас сэргийлнэ. Сэтгэлийг зөв удирдаж тэвчээр гаргаж чадваас уур хилэнгээс зайлна. Хүний хүсэл шунал хязгааргүй. Давстай усыг хичнээн уувч амны цангаа гаргадаггүйтэй адил хэмээн эртний сударт мөн өгүүлжээ.

Хүн шунал тачаал, уур хилэн, мунхаглалаас болж муу үйл (нүгэл хилэнц)-ийг үйлддэг. Энэ үйлийнхээ үрээр зовлон эдэлнэ. Ертөнцийн энэ гурван хор эцэс төгсгөлгүй эргэх хүрд болж, ертөнцийн хүмүүс энэ хүрээнээс гарч чаддаггүй тэр цагираг хүрээндээ л нэг төрлөөс нөгөө төрөлд дахин дахин төрж, төрөл арилжих үйл эцэс төгсгөлгүй үргэлжилдэг болой.

Үнэндээ энэ ертөнц дээрх бүх юм маш хурдан урсан өнгөрч өөрчлөгдөж байна. Бүр нэг мөчийг, нэг хормыг сая живаа хуваасны нэгтэй тэнцүү хугацаанд амьтай

амьгүй байгаль юмс мөн тэр хурдтай өөрчлөгддөг хэмээн Бурханы сургаал, сүүлийн үеийн шинжлэх ухаан хоёр нотолжээ. Мөнхийн юм гэж алга. АНУ, Нью-Йоркт болсон агаа хорсол, өш хонзон, дайсагналаас үүдсэн үйл явдал, хүний гараар бүтсэн, ховорхон хосгүй бүтээлүүд хэсэгхэн хугацааны дотор үнс нурам болохыг энэ ертөнцийн бүхий л хүмүүс элэг эмтрэн харлаа шүү дээ.

Цаашилбал, өндөр барилга, суварга байтугай хот, улс, энэ дэлхий ч үнс нурам болохыг үгүйсгэх газар үгүй билээ. Ихэнх хүмүүс сайн, муу үйлийг үл ялган авах, хаях гээх сургаалийг үл ойшоон гагцхүү муу үйл хийх нь арвин ажээ. Хурал номд дуртай нь цөөн, хулгайд нь олон гэдэг шиг...

Иймээс бид үйлийн үрийн хуулиар үлэмжийн их лай ланчиг зовлонг эдэлж байна. Хүүхэд багачуул маань үйлийн үр гэдгээ ч мэдэхгүй өсч байна. Сайн үйл хийхийг буян, муу үйл хийхийг нүгэл гэнэ. Буян хийвэл жаргана, нүгэл хийвэл тарчилна. Ердөө л ийм энгийн ухамсар ойлголт. Аминч үзлээс татгалзвал бусдад туслах сэтгэл төрнө. Жаргал гэдэг яг ийм түүдгээс гал авалцах маягаар үүсдэг хэмээнэ.

Бамбарын галаас хичнээн бамбар асаавч түүний гал буурахгүй. Түүний адил аз жаргалыг хичнээн хуваасан ч түүний ай сав бас дундрахгүй. Та бид ертөнцөд төрсөн нь үнэн, үхэх нь үнэн. Энэ хоёр үнэний дунд хүмүүний амьдралын мөн чанар гэж юу болохыг зөв ухаанаар мэдэрч сэтгэлээ номхруулж чадах аваас ГЭГЭЭРЭЛД хүрмой. Гэгээрэл гэдэг бол оюун сэтгэлийн чанадад хүрч, хүн дахин төрөх шиг ертөнц болоод амьдралыг өөрийнхөөрөө танин муу муухай бүхнээ дотор сэтгэлээсээ авч хаян, сайн сайхан зүйлийг сэтгэл дотроо ариун тансаг үнэрт цэцгийг ургуулах адил явдал юмаа.

Ингэж сурваас гэнэн будангуйрал, дэмий бодол санаа гэгээрэл болно. Бид бүгдээрээ гэгээрэх юмсан. Ертөнцийн бүх хүн ГЭГЭЭРЭЭСЭЙ. Гэгээрэл бол ертөнц дахиныг гэрэлтүүлэх

нарны тусгал адил гэрэл болой.

Энэ ертөнц дээр янз бүрийн ааш араншинтай, янз бүрийн сэтгэл оюунтай хүмүүс оршин буй. Ер нь бид “Сайн явбал санааных, сайхан төрөх заяаных” гэдэг шиг өөрт заяагдсан үйлийн үрээр л амьдрах бөлгөө. Үнэхээр бид яаж амьдарч, яаж явахыг биднийг хөглөж буй “сэтгэл” гэдэг аугаа их найрал хөгжим удирдан залах амой. Тийм болохоор хүн өөрийн сэтгэлийг өглөө бүр байнга ариусган үдэш орой бүр амаржуулж байх ёстой юм байна. Хүмүүний сэтгэл хиргүй тунгалаг аваас аян зам шулуун, амьдрал нь аз жаргалтай болдог ажээ. Хүн бүхэнд ариун цэвэр сэтгэл оршдог авч мунхагийн харгайгаар орчин ахуйгаас урган гарч ирдэг шунал хүслийн тоосонд хиртсэн байдаг. Сэтгэл хиртэж бохирдвоос амьдралын бартаанд ихээхэн бүдэрч зовдог байна.

Юм бүхэнд “би” гэж цээжээ дэлдэж, “минийх” гэж өмчирхөх нь хүмүүний тэнэг мулгуу сэтгэлийн эндүүрэл юм. Юмны бодит байдлыг үл ухаарах ердийн амьдралаа хэт шүтэж явах хүмүүсийг эртний сургаалд нялхас буюу нялх ухаантан гэдэг байжээ. Хиртэж бохирдсон сэтгэл үргэлжийн айдаст автагдан зовж шаналж байдаг ажээ.

Өнгөрсөн болоод одоо, ирээдүйд байнга шаналж, харамсаж шунаж, өширч хорсож байх нь сэтгэлд тань мунхагийн харанхуй, зовлонг дур хүсэл үүсч шатсанаас болдог байна. Гэтэл Бурхан багш өнгөрсөн юманд бүү харамс, ирээдүйд тэгтлээ бүү шанал, гагцхүү өнөөдрөөр зөвхөн байгаагаараа сэтгэл ханаж амьдрахыг сургасан байдаг.

Сэтгэлээр ариуссан хүн мунхаг, шунал, уур хилэн, хувиа хичээх, аминч муу үзлээс аль болох татгалзаж чадах ба Бурханы сургаалаар сэтгэл нэн ханамжтай болж жаргах болно. Ерөөсөө сэтгэлээ номхруулж, цэвэр ариун сэтгэл оюунаар үйл явдлаа бүтээж, цэгцтэй ухаантай зөв үсгээр бусадтай харьцаж явбаас амгалан тайван, аз жаргал сүүн зам сүүдэр мэт дагадаг ажээ.

Тунгалаг ариун сэтгэлээр өгүүлэх буюу үйлдвээс

Туршдаа амгаланг олох нь

Тусах сүүдэр хагацаж үл болохчлон... хэмээн дээдсийн зарлигт айлджээ.

Хүн сэтгэлийн ариуслыг олж амгалан тайван, аз жаргалтай байж болох бүхий л бололцоог эрэлхийлж, түүнийхээ төлөө тэмцэх нь ховор. Харин бусдаас илүү эрх дарх эдэлж, их мөнгөтэй, үнэтэй хувцас эдлэл хэрэглэхийг хүсэх, товчоор хэлбэл онцгой эрх дархын эзэгнэлийг л хүсч, үүнийхээ төлөө зүтгэж тэмцэж амьдралын гол зорилгоо болгох нь элбэг байх юм.

Гутлын ул алт байсан ч шороон дээр л гишгэнэ. Бүх дэлхийг захирч эзэгнэсэн ч энэ нас хязгаартай. Энэ насны эцэст бид эрлэг номун хааны өмнө зэрэг дэв, зиндаа хөрөнгө харгалзахгүй яг л ижил нэг улаан шугаман дээр зогсох билээ.

Амьдрал дээр бид үр ачийнхаа өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ойлгож дутах гачих юмгүй сайхан амьдрахаар тэмцэх нь мөн боловч хэт ихэд шунаад ирэхээр эцэс төгсгөлд зовлонг урин дуудаж байгаа нь тэр.

Хэн нэгэн нэг алтны уурхайтай боллоо. Түүнийгээ зөв сайн эзэмшээд амьдралын хэрэгцээгээ хангаад зогсох нь үгүй, дахин нэг, бас дахиад нэг уурхайг эзэмшихийг хүснэ. Үүнээсээ болж хэн нэгэнтэй өрсөлдөж, тэмцэж, заргалдаж гарна. Хэтэрсэн шунал мунхагийн тоосонд

дарагдаж эхэллээ гэдгээ мэдэхгүй улам өрсөлдөнө. Үүнийгээ амьдралын утга учир, нийгмийн сайн сайхны төлөө гэж тайлбарлаж байгаа ч сэтгэлээ номхруулахыг хүсдэггүй байх жишээтэй. Одоо боллоо гэж сэтгэл нь ханадаггүй. Өнөө үед ухаад дуусгачихвал хойч үе маань юугаа хэрэглэх вэ? Сэтгэлээ ариусгана гэдэг зөвхөн ном уншаад ч болчихдог юм биш. Их ухаарал, хатуужил тэвчээр, бясалгал төвлөрөлд суралцах нь илүү үр өгөөжтэй.

Хэрцгий догшин амьтад ертөнцөөр дүүрэн байдаг

Хэзээ ч тэд нарыг устгаж дийлэхгүй

Хилэн хорслын сэтгэлээ л дарж чадах аваас

Хэмлэлдэх дайснаа дарсан мэт больюу

Өргөст дэлхийг ширээр бүрхэе гэвч

Өдий хэмжээний шир хаанаас олдох вэ?

Өөрийнхөө л гутлын улыг бөх ширлэх аваас

Өргөн дэлхийн өргөсийг бүтээснээс ялгаа юун...

Зөвхөн жаргах цэнгэхийг урьтал болгодог, ухаан бодол нь хяналтгүй, хоол унд нь замбараагүй, залхуу хүнийг зулзаган модыг ширүүн салхи ховх татан унагаахын адил сэтгэлийн шунал эзэлж авдаг ажээ. Харин сэтгэл оюунаа сайтар хянадаг, шударга журамтай хүнийг салхи хадан уулыг илбээд өнгөрөхтэй адил хөдөлгөж дийлдэггүй байна. Надад хань ижил, үр хүүхэд, идэх хоол, өмсөх хувцас, орон гэр бүгд байна. Би болж байна гэж сэтгэл ханаж чадаж байвал таны сэтгэл ариусч, номхорч, гэгээрч болох боломж нээгдэж байгаа нь тэр. Би ядарч байна, ядуу байна, зовлон намайг ээрч байна хэмээн зовлонгийн үүр болгож зүдрээгээд байвал таны өмнөх бүх гарц хаалттай болно. Гэргүй хүнд дэлхий тэр чигээрээ гэр нь байдаг гэдэг үг ч байдаг даа. Тиймийн тулд тэвчээр хатуужилд суралцаж, аливааг хүлцэн тэвчиж сурах хэрэгтэй. Чингэвээс олдохуйяа бэрх чөлөө учралт энэ насандаа сэтгэлээ ариусган аз жаргалтай амгалан аж төрөх болноо.



Төрийн соёрхолт, МУГЖ Д.СОСОРБАРАМ:

“Эртгэч монгол” уулзалт хүн бүрийн, байгууллага болгоны хэрэгжүүлдэг ажил байх ёстой

Японы нэг эрдэмтний “Өглөөний хүн” гэдэг номонд нэгэн парламентийн гишүүн өглөө эрт 04 цагийн үед босоод унадаг дугуйгаар ажилдаа явдаг тухайгаа ярьсан байсан. Тэр хүн, “Туйлшрахгүй, хурцдахгүй, төвийг сахих үзлийг голчлон барьсан хэрнээ шударга үнэний талд зогсож чадвал жинхэнэ улс төрч болно” гэж хэлсэн байна. Би өнөөдөр энд ирсэн хүмүүсээр бахархаж байна. Манай дарга нар хэр эрт босдгийг би сайн мэдэхгүй. Ажил хөөцөлдөөд өглөө эрт очихоор их хүлээлгэдэг. Энэ уулзалт төрийн байгууллагын нэгж бүр, ажилтан бүхэн хамгийн түрүүнд хэрэгжүүлэх ёстой сайхан ажил байна. Үүнийг зохион байгуулж байгаа, ялангуяа оролцож байгаа хүмүүст би их талархаж байна. Хүн орой 21 цагт унтаж өглөө 04 цагт босоод өдрийн 14 цаг гэхэд ажил төрөл, бүх юмаа эмхлэхчээд, 14-18 цаг хүртэл унтаж, эргээд 24 цагт унтаад өглөө 04 цагт босдог бол сайн. Цагийн ийм эргэлтэнд орох нь хүний ажлын болоод оюун сэтгэхүй, бие бялдрын чадварыг сайжруулдаг гэсэн шинжлэх ухааны үндэслэл гарсан байна лээ.

Хүн бол буян нүгэл хоёрыг зэрэгцүүлэн үйлдэхээр ирсэн үйлийн лайтай амьтан юм даа. Ирнэ буцна, бусад нь бүгд худлаа бусармаг, зальхай, бялдууч зусард хутгалддаг. Тиймээс зальхай, бялдуучаас зугтаж, үнэнээр багана хийж, зөвийн цулбуураас атгаж явбал аливаа хүн онох нь илүү алдах нь цөөн болдог гэж би үздэг. Бас нэг хачин бодол нь хүн бусдаас арай илүү өнгө төрхтэй, царайлагдуу байвал их зантай, мулгуу шинж ажиглагддаг. Ангид нэг хөөрхөн охин байхад хөвгүүд нь бүгд хошуурна. Тэгээд нөгөө охин өөрийгөө хорвоогийн хамгийн хөөрхөн нь байна гээд андуурлын паянд орж, амьдралын утга учир, хүн байхын утга учраа хар нялхаараа мөхөөчихдөг. Хөвгүүд ч гэсэн адилхан. Сэргэлэн цовоо, нүд ам, бие хаа сайтай бол охидууд шаваад унадаг. Энэ араншингаас яаж холдох вэ гэхээр бид өөрөөрөө байх учиртай. Энгийн байх шиг гайхамшигтай юм орчлонд байхгүй. Эгэлээс эгэлгүйд хүрэх боломж хүн болгонд байдаг учраас бүх зүйлийг хийж чадах боломж нь жирийн бөгөөд өөрөөрөө байхаас эхэлнэ гэж би үздэг. Хүн гэдэг амьтан эцгийн цагаан дусал, эхийн улаан бөөмнөөс бүрддэг. Анх ирэхдээ тэр чигээрээ ус байдаг гэнэ. Одоо бид нар бол 70% нь ус байгаа.

“Хатмал цөлд явахад хар ус амттай

Харанхуй шөнийн дунд өнчин зул гэрэлтэй” гэж Р.Чойном хэлсэн байдаг. Яагаад заавал хар ус гэсэн юм бэ? Усыг хар гэж харааж байгаа муу ёрын үгэнд харалган утга байна гэж ойлгосон. Хар ус битгий хүнд өг гэж ярьдаг. Гэвч хар гээд байгаа ус чинь биднийг авардаг

чандмань эрдэнэ байна. Тэгэхээр зүгээр нэг усгээгүй хар гэдэг нь хүний амин дэм юм гэж хүндэлсэндээ, хар ус амттай гэдэг нь бүр илүү чиний аврал, амьд байх үнэ цэнэ, чи өөрөө ус учраас усанд найртай, хайртай хандаж байх ёстой гэсэн хандлага юм байна гэж би ойлгосон. Үүнийг би дэлхийн олон эрдэмтний судалгаанаас уншсан. Шилэн аяганд ус хийгээд харааж зүхээд, муу муухай үг хэлээд хөргөгчинд хөлдөөхөд их муухай өнгө, галбиртай хөлддөг. Тэгээд нөгөө усаа магтаад чи бол гоё, амттай, чи бол миний аврал гээд хамгийн сайхан үгээр хэлээд хөлдөөхөөр хүн гараараа зорсон юм шиг, хүн оюун сэтгэхүйгээрээ бүтээсэн юм шиг хачин гоё хээ угалзтай, талсттай болоод хөлдсөн байна. Тиймээс ус амьтай юм байна. Ус амьтай юм чинь дэлхий амьтай байж таарна. Амьтай учраас газар тэнгэр хоорондоо хурьцдаг. Тэгж байж зун, өвөл болдог. Газар тэнгэр хоёр хоорондоо хачин их хайртай. Заримдаа уурлахаараа бие биендээ туньж цахилгаан цахин пижигнээд л, үүл гарч хуйлраад эхэлдэг. Бид ийм амьд байгаль, амьд зүй тогтолд байгаа учраас хайрлах хэрэгтэй.

Хүний биеийн жинхэнэ бүрэлдэхүүн хэсэг бол оюун ухаан, сэтгэл санаа, ухаан бодол, сүнс юм. Бид ийм зүйлээс бүрдчихээд яагаад арчаагүй амьдардаг вэ гэхээр хайраас үүдэлтэй юм байна. Будда өөрийгөө хайрла, Сократ өөрийгөө тань гэж хэлсэн байдаг. Энэ аугаа суутнуудын хэлсэн хоёр үгийн утгыг задлаад бодохоор өөрийгөө хайрласан хүн үнэ цэнээ мэдэрнэ. Үнэ цэнээ мэдэрч өөрийгөө танина. Өөрийгөө ойлгож таньсан хүн өөрийгөө олно. Өөрийгөө олсон хүн бусдыг хайрлаж чадна. Би чамд хайртай гэж дахин дахин хэлээд байвал хайргүй гэдгээ илэрхийлж байгаа нь тэр. Эхнэр нөхөр 2 чамдаа хайртай шүү гээд өглөө гарахдаа хэлээд байвал чамайг хуурна даа гэж байгаагийн үндэс гэж би ойлгодог.

Өөрийнхөө дотоод ертөнцийг таньсан хүн бусдын дотоод ертөнцийг сайн мэдэрдэг. Өөртөө хайргүй хүн бусдын нүгэл дээр жаргал эдэлж, бусдын алдаан дээр вальс эргэх хүсэлтэй болчихдог. Хамгийн түрүүнд өөрийнхөө жам ёсны үнэ цэнийг мэдэж, жам ёсны эрх чөлөөгөө дөвийлгөхийн тулд жам ёсны хайраараа өөрийгөө үнэлж хайрлаж явах ёстой. Хүний оюун ухааны 35% нь эцэг эхээс удамшдаг, 20% нь эхийн хэвлийд байх 10 сарын хугацаанд бойждог. Үлдсэн 45% нь нийгэм хамт олон дундаас бүрддэг байна. Өөрийгөө хайрлаагүй хүн үр хүүхдээ, үндэс угсаагаа ч хайрлаж чадахгүй. Бие биендээ хатуу үг хэлдэггүй, гомддоггүй айлыг би энэ орчлонгоос олохгүй. Р.Чойном энэ тухай

“Хэтэрхий хайртай чамдаа би

Хэрэлдэх л гэж дурласан юм

Хэрүүлийн дараа улам хайрласаар

Хэтдээ хагацах л гэж дассан юм

Амьдрал дандаа цэцэглэх гэж

Арван хуруу тэгш цэнгэх гэж

Алтан дэлхий заяасан юм биш

Алсдаа мөхөх гэж үүссэн юм

Хатах гэж гол мөрөн урсдаг юм

Шатах гэж ой мод ургадаг юм

Үхэх гэж хүн амьтан төрдөг юм

Үрэгдэх гэж хот суурин босдог юм

Ер нь чадалтай нь чадалгүйгээ дарах ёс л

Ертөнцөд мөнх үлдэж мэдэх юм” гэж хэлсэн. Энэ нь хэн ч хэлж болмоор мөртлөө Р.Чойномоос өөр хүн хэлж чадаагүй зүйл.

Айл гэрт маргаан зөрчилдөөн байх учиртай. Харин түүнээсээ шинээр сэрж, мэдэрч байвал сайн.

Эмэгтэй хүмүүс жирэмсэн болоод нэг, хоёр сар болоод ирэхээрээ их гомдомхой, идэмхий болдог. Би л эхнэрээ тэгж мэдэрч байсан. Тэрийг нь ойлгохгүй бол хэвлийд нь байгаа хүүхдийн 20%-иас хасагдана гэсэн үг. 15-18 наснаас дээш насны охид хөвгүүдэд сайн, муугийн тухай ойлголтыг харамгүй хэлж байх ёстой. Тэр асуудал хүүхэд олоход өдрөөс эхэлнэ гэж би боддог. Тэр нь ямар өдөр, ямар гараг юм, тэр үед та хоёрын тэмүүлэл ямар байсан гэдгээс их зүйл шалтгаална. Айж тэвдсэн үед олдсон хүүхэд бол тийм л хүн болдог. Тиймээс эхнэр нөхрийн хоорондын харьцаа бясалгалын хэмжээний ажил байж бидний үргэлжлэл, Монголын үргэлжлэл сод суут хүмүүс болж төрнө гэж боддог.

Хайр бол хүний жинхэнэ мөн чанарыг нээж өгдөг аугаа зүйл юм. Өөрийгөө хайрладаг хүн өөрийг нь үзэн яддаг хүнийг хүртэл хайрлаж эхлэдэг. Би нэг амьд жишээ ярья. Миний дотны найз шог зураач Цогтбаяр өөрийнхөө мэндэлсэн өдөр ижий рүүгээ очдог. Хүмүүс энэ өдрөө их гажиг тэмдэглэдэг гэхэд хилсдэхгүй, тэнэг гэсэн ч оновчтой юм шиг. Баар саванд сууж, анги хамт олноо дуудаад өөрийг нь гаргасан ганц бурхан ижий рүүгээ очихгүй, тэс өөр амьтантай хундага тулгаад, маргааш нь өрөөсөн нүд нь хөх, хөл нь доголлон байх жишээтэй. Тэгвэл миний найз мэндэлсэн өдрөө ээжийгээ баярлуулдаг. Би хэд хэдэн удаа Цогоогийнхоо мэндэлсэн өдрөөр ээж рүү нь хамт очиж байсан. Нэг удаа цуг очиход ээж нь хөл нүцгэн сууж байхад шууд очоод ээжийнхээ хөлийг үнссэн. Энэ ямар их хайр вэ? Эх нь үрээрээ бахархахын буян, үр нь эхээ хайрлахын аугаа их чанар бол энэ. Бид тэгж чаддаг уу, үгүй юу гээд бодохоор харамсалтай байдаг. Би найзыгаа дуурайж өөрийнхөө мэндэлсэн өдрөөр ээж рүүгээ очдог болоод 10 гаруй жил болж байна. Сайн нөхрийн нөлөө, андын барилдлага ийм л байх учиртай.

Миний найз заримдаа ээждээ ааруул нүдэж өгнө. Ээж нь шүдгүй болохоор “миний хүү дандаа ийм сайхан юм хийж өгдөг” гээд долоож иднэ. Энэ жил би мэндэлсэн өдрөө найз нараа дагуулаад ээждээ очсон. Цогтбаярын энэ жаягаас улбаалаад ах эгч, дүү нар нь бүгдээрээ өөрсдийнхөө мэндэлсэн өдрөөр ижий рүүгээ очдог болсон. Жинхэнэ үрийн хайр гэж үүнийг хэлнэ. Баримтаар би үүнийг ярих дуртай. Хайр ийм байдаг гэж худлаа цэцэрхээд нэмэргүй. Бид мэддэг мөртлөө мэддэггүй, чаддаг хэрнээ чаддаггүй зүйлийг бие биендээ хэлэхгүй бол хоосон мөрөөдөлдөө авгаж явсаар мөхнө.

Яруу найрагч Д.Урианхайн нэг шүлгэнд, “Эх орноо би бурханд мартагдах өдрөө хүртэл эрлэг цухалдтал хайрлана” гэж байдаг. Бид бие биендээ дулаан уур амьсгал өгөхөө байчихсан байна. Өглөө ирээд хэн нэгнээ чи сайхан харагдаж байна гэж хэлэхээс татгалздаг, хэлчихээр л тэр хүн өөрөөс нь илүү болчих юм шиг харагддаг.

Хүний амьдрал баян. Хоёр тийшээ болчихоод бүтээгүй амьдралын төлөө бие биенээ муулаад, нэгнийхээ алдаа, оноог сөхөж ярихын оронд намайг ижий болгосон, үрийн минь аав шүү дээ, сайн яваасай гэж залбирсан нь дээр. Эр хүн байхын учир утгыг надад мэдрүүлсэн, үр удам, яс цусыг минь авч гаргасан, Монголын үргэлжлэлийг бас хамт гаргасан хүн шүү дээ, хэдий хоёр тийшээ болсон ч сайн яваасай, бие хаа нь зүгээр байгаа гээд хааяа нэг бодчих хэрэгтэй. Хааяа нэг залбирч, сүү өргөхөд хүний нүдэнд харагдахгүй ч асар хүчтэй хайр очно. Яагаад би үүнийг хэлж байна гэхээр хүний оюун санаа маш хурдтай, 1000 км-ийн цаана давж очдог. Хүн оюун санааныхаа дотоод ертөнцийг, сүнсээ уудалж далд ухамсараа гаргаж чаддаг бол, махан биенээсээ салж чаддаг бол маш их хүч байдаг. Үүнийг шинжлэх ухаан нотолчихсон. Хүний оюун тархийг нээж амжаагүй, тиймээс оюун тархи маш хүчтэй. Ийм хүчтэй бас гэгээтэй хайрыг биеэсээ цацруулж чадваас амар амгалангийн тухай ярьж болно. Амар амгалан гэж шүлэг бичээд, хоосон яриад хэрэггүй гэж би боддог. Хайр бол хаа нэгтэйгээс хайгаад, тэр намайг хайрлахгүй байна, өрөвдөхгүй байна гэдгийн эсрэг зүйл шүү.

Бид хүүхдүүдийг хүн болгохоосоо түрүүнд сургах гэж оролддог. Эхлээд зөв хүн болгох хэрэгтэй. Ах захтай, ёс зүйтэй хүн болгохын тулд зодож занчих, айлгаж сүрдүүлэх биш, сүүлийн үед Моцарт, Битлзийн гээд дэлхийн сонгодог хөгжмийг хүүхдийн араншинд тааруулаад хийчихсэн байна. Тэрийг би хоёр ачдаа авч өгсөн чинь тэрэндээ тохируулаад бүжиглэж, сонсох хачин дуртай. Хүүхдийг өөрийнх нь дуртай зүйлээр нь тоглуул. Аав ээжүүд хүүхдээ багш нарт хүлээлгэж өгөхдөө эхлээд хүн суурийг нь бэлдэж өгөх ёстой. Сургуульд өгчихөөд миний хүүхдийг сайн хүн болгож өгсөнгүй гээд байх шаардлагагүй. Эхлээд гэр бүл, хөгшдийг тэжээхээс урьтаж асрахгүй бол болдоггүй юм. Тэжээж байна гээд асаргаанаасаа түрүүлээд хоол ундаар нь цаггаж хаячихаад байвал хамгийн том нүгэл болно. Эмчлүүлж байгаа хүнийг эм тариагаар шахахаасаа өмнө сувилах хэрэгтэй. Монголын гүн ухаанд ийм сургааль байдаг.

Дээд баян эрдэм ном

Дунд баян үр хүүхэд

Адгийн баян эд хөрөнгө гэж үг бий. Дээд баян эрдмээр баяжсан хүн дунд баян үр хүүхдийг тэр зиндаа руу аваачихын тулд зөв хүн болгоно. Эд хөрөнгө бол зүгээр л хэрэглээ. Энэ шунал, машин техник, эд хөрөнгө бидний тухтай байх, амьдрах хэрэглээ. Үүнийг ачаад үүрээд авс руугаа орохгүй. Тиймээс жаахан хямгатай, ухаантай хандахгүй бол их дэмий юм байна. Зөв шунал бол сурахад чиглэсэн, эрдмийн баялагтай, мэдлэгтэй байхад чиглэсэн, авьяасаа хөгжүүлэхэд чиглэсэн байдаг. Энэ зөв шуналыг дагаад эд баялаг аяндаа зүгээр хэрэглээ болоод ороод ирнэ. Чой.Лувсанжав гуай “Хүн болоогүй хүнд эрдэм боловсрол эзэмшүүлэх юм бол босоо ороолонд алтан шүд хийгээд босгосонтой адилхан” гэж хатуу бөгөөд үнэн үгийг хэлсэн. Бид зөв төгөлдөр хүнийг Монголд үлдээхийн төлөө хичээх хэрэгтэй. Үүний тулд өөртөө хайртай байх хэрэгтэй. Яагаад би өөртөө хайртай байдаг тухай товчхон хэлье. Намайг хүмүүс их сагсуу, онгируу гэж ярьдаг. Хамаагүй ээ, ярьж л байг. Миний энэ зан бол

зүгээр гадна талд харагдаж байгаа хэлбэр болохоос биш дотор талын зүйл биш. Би өөрийгөө тоохгүй, үнэлэхгүй бол, би өөрийгөө өмөөрөхгүй бол хэн ч намайг өмөөрөхгүй, тоохгүй. Чамд чи хайртай, чамайг чи л өмөөрнө. Өөрийгөө хайрлаж хүндлэхгүйгээс болоод нөхөр, эхнэрээ боолчлох асуудал гэр бүлд байдаг. Гүн зөв итгэлцэл дээр айл гэрийн амьдрал тогтдог. Хамгийн эхлээд өөрийгөө хайрлах үндэс байгаа цагт итгэлцэл бий болно. Чиний эхнэр, чиний нөхөр ширээ сандал биш, унтдаг ор дэвсгэр, хэрэглэдэг хэрэглээ биш амьд хүн. Тиймээс бие биенийгээ боолчилсон, хардаж сэрдсэн өвчлөлөөр дүүргэх юм бол тэр гэр бүл сүйрнэ. Өөрийнхөө эрхтэн болгонтойгоо ярьж үзэх хэрэгтэй. Хүн л бол хүн шүү дээ. Царай зүс, гадна төрх ердөө хамаагүй. Хэтэрхий ганган хүн юу ч мэдэхгүй байх тохиолдол зөндөө. Нүдтэйгээ ярьж үзсэн үү гэж хүмүүсээс асуухаар гайхдаг. Нүдээрээ харах харахгүй юм хараад, хялайх хялайхгүй юм хялайгаад байж болохгүй. Хаалганы цаана ямар нэг нууц зүйл болж байж болно. Хамраараа хэрэгтэй хэрэггүй юм үнэрлэж, шиншлээд айлын хоол илүү гоё үнэртэй санагдаад, чихээрээ болж бүтэхгүй юм сонсох гээд давхиад байж болохгүй. Ам хэлээ ч зөв ашиглах ёстой. Уруулаараа үнсэх хүнээ л үнсэнэ. Энэ мэтээр бүх эрхтэнтэйгээ ярих хэрэгтэй.

Монголчууд эрх чөлөөг зоргоороо авирлах гэж үзээд байгаа. Эрх чөлөө нь товчхондоо хариуцлага хүлээх чадвартай хувь хүмүүсийн эрүүл саруул зорилго юм. Энэ үгийг 1976 оны Нобелийн шагналт Америкийн эрдэмтэн Мильтон Фрийдман “Хувь заяагаа сонгох нь” номондоо бичсэн. Би энэ номыг хэд хэд уншиж байж ганцхан ийм өгүүлбэртэй үлдсэн. Өөртөө ачаа үүрч, хариуцлага хүлээх явдал бидэнд их сул байдаг. Би харин та нарт баярлаж байна. Өөрсдөдөө ийм хариуцлага үүрээд, өглөө эрт ирж байгаа нь сайн хэрэг. Өчигдөр энэ охиныг утсаар ярихад, хар үүрээр хүн цуглах юм уу гэж асуусан. Цугладаг юмаа ахаа гэхээр нь юу л болдог бол доо гэж бодоод ирсэн чинь ийм олон хүн ирчихсэн байдаг юун сайн юм.

Би өглөө болгон 04-05 цагийн хооронд босдог. Өглөө эрт гарахад хамаг ажил бүтдэг. 12,13 цаг үдийн цайнаас өмнө би ажлаа амжуулж чаддаг. Монголчууд орой унтаж эрт бос гэдэг. Би бол орой унтахын эсрэг байгаа, эрт унтах хэрэгтэй. Зурагт үзээд байх шаардлагагүй, дандаа хов хэрүүл явж байна. Ядаж нэг сонгодог кино явуулчихгүй, дандаа солонгос кино гаргана. Солонгосчууд үндэснийхээ эрх ашгийн үүднээс дэлхий даяар киногоо цацдаг. Тиймээс би солонгос киноноос хүн болгон татгалзаасай гэж боддог. Миний сурсан нэг зан бол өглөө болгон усанд орно. Би хөдөөний, бүр малчны хүүхэд. Бага байхад ээж минь тогоо нэрдэг. Жалавчин дээрээ халаасан усыг нь хамаагүй асгахгүй, нэг жижигхэн ваннд хийчихдэг байсан. Хүүхэд байхдаа түүнд нь ороод тоглоод сурчихсан. Ингэж багаасаа усанд ороод сурчихсан болохоор усанд орохгүй байж чаддаггүй. Нэг л өдөр өнжих юм бол энд тэнд загатнаад унана. Сурсан зуршил бол их хэцүү.

“Эрх чөлөөгүй хайр аагим халуун ган гачиг, хайргүй эрх чөлөө бол хахир хүйтэн зуд турхантай адил. Тиймээс эрх чөлөөг гандаахгүйн тулд хайр хур шим нь болдог, хайрыг хөлдөөхгүйн тулд эрх чөлөө ээл дулаан нь болдог” гэж нэгэн гэгээнтэн сургажээ. Ийм жам жаягийг, ийм баримжааг барьж явбал туйлын сайн гэж би үздэг. Хүн гэдэг үгийг урдаас нь уншихаар “хүн” гэсэн үг гарна, буцаагаад уншихаар “нүх” гэсэн үг гарна. Тийм учраас хүн биологийн хувьд ч, сэтгэхүйн хувьд ч, оюун санааны хувьд ч хүн бол хүн, нүх байх учиргүй шүү гэдгийг хэлээд яриагаа өндөрлөө.



МУСГЗ, ОУ-ын сэтгүүлч, философийн ухааны доктор, профессор Б.ДАШЗЭВЭГ:

“Өглөө болгон би залуужаад босдог, өглөө бүр би дахин төрдөг”

Монгол оронд маань шинэ өглөө ирлээ. Тунгалаг сайхан өглөөний мэндийг та бүхэнд айлтгая. Би эрт босдог хүн, Шадивлангийн зуслангаас энд ирлээ. Машинаа асаагаад ирэх замд нөгөө бөөгнөрсөн олон машин, уур уцаартай хүмүүс байхгүй, хааяа нэг тайвнаар алхах хүмүүсийг хараад, мандаж байгаа нарны туяанд сэтгэл бүлээцээд, яасан сайхан юм бэ? “Өглөө болгон би дахин төрдөг, өглөө болгон би залуужаад босдог юм” гэж нэгэн шүлгийнхээ тухай бодлоо. “Эртэч монгол” уулзалт, бусад олон ажлыг улс орныхоо хөгжлийн төлөө хийж байгаа “Монгол тэмүүлэл-Сайхан Монгол Орон” ТББ-ынхандаа асар их талархаж, ажилд нь оролцдог юм. Яагаад гэвэл хамгийн гэгээлэг, ялангуяа залуучуудад, уран бүтээлчдэд, нийт хүмүүст хандсан олон сайхан ажил зохиодог болохоор цаашид бие сэтгэлээрээ, уран бүтээлээрээ, өөрийнхөө мэдлэг оюунаар хүчин чармайлт гарган оролцож байх болноо.

Английн нэгэн зохиолч “Миний амьдралын хамгийн сайхан цаг хэзээ вэ?” гэж өөрөөсөө асуугаад “Өглөө” гэж өөрөө хариулсан байдаг. Өглөө эрт босоод нэгдүгээрт ээж аавдаа, бурхан тэнгэртээ залбир, сөгдөн мөргө. Яагаад гэвэл би амьдарч байна, бид амьд байна. Энэ бол гайхамшиг. Хоёрдугаарт нь өөрийнхөө аз жаргалыг төлөвлө, бүр биччих. Гуравдугаарт өглөө бүхэн өөрийн амьдралдаа итгэсэн шиг итгэж ажилла, амьдар!

Яриагаа би яагаад ингэж нэрлэсэн бэ гэхээр өглөө бол миний амжилт бүтээл гаргах үндэс болсон юм. Би их эрт унтдаг хүн. Орой найм, есөн цагт унтаад, өглөө таван цаг гэхэд ямар ч үед босно. Таван цагаас өөрийн тусгай программтай. Үүнийгээ би та бүхэнд ний нуугүй дэлгэж ярья. Боссоныхоо дараа цэв хүйтэн усаар нүүр гараа угаана. Зөвхөн усанд орохдоо л нүүрээ бүлээн усаар угаадаг. Дараа нь богино хугацаанд тогтсон дасгалаа хийнэ. Тавин нас хүртлээ би пааран доогуур хөлөө хийж, ардаа мухар сандал тавиад 50 удаа суниадаг байсан. Тиймээс надад гүзээ сууна гэж хэзээ ч байхгүй. Тавь хүрээд их ачаалал өгөхгүй байх ёстой учир энэ дасгалаа хийхээ больсон. Нас явах тусам хүний хаагуур өвддөг, хөгширдөг билээ гэдгийг бодсон. Энэ бол өвдөг, үе мөч. Одоо би 66 настай, орой болгон олон цаг бүжиглэж чадна. Мөн гэдэсний тусгай дасгал хийнэ. Дараа нь биеийнхээ эд эсийг сэргээн иллэг бариа хийгээд, шар тос юмуу хонины сүүлээр бөөр цээжээ тослоно. Дараа нь толгой, цээжний дасгал хийчихээд нэг аяга зөгийн балтай ус юмуу зүгээр буцалсан ус уудаг. Тэгээд компьютерийнхээ өмнө суугаад вэб сайтуудаар орж дэлхий дахины мэдээллийг толгойдоо бичдэг. Дараа нь ээжийнхээ хажууд байсан дадал заншлаар асар их аагтай цай хоёр аягыг ууна. Их өтгөн цайг зөвхөн хоёр аягаас илүү уухгүй. Тэгээд унтталаа цай ууна гэж байхгүй,

дандаа ус ууна. Ус бол хүний биеийг эрүүл, цэвэр болгож байдаг. Өглөө 7-9 цагийн хооронд уран бүтээлээ хийнэ.Тэгээд ажилдаа явахад ерөөсөө ядрахгүй. Өдрийн цаг бол миний хамгийн чөлөөтэй, хичээл заахдаа оюутнуудын дунд байх ямар ч үед аль болох өөдрөг байхыг эрмэлздэг. Миний үс халзрахгүй байх, яагаад гэвэл би 96 насална гээд 96 удаа булдруутай самаар самнадаг байсан. Миний ээж 76 насласан. Би 96 хүрнэ гэж боддог.

Би их сургуулиа төгсөөд “Мэдээлэл радио телевизийн улсын хороо”-д орж 40-өөд жил ажиллахдаа бүх шатны ажлыг хийж сурах зорилт тавьсан. Монтажчин, найруулагч, сурвалжлагч болно, тийм тийм хэлний орчуулагч болно гээд биччихдэг байлаа. Миний дэвгрийг очоод үзвэл инээд хүрмээр юм их байгаа. Сургууль төгсөөд хоёр жилийн дараа авгай авна гэж бичсэн байсан. Бас МАХН-д элсэнэ, тийм ном зохионо, ЗХУ явна гээд биччихсэн байдаг. Тэр бүхэн миний мөрөөдөл, тэмүүлэл байсан. Тодорхой хэмжээгээр түүнийгээ биелүүлсэн. Саяхан намайг тэтгэвэрт гарахад “Мэдээлэл радио телевизийн улсын хороо”-ны ерөнхий нягтлан бодогч, “Таны хөдөлмөрийн дэвгрийг бичсэн чинь зөвхөн нэг л газар /МРТУХ-нд тоймч, орчуулагчаар/ 39 жил ажилласан байна. Ямар сайхан юм бэ” гээд гайхаж байсан. Энэ бол миний хувьд зорилго тэмүүлэлдээ тууштай зүтгэсний баталгаа. Олон улсын сэтгүүлч болно гэж тэмүүлдэг байлаа. Тэр үед орос хэл сайн мэддэг хүн Москвагийн радиод очиж орчуулагч болох томоохон өрсөлдөөн байдагсан. Тэгэхэд манай дарга, “Дашка ерөөсөө хүсэлт тавихгүй юм, одоо чиний ээлж болсон” гэхэд нь гуравдагч орон буюу хөрөнгөтөн оронд очиж ОУ-ын сэтгүүлч болно гээд татгалзсан. Манай гэр бүлийн хүн үүнийг сонсоод Москвад мэргэжилтэн болоод гэр бүлээрээ явах тийм сайхан боломжоос татгалзаж байдаг яасан тэнэг хүн бэ гээд уурлаж байлаа. Дараа нь 1994 онд Европын холбооноос улс төрийн талаар мэдлэгтэй, англи, франц хэлийг ажлынхаа хэмжээнд мэддэг нэг сурвалжлагч авч явна гэсэн. Тэр үед надтай өрсөлдөх хүн байгаагүй. Ингээд гэр бүлээрээ баруун Европ руу Бельгийн нийслэл Брусель хот руу явж байсан.

Уран бүтээлийн тухайд олон юм хийе гэж мөрөөддөг, мөрөөдлөө тодорхой хэмжээнд биелүүлсэн. Би яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиол, гадаад хэлний, замын тэмдэглэл гээд 12 ширхэг ном гаргасан. 17 кино зохиол бичиж заримыг нь найруулалцсан, 16 дуу нийтийн хүртээл болсон байна. Би бүх насныхантай уран бүтээлээрээ найзалчихдаг. 70, 80-тай хүмүүс “Ай даа хүмүүс минь амьдрах сайхан...” гээд дуулдаг. 30,40-тэй нь “Найзаар минь намайг таньдаг учиртай...” гэж дуулдаг бол, 20 настай оюутан бүсгүй “Хайр гэж юу юм бэ” гээд дуулж байхад 6,7-хон настай хүү “Цэнгэн хөгжилдөө” гээд дагаад бүжиглэдэг юм. Хамгийн сүүлд электро хөгжим гэхээр хүмүүс их гайхсан. Гэнэтхэн би насаараа сэтгүүлч байснаа одоо хөгжмийн урлагт хүчээ үзэхээр боллоо. Үүнээс хойш та нар намайг DZ MAN гэж дуудаарай гэж UBS телевизээр ярилцлага өгсөн. Нөгөө дуу телевизээр гарахад хүмүүс утасдаад зарим нь, “чи чинь ийм хачин юм хийдэг юмуу, хөгшин азарга жороо сурна гэж болиоч ээ” гэж байсан. Гэтэл одоо ач, зээ нар маань жинхэнэ миний фен болчихсон. Энэ электро хөгжмийг би эртнээс бэлтгэсэн. Beatles, АВВА –гийн шүтэгч байлаа. Наян хэдэн онд ГЯЯ-ны сайд

М.Дүгэрсүрэн гэдэг гайхамшигтай дипломатч байсан. Түүнийг дагаад АНУ-д сурвалжлагчаар очихдоо Нью-Йоркийн төв цэцэрлэгт хүрээлэн дэх Жон Леноны дурсгалын самбарт “Монголын залуучуудын өмнөөс” гэсэн тууз бичиж тавиад ирсэн. Миний хамтран зүтгэгч Наранзуны өвөө Жамцын Бадраа гэж хөгжим, яруу найргийн гайхамшигтай мэдрэмжтэй хүн байсан. Би түүнийг шүтдэг байлаа. Гэтэл хүү Бадар-Уугантай нь телевизэд

олон жил хамт ажиллах хувь тохиосон. Бид сайн найзууд, хамтран ажиллагсад байлаа. Бадар-Ууганы хүү Наранзун одоо надтай электро хөгжмийг хамт хийж байна.

Гавьяат багш Ц.Түвшинтөгс бид хоёр чацуу. Олон жилийн өмнө их сургуулиа төгсөөд долоон залуу “Эрдмийн төлөө” гэдэг нийгэмлэг байгуулж байлаа. Энэ долоон залуугаас гурван гавьяат цолтон төрж, бүгдээрээ доктор болсон. Тэр үед одоонх шиг пиво гэж байхгүй, дундаа цай тавьж суугаад өөр хоорондоо мэтгэлцэж, шүлэг зохиол, эрдэм шинжилгээний судалгаа, нотлогоо олон талын яриа өрнүүлдэг байсан. Нэг сэтгүүлч надаас ярилцлага авахдаа “Чи сэтгүүлч, тоймч болоогүй байсан бол ямар хүн байх байсан бэ?” гэж асуухад нь “Би Говь-Алтай аймгийн Цогт сумын Бурхан Буудай уулын нэгэн салаанд том бор гэртэй, нэг ширхэг авгайтай, нээх олон хүүхэдтэй шар өвгөн, авгайгаа загнаад, хүүхдээ эрхлүүлээд сууж байх байсан” гэж хариулсан.

Амьдралдаа зорилготой, тэмүүлэлтэй байна гэдэг гайхамшигтай. Хүн толгой дахь мэдлэгээрээ ч гайхамшигтай гоц байх хэрэгтэй, бие бялдраараа ч сайхан, эрүүл чийрэг байж, хувцас хунар ч гоё, сайхан байх хэрэгтэй. Хамгийн гол нь дотоод талаараа ариуссан сайхан сэтгэлтэй, зөв үзэлтэй байх хэрэгтэй. Залуучууд оюутнуудад би амьдрах ухааны лекц уншдаг. Амьдрах ухааны лекц гэдэгт гурван зүйл орж байгаа. Нэгдүгээрт өчигдрөөс суралц, зөвхөн өчигдөр биш өнгөрсөн амьдралыг бүхэлд хэлж байгаа юм. Хоёрдугаарт өнөөдрөөр амьдар. Тэмүүлэлтэй, мэдлэг чадвартай хүн өнөөдөр сайхан, аз жаргалтай амьдарна. Гуравдугаарт нь маргаашдаа итгэ. Маргаашдаа итгэдэггүй хүн амьдардаггүй юм шүү. Хүн төрөлхтөн амьдралдаа гурван зүйлийн гайхамшигийг туулдаг. Нэгдүгээрт эхээс мэндлэх. Хүн болж төрнө гэдэг гайхамшиг. Ертөнцийн гурван шүтээний минь нэг эмэгтэйчүүд та бүхэнд мөргөө. Хийморьлог сайхан заяа түшсэн Монголынхоо бүх эрчүүдэд хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе. Хоёрдугаарт хамгийн чухал, мэргэжлээ сонгох, гэр бүлээ сонгох асуудал. Гуравдугаарт мэдээж үхэх. Энэ гурваас дундахыг нь л хүн өөрөө сонгоно. Гялайлаа.

Ай даа хүмүүс минь амьдрах сайхан!



Ай даа хүмүүс минь, амьдрах сайхаан! Амьдрахуй ухааны “Алтан дөл” ТББ-ын тэргүүн И.ЦЭРЭН:

“Зөвхөн өнөөдрөөрөө амьдардаг, зориг зүрхгүй хүнийг арьсан дотроо үхсэн хүн гэдэг”

Сайхан амьдралын төлөө энэ өглөө тэмүүлж ирсэн эртэч монголчуудаа хараад сэтгэл их хөдлөж байна. Амьдралын зорилго, хүсэл тэмүүллийн тухай та бүхэнтэйгээ хуваалцая.

Энэ дэлхий дээр асар их юмыг хийж бүтээсэн гайхамшигтай хүмүүс хүрсэн түвшин шигээ агуу их хүсэл мөрөөдөл, өндөр том зорилготой байжээ. Энд янз бүрийн насны хүмүүс байна, би бол насыг ердөө тоо гэж боддог. Хүний насыг оюун сэтгэлгээ тодорхойлдог. Юм хийх гээд нүд нь гялалзаад явж байгаа хүн 70-тай байна уу, 80-тай байна уу, 100-тай байна уу, энэ хүн залуу.

Дөнгөж 20, 30 хүрчихээд ямар ч хүсэл тэмүүлэлгүй, зөвхөн өнөөдрөөрөө амьдардаг, зориг зүрхгүй хүн залуу хүн бишээ. Арьсан дотроо үхсэн хүн юм.

АНУ-ын нэгэн их сургуулийн эрдэмтэн захирал сая доллараас дээш хөрөнгөтэй 4000 гаруй амжилттай хүмүүсийг судлахад 60 гаруй хувь нь ямар ч боловсролгүй, янз бүрийн насны, янз бүрийн ажил мэргэжлийн эгэл жирийн хүмүүс байжээ.

Гэхдээ эдгээр амжилттай хүмүүсийн амьдрал эгэл жирийн хүмүүсээс гуравхан зүйлээр ялгаатай байжээ.

Нэгдүгээрт: Амьдралын гараагаа эхлэхдээ тодорхой зорилго тавьсан

Хоёрдугаарт: Өөртөө чадна гэсэн итгэлтэй

Гуравдугаарт: Үл ухрах баттай зориг тэвчээр, асар их тууштай хүмүүс байжээ. Би урьд нь ямар ч зорилгогүй өнөөдрөөрөө амьдардаг хүн байсан. Дөрөв таван жилийн өмнөөс амьдралын зорилготой болж, өөрийгөө үнэлж эхэлсэн. Хүн харагдаж байгаагаасаа агуу. Хүний дотор Бурханы маш том орон зай, ертөнцийг эргүүлэх их хүч байдгийг мэдэрсэн цагаас би өөрийгөө бусдад хэрэгтэй, бусдын амьдралд өнгө нэмэх ёстой гэсэн зорилго тавьж эхэлсэн.

Үндэсгүй мод ургадаггүй. Азгүй амжилтгүй байгаагийн үндэс нь амьдралын зорилго, эцсийн төлөвлөгөөгүй байгаагаар холбоотой. Хамгийн эхний алхам амьдралын зорилготой, юу хийх, хаана очихоо мэддэг байх ёстой. Хүн үхэн үхтэлээ хийх ажилтай, зорилготой байвал эрүүл

саруул, урт удаан наслах боломжтой. Манай оронд эмэгтэйчүүд 55, эрчүүд 60 настай тэтгэвэрт гардаг. Гавьяаныхаа амралтыг аваад ирэнгүүт хүүхдүүд нь “Ээж минь, аав минь та хийдгээ хийсэн, одоо хөлөө жийгээд жаргадаг цаг, юу ч битгий хий, хоёр литр сүүгээ ав тэгээд болоо” гэдэг. Хоёрхон литр сүүний зорилготой хоносон ээж дэлхий ертөнцөөс хоёрхон литр сүү авах энергийг биедээ хуримтлуулдаг. Зорилгогүй, хийх ажилгүй, эрч хүчгүй болоод ирэхээр аль хэзээний тэтгэврийн эмээ дүрдээ итгээд хөл нь маажийж, хоёр литр сүүгээ аваад арай гэж шатаар гарч явахыг нь хүүхдүүд нь хараад, “Ээж минь наад хөл, гар чинь муудчихаж. Одоо юу ч битгий хий хэвт, бид нар авчирч өгч байя” гэдэг. Ээж хөдлөхгүй хэвтэх л юм бол үхлийнхээ зам руу шуударч байгаа юм. Хүн хөгширч үхдэггүй, хөшиж үхдэг. Та юунд тэмүүлж, юу бодож, ямар зорилготой байна, яг тийм хэмжээний эрч хүч, энергийг дэлхий ертөнцөөс татаж авдаг. Амьдралдаа том зорилго тавиад, эрч хүчтэй байгаа бол яг тийм хэмжээний энергийг хуримтлуулж, эрч хүчтэй, эрүүл байхаас гадна сэтгэлгээ нь хүртэл залуу байдаг. Өнөөдөр залуу нас гэдгийг хөөрхөн царай, булбарай хацар, хүдэр чийрэг биеэр тодорхойлохоо больсон.

Би дөрвөн жилийн өмнө хувийн бизнес хийж эхэлсэн. Надад айдас эргэлзээ, санаа зоволт, өөрөө өөрийгөө доош нь хийх бодол их байсан. Гэхдээ надад сайхан амьдрья, үр хүүхдийнхээ амьдралыг баталгаатай болгоё, амжилтанд хүрье гэсэн зүрхнээс ундарсан хүсэл тэмүүлэл маань сэтгэлзүйн салбарыг сүүлийн 4, 5 жил судлахад хүргэсэн. Энэ гайхамшигтай том шинжлэх ухааны дөнгөж үзүүрээс нь ойлгоод өөрийнхөө амьдралд бага ч гэсэн хэрэгжүүлэх гээд оролдож эхлэхэд миний амьдрал гайхамшигтайгаар өөрчлөгдөж эхэлсэн. Энэ салбарыг судлах тусам миний мэдээгүй ямар их зүйл байна. Мэдсэн сурснаа нэг хүнд ч гэсэн ойлгуулах юмсан гэсэн хүслээр Амьдрахуй ухааны “Алтан дөл” ТББ-ыг нээгээд, янз бүрийн сэтгэлзүйн болон хувь хүний сургалт семинарууд явуулж байна.

Дуртай ажил, дуртай хичээлээс л амжилт гардаг. Зүрхэнд нь хүсэл төрсөн бол ямар ч боломжгүй айлын хүүхэд өөрөө бие даан хичээлээ давтаад тофелийн шалгалтанд тэнцээд гадаадын их дээд сургуульд явж байхад, зүрхэнд нь хүсэл төрөөгүй бол ямар ч баян айлын хүүхдийг мөнгөөр зодоод явуулахад жижүүрийн хэдхэн үгтэй, хамаг муу юмыг нь сураад ирдэг. Зүрхнээс ундарсан хүсэл бол хүнийг асар их хөглөж өгдөг юм байна. Хүсэл мөрөөдөл байгаа цагт итгэл үнэмшил төрдөг, итгэл үнэмшилтэй хүний дотоод ухамсарт тэсрэлт, өөрчлөлт гардаг.

Тэр үед л аз жаргал, эрүүл мэнд, сайн хань, үр хүүхэд, амжилт ялалт цаг хугацаа, орон зайд кино шиг найруулагддаг. Киноны найруулагч нь хэн бэ? Та өөрөө билээ. Та өөрийнхөө архитектор, зохиогч, кино найруулагч нь. Амьдралаа орвонгоор нь өөрчилж, хувь заяагаа атгах хүч боломжийг бурхан хүн болгонд ижилхэн өгсөн. Хүн төрөхдөө гараа атгасан байдаг. Энэ нь хувь заяагаа атгаад төрлөө гэсэн үг юм. Хүн үхэхдээ бүх юмаа орхиод явдаг учраас гараа сул тавьдаг. Хүн хэрвээ хамаг юмаа аваад үхдэг байсан бол бэртэгчин, аминчхан нөхдүүд, “эхнэрээ аваад явна, байраа, машинаа аваад явна, би хамаг алт мөнгөө авна” гэх байх. Хэрвээ ингэж болдог байсан бол бүх хүнийг оршуулах газар ч олдохгүй болох байх. Хүн энэ дэлхийд нүцгэн ирээд нүцгэн буцдаг.

Та эхийн хэвлийд олдсон цагаасаа аугаа их ялагч болж ирсэн. Хүн аавынхаа үрийн шингэний 10 сая сперматозоидын амьдрах тэмцэлд орж тэр нь 60 сая хромсом болон задраад үүнээс

зөвхөн нэг нь ээжийнхээ өндгөн эстэй нийлж хүн болдог. Нэг үгээр хэлбэл 59,999,999 эсийг ялаад ганцаараа ялагч болон мэндэлсэн. Бидний өвөг дээдэс үүнийг “Хүний амь бүрэлдэнэ гэдэг зүүний үзүүр дээр уут шар будаа асгахад 1 ширхэг будаа тогтохын дайтай ийм ховор үнэ цэнээр бий болдог” гэж зүйрлэж хэлсэн байдаг.

Америкийн ДНК судлаач нэгэн эрдэмтэн хүн 100 тэрбум эсээс бүтдэг. Эс болгон өөрийн зорилготой, ухамсартай, хэлтэй. Эзнийхээ бодлыг уншдаг, бусад эстэйгээ өөрийн хэлээр ярьдаг, мөн ДНК-тай харьцдаг. Нэг үгээр хэлбэл бүх эс мэдээллээр программчлагддаг. ДНК бидний бодлыг уншаад өгүүлбэр болоод жагсдаг. Энэ нь хорвоо ертөнцөд захиалга болж бид бодлоороо бүх зүйлээ татсан байдаг. Хүн өдөрт 60000 бодол боддог боловч ДНК ганцхан бодлыг л сонгодог. Ямар бодлыг сонгох вэ? Олон удаа сэтгэл хөдлөлтэйгөөр бодсон бодлыг л сонгоно. Бидний гаргадаг алдаа бол хүсээгүй зүйлээ л боддогт байна. Хар муу зүйл бодож байхад ДНК тасардаг. Бид эерэг зүйл бодож, бодохоосоо өмнө юу бодох, юу бодохгүйгээ сонгож сурах ёстой. Муухай бодол орж ирвэл эерэг утгатай үгийг олон дахин давтаж хэлж сур. Учир нь бодлыг бодол өөрчилдөггүй, бодлыг үг өөрчилдөг.

Тэгвэл бидний зорилго тодорхойгүй, үг, бодол цэгцгүй учраас амьдрал маань шүүрэн шанага шиг байдаг.

Амьдрал болохгүй болоод ирэхээр ихэнх хүмүүс өөрөөсөө хайдаггүй, мэргэн түргэн хүн дээр очдог. Орлогын үүд нь хаагдаад зарлагынх нь үүд нээгдчихсэн байна гэдэг. Ном уншуулаад нэг гайгүй юм шиг байснаа дахиад л болдоггүй. Дахиад л орлогын үүд хаалттай. Бидний орлогын үүдийг нээдэг хаадаг түлхүүр нь хэн нэгэн хүнд байдаггүй юмаа. Орлогын үүдээ нээж, хаадаг түлхүүр таны дотор байдаг. Та өөрийнхөө хувь заяаг насан туршдаа засах засал эрх мэдэл нь танд байгаа. Амьдралын зорилгоо маш тодорхой хараад түүнийхээ төлөө үйл ажиллагаандаа ор, шийдвэрээ гарга. Таныг бүх зүрх сэтгэлээ зориулж эхлэх тэр л үед хорвоо ертөнц “ЗА” гэж хүлээж авдаг. Та нарт нэг гайхамшигтай, намайг хөглөж байдаг түүх ярьж өгье.

160 жилийн өмнө Орос Францын дайнд Дани улс ялагдал хүлээж дайны нөхөн төлбөрт хамгийн үржил шимтэй газраа өгчээ. Ингээд өвс, мод, тариа юу ч ургадаггүй нойтон намагтай, хүйтэн салхитай, үргэлж цас хялмаалж орж байдаг, адгийн хараагдсан газар үлдэж гэнэ. Олон жилийн дайнд эдийн засаг бүрэн дампуурч, дайнаас буцаж ирсэн эрчүүд юу хийхээ мэдэхгүй утга учиргүй архидах болсон. Эмэгтэйчүүд нь хүүхдүүддээ талхны мөнгө олохын тулд гадаадынханд биеэ үнэлэхээс өөр замгүй тийм аймшигтай эмгэнэлт байдал тулж ирсэн гэнэ. Ингэж Дани Улсад эр эм, ихэс доодос, хүүхэд хөгшидгүй үндэстэн ингээд мөхдөг юм байж, бид хэзээ ч босч ирэхгүй, бидэнд ямар ч гарц байхгүй байна, амьдрал маш хүнд байна, өлсөж үхэх нь гэж зуршил болтлоо үглэж байжээ. Гэтэл “Хүнд бэрх амьдралын өөдөөс хүч үзэн босье” гэж хашгирч боссон хоёрхон хүн байлаа. Нэг нь номлогч Курантив тосгон бүрт тариа тарих хөдөлгөөнийг өрнүүлж, тариа тарих эрдэм ухааныг зааж эхэлсэн. Мөн Библийн сургаалиар хайрыг номлож эх дэлхийгээ хайрлая, эцэг эхээ хайрлая, эх орноо хайрлая хэмээн хүмүүсийн зүрх сэтгэлд хайрыг номлож байв. Нөгөө хүн нь барилгын цэрэгт насаараа хурандаа цолтой байсан тэтгэврийн хөгшин Дал Гас “Алдагдсан нутгаа дотроосоо олье” гэсэн хөдөлгөөнийг зохион байгуулсан. Нутагтаа ургаж болох модыг тарих гэж оролдсон ч нойтон намагтай, хүйтэн салхитай нутаг учраас ямар ч мод ургахгүй, үхээд

байсан. Гэхдээ Дал Гас олон удаагийн уйгагүй оролдлогоор Жодоо гэдэг модыг гаргаж авсан байна. Модоо Альпийн нурууны хөндий, далайн эргээр тарьсан. Хэсэг хугацааны дараа мод ургаж салхийг хаасан. Салхи хааснаар цаг агаар дулаарсан. Ард түмэн урамшиж намгийн усыг шавхан үржил шимтэй хөрсийг бий болгож, мал аж ахуй, газар тариалан эрхэлж эхэлсэн байна. 100 жилийн дараа Дани улс дэлхийд хөдөө аж ахуй, мал аж ахуйн орлогоороо номер нэг улс болтлоо хөгжсөн. Нөхцөл байдал асар хүнд байсан ч хоёрхон хүний хүсэл мөрөөдөл хүнд нөхцөл байдлыг даван туулж, өнөөгийн өндөр хөгжилтэй Дани улс болоход нөлөөлсөн. Зүрх сэтгэлдээ аугаа их хүсэл мөрөөдлийг тээж яваа таны дотор зөвхөн өөрийн амьдралаа өөрчлөөд зогсохгүй, гэр бүл, найз нөхдөө, хамт олон, цаашлаад улс үндэстэн, хүн төрөлхтнийг өөрчлөх аугаа их хүч нуугдаж байдаг юм шүү, Та тэр хүчээ сэрээгээрэй.

Бид дэлхийн энергийн төв дээр байдаг. Монгол гэдэг бол зүгээр нэг нэр биш, Монгол Улс бол ариун дагшин ертөнцийн тэнцвэрийн төв. Монгол улсын газрын доороос 04-06 цагийн хооронд асар их хүчтэй энерги ялгардаг. Энэ энергиэр дэлхий тэжээгддэг байна. Монгол хүний зүрх зориг, оюун ухаан, монгол хүний цөс, хөх толбо асар их энерги. Бид ийм их хүчтэй энерги дотор амьдардаг учраас бодсон бодол, хэлсэн үг бүхэн биелдэг. Гэтэл өнөөдөр монголчууд том мөрөөдөхөө больчихжээ. Автобусны мөнгөгүй гэнгүүт автобусны мөнгө олддог, хоолны мөнгө дууслаа яанаа гэтэл хөдөөнөөс нэг хүн гуя барьчихсан ороод ирдэг. Тиймээс бүгдээрээ өнөө маргаашийн юм мөрөөдөхөө больё, алсын хараатай амьдаръя. Мөнгөгүй Монгол ядуу биш, мөрөөдөлгүй Монгол ядуу. Зүрх сэтгэлдээ аугаа их хүсэл мөрөөдлийг тээж, Монгол орныхоо ирээдүйн сайн сайхныг цогцлоох хувь заяа бидний гарт байна.

Бас нэг гоё зүйл бол бид алтан нано секундын үед амьдарч байгаа юм байна лээ. Би энэ мэдээллийг доктор Батсүх багшаас сонссон. Нано секунд гэдэг нь секундыг асар олон хуваах хэмжээний хамгийн бага хугацааг хэлдэг. Дэлхийн бүх насыг нано секундэд хуваахад 25 жил гардаг. Энэ 25 жилийг алтан нано секундын үе гэж эрдэмтэд үзэж байгаа юм. Яагаад алтан нано гээд байгаа юм бэ гэсэн чинь сансраас эх дэлхий рүү эерэг энергийг дэмжих асар хүчтэй энерги ирж байгаа юм байна. 1987–1996 онд тэр энерги 10 дахин нэмэгдсэн. 1997–2002 онд 100 дахин нэмэгдсэн. Тэгвэл 2003–2012 онд 100,000 дахин нэмэгдэж байгаа. Бид амьдралын зорилготой, эерэг сэтгэлгээг ихээр төлөвшүүлж, амьдралаа гэрэл гэгээтэйгээр харж, түүнийхээ төлөө зүтгэж байгаа хүн болгоныг ивээх ийм хүчтэй эерэг энерги /дэмжих энерги/ бидэнд үйлчилж байгаа юм байна. Гэхдээ энэ энерги нь амьдралын зорилгогүй, зүрх зориггүй, үргэлж хүнд гомдож, гоншигнож явдаг, нэг бол атаач, сөрөг хүмүүст огт үйлчлэхгүй. Та бүхэн энд сайхан амьдаръя гэж хүссэн учраас, таны сайхан амьдрах цаг болсон учраас, сайн сайхан юм руу тэмүүлдэг байсан учраас, энэ уулзалтанд эртлэн ирж оролцож, энэ мэдээллийг сонсож байгаа юмаа. Та бүхний санасан бүхэн сэтгэлчлэн бүтэж, сарвайсан бүхнээ атгаж, олон хүний амьдралд өнгө, гэрэл гэгээ нэмсэн сайхан үйлийг бүтээх өндөр зорилготой, уужим сэтгэлтэй, алсын хараатай амьдраарай гэж хүсэн ерөөе.



Амьдрахуй ухаан бясалгалын төвийн тэргүүн Ц.САРАНЦЭЦЭГ:

Монгол заяа

Үзэж өнгөрүүлсэн амьдралаараа туршлага цуглуулж, ажиглалт хийгээд түүнийгээ хуваалцан ярилцдаг нь хүний ёс юм. Та бүхэнд хэрэг болох болов уу гээд би “Монгол заяа” гэдэг лекцээ товчлоод хүргэе.

Монгол гэдэг үг Санскрит гаралтай “Ариун дагшин газар” гэсэн утгатай юм байна. Ариун дагшин газар ариун дагшин хүн төрөөд амьдралыг ариун дагшин болгох учиртай аж. Хүнд амьтнаас ялгаатай хэдхэн шинж чанар байдаг. Хамгийн наад зах нь амьтан инээмсэглэж чаддаггүй. Хүн нүүрэн дээрээ жинхэнэ инээмсэглэлийг авч ирэхэд маш олон жилийн нөр их хөдөлмөр хэрэгтэй байдаг. Инээмсэглэж өнгөрүүлсэн агшин бүр хүний амьдралд тооцогддог юм байна. Хүүхэд унтаж байхдаа хүртэл үнэгчилэх буюу инээж байдаг. Тэр нь цаанаасаа эд эс нь аз жаргал, баяр баясгалантай байгаа болохоор үнэн голоосоо инээмсэглэж байгаа юм байна. Сургуульд ороод ирэхээр инээмсэглэл нь эрс багасдаг, 4 дахин багасдаг байна. 10 жилийн хүүхэд өдөрт 17-18 удаа инээдэг. Тэгээд 11-р ангиа төгсөөд, дээр үеийнхээр 10-р ангиа төгсгөөд инээхээ больчихдог. Инээсэн ч гэсэн онгоцны үйлчлэгч шиг цааш хараад инээхээ больчихдог. Гэхдээ худлаа ч гэсэн инээмсэглэх нь хүний биед их хэрэгтэй юм. Дарга царайлаад, ухаантай царайлаад хөмсөгөө зангидаад ирвэл хүний нүүрэн дээр 78 булчин ажилладаг гэнэ. Гэтэл чин сэтгэлээсээ инээхэд нүүрэн дээр дөрөвхөн булчин ажилладаг. 78 булчинг ажиллуулахын тулд таниас маш их хэмжээний энерги зарцуулна. Тэртэй тэргүй бид нар амьдрах эрчим хүч гаргадаг, энэ гэрэл цахилгаан гардаг шиг амьдрах эрчим хүч байдаг. Тэгэхээр тэр эрчим хүчийг 78 булчинг дарга царайлахад зориулах уу, эсвэл 74 булчингаа сайхан амрааж байгаад дөрөвхөн ширхэг булчинг ажиллуулаад дараагийнхаа энергийг өөртөө цуглуулж авах тийм царайтай байх уу? Инээмсэглэнэ гэдэг нь ийм утгатай байдаг. Энерги гэж шинжлэх ухаанд нэрлээд байгаа болохоос уг нь энэ чинь Бурхан гэдэг нэртэй юм шүү дээ. Сүсэг бишрэлтэй хүмүүс дотор Бурхан гэдэг нэртэй, шинжлэх ухаан болохоор энерги гэдэг нэртэй, өдөр тутмын бидний амьдралд бол хайр гэдэг нэртэй юм. Та одоо зүгээр байж байгаад хайртай хүнийхээ тухай бод доо, өөрийн эрхгүй ходоодны чинь мухраас инээдэг, баяр төрөөд ирж байгаа. Үүний гадаад илрэл нь инээмсэглэл. Хөмсөгөө зангидчихаад, хаашаа хараад байгаа нь мэдэгдэхгүй хүнээс би айдаг. Мундаг юм байна гэж айж байгаа юм биш. Хөөрхий дөө, чааваас даа энэ хүн цаашид яаж амьдарна даа гэж бодоод өмнөөс нь айдас хүрээд байдаг юм.

Асар их буян үйлдэж байж хүн болж төрдөг. Тэр дундаа монгол хүн болж төрнө гэдэг бол зөвхөн эд материалын хувьд биш, зөвхөн хүнд тусласнаараа биш, оюун санаа сэтгэл зүрхээрээ

хүний сэтгэлд үлэмжийн их буян үйлдэж байж Монгол газар төрөх эрхийг олж авдаг. “Монголчууд диваажинд арын хаалгатай хүмүүс” гэж Далай багш хэлдэг. Далай багш хэлэхдээ “Хэрвээ диваажин гэж байгаа бол тэрүүний эзэд нь дандаа Монголчууд байгаа” гэсэн. Өөрөөр хэлбэл энэ диваажинд оруулах уу, болих уу, хасах уу, дараа жил хүлээлгэх үү гэдгийг шийддэг дарга нар нь дандаа монголчууд байдаг. Орос, Монгол хоёр хүн бясалгал хийж байгаад диваажинд очно гээд очиход нөгөө эзэд нь монгол байгаа учраас монголыг нь “за, чи орж бай” гээд Оросыг болохоор “чи дахиад нэг хоёр удаа хүн болж төрөөд бясалгалаа хийж байгаад ирээрэй” гэх жишээтэй.

Хүмүүс намайг муу хэлэх болов уу, эсвэл хүний мууг хэлж тэр хүний дургүйг хүргэж яах юм гэж айгаад байдаг мөртлөө хэлэхгүй байхаар, өөрийнхөө санаа сэтгэл дотор байгаа юмаа гаргаж илэрхийлэхгүй болохоор зовдог. Та өөрөө зүгээр зовж байгаа биш, сүнс чинь зовж байгаа хэрэг. Тиймээс Равжаа Хутагт, ” Хүний мууг хэлэхээсээ айдаг байж өөрийнхөө сүнсийг зовоохоос айдаггүй” гэж хэлсэн.

Бид зөвхөн энэ биеэрээ нарт ертөнц дээр амьдраад дуусна гэж бодож байгаа бол коммунист үзэл, энэ ганц биендээ л амгалан цатгалан гэвэл энэ бол маш том эндүүрэл. Энэ үзлээс л салж тусгаарахыг гэгээрнэ гээд байгаа шүү дээ. Стресснээс салангид амгалан тайван байдал гэдгийг мэдсэн, сүнсээ зовно гэдгийг ойлгосон ийм хүнийг л гэгээрсэн хүн гэж хэлж байгаа юм. Тийм хүний хажууд зүгээр суугаад баймаар, юм ярих ч үгүй хамт хажууд нь байхад их сайхан байдаг. Энэ яаж байна гэхээр миний сүнс баярлаж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл тэр хүний зүгээс над руу маш гоё аз жаргалын энерги өгч байгаа. Одоо шинжлэх ухаан энергийг фотон гэж нэрлэдэг болсон. Хүнийг амьдруулж байгаа, хүний санаа сэтгэлийг сайхан болгож байгаа тэр фотон гэдэг юмыг нилээн ихээр цуглуулахаар мэргэн болоод байгаа юм. Хүний амьдралд юу эс тохиолддог билээ. Заримдаа бид мэргэн хүмүүс дээр очдог. Мэргэлдэг хүн дээр очоод хэдэн төгрөгөө өгөөд асуудлаа шийдүүлж байна. Тантай адилхан иддэг, унтдаг, амардаг, ажилладаг мөртлөө яагаад танд тийм зоригтойгоор мөнгийг чинь авчихаад хэлж өгөөд байгаа юм бэ гэхээр тэр хүн фотоныг арай илүү цуглуулсан байгаа. Эрдэмтэд фотоныг судалж үзээд яг энэ гэрэл шиг гэж үзсэн. Гэрлийг хэмждэг нэгж нь фотон. Нэгэн орос эрдэмтэн “Үхлийн дараах амьдралын тухай” гэдэг ном бичсэн. Тэр номонд фотон гэдэг юм чинь бидний үхээд очдог тэр газар одоо болтол оршин тогтнож байна гэж байна. Тэнд байгаа гэрэл шиг цагаан юм дэлхий дээр байгаа бүх юм цахилгаан соронзон орон дотор байдаг болохоор бүх юм цэнэгтэй, бид нарын зүрх хүртэл нэмэх хасах цэнэгтэй, жаахан булчингууд хүртэл цахилгаан цэнэгээр ажилладаг. Өөрөөр хэлбэл дэлхий дээрх бүх юм цахилгаан соронзон орон дотор байдаг болохоор цэнэгтэй. Гэтэл тэр фотон гэдэг юм цэнэг байхгүй. Тийм болохоор юунд ч татагдахгүй, юунд ч түлхэгдэхгүй, өөрийн дураараа явна. 21-р зуунд энэ дэлхий дээр хамгийн түрүүн фотон гэдэг юмыг өөрийн дураар хэрэглэдэг тэр хүмүүс нь монголчууд бид юм. Тийм учраас монгол заяанд төрсөндөө, Монголд хүн болж төрсөндөө бахархах ёстой. Ариун дагшин газар хүн болж төрөхийн тулд нэлээн олон амьдралаа зарцуулж байж хүн болж төрсөн. Монгол газар ингэж амьдарсан хүн маань бахархаж онгирохоосоо гадна асар их хариуцлага ноогдож байгааг бодох хэрэгтэй. Маш их хариуцлага оногдож байгаа. Бусад орны хүмүүс зүгээр нэг хоол идээд, урьд насныхаа хүний хурааж ирсэн буянг идээд дуусдаг бол монгол хүн та бол үгүй. 2075 он гэхэд Монгол хүн гэж хэн бэ, ер нь энэ ямар учиртай хүмүүс вэ гэдгийг яруу тод харуулна. Өнөөдөр бид нэг америк хүн хажууд нь дуугарахаар намс гээд л явчихдаг. Тэгэж жижгэрч болохгүй ээ. Энэтхэг хүмүүсийн

гайхамшигтай чанар нь ерөөсөө ичдэггүй. Ичихгүй байна гэдэг хүнд маш их зориг өгдөг юм. Ичих л юм бол таны бахархал болон сурах гэсэн юм болгонд чинь садаа болно. Өнөөдөр монголчууд бид дандаа айдастай явдаг болж. Харанхуй бүрэнхий болохоор гадаа гарахгүй, ээж нь хүүхдээ сургуульд явахад нь хүүхдэд зодуулав, цүнхээ булаалгав, машинд дайруулав гээд л байдаг. Энэ чинь “дайруулаарай чи” гээд захиад явуулчихаж байгаа байхгүй юу. Ингээд хүүхэд багаасаа л машин зам гарахдаа айдаг, ийш тийшээ хараад бүлтэгнээд байдаг болчихдог. Хүний судасны тонус даарахаар агшдаг, айхаар агшдаг. Хамгийн түрүүн судас агшихад гэмтдэг эрхтэн бол бөөр байгаа юм. Бөөр бол хүний биен дотор байдаг усны хаан. Биен дотор байгаа бүх усыг бөөр зохицуулна. Чи ийшээ яв, чи тийшээ яв гээд бүгдийг нь шүүгээд өгнө. Нэг балга ус уухад бөөр тэрийг 1 сая фильтрээр шүүдэг. Ганц балга усыг 1 сая фильтрээр шүүхэд яг ритм шиг л ажиллана. Тэр ритмийг энерги, амьдрах эрчим хүч бий болгодог. Бөөрний ритм өөрчлөгдвөл хүний дотор байгаа усны солилцоо өөрчлөгдөнө. Иймээс та айхаа боль, өөртөө арслангийн зүрхийг суулгах хэрэгтэй.

Хүний гоо үзэсгэлэн дотроосоо ирдэг. Нэг ч үрчлээгүй гоё сайхан бүсгүй инээхгүй байвал шаазан хүн шиг, үхсэн ч хүн шиг харагдаж, айдас төрүүлнэ. Уурлаж байгаа үед сөрөг энерги ялгарч амь насыг чинь богиносгодог, эрүүл мэндийг чинь муутгадаг, ажил төрлийг чинь бүтэлгүй болгодог. Ийм энергийг үүсгээд тань руу бөмбөгдөх гэж байгаа юм шиг сумаа тавих тэр агшинд инээмсэглэл гэдэг бамбайгаар өөрийгөө хамгаалаарай. Тэгэхээр 2-3 минутын дотор маш гоё уур амьсгал үүсдэг. Бид нар бусдыг хүн хайрладаггүй, ууртай энэ мангар гээд байгаа ч үнэн хэрэг дээрээ та өөрөө тийм байгаа юм. Таны дотроос өөрөө мангар, хүнийг ойлгодоггүй, намайг гомдоочихлоо гэсэн энерги гараад байхаар түүний хариуг л нөгөө хүн чинь хийж байгаа шүү дээ. Цаад хүн чинь таны сэтгэл санааны байдлыг л үзүүлээд өгнө. Та өнөөдөржингөө инээмсэглээрэй. Нүүрээ үрчийхийг бүү бод, инээгээд л бай. Хүсэл болгон чинь биелж, өвчин зовлон үүсэж байсан бол эдгэрнэ шүү дээ.

Инээмсэглэл хичнээн хүчтэй болохыг Холливудын нэг жүжигчиний түүх харуулдаг. Тэр жүжигчин зөнөдөг өвчин тусаад эдгэрэхгүй юм чинь гэж бодоод өөрт байсан бүх мөнгөө нэг сувилалын газар өгчихөөд өөрөө тэнд өвчтөн болж хэвтсэн. Жаахан мөнгө илүү гарахаар нь Чарльз Чаплины кино авч чөлөөт цагаараа үзсээр байгаад эдгэрсэн байсан. Тэндээсээ гараад инээмсэглэлээр эмчилдэг эмнэлэг нээсэн. Тэр эмнэлэг одоо Америкийн Калифорни мужид байдаг. Ханиад хүрвэл очоод үзүүлэхээр өдөрт 2-3 удаа 15 минут инээлгэ гэсэн жор бичдэг. Монгол заяаг олж төрнө гэдэгт инээмсэглэж байх чанар бас хамаарна. Бид байнга л төлөв түвшин царайлаад байдаггүй, ходоодныхоо мухраас үхтэлээ инээдэг шүү дээ. Онигоо эхлэнгүүт л төгсгөлийг нь бодоод инээдэг. Гэтэл еврей хүн онигоо ойлгодоггүй гэдэг. Еврейчүүд маш ухаантай, Америкийн толгой бол еврей толгой гэгддэг мөртлөө инээдэггүй, онигоо ойлгодоггүй. Завхарсан юм яриад гээд инээдэггүй, Англи хүн болохоор хоёр инээдэг гэж байгаа. Тэд хүмүүс инээж байхад намайг мангар гэнэ гэж бодоод худлаа инээдэг, гэртээ очингуутаа нөгөөхөө ойлгоод жинхэнээсээ инээдэг. Гэтэл Монгол хүн онигоо эхлэнгүүт л ойлгож шууд инээдэг.

Хүмүүс их олон юмаараа уралдлаа, эдийн засгаараа уралдлаа. Ганцхан уралдаж үзээгүй юм байгаа, оюун санаагаараа уралдаж үзээгүй. Тэрийг шамбалын дайн гэж нэрлээд байгаа. Шамбалын дайн бол их буу, атомын бөмбөг гаргаж ирээд байлдах юм биш. Шамбалын дайны байлдагч нар дандаа шингэн дуутай торгон хувцастай эмэгтэйчүүд байна. Оюун санаагаараа

эрэгтэй хүмүүс дийлдэггүй. Учир нь юунд байна вэ гэхээр ээж хүнд, эх хүнд заяасан тэр хайр бол Бурханыхтай их адилхан. Өөрөөр хэлбэл тархиных нь баруун, зүүн хоёр тал нь яг тэнцүүхэн ажилладаг. Эрэгтэй хүнийх болохоороо зөвхөн зүүн тал нь буюу би мундаг гэсэн угаасаа жаахан эрч хүч илүүтэй учраас тархиных нь логик сэтгэхүй нь сайн хөгжчихсөн юм. Эрэгтэй хүн бол хүн төрөлхтөн гэж том ярьдаг, харин эмэгтэй хүн бол миний муу ээж, миний муу дүү гэж ярьдаг. Тэгэхээр эрэгтэй хүн байшингийн барилгыг томоор нь хардаг, эмэгтэй хүн болохоор ямар өнгөөр будах уу, юу дэвсэх үү гээд нарийн ухааныг нь хийдэг. Байгаль ээж эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг бие биенээ нөхөхөөр бүтээсэн болохоос нэгийг нь нөгөөтэй нь адилхан болгох гэж, хэрэлдэж тэмцэлдүүлэх гэж бүтээгээгүй. Тиймээс энэ мөрөн дээр байгаа бөндгөрөө хэрэглээд хоорондоо эв түнжинтэй амьдрах ёстой. Танд ямар гайхамшигтай тархи байдаг гэж бодно? Энэ уураг тархины ганцхан эс нь өдөрт бараг 40 хуудастай гардаг Нью-Йорк таймс сонины зургаан сая жил гарах мэдээллийг ганцхан секундэд тогтоох чадвартай байдаг. Гэтэл бид тэр гайхалтай тархиныхаа 5%-ийг хэрэглээд байгаа юм. 95% нь далд ухамсар гэж нэрлээд байгаа тэр юман дотор байж байгаа. Үлдсэн 95%-ийг бясалгалыг чин сэтгэлээсээ хийж байж далд ухамсар луугаа өнгийх гээд байгаа юм. Сод хүмүүс, гэгээрсэн хүмүүс бол 10 гаруй хувийг хэрэглэсэн. Ийм хүмүүс одоогийн байдлаар хүн төрөлхтний аравхан хувь нь, бусад 90 хувь нь ашиглаагүй. Бид яагаад ном уншиж, лекц сонсоод, клуб дугуйлан байгуулаад яваад байгаа вэ гэхээр тэр 95%-иас ганцийг ч болсон, 0,1%-ийг ч болсон авч хэрэглэх гээд байгаа хэрэг. Энергийг Номин супермаркет гээд ойлгочих л доо. Өөрөөр хэлбэл өөрийнхөө мөнгөний, торны хэмжээгээр сонголтоо хийгээд тэндээс бараа авч байгаа. Энерги бол яг тийм. Та сонголтоо хий гэсэн зарчимтай. Супермаркетэд ороод өөрөө сонгоод бараа авдаг болохоор худалдагчийн адил энерги мэдэрдэг болохоор сонгоод авдаг.

Орчин цагийн монгол хүмүүс биднээс гадна одоо гайхамшигтай хүүхдүүд төрж байгаа юм. Дэлхийн хамгийн гоё хүүхдүүд төрж байгаа. Ялангуяа 1990-ээд оноос хойшхи хүүхдүүд бол гайхамшигтай хүүхдүүд төрж байгаа, биднийг дагуулахгүй. Яг компьютер шиг программтай хүүхдүүд төрж байгаа. Тийм болохоор хүүхдүүдийн хувь заяаг хайрла, хүүхдүүдийг хайрла. Хэлж байгаа үгний чинь 80% нь хүүхдийг магтах ёстой шүү. Муу муухайгаар хэлж, дайран доромжилно гэдэг бол та монгол хүн биш. Монгол хүн чинь морио хүртэл хараадаггүй. Нохойгоо ч хараадаггүй. Хүүхдийг хамгийн түрүүнд өмөөр. Хошин шогийнхон тоглож байсан нэг зүйл санаанд орлоо. 13-тай хүүхдээ аав нь загнажээ. Чиний насан дээр өнчин Тэмүүжин дүү нараа тэжээгээд, ээжтэйгээ өрх гэрээ аваад явж байсан, бүх юмыг чинь бэлдэж өгөөд байхад чи ёстой өөдгүй золиг, олигтой сурсангүй гэсэн. Хүүхэд нь аавынхаа өөдөөс харж байснаа, аав аа, таны насан дээр Тэмүүжин Эзэн Чингис хаан болчихсон байсан юм биш үү? Та юу хийгээд байгаа юм гэсэн. Ийм айхтар ухаалаг хүүхдүүдтэй хандаж байгаа учраас бид нар өнгөрсөн зууны хүүхэд шиг харьцаж болохгүй. Гэхдээ тэднээс айх биш тэдний үнэнч нөхөр нь бай, хайрла, хүүхдийг магт.

2075 он гэхэд Монгол орон дэлхийд номер нэг улс болно. Түүний тулд өнөөдрөөс эхлээд инээмсэглэх хэрэгтэй байна. Хүн загнаж байсан ч урдаас нь инээж л бай. Мангар юм гэж бодвол бодож л байг. Тэр хүний дотор өөрөө мангар байгаа учраас инээж байгаа хүнийг мангар гэж харж байна шүү дээ. Хоёрдугаарт нь айдсаа боль. Алийн болгон алгын чинээ болох юм бэ? Та угаасаа арслан суудал дээр суусан юм чинь тэр чигээрээ архираад бай, арслан суудлаасаа бууж болохгүй. Гуравдугаарт эелдэг бай. Эелдэг байх шиг үнэтэй юм байхгүй. Ийм л гуравхан юмыг биелүүлээд явбал 2075 он гэхэд бид нар үүргээ гүйцэтгэх гээд

байна. 2075 онд дэлхийн хүмүүс монголчуудын амыг хардаг болно.



**Төрийн шагналт, шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, ШУА-ийн Физик техникийн
хүрээлэнгийн захирал, академич Б.ЧАДРАА**

Оюунлаг монгол хүн

Аливаа тусгаар тогтносон улсын иргэн хүний оройн дээд шүтээн сахиус, мөрдөж эрхэмлэх зүйл нь тусгаар тогтнолоо хэрхэн авч явж, хадгалан, дараагийн үедээ шилжүүлж өгөх вэ гэдэг асуудал юм. Үүнийг баталгаатай болгохын тулд ард түмэн нь оюунлаг, мэдлэгтэй болсон байвал зохино. Тусгаар тогтнолын гол баталгаа нь өргөн мэдлэгтэй, өндөр боловсролтой, халуун эх оронч, эрүүл чийрэг ард түмэнтэй байх явдал болно. Тэр тусмаа хоёр агуу том гүрний дунд байгаа цөөхөн монголчууд, бас цөлжилтөнд автагдаж байгаа ийм улс бол тусгаар тогтнолоо бэхжүүлнэ гэдэг туйлын хэцүү зүйл. Ийм учраас үүнийг авч үлдэх арга, ганц зам бол хүн ард нь оюунлаг байх явдал гэж би үзэж байгаа. Монгол улс 2200 жил энэ хоёр аварга гүрний дунд оршоод, амьдраад байгаа нь иргэн бүрт хоёр эрхэм үүрэг зорилго байдаг, түүнийгээ хэрэгжүүлдэгтэй холбоотой.

Нэгдүгээрт, Амьдрал ахуйгаа залгаж, хоол хүнсээ бэлтгэж, гэр орноо авч явах, хоёрдугаарт, энэ улсын иргэний хувьд эх орныхоо төлөө зүтгэнэ, үүнийхээ төлөө би хувь хандив оруулна, үүнийхээ төлөө би бүх бодол санаагаа зориулах. Тэгэхээр өнөөгийн бид үүнийг одоо хэрэгжүүлж чадах уу, үгүй юу гэдэг талаар хэдэн зүйл хэлье.

Нэгдүгээрт, монгол үндэстэн, монгол хүн гэж хэн юм бэ гэдгээ эхлээд мэдэж авах хэрэгтэй. Монгол үндэстэн одоогоос 2220 жилийн өмнө энэ нутаг дээр оршиж байсан Хүннү гэдэг улсаас анх бий болсон. Хүннүчүүд төв Азид анхны төрт улсыг байгуулсан. Дэлхийг өнөөдөр захиран удирдаж байгаа Америк гүрэн 200-хан жилийн түүхтэй. Манай хойд хөрш Орос улс бас хэдхэн зуун жилийн түүхтэй. Үнэн хэрэгтээ 17,18-р зууны үед Киевээс ирсэн хэдэн илгээлтийн эзэд Европ, Сибирийг эзэлж яваад л Орос гэдэг улс бий болсон шүү дээ. Үүнтэй харьцуулахад бид нэн эртний, баялаг түүхтэй улсын удам угсаа. Тэгэхээр Хүннү бол манай нутаг дэвсгэр дээр оршин тогтож асар их хүчирхэг, өндөр соёлтой, бичигтэй, номтой, эрдэмтэй, техник технологийг хөгжүүлсэн, металл эд ангиудыг янз бүрээр хийж чаддаг ийм том гүрэн байсан. Түүгээр ч барахгүй Европыг хүртэл эзлэн авч, холбоо тогтоож байсан ийм агуу гүрэн юм. Энэ нь Монгол Улсын Шинжлэх Ухааны академийн эрдэмтэд, Орос, Францын эрдэмтэд хамтраад Монголын газар нутаг дээр явуулсан сүүлийн 10, 20 жилийн судалгаанаас харагдаж байгаа юм. Архангай аймгийн Гол мод, Орхоны хөндий, Дорнодын тал, Хэнтий зэрэг энд тэндээс ямар агуу гүрэн байсан юм бэ гэдгийг харуулсан үнэхээр нүд бүлтийж, чих сортоймоор үзмэрүүд сүүлийн 10, 20 жилд олдсон. Оросын дэлхийд цуутай Киселёв гэдэг хүн, “Би дэлхийг их олон тойрч, газар нутгийг нь ухаж, соёлтой нь танилцсан. Монгол шиг

газрын дээрээ, доороо ийм их соёлын өвтэй газар нутгийг хаана ч үзээгүй, сонсоо ч үгүй юм байна. Агуу гүрэн юм аа” гэж хэлсэн байдаг. Францад Монгол Улсын 3 дахь Ерөнхийлөгч Н.Энхбаяр зочилсон. Надад дагалдаж явах аз завшаан тохиолдсон. Францын Ерөнхийлөгч, францын ард түмэн юу ярьж байсан бэ гэвэл, “Бид монгол гэдэг жижигхэн оронг мэднэ. Гэхдээ дэлхийн их долоогийн түвшинд танай Ерөнхийлөгчийг хүлээн авч байна. Яагаад ингэж хүлээж авч байна гэвэл монголчууд маш хэцүү түүхийн хүнд бартаат замыг туулж, янз бүрийн дарамт даралт, дайн байлдааны үед ч нэн эртний гайхамшигт соёлын түүх дурсгалыг мөрөн дээрээ чирсээр яваад өнөөдрийн хүн төрөлхтөнд авчирч өгсөн ийм их гавьяатай ард түмэн. Тийм учраас танай орны төлөөлөгчийг их долоогийн хэмжээнд угтан авч байгаа юм” гэсэн. Энэ бол ихээхэн том хүндэтгэл гэдгийг хэлье гэж бодож байна.

Монгол хүн гэдэг ямар хүн бэ гэдэг талаар би зарим зүйлийг хэлье. Түүхийг гуйвуулсан хачин юм их бий л дээ. Хүннүгийн дараа бий болсон Жужан, Татар, Сяньби, Уйгар, Кидан, Их Монгол зэрэг улс нь өндөр соёл, техник технологи, амьдралын ахуйн хэрэгцээнийхээ юмыг хадгалсаар, хийсээр яваад ирсэн ийм их гүрэн, аугаа ард түмэн юм. Тэр үеийн монголчууд айхтар бяр чадалтай, сэлэм жад барьчихаад дэлхийг байлдан дагуулсан юм биш ээ. Тэр үеийн монголчууд бол техник технологи, багаж хэрэгсэл, оюун ухааныг бусад орон, үндэстэнээс илүү эзэмшиж байснаараа дэлхийн талыг эзэлж явсан юм гэдгийг мэдэх хэрэгтэй. Очсон газар болгондоо тэд одон орныг судлах оргил байгуулдаг. Тэгээд бүх довтолгоог шөнийн цагт хийдэг. Өөрөөр хэлбэл одны хөдөлгөөнөөр баримжаалдаг байсан. Энэ нь маш нарийн, одоогийн GPS гээд хүмүүс машиндаа координатаа тэмдэглээд явж байгаа шиг тиймэрхүү маягийн хөдөлгөөнөөр, түүнийгээ мэдэхийн тулд одон орныг судлах оргилыг байгуулж ажиллаж байсан улсууд юм билээ. Хэрэглэдэг техник технологи нь хаана ч байхгүй, хосгүй, хүн ойлгохын аргагүй байсан. Хятадын урт цагаан хэрэм гээд хэн ч давж чадахгүй хэрэм байна. Үнэн хэрэг дээрээ олон мянган жилийн өмнө талын монголчууд, Хүннүчүүдээс тэд өөрсдийгөө хамгаалж барьсан зүйл. Түүнийг Чингисийн үеийнхэн тэсрэх бөмбөг буюу өнөөдрийн хэлээр пуужин хийгээд, тэр өндөр хэрмийг давуулаад, цугларсан улсууд, арми нь байгаа газрыг олж гал голомтон дээр нь бөмбөгөө дэлбэлээд, тэднийг сандралдаж байх хооронд нь хэрмийг даван орж байлддаг байсан юм. Европ руу дайрахдаа маш нарийн оньсон техник технологийг хэрэглэсэн нум сум, жад зэргийг хэрэглэдэг байжээ. Сүбээдэй баатрын мэргэн харвасан газрыг чулуун дээр сийлээд тэр чулуу нь Ленинградын Эрмитажад хадгалагдаж байдаг юм. Тэнд 596 алд газар нум сумаар харваад байгаа оножээ. 596 гэдэг чинь ойролцоогоор 500 метр гэсэн үг. Одоо манайхан Англи Америкаас мэргэн буучид, анчид цууд гарсан бууг ховор амьтан буга, гөрөөс, гахай, туулай ална гээд авчирч байна шүү дээ. Үүний чинь тохируулдаг оновчтой зай, нүдний хараа хүрдэг газар бол 200 метр байдаг юм. Тэгэхэд тэр үед 500 метрийн цаадахыг онож байсан. Яаж тэгдэг вэ гэхээр өнөөдрийн энэ техник технологийн гол зарчим болох гидравлик, пружин техник, механикийн гол онолуудыг ашиглаж байсан байгаа юм. Тэр нум сум нь гидравлик хүчинд тулгуурласан нум нь дотроо нарийн хоолойгоор дүүргэсэн устай, татахад хоёр тал руугаа гүйж хүч хуримтлуулдаг. Бас төмөр пружинтэй учраас тавихаар тийм хол бууддаг, онодог байжээ. Европ руу дайрахад Австрийн Янжун гэдэг түүхч хар лам тэр үед бичихдээ, “Европыг алдахгүй, талын монголчуудад эзлүүлэхгүйн тулд бид бүх хүчээрээ бэлтгэсэн. Хүнд морин цэрэг, зэр зэвсэг гээд юу байдгаа бэлтгэсэн. Тэгээд бид монголчуудтай тулгарсан. Манай зэр зэвсэг харвасан сум алс зайд ононо гэж бодоод ганц нэгийг туршаад байж байтал гэв гэнэтхэн монголчуудын нум сум бидэндээр мөндөр бороо шиг буусан. Манай нум сум газрын талд нь буугаад, бид

яаж ч чадахгүй бууж өгөхөд хүрч билээ” гэсэн байдаг. Ийм зэр зэвсэгтэй, ур ухаантай, оюунлаг байсан учраас бидний өвөг дээдэс дэлхийг эзэлж байсан гэж ойлгох хэрэгтэй.

Өнөөдрийн монголчууд бид тэр их агуу техник технологи, шинжлэх ухааныг эзэмшсэн ухаалаг хүмүүсийн удам угсаа. Үүнийг авч дараа дараагийн үедээ өвлүүлэн үргэлжлүүлэх ариун бөгөөд хариуцлагатай үүргийг хүлээсэн хүмүүс. Тийм учраас өндөр хариуцлага үүрсэн, удам угсаагаараа их бахархах, монгол хүн болж төрснөөрөө баярлах хүмүүс. Монгол гэдэг улсыг, Монгол гэдэг үндэстэнг авч явах, гал голомтыг сахиж үлдсэн, энэ гал голомтыг бадраагаад, цааш нь үргэлжлүүлэн хөгжүүлэх ариун үүргийг хүлээсэн ийм хүмүүс билээ. Харамсалтай нь бид өнөөдөр их үхээнц, арчаагүй, дэлхийн бөмбөрцөгийн бүх улсуудаас доогуур түвшинд ажиллаж, амьдарч, хүмүүнлэгийн тусламж гуйж, өдөр шөнийг өнгөрөөж байгааг харахаар үнэхээрийн харамсаж, өнөөдрийн монголчууд гэдэг чинь гутарсан, юм сэтгэж, хийж чадахаа байсан хүмүүс болсон юм болов уу гэдэг асуудал аяндаа гарч ирээд байгаа юм.

Тэгвэл үгүй юмаа. Жинхэнэ монгол удам угсааг авч үлдсэн, чаддаг, сэтгэдэг чадавхитай ийм монгол хүн гэж би ойлгодог. Монголчууд цөөхөн ч гэсэн дэлхий даяар тархаж тааралдахгүй газар гэж байхгүй. Би Өмнөд Африк, Мозамбек зэрэг болон Өмнөд Америкийн орнуудаар явж байгаад энд ёстой монгол хүн гэж нүдний гэм гэж бодож байтал алхаж байгаа нь яг монгол хүн мөн дөө, тэгээд хөөе чи энд юу хийж яваа юм гэсэн чинь мань эр монгол хүн байна гээд л намайг тэврээд авсан. Би тэгэхэд ер нь энэ монголчууд сайн тархжээ, дэлхий дээр байдаггүй газар үгүй юм байна. Бас ч гэж шөрмөстэй ард түмэн юм даа гэж бодож байсан. Үүгээр би юу хэлэх гээд байна гэвэл тогтсон газраа толгой цохиж явдаг цөөхөн хүн бол монгол үндэстэн юм. Гагцхүү хөгжих нөхцлийг нь бүрдүүлж өгөхгүй урагшгүй төр засагтайгаар 20,30 жил болж байгаад л хамаг учир байна. Цөөхөн монгол хүнд нь ясны, шүүсний, мах цусны тэр агуу их чанар, онцлог нь хадгалагдан үлдсэн байна. Би Америкийн, Оросын урдаа барьдаг их сургуулиудыг бүгдийг нь хамруулж байгаад Технологийн дээд сургууль байгуулсан юм. Дараа нь Улаанбаатарын их сургуулийг байгуулсан. Тэндээс 200-аад монголыг 2-р анги төгсгөөд Америк явуулсан. Би ШУА-ийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчөөр 21 жил ажилласан учраас академийн шугамаар олон залуусыг гадаад явуулсан. Тэнд очоод хэдхэн жил болсоны дараагаар манай залуус лабораторийн эрхлэгч, Нобелийн шагналтны юмыг бэлтгэж өгдөг ажилтан, эсвэл төслийн удирдагч зэрэг ажил хийдэг болчихсон. Нэг удаа би Америкт очоод явж байсан чинь хоёр энэтхэг хүн надад: “Та манай дарга нарт юм өгөөд танай хүмүүс ийм хурдан дэвшээд байдаг юм уу? Бид нар 20,30 жил ажиллаад гүйцэтгэх ажилтан л хийдэг. Монголчууд нь 2,3-хан жил болоод дэвшээд яваад өгөх юм” гэж байсан. Би юу өгөх вэ дээ, хамтын ажиллагааны хүрээнд л хэдэн залуу явуулсан. Хамгийн хэцүү салбар бол оюуны салбар байдаг, энд манайхан тодорсоор л байна.

Булчин шөрмөс биеийн хүчний асуудлыг цус маханд нь Чингисийн үеэс суулгаад өгсөн учраас олимпийн аварга, сумогийн аварга болж байна. Яагаад гэхээр 2000 гаруй жилийн бэлтгэлтэй. Харин оюун ухаанаар дэлхийн бөмбөрцөг дээр толгой цохино гэдэг бол өөр, энэ бол хэцүү. Гадаадын эрдэмтэн болгон тэр хүчит багаж төхөөрөмж, эрдэм шинжилгээний юмаар зодоод байгаль ертөнцийн нууцыг илрүүлэх гээд дийлэхгүй байхад нусаа гоожуулсан хоёр гурван монголчууд очоод тодроод, товойгоод, цахиур хагална гэдэг бол туйлын хэцүү. Тэгэхдээ чадаж байна. Би ганцхан жишээ хэлье. Монгол хүн сансарт нисэх үед хадаас хийж

чаддаггүй монголчууд юун сансарт багаж гаргах, тэр мөнгө нь ч байхгүй гэж дарга нар хэлж байж билээ. Би ч хор шар ихтэй байсан, өмнө нь Орост байхдаа хиймэл дагуул хөөргөхөд оролцож явсан. Хэдэн монгол залуу цуглаад за хэдүүлээ нэг юм хийе, энэ болдог юм гээд өдөр шөнөгүй суугаад хийсний дүнд манай сансарын нисгэгч задгай сансарт багажаа гаргаад, дотор нь туршилт хийж байсан. Задгай сансарт багажаа гаргасан тэр төсөлд оролцсон нэг ч орон байхгүй. Тэгээд бүх мэдээг нь Улаанбаатарт одоо манай хүрээлэн дээр хэмжиж аваад, Гүрээгийнхээ дуу шууг нь сонсоод, сонссон хүмүүсийн нулимс нь гоожиж байсан. Зургаахан залуу шүдээ зуугаад, өдөр шөнөгүй хүнд нөхцөлд тэр ажлыг хийсэн. Тэгэхээр монгол хүн сэтгэж чадаж байгаа биз дээ?

Хоёрдугаарт, одоо янз бүрийн компьютер энд тэндгүй байна. Одоо SAMSUNG гэж жилд 40 миллиард долларын электрон багаж хийдэг тийм газар байна. Энэ компани нь тэр үед Вольт амперметрийг модон хайрцагтай хийж байсныг музейгээс нь харж болно. Тэгэхэд бид 300 компьютер хийгээд, MONEL гэдгийг байгуулаад, түүний өмнө нь багаж төхөөрөмжийн үйлдвэр гэж байгуулаад Финляндаар дамжуулаад баруун зүгт гаргадаг байлаа. Тэрнээсээ болж Орос, Германаас сурсан юмаа чи хөрөнгөтөн оронд гаргаж байна гэж арга хэмжээ авахуулж, тархи толгойгоо хага цохиулж явлаа. Хэрвээ түүнийг хөгжүүлээд явсан бол болох л байсан. Монгол хүнд үүрэг өгөөд хий гэвэл юуг ч хийж чаддаг ард түмэн гэдгийг ойлгуулахын тулд ийм хоёр жишээ хэлье гэж бодсон юм. Ер нь монголчууд гэдэг чинь агуу юм шүү дээ, юм бүтээж чадах тэнхээтэй үлджээ. Бид, танай хүүхэд бүгдээрээ тэр агуу улсуудын ул дэвсгэр, халдвар, дархлаа нь болж үлдсэн. Тэднийг зөв чиглүүлээсэй, тэгэх юм бол болно. Тусгаар тогтнолоо хамгаалах хамгийн гол зүйл бол оюунлаг ард түмэнтэй болох явдал юм. Оюунлаг ард түмэнтэй болохын тулд бид яах вэ гэвэл олдсон хэдэн мөнгөө боловсрол, шинжлэх ухаанд л зарцуулах хэрэгтэй. Тэгвэл үеийн үед, хэдэн зуу мянган жил монголчууд цааш явнаа. Тэгээгүй цагт байгаа хэдийгээ өнөөдрийнх шиг үрэн таран хийгээд, хүнд өгөөд устгачих юм бол Монгол улс цаашаа явахгүй. Америкт боловсролд зарцуулсан хөрөнгө оруулалт эргээд Америк улсдаа ч, хувь хүндээ ч 2,6 дахин болоод эргэж очдог. Худалдаа наймаанд зарцуулсан хөрөнгө сайндаа л 10%, 20%, түүнээс дээш ерөөсөө байдаггүй гэж үздэг. Тийм учраас хамгийн зөв хөрөнгө оруулалт бол боловсролд зарцуулсан хөрөнгө оруулалт юм.

Путин “Орос үндэстний сэтгэх чадвар, юм бүтээх чадавхи нь дэлхийн бусад орнуудын үндэстэнгээс үргэлж дээгүүр байж л бид хүнд байдлаас гарна. Тийм учраас Оросын ард түмэн үндэстнийхээ сэтгэх байдлыг, бүтээх чадавхийг нь өндөр байлгахад бүх хүчээ зарцуулна. Ингэж байж бид дэлхийд товойж гарна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд Оросын сэтгэлгээний төв болсон Орос улсын Петр Первийн байгуулсан академийг би өөрийн харъяандаа, гартаа авсан. Оросуудын сэтгэлгээний төвийг, сэтгэх чадвар үргэлж өндөр байлгахын тулд энэ академийг би авсан” гэж хэлж байсан юм.

НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннан “21-р зуунд өөрийн үндэсний шинжлэх ухаан, технологийн чадавхгүйгээр ямар ч орон үл оршмой” гэж хэлсэн байдаг. Тийм учраас бүх улсууд шинжлэх ухаан, технологио хөгжүүлэхийн төлөө үхэн хатан зүтгэж байна. Харин Монголд шинжлэх ухааныхаа академийг яаж устгах вэ гэж оролдсоор л байна. Шинжлэх ухааны гол гурван тулгуур болох физикийн технологи, химийн технологи, биотехнологийг гурвууланг нь устгана гээд Засгийн газарт өргөн барьчихаад явж байгаа шүү

дээ. Энэ үнэхээр гутамшигтай. Монголчууд ухаантай юм чинь нэгэн цагт үүнийгээ бодох байхаа.

Монголчуудынхаа, түмэн олныхоо буянд би их ч юм үзлээ. Энэ Монгол Улс яаж хөгжих вэ гэдгийг дэлхий тойроод явж байхдаа харьцуулж үзээд нэг юм хийе гэсэн юм. Монгол Улсын үндэсний хөгжлийн хөтөлбөр гэдгийг би 15 жилээр боловсруулаад “ОЮУНЛАГ МОНГОЛ” академич Б.Чадраа гэдэг юм боловсруулсан. Үүний үндэс нь юу вэ гэхээр Герман, Франц, бусад том хөгжилтэй орны дунд Швейцарь гэж нэг жижиг орон байдаг. Гэхдээ дэлхийн хамгийн хөгжилтэй орон. Монголыг аваад үзэх юм бол Орос, Хятад хоёрын завсар цөөхөн хүнтэй адилхан жижигхэн орон. Яагаад Монгол Швейцарь шиг хөгжилтэй орон болж болдоггүй юм бэ гэдгийг ойлгохын тулд би бүр зориуд Швейцарьт өдий төдий очсон. Нобелийн шагналт Эрнест Ричард гэж Швейцарийн иргэн, миний найз Монголд ирээд, олон улсын хурал зөвлөгөөн дээр ярьсан зүйлээс Монгол Улс ингэвэл хөгжиж болох юм гэдгийг би ойлгосон. Тэгээд үүнийг бичсэн юм. Хэрэв мөнгө олдог л юм бол түүнийгээ боловсрол, шинжлэх ухаанд зарцуулбал ард түмэн оюунлаг мэдлэгтэй болоод улс чинь хөгжинө. Боловсролтой хүний нэг онцлог нь юу вэ гэхээр тухайн үед би юу хийвэл ашигтай вэ гэдгийг мэддэг болдог. Үүнийгээ яаж хийх вэ гэдгээ бас мэддэг, өөрөө хийдэг. Өөрөөр хэлбэл үйлдвэр байгуулаад, наймаа хийдэг. Үүнийгээ яаж боловсруулах уу, борлуулах уу гэдгээ бас мэддэг. Ийм хүнийг боловсролтой хүн гэдэг. Ер нь боловсрол гэдгийн ач холбогдол энэ. Харин боловсролгүй хүн бол ажил хайгаад л, гудамжинд гутлаа цоортол, тавхайгаа элэгдтэл цогиод байхаас өөр чадваргүй байдаг. Тиймээс Америкчууд боловсролыг хөгжүүлэхийн төлөө зүтгэж байгаа юм. Дахиад хэлэхэд өргөн мэдлэгтэй, өндөр боловсролтой, сэтгэх чадвар сайтай, хамгийн гол нь халуун эх оронч ийм хүн Монголын тусгаар тогтнол, тогтвортой хөгжлийн үндэс суурийг бий болгоно.

Аливаа улс орон хөгжье гэвэл хангалттай эрчим хүчтэй болох хэрэгтэй. Хангалттай эрчим хүчгүй орон хэзээ ч хөгжихгүй, нэг ч юм хийж чадахгүй. Ажилгүйдэл туйлдаа хүрч, хамаг юмаа гадаадад алдана гэсэн үг. Манайх өнөөдөр эрчим хүчгүй учраас хамаг юмаа гадныханд алдаж байна. Жишээ нь та нэг томоохон жорлон барья цахилгаан өгөөч гээд очих юм бол эрчим хүч байхгүй ээ, уучлаарай гэх л болов уу. Бас нэг жишээ хэлье. Африкийн баялаг гэж гайхалтай, манайх юу ч биш. Алт, мөнгө, алмаз, зэс, нефть гээд бүгд байна. Тэнд яадаг вэ гэхээр танай эрдсийг гулдмай болгоод гарганаа гээд тив алгассан луйварчин компаниуд орж ирж байгаа юм. За, би 600 сая доллар зарцуулаа. Одоо зэсний үйлдвэр байгуулах хэрэгтэй байна. Надад 200 мегаваттын цахилгаан хэрэгтэй гэж байхгүйг мэдсээр байж асууна. Байхгүй юмыг чинь байхгүй л гэнэ. Өө ямар харамсалтай юм бэ? Би одоо энүүхэн энд Араб,

Энэтхэгт боловсруулья даа, энд ямар мөнгөө хаялтай нь биш гээд л хэдэн төгрөг өгөөд юутай хүүтэй нь шороогоор нь аваад явчихаж байгаа юм. Тэгээд хүмүүс нь энд тэнд цуглараад худлаа юм ярьцгаагаад л, хот нь хогоор дүүрчихсэн, хүмүүнлэгийн тусламжаар амьдардаг. Мозамбек, Кени, Танзан гурав бол хамгийн гоё байгальтай, нөгөө кино зураг авдаг, арслан бар нь байдаг нутаг шүү дээ. Тэдний ярианы сэдэв бол нам байгуулж тоглох, өнөөх харийн компани байгууллагууд чинь мөнгө өгөөд, тийм хөдөлгөөн, тийм нам гэж хооронд нь хагаралдуулаад, зодолдуулаад, бүр сүүлдээ зэр зэвсэгийг нь хангаж өгөөд цусан байлдаан хийлгэж байна. Мозамбект 42 нам байгаа, хоорондоо үзэж тарна шүү дээ. Тэр улсуудын хийдэг ажил нь тэр. Ингэж байх хооронд дарга цэрэгт нь хэдэн төгрөг өгөөд бүх юм дуусч

байгаа юм. Тийм учраас эрчим хүч гэдэг бол номер нэг асуудал. Харамсалтай нь манай сүүлийн таван сайд нэг ширхэг ч эрчим хүчний эх үүсвэр байгуулсангүй. Түүнийг дэмждэггүй юм шиг байгаа юм. Байгуулах гэсээр байтал нь нөгөө Оюу толгой, Таван толгой бүгдийг нь зөөж амжина. Дэлхийн бөмбөрцөг дээр маш сайхан өчүүхэн жижиг станцууд, шинэ техник технологиуд байна. Дөргөн, Тайширын цахилгаан станцуудаас хамаагүй их эрчим хүч гаргадаг, ямар ч хаягдал байхгүй цахилгаан станцууд байна. Ерөөсөө аккумулятор л гэсэн үг. Түүнийг газар доор булчихаар тэндээсээ эрчим хүч гаргадаг. Англи, Америкууд ийм юм хэрэглэдэг. Түүнийг яагаад Монголд оруулаад тавьчихаж болдоггүй юм. Монгол Улс эрдэс баялгаа шороогоор нь гадагшаа гаргана гэдэг бол маш буруу. Жишээлбэл Оюутолгойгоос зэс гаргана. Зэсээс хэд дахин үнэтэй байж магадгүй газрын ховор элемент тэр дотор байдаг. Оросын геологичид олон жил ирж судалсан, заримдаа жилд 400 хүн ирж судалж байлаа.

Тэд Монголын баялгийг дээд зэргээр мэддэг. Түүний толгойлогч, академич, Дэлхийн геологийн ассоциацийн дэд ерөнхийлөгч Ян Шин гуай Ю.Цэдэнбал даргад “Танай Өмнөговьд байгаа тэр газрын ховор элемент чинь Африкийн Нигер мэтийн орноос илүү их, ховор эд шүү, үүнийгээ хадгалаарай” гэж хэлж байсан. Одоо түүнийг ярьж байгаа ч хүн алга, юутай хүүтэй нь зөөхийг л бодож байна. Түүнийг эрдэмтэд очоод судалъя гэхээр зөвшөөрөхгүй байгаа. Эрчим хүчтэй болох хэрэгтэй, эрдэс баялагаа өөрсдөө боловсруулдаг болох хэрэгтэй. Би саяхан 7 хоногийн өмнө тэр Таван толгойн нүүрсний баяжуулах Ухаа худаг гэдэг газар очлоо. Би үнэхээр их баярласан. Монголын говьд боловсруулах үйлдвэрийг анх удаа байгуулсан. Хамгийн гол нь түүний эзэд нь монголчууд юм. Тэнд алдаа дутагдалтай зүйл байгаа хэдий ч би үнэхээр их баярлаж байна. Үүний эзэд нь монголчууд та нар, алив ахиухан ид, уу, та нар чадна аа. Тэр Австрали, Канад, Хятадынхан харин идэж ууж болохгүй, та нар хагарч, цадталаа ид. Та нарын мөнгө энэ нутагт, энэ ард түмэнд үлдэх учраас би анх удаа идэх, уух зүйлийг чинь дэмжиж байна гэхэд зарим нь хөхрөөд л, алга ташаад өнгөрнө лээ.

Монгол хүн ямар байх ёстой вэ гэдгийг 1000 жилийн өмнө Дорно дахины Нармай хамартны сургаалийг бичсэн нэг их хүн хэлсэн байдаг. Чи энэ дэлхий дээр ээж ааваасаа хүн боллоо гэж гарсан бол жинхэнэ хүн болох л хэрэгтэй. Хүн болохын тулд чи 3 тэнхээг эзэмших хэрэгтэй.

1. Сэтгэлийн тэнхээтэй болох хэрэгтэй. Сэтгэлийн тэнхээтэй бол чи ном сурч болно, бэрхшээлийг туулж болно, гутрахгүй явж болно.
2. Биеийн тэнхээтэй байх хэрэгтэй. Эрүүл чийрэг хүн бол бүгдийг хийж болно.
3. Мэдлэгийн тэнхээ.

Энэ гурвыг эзэмшсэн монгол хүн бол үнэхээр олон зуун жил тусгаар тогтнолоо хадгалаад, цэнгэлийн манлай руу тэмүүлсэн, баян чинээлэг, бүх дэлхий монголчуудыг гайхан, бишрэн, шүтдэг, магтдаг, уулзахыг зорьдог ийм болно. Өнөөдөр харамсалтай нь яг нэг юмны ирмэг дээр ирчихсэн юм шиг байна. Монгол улс дээшээ цэнгэлийн манлай руу тэмүүлэх эсвэл сөнөж, устаж үгүй болох гэсэн хоёр зам байна. Энэ юунаас хамаарах вэ гэвэл монгол төр эдийн засгаа, хүмүүсээ яаж удирдахаас хамаарна. Энэ өглөө эрт ирж мэдье, тэмүүлье, эх орноо хөгжүүлье гэдэг дээр сэтгэл нь зовж байгаа ийм хүмүүстэй, улсуудтай учирч ярихдаа, ийм ярианд оролцсондоо би их баяртай байна. Та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Монгол Улсын хөдөлмөрийн баатар, дархан аварга, УИХ-ын гишүүн Б.БАТ-ЭРДЭНЭ:

Монгол ёс жудаг

Энэ бие хэврэг

Ардчилал, зах зээлийн шинэ харилцаанд шилжсэн энэ 20 гаруй жилийн хугацаанд бид хүн төрөлхтний олсон ололт, бий болгосон үнэт зүйлийг даган хөгжинө гэсэн боловч түүнээс жаал гажсаны улмаас уламжилж ирсэн монгол ухаан, ёс заншил, уламжлалт сэтгэхүй сэтгэлгээ маань зарим талаараа алдагдаж байгаа нь ил ажиглагддаг. Тийм учраас дэлхий нийт, хүн төрөлхтний үнэт зүйл, Монголын уламжлалт ухаан хоёрыг нэгтгэхийн тулд үгээ хэлж, санал бодлоо хуваалцаж байх хэрэгтэй гэж би боддог.

Ардчилал гэхээр хязгааргүй эрх чөлөө, дур зоргоороо авирлах гэж ойлгох явдал газар авчээ. Зах зээл гэхээр бүхний хэмжүүрийг мөнгө гэж ойлгох болсон байна. Бас нэг айхтар туйлширч байгаа ойлголт бол амин хувиа хичээх үзэл, тийм сэтгэлгээ асар их газар авч байна.

Бидний уламжлалт монгол ухаанд мөнгөнөөс илүү үнэтэй зүйлс хүний амьдралд, энэ хорвоо ертөнцөд байдаг гэж ойлгож, аливаад ийм байр сууринаас хандаж ирсэн. Ардчилал гэдэг бол өөрийнхөө эрхийг эдлэхдээ бусдын эрхийг зөрчилгүй хүндэтгэж, хууль ёсыг дээд зэргээр сахин биелүүлж амьдрах амьдрал юм.

Монголчууд хорвоо ертөнцийн мөн чанар, учир холбогдлыг их эртнээс ухааж таньсан улсууд. Хорвоо гэдэг орон зай, цаг хугацааны орчил, байгаль эхийн шүтэлцээн дээр оршдог гэдгийг нарийн таньж мэдээд, түүндээ тохирон зохицсон амьдрал, ухааныг бий болгож хэдэн мянган жилийн турш амьдарч ирсэн. Зөвхөн өөр зуураа амьдраад зогсохгүй бусдад нөлөөгөө үзүүлж, дэлхийн талыг эзэлж байсан агуу үндэстэн Монголчууд энэ ертөнц дээр хүн ирээд буцдаг гэдгийг маш хатуу ойлгож амьдралын чиг баримжаа болгож явдаг. Миний амьдрал бол үлдэх ирээдүй хойчийнхоо сайн сайхны төлөө гэсэн ойлголтоор амьдарч, энэ амьдрах хугацаандаа бусдад гэрэл гэгээ өгөх сайн сайхан зүйлүүд бүтээж үлдээе, бие гэдэг хэврэг зүйл учраас энэ бие үрэгдэж нэр үлдэнэ гэсэн ерөнхий ухаарлыг амьдралынхаа философи болгодог ард түмэн. Аливаа хүн гэдэг дандаа бусдынхаа дэмэнд, олныхоо хүчинд амьдардаг болохоор хүн олныхоо төлөө гэсэн сэтгэлтэй, зүтгэлтэй байж л зөв амьдарна гэж үздэг сайхан уламжлалыг орхиж огт болохгүй.

Энэ биеийг хөгжүүлэх нь чухал

Хүн бол харагдаж байгаа махан бие, нүдэнд харагдахгүй гарт баригдахгүй, дотоод сэтгэл

оюун гэсэн хоёр биеэс цогцолж байдаг. Тийм ч учраас монголчууд энэ хоёр биеийн харилцан хамаарлыг ихэд шүтэлцүүлэн эрүүл биед саруул ухаан оршино гэсэн сургаалийг баримталж амьдардаг.

Энэ сургааль нь зүрх сэтгэлийн олон сайхан зан чанаруудыг агуулж байдаг алдхан биеийг ихээхэн тордон хөгжүүлэн хатуужуулж дасгалжуулах учиртай гэсэн утга санаатай юм. Монголчууд “Хүн болох багаасаа”, “Насны багад эрдэм сурах”, “Эрхийг сурахаар бэрхийг сур” гэх мэтчилэнгийн сургаалиар бодгаль бие, дотоод сэтгэлийн ертөнц энэ хоёр биеийг тэнцүүхэн хөгжүүлэх үзлийг баримталж ирсэн. Саруул ухаанаар өөрийгөө удирдан чиглүүлж чадах юм бол энэ олдсон биеэ яаж урт удаан амьдруулах уу, яаж илүү эрч хүчтэй байлгах уу зэргийг шийдэж болно. Хүн хичнээн сайхан сэтгэл гаргах ёстой, бусдын төлөө ажиллах ёстой гэдгийг мэддэг байлаа ч өөрөө биеэрээ сул дорой, тэсвэр хатуужилгүй бол бодсоноо биелүүлж чадахгүй. Хамгийн наад захын жишээ гэхэд автобусанд ахмад буурлууддаа сандал тавиад өгье гэхэд өөрийнх нь хөл чилж өвдөөд, зогсож чадахгүй бол хүнд тусалъяа гэсэн сэтгэл нь бүтэхгүй. Тийм учраас энэ биеийг хөгжүүлэх нь чухал. Манай орны хатуу хүйтэн, эрс тэс уур амьсгал, байгаль, ахуй амьдралын онцлог зүйлүүд нь бидний хатуужил тэвчээрийг үргэлж шалган сорьж байдаг. Энэ бүхнийг монголчууд хэдэн мянганы турш таньж мэдээд үр хойчоо хүмүүжүүлэн, өөрсдөө үлгэрлэж амьдарч ирсэн гайхамшигтай өв соёлтой ард түмэн юм. Эдүгээ энэ бүхэн нилээд алдагдах, мартагдах тал ажиглагдаж байна. Тийм учраас бид олон нийтийн байгууллагуудаар, нийгмийн гэгээрлийн чиглэлийн үйл ажиллагаагаар бүгдээрээ санал бодлоо солилцож, мартсан санасан зүйлээ сэргээж ярих юм бол энэ бүх ёс уламжлалын зүйлүүд маань биднээс холдож алга болчихоогүй байна. Эргээд сэргээхэд хүнд хэцүү, болшгүй зүйл алга. Буурал дээдсийнхээ сургаалийг сэргээнэ гэхээр нэг л их холоос хайх юм шиг боддог. Гэтэл энэ маань Эзэн Чингис хаанд ч өөрт нь хэдэн мянганы өмнөөс уламжлагдаад ирсэн, тэрнээс хойш бидэнд уламжлагдаад ирсэн, өнөөдөр энд байгаа бүх хүмүүсийн цусанд нь шингэчихсэн, сэтгэлийн гүнд нуугдаж байгаа, өөрийнх нь өдөр тутмын ажил амьдралд нь биелэгдэж байгаа тэр л зүйл. Эдгээрийг сайтар ойлгож өнөөдрөөс өөрсдөдөө, өрөөл бусдад таниулж хэлж үлгэрлэж явах юм бол Монгол улсын, бидний ирээдүй их өөдрөг, гэрэл гэгээтэй сайхан байгаа юм.

“Хүзүүнээс нь татаж, хүний зэрэгт хүргэх”

Монголчууд эзэн хичээвэл заяа хичээнэ гэдэг. Эх орныхоо эзэн болсон бид хичээхгүй бол хэн нэгэнд хандаад, хэн нэгэнд найдаад нэг их бүтэлтэй зүйл болохгүй. “Эзэн хичээвэл заяа хичээнэ”, “чи өөрөө өөрийнхөө эзэн нь шүү”, “хувь заяа чинь чиний өөрийн гарт байгаа шүү” гэж бидний өвөг дээдэс сургаж ирсэн. Харамсалтай нь хуучин тогтолцоо, шинэ өөрчлөлтийн энэ 20 жилд өөрийнхөө хувь заяаны эзэн байх биш, дандаа бусдад даатгасан найдсан байдлаар амьдарч ирлээ. Болохгүй зүйл байх юм бол бүгдийг бусад руу нялзааж байдаг. Өнөөдөр хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн оролцоо туйлын хангалтгүй байгаа тухай ярьж байна. Энэ үнэн. Өөрийнхөө төрүүлсэн хүүхдээр хүн хийх нь хүний байтугай амьтны үүрэг шүү дээ. Тэгтэл энэ үүргээсээ зугтаагаад гаргасан үрээ хурдхан шиг цэцэрлэг яслид аваачиж өгөх юмсан, дараа нь сургууль багш хамт олонд нь аваачиж өгөөд өөрөө л тэр ажлаас чөлөөлөгдөж байх, дараагийн ээлжинд цэрэгт явуулчих юмсан гэсэн бодолтой болчихож. Цэргээс хүрч ирээд буруу өссөн хүүхэд бухын хүзүүнээс хатуу гэдгээр бүүр болохгүй бол цагдаа ирж авдаггүй юм байх даа гэсэн ийм л сэтгэлгээтэй болчихсон байна. “Хүзүүнээс нь

тагаж хүний зэрэгт хүргэнэ”, “эгэмнээс нь чангааж эрийн зэрэгт хүргэнэ”, “борвийг нь сунгаж бохирыг нь цэвэрлэж хүн болгоно” гэдэг бол хүн ёсны үүрэг шүү дээ. Энэ үүргээсээ холдож байгаа нь сайн зүйл биш. Түүнчлэн болохгүй байгаа бүх зүйлийг удирдлага руугаа, улсын хэмжээнд бол төр засаг руугаа нялзаадаг, төр засаг нь гадныханд найддаг, даатгадаг, нийтээрээ өөрсдөдөө итгэх итгэл суларсан ийм гажуудал бий болсон. Эдгээр зүйлүүдийг цэгцэлж, зөв ойлголттой явбал буурал дээдэс маань сайхан газар нутаг, арвин их баялаг, сайхан түүх, ахуй соёл, монгол ухааныг бидэнд үлдээсэн байна шүү дээ.

Монгол бөхөөр хичээллэх чухал

Монгол уламжлалд эрэгтэй хүүхдийг Монгол бөхөөр дамжуулан эр хүн болгодог аргууд бий болгосон байдаг. Монголчууд хүү төрвөл миний хүү бөх хүн болно гэдэг. Бөх болохын цаад утга нь сайн хүн болно гэсэн үг. Яагаад сайн хүн болно гэж байна гэхээр бөхөд Монголчуудын эрхэм нандин зан суртахуун, оюун ухаан, бие бялдрыг зөв хөгжүүлэх ухааныг шингээсэн байдаг. Бусадтайгаа, олонтойгоо эвсэж зохицон амьдарч чаддаг, өөрийгөө шахаж дайчилж чаддаг, бэрхшээл тулгарсан үед зөв шийдвэрийг өөрөө гаргаж чаддаг, аливаа юманд зөв сэтгэлгээгээр хандах зэрэг чухал чанаруудыг Монгол бөх хүнд өгдөг. Иймээс эрэгтэй хүүхэд бүр Монгол бөхийн барилдаанаар барилдаж өсөх ёстой.

Их энгийн . . .

Монгол эр хүний ёс жудаг, ухаан гэдэг бол их энгийн. Хамгийн нэгдүгээрт: “За гэсэн бол ёогүй” байх чанар чухал. “Олны хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтнэ” гэдэг үг бий. Чи өөрийгөө сайн явуулах хамгийн шилдэг арга бол бусдыг бодох, бусдад туслах . Олныг, бусдыг бодож чадахгүй бол ажил амьдрал өөдлөхөд бэрх болно. Хүний амьдрал бол ерөөсөө өөрийгөө ялах, өөртөө маш хатуу шаардлага тавих, өрөөл бусдад зөөлөн сэтгэл гаргах, бусдыг бодож чадах ийм л юм. Үүнийг монголчууд хатуу баримталж ирсэн. Өөрийнхөө эхнэр, хүүхдээс гадна өөрийнхөө хажууд байгаа ах дүү нарынхаа төлөө юу хийх вэ, анд нөхдийнхөө төлөө яаж сэтгэл санаа тавих вэ, хамт олон байгууллагынхаа төлөө яаж сэтгэл тавих вэ гээд өөрийгөө зориулаад байхад гэр бүл, ажил үйлс улам сайн болоод л байдаг. Танай байгууллага, хүрээллийн хүмүүс олны төлөө гэсэн эрхэм чанарыг эзэмшээд түүнийг өөртөө шаардлага болгон тавиад бусдад сэтгэл гаргаад байвал ажил үйлс тань өөдрөг бүтэмжтэй, ахиц урагштай байдаг ийм л зүй тогтолтой. Иймээс өөрийн алд биеийг жинхэнэ сайн юманд сургах хэрэгтэй. Бидний өвөг дээдэс тоононы хүрээн дээр нар тусахад босоорой миний хүү, өглөөний галд унтдаггүй юм гэж хэлээд биднийг өглөө босгоод сургачихсан. Зун хөл нүцгэн явуулж сургасан. Тэр сайн сайхан зүйлүүд насан туршдаа эрүүл явах суурийг бидэнд суулгаж өгсөн байна.

Миний хувийн амьдрал гэвэл ...

Би зуны халуун наранд, зунгаг үнэртсэн ноосон дунд 7 наснаасаа эхлээд 15,16 нас хүртлээ ээжтэйгээ хамт хонь хяргасан. Манай ээж бол тууврын хонийг нилээн сайн хяргадаг хүмүүсийн нэг нь байсан. Аав бол мужаанаас эхлээд бүх юмыг хийнэ. Аавыгаа дагаад бүх зүйлийг хийдэг байсан. Эрэгтэй хүн бол гэр бүлд хамгийн их үүрэгтэй, ачааны хүндийг үүрч байх жамтай. Монгол ээж бол энэрэл хайраа бусдад зориулж байдаг. Эр, эм хоёрын арга билиг хоёр нэгдэж байж агуу хайрыг бий болгоно. Тэр хайран дунд хүн төлөвшдөг. Монгол

эхийн бүхнийг алагчлалгүй хайрладаг нандин хайр Монгол аавын алс ухаан дунд Монгол хүн өсч бойждог. Хүчирхэг монгол аав, ээжийн хүмүүжлээр жинхэнэ Монгол эр хүнийг бий болгохын төлөө үнэхээр зүтгэх хэрэгтэй юмаа.

Монгол хүнд “Нэр хугарахаар яс хугар” гэсэн сайхан сургааль бий

Нэр бол хамгийн чухал капитал юм. Миний тухайд гэхэд намайг худалч эсвэл хуурамч гэдэг юмуу миний тухай ямар нэгэн муу ойлголт миний ойрын хүрээллийн хүмүүсээс гарахгүй. Энэ бол миний хувьд асар их үнэ цэнэтэй зүйл.

Нэг идэх хоол хугас өдрийн хань, Нэг өмсөх хувцас хагас жилийн хань

Нэг олдох нэр энэ насны хань, Бие үхэж нэр үлддэгийг бүү март хэмээн сургасаар ирсэн нь учиртай.

Цаг тохироод 10,20 минут хоцроод ирвэл энэ нь жижигхэн юм шиг хэрнээ маш том дутагдлын эх болно.

Сүүлийн үед манай нийтлэлчид гадны улсын түлхээсээр “монголчууд бол хамгийн арчаагүй, энэ нь шашинтай нь холбоотой, нүүдлийн мал аж ахуйтай нь холбоотой, монголчууд хэзээний цаг барьдаггүй, цагийг нараар баримжаалдаг, монгол хүн бол заяаны хулгайч” гээд бичээд байхаар бид өөрсдийгөө нээрээ л тийм дээ гээд ойлгочихсон байна. Гэтэл бодит байдал дээр хэзээ ч тийм биш. “За гэсэн бол ёогүй”, “бороотой ч болзоондоо, хуртай ч хугацаандаа” гээд зуны 15-ны тэргэл сарнаар уулзана гээд тохирсон л бол яг тэндээ л очдог ийм уламжлалтай ард түмэн. Одоогийнх шиг шууд онгоцны билет бичүүлээд ирэх гэж байгаа ажил биш шүү дээ. Хичнээн сараар өдөржин шөнөжин сэлэмтэй, бамбайтай, морьтой нүдэлдсээр байгаад л хугацаандаа очдог. Саяхныг хүртэл айлын үүд цоож цуурга байхгүй, эсвэл гэрийнхээ түлхүүрийг бүслүүрэнд нь хавчуулчихаад л явдаг байсан. Өнгөрсөн түүхээ үзээд, түүгээрээ хүч аваад, ирээдүйгээ тодорхойлоод урагшаа явах гурван цагийн хэлхээс гэдэг их чухал юм.

Юманд хайр хямгатай хандаж сурах чухал

Сүүлийн үеийн зах зээлийнх нь өөрийнх нь араншин ч юм уу монголчууд бид аливаа юманд хайр хямгагүй ханддаг болж. Цаасан алчуур хэрэглэсэн ч аятайхан гамтай хэрэглэхийг бодохгүй дээгүүр харж байгаад л татаад татаад, сугалаад сугалаад хаячихдаг. Нэг цамцыг хэдхэн удаа өмсөөд л хаячихдаг. Хурдан эргэлт хийх зах зээлийнх нь мангас хэрэглээний араншин ч байж болох юм. Монголчууд бол тийм биш, аливаа юмыг хэмнэдэг, гамнадаг, хүргэдэг, барж биш мэрж хэрэглэдэг ийм үзэл сэтгэлгээтэй ард түмэн. Тэр нь бид нарт уламжлагдсан байгаа. Өөрийн амьдралын нэг жишээ хэлье. 1992 оны Барселоны олимпоор бид нарт тавьж өгсөн Адидасын бэлтгэлийн хувцас надад байдаг юм. Тэр хувцасыг би хорин жил өмсөж байна. Тэр хувцасаа зүгээр өдөр тутам өмсөж байгаа биш, барилдана, ноцолдоно, гүйнэ харайна, байн байн хөлсийг нь угаана тэгсээр байгаад одоо бүүр марль шиг сэмэрхий болчихсон. Энд тэндээ урагдсаныг нь сайхан оёчихдог. Ийм олон жил өмссөн гэхээр миний шавь нар гайхдаг юм. Хараад байхад сүүлийн үеийн хүүхдүүд дандаа шинэ юм авах хүсэлтэй, миний хажуу талын хүүхэд шинэ хувцастай байхад би ийм хуучин хувцастай байна гэж боддог юм байна. Хүүхдүүд төдийгүй манай УИХ-ын гишүүд, гадаадын парламентийн гишүүд ийм

өндөр цалин, хангамжтай байна гээд ярьдаг. Монгол улсын эдийн засгийн байдал ямар байна, үүндээ бид нар тохируулах хэрэгтэй. Би гишүүдэд та нар том том хаусанд амьдардаг бол түүнийгээ түрээслээд 2-3 өрөө нийтийн байранд амьдар, том том жийпнүүдээ граждаа тавиад жижиг машин уна гээд баахан ухуулга хийсэн чинь хэзээ ч бүтэхгүй юм яриад байх юм, боль гэж байна. Тэгэхээр нь би өөрөө жижиг машинтай давхиад, эсвэл таксигаар явдаг боллоо Түүнийг харсан хүмүүс, мөн УИХ дээр миний хэлсэн үгийг сонсоод, олон хүн “За, Бат-Эрдэнэ минь чи их зөв юм хэллээ, их зөв үлгэр дуурайл болж байна, чамайг би Улаанбаатар хотод жижиг вернатай явж байгааг чинь хараад бусдаас ичиж амьдрахаа болилоо” гэж хэлж байна. Бид нар ингэж нэрэлхэж, бусдад чирэгдэж үйлээ үзэж үсээ үгтээж амьдрах ямар ч шаардлагагүй. Би өмссөн костюмаа элэгдтэл нь хэрэглэхийг боддог. Одоо залуучууд магадгүй 100 долларын үнэтэй зангиа зүүж байгаа байх. Тэгээд юу өөрчлөгдөх юм бэ? Гаднах хувцас элэгдсэн, гялайсан байж болно. Хамгийн гол нь дотроос нь гарч байгаа сэтгэл зүрх цэвэр ариун, бадарч байх ёстой.

Тэмүүлэл зорилго алсын хараа

Тэмүүлэл, зорилго гэдэг бол их чухал. Монгол хүн алсыг зорьсон ч гэсэн за би сумын төв орно гэж гараад өртөө газар мордоод шогшиход сумын төв, сумын төвийн хойд талын Баян уулаа хараад урдах замаа, мориныхоо явдал суудал бүх юмыг зохицуулж явсаар тэндээ хүрдэг. Энэ нь нөгөө алсын хараа, зорилго тэмүүлэл бүх юмнуудаа боддог чанаруудтай холбоотой юм. Хүн зорилготой байх ёстой. Дотроо бадрангүй мөрөөдөл тэмүүлэлтэй, алсыг харсан, түүндээ хүрэхэд тулгарах жижиг бэрхшээлд шантрахгүй байнгын хичээл зүтгэлтэй байх ёстой.

Эцсийн дүндээ өөрийгөө зольж, өөртөө асар их шаардлага тавьж байж амжилтанд хүрнэ. Олныхоо төлөө гэсэн сэтгэлээр монгол уламжлалаараа сайхан явахад

бид хаана ч газардахгүй. Хаа хүрэх нь тодорхойгүй хоосон мөрөөдөл тавьчихаад зүтгээд дэмий үрэгдэнэ. Жижигхэн ч гэсэн зөв зорилготой бол их юмны үүд хаалга нээгддэг юм.



МҮЭХ-ны Ерөнхийлөгч С.ГАНБААТАР:

Эдийн засаг бол амьдралын ухаан

“Монгол тэмүүлэл”-ийн үйл ажиллагаанд би ирэх болгондоо чин сэтгэлээсээ баярлаж талархаж хүлээж авдаг бас оролцох болгондоо эмээж, дараа дараачийн зүйлд нь би одоо оролцож байгаагаасаа илүү хариуцлагатай яаж оролцох билээ гэж боддог. Монголд ийм л чин сэтгэлээсээ хийж байгаа энгийн зүйл маш их хэрэгтэй байгаа. Үүнийг цааш нь олон монгол хүнд дамжуулах юмсан. Энэ ажил бол хэдхэн хүний нуруун дээр байх биш олон хүний дэм тусаар их эрчтэй, удаан мөнх үргэлжилнэ гэж би ойлгож байгаа. Худгаас хүн болгон ус уухдаа баярладаг, харин тэр худгийг анх хэн ухсан бэ гэдгийг бид санаж байх хэрэгтэй.

Өнөөдөр миний ярих сэдэв их энгийн ойлгомжтой, эдийн засаг гэж юу вэ гэдэг талаар ойлголт өгнө. Эдийн засаг гэж юу вэ? Эдийн засаг бол физик, математик, хими биш эдийн засаг бол амьдралын ухаан. Олон хүмүүс физик, математик, хими шиг тайлбарлах гэж оролддог. Үгүй. Энэ бол амьдралын бэрхшээлүүдийг шийдэх ухаан. Ажилгүйдэл бий болоод, юмны үнэ өсөөд, ямар нэгэн эдийн засгийн хямрал эхлэхийн алдад эдийн засгийн тухай ярьж эхэлдэг. Бүр нарийн ярьвал эдийн засаг бол хүн судлалын ухаан байгаа юм. Тийм учраас би өнөөдөр нилээн амьдралын талаас нь ярья.

Өнөөдөр шинжлэх ухаанд эдийн засаг гэж юу вэ гэсэн асуултанд хариулахдаа хязгаарлагдмал нөөц бололцоогоор хязгааргүй эрэлт хэрэгцээг хангах ухаан гэж тайлбарладаг. Цаашилбал, эдийн засаг өрхийг баяжуулна, улс орныг баяжуулна гээд баахан юм ярьдаг. Яг хариултыг нь нарийн ажиглах юм бол эдийн засаг юу хийх вэ гэдгийг яриад байгаа болохоос биш эдийн засаг нь өөрөө юу вэ гэдгийг ерөөсөө хариулахгүй байгаа юм. Жишээ нь, машин гэж юу вэ гэж асуухад төмрөөр бүтсэн, оньсон төхөөрөмжтэй, бензин хийхээр явдаг гээд хариулж болно. Түүнээс биш машин гэж юу вэ гээд асуухаар машин бол ачаа зөөх ёстой гэхгүй. Яг үүнтэй адилхан өнөөдрийг хүртэл эдийн засаг гэдгийг хэн ч тайлбарлаагүй. Петер Дуракер гэж гурван жилийн өмнө 97 настайдаа өөд болсон Австри хүн байгаа. Намайг эдийн засаг гэж ойлгоход гол түлхэц өгсөн хүн. Тэр хүнээс эдийн засгийн 4-р курсын оюутан “Дуракер багшаа, эдийн засаг гэж юу вэ? Би 4-р курсэд орчихоод одоо болтол ойлгохгүй байна” гэж асуусан. Өөдөөс нь “Би 34 жил багшилж байна. Өнөөдөр хүртэл би үүнд чинь хариулж чадаагүй байна. Гэхдээ би чамд хэлэхийг оролдъя. Хамгийн зөв гэж би өнөөдрийг хүртэл хайж олсон тодорхойлолт бол эдийн засаг гэдэг бол эдийн засгийн номон дээр бичигдсэн зүйлүүдийг л хэлнэ” гэж хэлсэн. Өөрөөр хэлбэл нэг тодорхойлолтоор хэлэх аргагүй. Адам Смитийн 1854 он юм уу, Карл Марксын капитал гарч байх үед эдийн засагт хамгийн том монополь компани нь Фридрих Энгельсийн 300 хүнтэй ноолуурын угаах цех л байлаа шүү

дээ. Тийм үед эдийн засгийн онолууд бичигдсэн. Өнөөдөр доод тал нь 500, тэгээд 1000,2000,...,5000 хүнтэй компаниуд дэлхийгээр дүүрэн байна. Ийм нөхцөл байдалд тэр үеийн ярьсан зүйлүүдийг оруулахад хэцүү, гэхдээ хаяж болохгүй.

Эдийн засаг гэдгийг хүн сурахын аргагүй юм гэж үзэхгүйгээр хүн болгон өөрсдөө сонирхох ёстой зүйл. Хязгаарлагдмал нөөц бололцоогоор хязгааргүй эрэлт хэрэгцээг хангах урлаг бол эдийн засаг гэдэг нь Кремлээс бид хамаг мөнгөө авдаг байсан төвлөрсөн зах зээлийн үед бол хамгийн тохиромжтой тайлбар. Өнөөдөр УИХ төсөв баталдаг. Тэрийг яаж эхийг нь эцээхгүй, тугалыг нь тураахгүй тараах вэ гэдэг онол бол эдийн засаг болж таарч байна. Аманд ч үгүй, хамарт ч үгүй бүгдэд нь гомдолгүй тараах тэр онол хоцрогдож байгаа ч гэсэн бас хаяж болохгүй. Түүний цаад анхдагч санаа бол эдийн засаг гэдэг нь шударга хуваарилалт юм шүү.

Монголчууд Есопому гэдэг үгийг их зөв орчуулсан гэж боддог. Хэмнэх гэдэг үгийн яг үндсэн утга руу нь оруулаад эдээр нь засаглаж хуваарилалтыг шударга, тодорхой болгоно гэсэн үг. Энэ тайлбарын үүднээс нэг сонирхолтой юм хэлье. 2000 онд улсын төсөв 420 тэрбум төгрөг байхад цалингаа ч тавьж чадахгүй шахуу, ядуу хүмүүс 850,000 байна гэж бүртгэгдэж байсан. Дараа нь 600 тэрбум болсон, энэ маягаар өссөөр 2010 онд буюу 10 жилийн дараа улсын төсөв 2,7 триллион төгрөг болсон. Даруй долоо дахин нэмэгдсэн. Шууд 700% нэмэгдчихсэн байна. Ядуу хүмүүс 950,000 хүрсэн, сая хүн рүү ойртож байна гэсэн үг. Монгол оронд мөнгө маш их орж ирж байхад яагаад ядуу хэвээрээ байгаа юм бэ гэвэл эдийн засгийн хуваарилалт нь шударга биш байна, өөрөөр хэлбэл баян хүмүүс нь л улам баяжиж байна гэсэн үг. Төрөөс олон тэрбумтан төрж байнаа гэсэн санаа. Яг тэр нийт масс руугаа энэ мөнгөний хуваарилалт нь нялзахгүй байна. Сонгуулийн үеэр жаахан жаахан угаадас шиг 70,000, 10,000 төгрөг тараадаг гэсэн санаа. Үүнийг тэгвэл яаж шударга хуваарилах вэ? 70,000-аа 700,000 болго гэсэн үг юм уу, 1,5 сая төгрөгөө бодитой өг гэсэн санаа юм уу? Би яг тэгж хэлэх гэж хичээсэнгүй. Эдийн засаг яг онолын утгаараа манайд зөв хэрэгжихгүй байна гэдгийг л би хэлэх гэсэн юм.

Нийгэм бий болсон баялгаа буцаагаад шударгаар хуваарилдаг 3 механизм байдаг.

Нэгдүгээрт, татвар шударга байх ёстой. Хамгийн том архины үйлдвэр, подвольд ажиллаж байгаа 5-10 хүнтэй ундааны цех хоёр адилхан хэмжээний татвар төлнө гэдэг бол эдийн засгийн хувьд бүр ойлгохын аргагүй зүйл, байж болохгүй зүйл. Өмнө нь хоёр, гурван шатлалтай татварын систем байж байгаад одоо яагаад нэр төдий байгаа юм бэ? Татвар гэдэг бол эдийн засгийн буцаан хуваарилалт. Өөрөөр хэлбэл бидний хүүхдүүдийн цэцэрлэгийн багш нарын цалинг тавьдаг, халаалтыг нь өгдөг, өнөөдөр гудамжинд миний аюулгүй байдлыг хамгаалж байгаа цагдаагийн форм, бороохойны мөнгийг татвараас өгдөг. Татвар бол уг нь урамшуулал гэсэн үг. Нийгмийн буцаан хуваарилалтын нэг механизм.

Хоёрдугаарт, эдийн засгийн хуваарилалтын гол механизм бол нийгмийн даатгал. Өөрөөр хэлбэл өнөөдөр ажил хийж байгаа хүмүүсийн ирээдүй нь баталгаатай байхын тулд ирээдүйд нийгмийн баялгаас хөрөнгө оруулж байх ёстой. Тэр хэлбэр нь өөрийнх нь мөнгөнөөс авч болно, эсвэл ажил олгогч өгнө. Эсвэл улсаас ч гэсэн өгдөг. Өнөөдөр энэ зааланд байгаа хүмүүсийн ирээдүйн нийгмийн даатгал маш аюултай байдалд байгаа. Улс 2,1 триллион төгрөгийг Монголын ард түмэнд буцааж олгоно гэсэн өрийн бичгээ гаргасан. Яг дансанд нь өнөөдөр 180 тэрбум төгрөг л байгаа. Энэ янзаараа ямар нэгэн алхам хийхгүйгээр явах юм бол

2015 оноос хойш нэг хүн дунджаар 42,000 төгрөгний тэтгэвэр авна. Монгол Улсын Ерөнхийлөгч 97,000 төгрөг авах тооцоо байгаа. Энэ бол аюул. Гитлерийг германчууд таашаадаггүй, дургүй. Манайхан Чингистээ хайртай шиг жаахан хайртай байх гэж бодоод тандалт хийхээр үнэхээр дургүй. Яагаад та нар энэ хүнд дургүй байгаа юм бэ гэхээр дайн өдөөсөн муу хүн гэж хэлдэг. Хамгийн гол шалтгаан нь тэдний ирээдүйг баталгаажуулсан нийгмийн даатгалын мөнгөөр дайн хийсэнд л эгдүүцдэг. Амьд байгаа хөгшчүүд нь миний мөнгө хаана байна гэж одоо хүртэл заргалддаг. Засгийн газраас мөнгө гуйж байгаа юм уу нэхэж байгаа ч юм биш. Хөдөлмөр хүчээ дусааж олсон мөнгөний 20% нь хаана байна? Гадаа инфляци хөөрөгдөөд байхад бидний мөнгө яагаад өсөхгүй байна? Банкинд хийсэн хадгаламжтай яг адилхан. Нийгмийн даатгалын хуулиараа нийгмийн даатгал буюу та нарын ирээдүйгээ баталгаажуулж хадгалуулж байгаа мөнгийг чинь гурван зүйлд байршуулах ёстой. Арилжааны банкинд, гэхдээ энэ нь эрсдэлтэй байж болно. Монгол банкны үнэт цаас, засгийн газрын бонд гэсэн ийм гурван зүйл байдаг. Бидний дуурайх гээд байгаа барууны айхтар орнуудын сонгодог улс төр нь хоёрхон зүйлийг голчилж ярьдаг. Нийгмийн даатгалыг чинь яаж хөгжүүлэх вэ, яаж баталгаажуулах вэ, мөн яаж ажлын байр бий болгох вэ гэсэн хоёрхон зүйлийг л ярьдаг. Нэг нь тэтгэврийн нас руу ойртож байгаа юм уу, тэтгэвэрт гарчихсан хүмүүст чухал. Нөгөөх нь залууст чухал. Өнөөдөр Монголд дунджаар 20 жил ажилласан багш хүний нийгмийн даатгалын санд дунджаар 25 сая төгрөг байх ёстой. 25 сая төгрөг арилжааны банкинд байршуулахад доод тал нь жилийн 13%-ийн хүүтэй байна. Монгол банкны үнэт цаас, засгийн газрын бонд доод тал нь 10% байдаг. Хуулиараа доод тал нь жилийн 10% өснө гэвэл 25 сая төгрөгтэй хүний хувьд ертөнцийн мөнх бусыг үзэтлээ үндсэн мөнгөндөө оролгүйгээр жил бүр 2,500,000 төгрөг байнга авна гэсэн үг. Үүнийг бид засгийн газарт маш хүчтэй тавих нь эдийн засгийг эрүүлжүүлэх үндсэн нэг механизм. Засгийн газар бидний мөнгөний талаар зөв зохицуулалт хийж, шийдвэр гаргадаг л байгууллага. Хэзээ ч мөнгө ургуулдаг байгууллага биш. Одоо өөрсдөө ургуулдаг гээд итгэчихсэн, тэгээд бас хүмүүст яг ургуулдаг юм шиг, мөнгөний тариалантай хүмүүс шиг л юм ярьдаг. Үгүй, бидний мөнгийг яаж зохицуулах вэ гэдэг шийдвэр гаргадаг л улсууд. Энэ утгаараа Оюу толгой ч юм уу, Таван толгой ч юм уу уул уурхай нь түүхэндээ анх удаа Монголын ард түмний нийгмийн даатгалд буюу ирээдүйг баталгаажуулсан энэ тогтолцооны гажуудлыг засах нэгхэн боломж. Үүнийг алдах юм бол энэ мөнгө баахан тэрбумтан төрүүлнэ, үндсэндээ эргэлт буцалтгүй Африкийн замаар орно гэсэн үг. Өнөөдөр би дандаа үзэл санаа ярьж байгаа, дараагийн түвшинд яаж сайн болгох вэ гэдэг хувилбарыг л ярьж байгаа шүү. Би ерөөс шүүмжлэхгүйгээр дараагийн гарцыг ярилаа. Зарим хүмүүс монголчууд яагаад ийм хөгийн юм бэ, ямар өөдгүй вэ гэдгийг үндсэндээ 20 жил даапаалж сонин дээр бичлээ. Ямар уран цэцнээр биднийг дамшигладаг юм бэ? Хэрвээ өнөөдөр гарцыг нь, аргыг нь хэлэхгүйгээр чиний үйлс чинь пад харлачихжээ гэж хэлэх юм бол нүгэл гэсэн үг. Гарцыг нь хэлэхгүй л шүүмжлэх нь нүгэл юм. Би хоёр зүйл ярьсан. Татварын тогтолцоо аймшигтай байгааг засах ёстой, нийгмийн даатгал буюу өөрсдийгөө хамгаалдаг хамгаалалтын тогтолцоог нь хөгжүүлэх.

Гадаадын нөлөөллийн бодлого гэж байгаа. Манай улс орныг яг туйлдуулах бодлого байдаг. Энэ дээр би илэн далангүй хэлье. Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Олон улсын санхүүгийн байгууллагууд бол ерөөсөө өр барагдуулах алба гэсэн үг шүү дээ. Монгол оронд маш том зээлийг хөнгөлөлттэй нөхцлөөр өгөөд одоо 250 тэрбум төгрөгийг Монголын ард түмэн гадаадыганд өгөхөөр болчихсон. Орж ирсэн мөнгө хаашаа яаж явдаг вэ гэхээр маш

аюултай юм ярина. Сангийн яамны дэргэд байгаа өр барагдуулах алба гэдэг бол улс төрчдийн хамгийн гол анхаарлын төвд, тэнд хэнийг тавих вэ гэдгээ шийддэг ийм газар. Бидний өнөөдөр төрөөгүй байгаа маш олон хүүхдийн нуруун дээр карманаас нь зөвшөөрөлгүйгээр хулгай хийж зээл авна гэдэг бол ирээдүйн хүүхдүүддээ өр тавьж байна гэсэн үг. Тэдний карманаас бид хулгай хийж байна гэсэн үг. Газрын доороо ч , газрын дээрээ ч асар их баялагтай мөртлөө Африк яагаад гуйлгачин хэвээрээ байгаад байгаа юм бэ? Хүмүүс нь тийм усан тэнэг бас биш. Ямар ч байсан Кофи Анан тэр нутгаас төрсөн байх, маш олон ухаалаг хар хүмүүстэй би дотно найзалж байсан, одоо ч найзалдаг. Тэр орон зүгээр л гадаадын ерөнхий бодлогод өртсөн орон. Үндсэндээ 5 том GEP гэж бодлого байдаг. Тэрний Монголд хэрэгжиж байгаа магадлалтай нэгийг нь ярья. Маш их мөнгө эхлээд өгдөг. Африкийн аль ч орон байсан эхлээд 20 намд задарч хуваагдаад, тэр донор тусламжийн төлөө 20 нам хоорондоо алалдаж эхэлдэг. Маш их тэмцэлдээн болдог. Ингээд үндсэндээ хоорондоо маш их өрсөлдөөний зах зээлийг бий болгоод хоорондоо улс төр ч гэдэг юм уу, олигарх тэр бизнес гэдэг юмны төлөө маш их өрсөлдүүлээд, ухаан жолоогүй өрсөлдөж байх хооронд нь ар хударгаар нь хамаг баялгийг нь авч явдаг. Тэрийг тоодог хүн байхгүй. Бүүр зарим тохиолдолд дайн үүсгэнэ, зэвсэг өгнө. Ингээд авлаа, нөгөөдөхөө зах зээл дээр гаргаж зарлаа, түүний 7%-ийг буцаагаад донор хэлбэрээр өгдөг. Энэ цикл хэзээд ингэж зогсохгүйгээр явдаг. Авч байгаа юмаа ярихгүй, өгч байгаа 5 доллараа 500 доллар юм шиг гайхамшигтайгаар ярьдаг. Бид энэ ангал руу, энэ хавх руу орж болохгүй. Дэлхийн банкны бодлогын эсрэг ажилласан дөрөвхөн орон энэ дэлхий дээр хөгжсөн. Япон, Солонгос, Тайвань, Сингапур гэсэн дөрвөн орон байдаг. Эдгээр орнуудад бизнест нь төрийн оролцоо байсан. Яагаад төрийн зохицуулалт хүчтэй ордог юм бэ гэвэл төрд хамаг бизнесийг дэмжих мөнгө нь байдаг. IBN гээд дэлхийн том компани байна. IBN дэлхий даяар компьютерээ шахдаг бизнесээ хийхээс өмнө бүтэн дөрвөн жил Пентагон бүх компьютерийг нь худалдан авч хөл дээр нь босгосон. Холливудын анхны кинонуудыг Америкийн засгийн газар худалдан авдаг байсны хүчинд өнөөдөр дэлхийн бүх киноны 70%-ийг Холливуд хийж байгаа. Өнөөдөр манайд үүнийг хүлээн зөвшөөрөөд бодитойгоор эдийн засгийн бодлого руу оруулбал их амар болно. Яагаад гэвэл нийт монголын эдийн засаг 7 триллион төгрөгний эдийн засаг байдаг. Түүний 2,7 триллион төгрөг буюу бараг 40% орчим нь үндсэндээ төсвийн зардал. 1,3 триллион төгрөг буюу 1300 тэрбум төгрөг бол захиргааны зардал буюу төрөөс бизнесүүдийг дэмждэг янз бүрийн тендерийн зардал. Энэ 2,7 триллион төгрөгний дөнгөж 14% нь л цалин хөлсөнд явж байгаа. Монголын эдийн засаг 7 триллион гэж байгаа боловч 3 триллион далд эдийн засаг гээд нийтдээ 10 триллион эдийн засагтай гэж тооцож болно. Далд эдийн засаг манайд ихтэй, нууц мөнгө ихтэй, Нарантуул дээр хамаг мөнгө явж байгаа нь үнэн. Энэ 10 триллионы үндсэндээ 21-хэн хувь буюу 2,1 триллион төгрөг л нийт монголчуудын цалин хөлсөнд явдаг.

Гуравдугаарт, эдийн засгийн хуваарилалтын нэг механизм нь цалин. Монголчуудын цалин 21%, социализмын хувьд 18% байсан. Одоогоор үнэхээр дэвшилттэй байгаа. Гэхдээ социализмын үед 18%-иар цалин өгдөг байсан боловч үнэн утгаараа бид эмнэлгээс ямар ч үнэ төлбөргүй үйлчилгээ авдаг, хүмүүсийг амруулдаг, нийгмийн халамжийг хүртдэг байсан. Тэгэхээр Америкт яагаад хүмүүсийн цалин бидний дундаж цалингаас 16,7 дахин өндөр байгаа юм бэ? 1,3 тэрбум хүн амтай Хятадуудын дундаж цалин өнөөдөр бидний дундаж цалингаас 2 дахин илүү байна. Орос биднээс 4 дахин илүү цалинтай. Монгол багш өнөөдөр хэлтэй амтай 200 доллар авах гээд бөөн юм болж байхад Буриадад өнөөдөр 800 долларын цалин аваад голж байгаа. Тэнд цэвэрлэгч 500 доллар авч байгаа. Шалтгаан нь орлогын

хуваарилалт шог байна гэсэн үг. Энэ байдлыг яаж засах вэ? Өнөөдөр хүмүүс үнэхээр нэг нэгээрээ, амь амиа бодож няц гишгүүлж байна. Хүмүүс өдөр тутмынхаа таксины орлогыг алдахгүйн төлөө уралдааны морь шиг яваад л байна. Нэг хоёр өдрийн таксины орлогоо золиослоод нийт хүмүүсийн эрх ашгийн төлөө дуугарах тэнхээ тун бага байна. Өөрийгөө золиослоод ч болов шударга, сайн зүйлийн төлөө явъя л даа. Хүмүүсээс цалинг л харамлахгүй байгаарай гэдгийг маш их хэлмээр байна. Барилга дээр ажиллаж байгаа барилгачин хүнд хамгийн эхэнд цалинг нь хамгийн ихээр өгөөрэй, юм үлдвэл хамгийн сүүлд өөрөө аваарай гэж капиталистууд ярьдаг юм байна. Ямар сонин юм, бараг социалист маягийн юм яриад байна гэж бодоод сонирхсон. Яагаад гэвэл барилга хурдан чанартай баригдаад дуусаа л бол барилгачид дараагийн барилга руу явдаг, барилга надад үлддэг. Энэ нь жинхэнэ капиталист хүний сонирхол. Цалинг сайн өсгөмөөр байна. Яагаад цалинг

Монголд дор хаяж 3 дахин өсгөх боломж байгаа гэж би ярьдаг, итгэдэг, тэмцдэг вэ гэвэл бид тэр 21%-ийг дор хаяж 70-80% болгох боломжтой л гэсэн санаа. Үндсэндээ 100 сая төгрөгний цэвэр ашигтай ажиллаж байгаа барилгын компани ажилчиддаа 20 сая төгрөг өгөх биш 80 саяыг өгөөд ажил олгогч өөрөө 20 саяыг авна гэдэг бол эдийн засаг эрүүлжинэ гэсэн үг. Хүмүүс мөнгөтэй болоод ирэхийн алдад талх худалдаж авна, харин мөнгөгүй болбол боорцогоо хийж эхэлнэ, ингэвэл талхны үйлдвэрүүд дампуурна гэсэн үг. Цахилгаан тогоо худалдаж авч чадахаа болихоор лаагаа асааж эхэлнэ, лаагаа асаагаад эхлэхээр цахилгаан станцууд үүдээ хаана. Үндсэндээ эдийн засгийн амин цус сэлбэгч нь бол хүмүүсийн мөнгөтэй байх явдал юм. Хүмүүсийг мөнгөтэй байлгахын тулд зүгээр бэлэн мөнгө өгөхгүй, орлоготой байлгах хэрэгтэй. Өнөөдөр хилээр цагаан будаа 1 кг нь 390 төгрөгөөр орж ирж байгаа. Бидний гар дээр 1600-2000 төгрөгөөр ирдэг. Монгол орон ченжүүдийн гарт хага базагдчихсан. Энэ монополийг задална гэдэг бол нэгдүгээр зорилго. Манай төрийг барууныхан “Барьцаалагдсан төр” гэж ярьдаг. Энэ барьцаалагдсан төр өөрөө өөрийгөө барьцаанаас гаргана гэж та нар бодож байгаа бол эндүүрэл. Бид хөдөлж байж, дуугаа нэгтгэж байж, бас нэг олон долоон юм ярьдаг хүмүүс олширч байж энэ төр барьцаанаас гарна. Эдийн засгийн цаад шинж чанар, мөн чанар бол ийм олон зүйл рүү ордог. Эдийн засаг гэдэг бол нийгмийн ухаан. Нийгэм гэдэг бол улс төрийн ухаан. Улс төр нь явж явж эдийн засгийн тухай л ярьдаг. Төрийн албан хаагчдын цалинг нэмсэнээс болж инфляци хөөрөгдчихлөө гэж яриад байна. Өнгөрсөн 3 жилд цалин хөлсөнд нэг ч гар хүрээгүй. Хямралтай гээд үнэхээр тэмцэл хийгээгүй. Өнгөрсөн 3 жил цалинд ерөөсөө гар хүрээгүй байхад яагаад инфляци жил болгон 14-18% өсөөд байсан юм бэ? Цалин хөлс нэмсэнээрээ инфляци нэмэгдэнэ гэсэн ойлголт газар авсан байна. Албан бус эдийн засагт цалинг яаж нэмэгдүүлэх вэ гэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг дээр хүчтэй механизм байдаг. Эдийн засаг гэдэг хүчний төвлөрөл, Монгол орон өнөөдөр бүх талаараа хүчтэй байна гэдэг нь бүх талаараа сулын шинж. Японы эдийн засаг электроникийн бараа бүтээгдэхүүн дээр төвлөрсөнөөрөө л гарч ирсэн. Финлянд ганцхан Nokia гэдэг гар утасны үйлдвэрлэл дээр төвлөрсөнөөрөө дэлхийн гар утасны 42%-ийг үйлдвэрлэж байна. Барууны томоохон гар утас үйлдвэрлэгч нар Финляндыг цохиж чадахгүй байгаа. Швейцарь дэлхий дээр цагаар дагнаж гарч ирсэн байна. Хүчний төвлөрөл гэдэг бол стратеги. Манай Чингисийн том стратеги байна шүү дээ, “Өөрийнхөө давуу тал дээр тулгуурлаж дайсныхаа сул тал руу довтлохыг ялалт гэнэ”.

21-р зууны эхээр Монголын эрэлхэг хөх цэргүүд тэнгэрээс бууж ирнэ гэж Нострадамус хэлсэн. Хүн болгон бараг мэддэг мөртлөө яагаад монголчууд ярьдаг юм бүү мэд. Хэрвээ

хятадууд бууж ирнэ гэж ярьсан бол өнөөдөр бүүр хоногштол ярьж байгаа, одоо болноо, ойлголоо гэтэл ярих байсан. Энэ үгийг яагаад би хэлж байна гэхээр ухаантай хүн гэдэг бол өөрийгөө ухаантай хүн гэж итгэсэн хүнийг хэлнэ гэж байгаа. Монголчууд ухаалаг, монголчууд үнэхээр өснө. Энэ 21-р зуунд үүлэн чөлөөний нар шиг монголчуудад дээшээ гарах нэг боломж гарч ирж байгаа. Энэ боломжийг гэрт орж ирчихээд байхад олж харахгүй байна гэдэг бол нүгэл болно шүү. Хэдүүлээ нэг зүтгээд үзье л дээ, алдах юм юу байгаа юм? Ингээд эртэч монголчууд та бүхэндээ сайн сайхныг хүсье. Баярлалаа.



УИХ-ын гишүүн Д.ЭНХБАТ:

Өнөөдөр цаасан үеэс электрон үе рүү шилжиж байна

Өнөөдөр би мэдээллийн буюу удирдлагын тухай ярих болно. Өөрөөр хэлбэл мэргэжлийнхээ талаар түлхүү ярих гэсэн юм. Монголчууд бид ямар цаг үед амьдарч байна вэ гэдгээсээ эхлэх хэрэгтэй. Би та бүхэнд халаасандаа байгаа нэг хавтас үзүүлье. Зарим нь зурагтаар харсан байх аа, энэ бол Амазон Киндл гэдэг сүүлийн үеийн төхөөрөмж. Яг цаас шиг харагддаг дэлгэцтэй, нарны гэрэлд хүртэл уншиж болдог ийм цахим ном. Би яагаад энийг ярьж байна вэ гэвэл зөвхөн энэ цахим ном 500–1000 ширхэг ердийн номыг хадгалах чадалтай. Жишээ нь би энэ хавтсан дотор 70-80 ном хадгалчихсан байгаа, түүнийгээ байнга уншдаг. Үүний ард талд Амазон гэдэг дэлхийн том компани байгаа. Амазон компанийн номын дэлгүүрт англи хэл дээр ойролцоогоор нэг сая нэрийн ном байна. 1920-иод оноос хойш гарсан бүх чухал номууд ч байгаа. Тэр номын дэлгүүрээс та ном авахын тулд энэ хавтас дээрх нэг кнопыг дарахад л ердөө нэг секундын дараа ном тань энэ хавтас руу ороод ирнэ. Энэ номын дэлгүүрт олон классик ном үнэгүй байдаг. Бидний мэддэг “Монтэ Кристо Гүн”, “Жульвэрн” гээд сонгодог зохиолууд бүгд үнэгүй байгаа. Орчин үеийн номнууд нь дунджаар нэг ном 10 долларын үнэтэй. Би сардаа ойролцоогоор хоёр ном авч үздэг. Энэ дэлгүүрт мөн дэлхийн 300 гаруй том сонин, 200 гаруй том сэтгүүл бас байдаг. Та сэтгүүл сонин захиалбал өглөө 06:00 цагт сэрэхэд тань энэ дээр таны унших гол сонингууд орчихсон байж байдаг. Жишээ нь би “Интернэшнл Хералд Тэрбиюнь”, “Нью-Йорк таймс”, “Вашингтон Пост”, “Таймс” сэтгүүлүүдийг уншдаг. Өглөө цайгаа уухдаа л харахад өглөөний бүх сонингууд орчихсон байдаг. Үүгээр би юу гэж хэлэх гэсэн бэ гэхээр бид бол цаасан үеийн хүмүүс, одоо залуучууд бол электрон үе рүү шилжиж байна. Ийм л цаг үед бид ирж байна. Ийм зүйлийг ялангуяа залуучууд их авч үзээрэй.

Одоо би мэдээлэлтэй холбоотой ганц хоёрхон зүйлийг хэлье. Өгөгдөл, мэдээлэл, мэдлэг гурвыг хүмүүс ялгадаггүй. Жишээ нь, 27 гэдэг тоо байж. Энэ бол өгөгдөл. Хэрвээ агаарын температур 27 хэм гэж хэлбэл тэр бол мэдээлэл. Агаарын температур 27 хэм болохоор улаан буудай хатдаг, тэр үед услах хэрэгтэй гэдэг ч юмуу, өөрөөр хэлбэл ямар нэгэн мэдээллийг дагаад түүнийг ямар нэгэн ашигтай үйлдэл ажил хийж болохоор бол тэр бол мэдлэг болдог. Манай Монголын сургуулиуд бол ихэнхи нь хүнд мэдлэг биш мэдээлэл олгодог. Мэдлэгт тулгуурласан сургалтын систем бол өөр байдаг. Тухайлбал, Шинэ Зеландад очсон чинь жижигхэн ойн зурвасхан газарт тооны дэвтэр шиг тор татчихаж.

Хоорондоо нэг метрийн зайтай цагаан утас татаад утас болгон дээр номер хадчихаж. Энэ ямар учиртай юм бэ гэж асуусан чинь манай хүүхдүүдийн ажиглалтын талбай гэж хэлсэн.

Нэгдүгээр ангийн хүүхдүүд хавар, зундаа тэнд очоод өөр өөрийн талбай дээр байгаа шоргоолжийг тоолдог юм байна. Манай шоргоолж тэд байна, одоо тийшээ гүйгээд байна, тэнд ийм өвс ургачихаж гээд л... Ийм орчинд хүүхдүүд байгаль экологийн талаар нарийн мэдэж авдаг. Энэ бол тэр хүнд мэдлэг олгож байгаа юм. Яагаад гэвэл өөрөө түүнийгээ дагаж ашиглаж, юм хийж чадаж байгаа учраас энэ бол мэдлэг юм.

Төгсгөлд нь улс төрийн чанартай, мэдээллийн чанартай ганц нэг юм хэлье. Өнөөдөр Монголчуудын сонин телевизээр “Оюу Толгой”, “Таван Толгой” –г олборлоод Монголчууд хачин баян болно гээд яриад байгааг шинжлэх ухааны үндэстэй авч үзвэл тэр худлаа гэдгийг амархан баталж болно. Нэг шог зүйрлэл хэлье л дээ. Өвөг эцэг нэг гэрээслэл үлдээж. Тэр гэрээслэл дээр “Чиний өвөө агуу баян хүн байсан. Гэхдээ өвөөгийнх нь алт өөр газар бий. Ангараг гариг дээр миний Богд уулын чинээ алт том байж байгаа. Ангараг гариг дээрх түүнийгээ чамд өвлүүллээ” гэжээ. Би тэр гэрээслэлийг авлаа гэж бодоход би баян хүн мөн үү, биш үү? Би бол өөрөө сэтгэлээрээ баян, яг амьдрал дээр баян биш. Яагаад гэвэл Ангараг гариг дээрх алтыг аль ч банк барьцаанд авахгүй, Ангараг гариг дээрх алтаар би ямар ч наймаа хийж болохгүй. Яг түүнтэй адилхан ашиглаж болохгүй баялаг бол баялаг биш болно. Ангараг гариг дээрх алт байх, Алтай нурууны ёроолд 3 км-ын гүнд байх яг адилхан. Аль нь ч баялаг биш. Ийм их баялаг байнаа гээд бичээд байгаа бол худлаа, түүн дотроос авч болох нь маш цөөхөн. Таван Толгой, Оюу Толгой эхэллээ, ингээд хэдхэн баялаг байгаа.

Тиймд ухаж авч чадахгүй бол тэр огт баялаг биш. Ухаж авч чаддаг болсон үед л энэ бол баялаг болно.

Бас нэг жишээ хэлье. Нэг кг түүхий төмөр ойролцоогоор 7 центийн үнэтэй гэе. Тэгвэл төмрөөр авто машин хийчихлээ гэвэл нэг кг машины эд анги болсон төмрийн үнэ ойролцоогоор 7 доллар болно. Хэрвээ 1 кг төмрөөр компьютерийн микропроцессор, электроникийн багажууд хийвэл 1 кг нь 7000 доллар болно. Тэгэхээр нэг кг байгалийн баялаг ямар үнэтэй болж хувирч байна вэ? Өнөөдөр Монгол нэг кг төмөр, зэсийг 7 центээр зарж байгаа, түүнийг худалдан авсан орнууд буцаагаад бидэнд машин болгоод нэг кг –ыг нь 7 доллараар, 700 доллараар, электрон барааг нэг кг-ыг 7000 доллараар зарж байгаа. Өөрөөр хэлбэл биднээс авсан зүйлээ бидэнд буцаагаад 100.000 дахин үнээр өгч байгаа. Нэг кг 7 центийн төмөр 7000 долларын электрон төхөөрөмж хоёрын хооронд 6999.93 долларын ялгаа байна даа. Энэ ялгаа бол материалд шингэсэн мэдлэг гэсэн үг. Хэрвээ бид баялгаа 1:100.000 харьцаатайгаар зарах юм бол Монгол улсын баялаг их баялаг ерөөсөө биш. 1:100.000 өгч авч байхад байгалийн ямар ч их уурхай дороо л дуусна. Тэгэхээр байгалийн баялаг бол улс орныг хэзээ ч баян болгодоггүй. Бид хэрвээ байгалийн баялгаар машин хийж чадвал арай баян болно, онгоц хийвэл бүр баян болно, электроник хийвэл бүр илүү баян болно. Бидний хөрш улсууд ОХУ, Хятад, Япон, АНУ нэгж металл бүтээгдэхүүнд оногдох мэдлэгийн үе нь 1:100.000 хүрсэн үе. Япон бол 1:100.000 хүрчихээд байна. Ийм улсуудтай байгалийн баялгаар наймаа хийгээд баяжна гэдэг худлаа. Дүгнэж хэлэхэд байгалийн баялаг бол хүн төрөлхтний түүхэнд хэзээ ч хөгжлийн түлхүүр болж байгаагүй. Харин ганцхан тохиолдолд болж байгаа нь нефть. Нефть бол байгалийн өвөрмөц баялаг буюу эрчим хүчний эх үүсвэр. Эрчим хүч, ус хоёр бол байгалийн өвөрмөц баялаг. Тийм учраас XXI-р зуунд ямар улсууд дэлхий дээр хамгийн найдвартай байх вэ гэхээр эрчим хүчээ хянаж байгаа, усаа хянаж байгаа орон л хамгийн хүчтэй байж чадна. Өөрөөр хэлбэл XXI-р зууны үеийн улс орны үндэсний аюулгүй

байдлын хамгийн гол тулгуур хоёр зүйл бол эрчим хүч, ус хоёр юм.

Тэгэхээр байгалийн баялаг бол түр зуурын амь аргацаасан зүйл юм. Байгалийн баялаг эрдэмтэй хүний гарт бол алт болно. Эрдэмгүй хүний гарт бол архины мөнгө л болдог. Залуучууд сайн мэдэх байх Жульверний “Капитан Грантын хүүхдүүд” гээд ном байдаг. Тэр номонд нэг ийм үг байгаа, “Австрали тив рүү усан онгоцоор явж байгаа хүү, Австрали чинь маш их алттай сайхан орон шүү дээ гэж хэлдэг. Гэтэл тэнд байгаа эрдэмтэн, үгүй ээ, алттай орон ядуурч, төмөртэй орон баяждаг юм” гэж хэлдэг. Алттай орон яагаад ч баяждаггүй, үргэлж ядуурдаг. Яагаад гэвэл алтыг дагаж үйлдвэрлэл үүсдэггүй, мэдлэг үүсдэггүй. Харин төмрийг дагаж хөдөлмөр хөгждөг. Жишээ нь, халбага сэрээ, янз бүрийн юм хийнэ. Үүнийг дагаж мэдлэг үүсдэг. Тэгэхээр орчин үед хамгийн их үнэтэй зарагддаг бараа бол мэдлэг.

Африкийн Нигер гэдэг улс байдаг. Африкийн Нигер улс бол цагтаа Африкийн номер нэг, дэлхийд 10-т ордог нефтьтэй орон байсан. Африкдаа хамгийн их нефть олборлодог. Ийм их нефтьтэй орон чинь хагартлаа баяжнаа даа. Гэтэл Нигер одоо мөнхийн дайнтай, авилгалд идэгдсэн аймшигтай орон байгаа. Тэд их мөнгөтэй боловч түүнээсээ их өртэй. Яасан гэхээр яг одоо бидний хийж байгаа зүйлийг 30 жилийн өмнө хийсэн. Нигер улс 1970-аад оны үед нефть олсон. Асар их нефть олборлоод цөмөөрөө баян болсон. Дэлхийн Олон Улсын Байгууллагууд очоод Нигерт танайх бол хязгааргүй мөнгөтэй юм байна зээл авья гэвэл хэдийг бол хэдийг өгнө гэсэн, үнэхээр ч тийм байсан. Нигерийн удирдагч нар асар том төслүүд хийсэн. 10 тэрбум доллараар өндөр хурдны зам, усан далан, цахилгаан станц гээд л агуу их мөнгө олж байгаа юм чинь юунаас нь айдаг юм гээд бариад л байсан. Америк, Англичууд их ухаантай болохоор Нигерт зээлийг нь өгөөд барилгыг нь эхлүүлээд олон тэрбум долларын зээл өгөөд бүх юм эхэлсний дараа иргэний дайн гарсан. Хэдэн партизан явуулаад нөгөө нефтийн цооногуудыг нь шатаасан. Тэгээд 10 жил дайн болсон. 10 жилийн дараа байшин ч баригдаагүй, нефть ч шатсан, өөрсдөө ч өрөндөө орсон. Тэгэнгүүт 10 жилийн дараа Англи, АНУ-ын корпорациуд за за, Нигерт туслая, харин зээлийн хүүгийхээ оронд нефть авья гэсэн. Тэгээд хүүгийхээ оронд нефть авахаар зөвшөөрсөн байдаг. Одоо дайн дууссан ч гэсэн ихэнх нефтиэ өгөөд ч зээлээс гарч дийлэхгүй байгаа. “Таван Толгой” бол яг тэгнэ, 10 тэрбумын зээл өгнө. Дараа нь Өвөрмонголын Шинжаньд газар хөдөлдөг ч юмуу, үймээн гардаг ч юм уу тэгээд л Монголоос нүүрс авахаа байчих боломжтой. Яагаад гэвэл Хятадын өөрийн нүүрсний нөөц Монголоос олон дахин их. Орост дэлхийн нүүрсний 50% нь байдаг. Тэд Монголоос нүүрс авахгүй байж чадна. Монголд хэдэн тэрбумын зээл өгөөд Хятадын төмөр зам хаагдлаа гэхэд 5 жил болсны дараа бид өрөндөө нэг шатна даа. Тэр үед Хятадууд ямар санал тавих вэ гэхээр зээлийн хүүгийнхээ оронд л нүүрс авья гэнэ. Хүүгээ арайхийж төлсөн ч бид өртэй үлдэнэ. Иймээс байгалийн баялагт хамаагүй дулдуйдаж болохгүй. Хамгийн гол нь чадвар, мэдлэг хэрэгтэй.

“Сайн аав, ээжийн хүүхэд чадваргүй, мэдлэггүй бол аав ээжийнхээ дараа хамаг юмыг нь зарж л иддэг” гэдгийг бид мэднэ.

Монголчууд өнөөдөр төрийн бодлогоо хаашаа явж буйг сайтар ойлгох хэрэгтэй. Та бүгдэд нэг жишээ хэлье. Энэ бол бас нэг гашуун түүх.

Чингис хааны Их Монгол улсыг 300 жил атгандаа барьж байсан Манжууд өнөөдөр хаачсан юм бэ? Хятадыг цэргийн хүчээр барьж байсан, Монголыг цэргийн хүчээр барьж байсан,

баруун хил нь Казакстанд хүрч байсан Их Чин улс хаачсан бэ? Туркменстаныг эзэлж байсан, Төв Азийг эзэлж байсан тэр том улс одоо байхгүй байна, хаачив аа?

Манжийн үед Хятадад нэг айхтар гурван хууль л гарсан гэдэг. Энэ хуулиудыг Манжуудыг халамжлан устгах хуулиуд гэж ойлгож болно.

1) МАНЖ ХҮН БОЛ ТЭНГЭРИЙН УДАМТАЙ. ТИЙМ УЧРААС ЗААВАЛ НОЁН БАЙХ ЁСТОЙ. ТЭГЭЭД ЦӨМӨӨРӨӨ НОЁН БОЛСОН, ГЭХДЭЭ НЭГ ТОСГОНД 3 НОЁН БАЙЖ БОЛОХГҮЙ УЧРААС МАНЖ ХҮН БОЛГОН ХЯТАДЫН ОЛОН ХОТ, ТОСГОН БҮГД НОЁНГООР ЯВСАН. ЦӨМӨӨРӨӨ НОЁН БОЛЖ ХЯТАДААР НЭГ ТАРСАН.

2) МАНЖ ХҮН БОЛ АРИУН ТЭНГЭРИЙН ГАРАЛТАЙ ХҮН УЧРААС ХАР АЖИЛ ХИЙЖ БОЛОХГҮЙ, БАГААС НЬ ЦАЛИН ӨГНӨ ГЭСЭН. ХЯТАДЫН БОДЛОГООР МАНЖИЙН ЭРЭГТЭЙ ХҮҮХЭД БҮРТ ТӨРӨХӨӨС НЬ АВАХУУЛААД ЦАЛИН ӨГСӨН. БҮГД ЦАЛИНТАЙ Ч АЖИЛГҮЙЧҮҮД БОЛЖ ХУВИРСАН.

3) МАНЖ ХҮН ТЭНГЭРИЙН ГАРАЛТАЙ ХҮН УЧРААС ХЯТАД ЭХНЭР ҮНЭГҮЙ АВЧ БОЛНО.

Тэд хамгийн сайхан хятад хүүхнүүдийг авгай болгож авсан. Ингээд 100 жилийн дараа эргээд харсан чинь Манж байхгүй болсон байсан. Үүнийг хийсэн Хятадын түшмэлийг тэр цагт Хятадын ард түмэн үзэн ядаж байсан гэдэг. Хятадын ард түмнийг зовоож байна, манжуудыг

ёстой тэнгэрт гаргаж байна, хятадын ард түмний хөлс хүч, охидуудыг нь манжуудад өгч байна гэж харааж байсан байдаг. 200 жилийн дараа эргээд харсан чинь тэр хүн жинхэнэ Хятадын баатар байсан. Яагаад гэвэл цэргийн хүчээр байлдаад 300 жил яаж ч чадаагүй тэр үндэстэнг ухаанаар алга болгочихсон.

Өнөөдөр АНУ-д яадаг билээ. Индиануудад архи өгдөг, цалин өгдөг. Австралид бас мөн адил Индианчууд нь мөнгө авна, архи ууж, казинод ордог.

Энэ бүгд ямар учиртай юм гэхээр колончлогч улс орнууд газрын баялгийг булааж авахын тулд заавал байлддаггүй юм. Хамгийн сайн арга бол халамжийн бодлого байдаг. Бүгдэд нь цалин өгч, бүгдийг сайхан болгохыг оролддог. Өнөөдөр Монголд ямар байгаа билээ та нар жаахан эргэцүүлээд үзээрэй.

Мэдлэг, байгалийн баялаг, саяны асуудлыг зэрэгцүүлээд үзэхээр бид ганцхан юмыг мэддэг. Монголын 3 сая хүн дэлхийн 7 тэрбум хүний дунд яаж амьдрах гэхээр нэг кг түүхий эд дотор хичнээн мэдлэг шингээж байна вэ гэдгээрээ л хэмжигдэнэ. Монгол хүн герман, япон, орос хүнээс юугаараа илүү байх вэ гээд асуухад нийгмийн нэгж төгрөг доторх бүтээгдэхүүн доторх материалын болон мэдлэгийн харьцааг нь гаргаад ирдэг. Монголынх бол 1 төгрөгний бүтээгдэхүүний дотор 90 гаруй мөнгө нь материал, 10 хүрэхгүй мөнгө нь мэдлэг байдаг. Бусад үйлчилгээ мэдлэг. Яагаад гэвэл Монголын экспортын хэдэн хувь нь түүхий эд байдаг билээ? Харин Японых бол эсрэг байдаг. 1 кг материал болгоны 96% нь мэдлэг, технологи, шинжлэх ухаан, дөрөвхөн хувь нь материал байдаг. Дэлхийн томчууд хэлэхгүй байгаа болохоос биш мэдлэг гэдэг бол доллароос ч илүү үнэтэй. Монголчууд бид ногоон мөнгө

авахаар баян болно гэж бодоод байдаг. Ногоонмөнгө доллар бидэн дээр тогтохгүй. Яагаад гэвэл Нарантуул ороод буцаад Эрээн лүүгээ гараад явчихна. Монголд ямар ч мөнгө оруулаад толгой ажиллахгүй бол тогтохгүй, буцаад гараад явчихна. Арай гэж олсон мөнгөөрөө Бенз аваад уначихна, арай гэж олсон мөнгөөрөө Эрээний юм авчихна. Харин ганцхан тогтдог зүйл бол мэдлэг. Нэгж бүтээгдэхүүнд оногдох мэдлэгийн асуудал бол хамгийн чухал. Монгол улсын байгалийн баялгийн асуудал, мэдлэгийн асуудал, ялангуяа залуучуудын асуудал, залуучууд явал мэдлэгтэй байх вэ? Энэ бүгд нийлээд XXI зуунд Монгол улс яаж хөгжих вэ гэдэг зураг харагдана.

Би бол мэдээллийн үеийн хүн, мэдлэгийн салбарт ажилладаг. Миний энэ ярьж буй зүйл бол байгалийн хуулийн тухай л яриа. Монголд мэдлэгийг яаж олж авах вэ? Би Японд бага сургуульд очиж үзсэн. Бага анги нь хоёр өрөөтэй байдаг. Нэг өрөөнд нь хичээлээ хийдэг, нөгөөд нь унтдаг, тоглодог. Санаандгүй ярьж байтал Японд байдаг сургуулийн захирал нь манай бага ангийн багш нар сургуульдаа хамгийн өндөр цалинтай. Анги нь багасах тусмаа цалин ихсэдэг гэсэн. Би гайхаад яагаад тэгж байгаа юм бэ гэж асуусан чинь тэр багш маш ухаантай үг хэлсэн. Бага ангийн багш бол “Япон хүн”-ийг бэлддэг юм, харин ахлах ангийн багш бол Япон хүнд зүгээр л хичээл заадаг гэсэн. Монголын хамгийн том дутагдал бол хүмүүжлээ хаячихсан байгаа. Хүүхдийг “Монгол хүн” болгож хүмүүжүүлэх асуудал юм. Ямар ч Япон хүнийг хараад л Япон хүн байна гэж харагддаг, ямар ч Герман хүнийг Герман хүн байна гэж харагддаг. Харин Монгол хүнд бол яг тэгээд хэлэхэд хэцүү аль эсвэл “Билэг Танхай” гэж хэлбэл хэлэх юм. Тэгэхээр “Монгол” гэж чухам яг юуг хэлээд байгаа, “Монгол хүн” гэж хэн бэ гэдгээ бага насанд сайн суулгаж өгөх хэрэгтэй байна. Суурийг нь сайн болгох. 200 жил Монголчууд бид

Манжийн дарлалд байлаа, өөрсдийгөө мартаж шахлаа, дараа нь 70 жил Орос хүн болох гэж үзлээ, болсонгүй. 20 жил ганзагын наймаа үзлээ, бас хэцүү юм байна. Одоо цөмөөрөө Солонгос болох гэж үзэж байна, бас л болохгүй байна. Өнөөдөр Монголчууд бид үнэхээр тусгаар тогтнолоо оллоо, байгалийн баялагтай боллоо, эрх чөлөөтэй боллоо. Одоо л яг “Жинхэнэ монгол хүн” гэж хэн юм бэ, юугаараа бусдаасаа илүү байх юм, дэлхийн тавцанд бид юугаараа илүү байх юм бэ гэдгээ гаргаж ирэх хэрэгтэй. Үүнийг улс төрчид гаргаж ирж чадахгүй. Би ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины зөвлөхтэй уулзаад сууж байхад “Монгол орон хэзээ улс төрийн тогтвортой байдалд орох бол?” гэж асуусан. В.Путины хоёр зөвлөх “Монгол улс бол ойрын жилүүдэд улс төрийн тогтвортой байдалд орохгүй ээ” гэж хэлсэн. Яагаад гэж асуухад танайд “Оюун санааны лидер” төрөөгүй цагт, монгол хүн Би чухам хэн юм бэ гэдгээ ойлгоогүй цагт улс төр юу ч шийдэж чадахгүй. Улс төр бол эрх мэдлийн төлөөх асуудал болохоос биш оюун санааны тухай ажил биш. Тийм учраас Монголчууд одоо энэ тухай бодох хэрэгтэй. Монголчуудаас “Оюун санааны лидер”-үүд төрөх ёстой. Японы сургууль дээр очиход Япон хүүхдүүдийг нэг юманд сургах гэж их зовж байгаа. Япон хүүхэд чинь ерөөсөө арав арваараа нийлчихээд команд өгөхөөр яг цэрэг шиг явдаг, сахилга бат гэж жигтэйхэн ийм хүүхдүүд байдаг. Японд багш нарын мөрөөдөл нь юу гээч дураараа, эрх чөлөөтэй, билэг танхай хүүхдүүдийг хүсээд байдаг. Түүнд юу ч хамаагүй, бусдаас айдаггүй, ганцаараа байсан ч хамаагүй явдаг ингээд ажиглаад байсан чинь Японы боловсролын системийн хүсээд байгаа хүүхдүүдийнх нь чанар Монголд байна. Дураараа дуртай юмаа хийдэг, чадвартай, энэ бүх бидний буруу гээд байгаа зүйл маань дэлхийн тавцанд маш зөв юм байна. Үүн дээрээ шинэ технологи, шинэ мэдлэг олгочихвол Монгол хүн боловсролтой, мэдлэгтэй болно. Монголын

боловсролын систем бол Японыг дуурайх ёсгүй. Харин Монгол хүний давуу талыг ашиглах ёстой. Биеэ даасан, зоригтой, дураараа байгаа нь магадгүй дэлхийн олон оронд хүсч байгаа чанар болно. Тийм учраас бид өөрсдийнхөө хэв загварыг олох хэрэгтэй. Тэгвэл Монголчууд бид суга үсрээд л гараад ирнэ.

Орос, Хятадын түүхийн номонд монголчуудыг 5 сая болгож болохгүй гэж байдаг. Яагаад гэвэл монголчууд 5 сая хүрвэл Орос, Хятадууд дийлэхээ болино гэдэг. Монгол хүнд өвөрмөц чанар байгаа юм. Би үндэсний үзлээ магтаад байгаа юм биш. Гаднаас ирсэн бүх жуулчид монгол хүнтэй уулзахаар нэг л өөр байдаг гэж хэлдэг. Яагаад гэвэл монгол хүн эрх чөлөөний мэдрэмжтэй байдаг. Ялангуяа Африк, Латин Америкт яваад үзэхэд хүмүүс нь нэг л хараа доогуур, гутрангуй, сонин байх юм. Харин Монголд ирэхэд хичнээн ядуу ч гэсэн эрх чөлөөтэй. Тэгэхээр эрх чөлөө гэдэг бол маш чухал. Энэ



МҮАН-ын дарга М.ЭНХСАЙХАН:

Монгол иргэншил, монгол үндэстэн, монгол төр, монгол бодлого

Би үндэсний үзлийг сүүлийн 5 жил Монголын улс төрийн амьдралд эргэлтэнд оруулах гэж их оролдсон. Таван жилийн өмнө манай Монголын нийгэм үндэсний үзэл гэдэг үгийг хэлэхээсээ айдаг, цэрвэдэг, эсвэл мушгин гуйвуулдаг байлаа. 5 жилийн дараа одоо үндэсний үзлийг цаанатай наанатай нь ойлгодог, хэр баргийн хүн ярьдаг болсон байна. Үүнийг Монголын нийгэм нэг түвшин дээшээ ахилаа гэж би дотроо бодож байгаа. Үндэсний үзлийг магтан дуулаад байвал зөндөө юм ярина. Би саяхан Профессор Гринфелдын нэг ном уншлаа. Номын нэр нь л өөрөө үндэсний үзэл ямар чухал болохыг хэлээд өгнө. Тэр номны нэр нь “The spirit of capitalism: nation-alism and economic growth” буюу “Капитализмын амин сүнс: үндэсний үзэл ба эдийн засгийн өсөлт”. Би тэндээс

Азид жишиг болж магадгүй, монголчуудад бас нэг санаа өгч магадгүй гэдэг үүднээс зөвхөн Японы үндэсний үзлийн талаарх хэсгийг орчуулаад “Япон үндэсний үзэл” гэдэг ном гаргасан. Ямар ч байсан үндэсний үзэл бол капитализмын амин сүнс нь байдаг юм байна. Номын зохиогч энэ номоо бичихээсээ өмнө ер нь улс орнуудын хөгжил ямар байдаг юм бэ гэж бодож байгаад анхны номондоо “Хөгжил таван модельтой юм байна” гэж хэлж байсан. Тэр таван модель нь Их Британи, Герман, Франц, Япон, Америк гэж нэрлэсэн байсан. Сүүлд нь өөрөө судалгаа хийгээд Хятад гэж том, хүчтэй гүрэн босч ирж байна, ер нь цаашдаа Орос гээд том гүрэн босч ирэх юм байна гэж бодсон. Эдгээр гүрнүүдийн хөгжлийнх нь амин сүнс нь юу юм бэ гэж хөөсөөр явж байгаад эцэстээ үндэсний үзэл юм байна гэдэг гаргалгаа хийсэн. Энэ бол их анхаарал татаж байгаа ном.

Тэр номонд “Дэлхийн хамгийн анхны үндэстэн бол англичууд” гэж бичсэн байсан. Би яахаараа англичууд дэлхийн анхны үндэстэн байдаг билээ гэж бодоод энд хэддүгээр зууны тухай ярьж байна гээд харсан чинь 16-р зууны тухай ярьж байсан. Тэгвэл монголчууд бид үндэстэн байгаагүй болж таарах уу? Монголчууд дэлхийн хамгийн анхны үндэстэн гэж би тэр том хүнтэй маргалдах гээд байгаа юм. Бид нар үүнийгээ зоригтой хэлэх ёстой байх гэж би дотроо боддог.

Монгол үндэстэн яаж үүссэн бэ гэхээр тал хээр амьдарч байсан монгол туургатнууд Монголын нууц товчоонд гардагаар

Одтой тэнгэр орчиж

Орондоо орох завгүй

Олзлолдон булаалдаж байв гэдэг шиг тэгтлээ замбараагүй оршин байсныг Эзэн Чингис хаан тэр олон тархай бутархай овог аймгуудыг нэгтгэж их төрийг байгуулаад, их төр нь өөрөө үндэстнээ төрүүлсэн юм байна. Үндэстэн нь өөрөө бий болчихоод төрөө байгуулах мөрөөдөлтэй улсууд зөндөө байна. Гэтэл монголчуудын хувьд агуу их төр нь бий болчихоод төр нь өөрөө үндэстнээ төрүүлж өгсөн юм. Үндэстнээ төрүүлсэн гэдгийг их олон юмаар хэлж болох байх. Ер нь үндэстэн улсын модель гэж байдаг. Үндэстэн улсын модель гэхээр өнөөдрийн байгаа улс орнудын моделийг хэлэх гээд байгаа. Үндэстэн улсын моделийг монголчууд анх сэдсэн юм байна. Яагаад гэхээр эзэн хаанаа Их хуралдайгаас сонгодог байсан. Эзэн хаанаа хуралдайгаар сонгодог тогтолцоо дэлхийн хаана ч байгаагүй, одоо ч байхгүй. Эзэн хаан бол хуралдайдаа үйлчилдэг, хуралдай нь түмт, мянгат, зуутдаа үйлчилдэг байсан. Энэ нь үндэстэн улсын анхдагч загвар байсан байна гэж би боддог.

Хууль ёс, хуулиа дагаж мөрддөг орон байсан гэдгээрээ монголчууд бид бахархах ёстой. Дэлхийн хамгийн анхны бичмэл хууль гэхээр баруунд “Магнакарта” гэдэг баримт бичгийг хэлээд байдаг. Гэтэл Монголын “Их засаг” хууль бол Магнакарта гэдэг тэр хуулиас 10 жилээр ах. Тэгэхээр хамгийн анхны хууль төр улсын дүр зураг бол Их Монгол улсаас харагддаг юм. Бид түүхээ аль болох гүнзгий мэдэх хэрэгтэй, өөрсдийнхөө бахархлыг олж харах хэрэгтэй. Бид дэлхийн анхны үндэстэн юм байна, бид дэлхийн анхны үндэстэн улсын модель юм байна, бид хуульт төртэй байсан юм байна гэдэг энэ бүх юмаа мэдэж авах нь асар чухал юм. Түүнээс гадна бид өөрсдөө үүнийгээ хэлэхгүй бол дэлхийн хамгийн анхны үндэстэн бол англичууд гээд дэлхийд ойлгуулаад байна. Энэ бол байж боломгүй юм.

Хүйтэн дайны үед социализм, капитализм гэж ялгараад хоорондоо тэмцэлдэж ирлээ. Дэлхий ертөнц үзэл суртлаар тэмцэлдэж ирсэн. Хүйтэн дайнаас хойшхи энэ дэлхий ертөнцийн тэмцэл зөрчилдөөнийг соёл иргэншлийн мөргөлдөөн гэж тайлбарлах болж. Дэлхий ертөнц дээр соёл иргэншлүүдийн хоорондын мөргөлдөөн, харилцан бие биедээ уусах зүйлүүд явагдаад байгаа нь харагдаж байгаа. Энэ чиглэлээр үзэж харъя гэвэл хамгийн их анхаарал татдаг ном бол Арнольд Томби гэж хүний “The study of history” гээд 12 боть, 6000 хуудастай ном байгаа. Асар их хэл ам таталсан зохиол. Энэ номонд хүн төрөлхтний түүхийг их урт хугацаанд харах юм бол улс орны түүхийн тухай биш иргэншлийн түүхийн тухай, хичнээн иргэншил бий болсон юм, яаж иргэншлүүд бий болсон юм, яаж тэр нь өөрөө хөгжиж байгаад оргилдоо хүрээд, дараа нь яаж уруудаад мөхөж устсан юм гэдгийг бүгдийг нь нарийн судалсан байгаа. Судалгаагаа хийхдээ Монголд хамаарах юмыг нь нүүдлийн соёл иргэншил гээд, тэгээд нүүдлийн соёл иргэншлийг “царцсан соёл иргэншил” гэж тодорхойлоод судалгааныхаа объектоос бараг гаргаад хаячихдаг. Бид ч өөрсдийгөө нүүдлийн соёл иргэншилтэй гэж ойлгодог. Нүүдлийн соёл иргэншил гэдгийн цаана монголчуудыг бүдүүлэг гэсэн санаа нуугддаг. Нүүдэг учраас бүдүүлэг, суурьшихаас нааш соёлжихгүй гэдэг ийм санаа юм. Гэтэл бид эх оронгүй цыган шиг нүүдэллэдэг улсууд биш. Бид байгальд хөөгдөж туугдаад, амьдрал хайгаад, идэх юм хайгаад гүйж байгаа Африк маягийн нүүдэл хийдэг улсууд бүр ч биш. Хэрвээ бид агуу их үндэстэн байсан юм байна, агуу их төртэй байсан юм байна гэдгээ холбож үзэх юм бол яагаад ч барууныхны томъёолдог нүүдлийн соёл иргэншил гэдэг ойлголтонд орох ёсгүй юм. Яг нарийн дээрээ орчин үеийн ертөнцөд олигархууд хүртэл нүүдэлчин гэж хэлэх гээд байна. Өвдөхөөрөө гадагшаа яваад эмчлүүлчихдэг, жаахан цаг

завгай бол далай дээр очоод амарчихдаг, өвөл болохоор халуун орон руу явдаг гээд бүгдээрээ л нүүдэлчин. Тэгэхээр нүүдэл гэдэг бол соёл иргэншлийг тодорхойлдог гол хүчин зүйл биш гэж би маргаан дэгдээх гэж, өөрөөр хэлбэл монголчуудын нурууг нь тэнийлгэж, түүний цаана бүдүүлэг гэсэн юм дандаа нуугдаж байдаг учраас барууны хэлж өгсөн тэр ойлголтоос мултрах хэрэгтэй байна гэж хэлэх гээд байгаа юм. Бид өөрсдийгөө “Монгол иргэншил” гэж томъёолох ёстой, нүүдлийн соёл иргэншил гэж ярих нь буруу юм. Энэ бол шинжлэх ухаан талаас нь хөөсөн ч гэсэн их ач холбогдолтой. Бид өөрсдийгөө агуу том Монгол үндэстний хэлтэрхий гэж хэлж болно. Дэлхий дээр Монгол шиг их гүрнүүдийн явуулгаар өөрийгөө зургаа тастуулсан ийм үндэстэн байхгүй. Арга ч үгүй байх. Яагаад гэхээр бид нар хамгийн анхдагч үндэстэн байсан, хамгийн анхдагч төр улсыг байгуулсан, хамгийн анхдагчийн эсрэг бүх дэлхий хөдөлсөн байгаа. Түүний гай нь бид зургаа тастуулсан үндэстэн. Тэр дотроо хамаг амийг нь тээгээд явж байгаа улс бол өнөөгийн бидний монголчууд юм. Үнэндээ бид жаахан гүйцэд юмаа ойлгохгүй, хариуцлагаа ухамсарлахгүй, арчаагүй, үлбэгэр байгаа гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Гэхдээ өнөөдрийн Монгол улс бол монгол туургатнуудын хувьд “Сүлд улс” байх ёстой.

Би зориуд Өвөр Монголоор, Буриадаар, төв Азийн орнууд болох Узбек, Казакстанаар зөндөө явсан. Бүгд л Монголын түүхэн дээр амьдралаа тээх гэж оролдож байна, эх үүсвэр авах гэж оролдож байна. Монгол яаж байна гэдгийг бүгд хардаг. Яаж байна гээд харж байна гэдэг чинь биднийг хариуцлагатай байхыг хүсч байгаа юм. Бид хариуцлагатай байж чадахгүй байгаа учраас тэр хариуцлагатай байх гэдэг санааг хүргэхийн тулд Сүлд улс гэсэн санааг гаргаж ирж байгаа юм. Монгол туургатны хувьд өнөөдрийн Монгол улс Сүлд улс байж л бид нар хариуцлагатай болно.

Арнольд Томбигийн зохиол дээр “Үндэстнийг устгахад сэхээтнийг л устгах ёстой” гэсэн утга гардаг. Үнэндээ түүхээ эргээд харахад Манж Хятадын явуулж байсан бодлого дандаа алтан ургийн эсрэг явагдаж байсан. Тэнд үндэстний амин сүнс тээгдэж байсан гэдэг утгаараа алтан ургийг хөнөөж дуусгах асуудал ярьж байсан. Дараа нь түүхийн нугачаан дунд бид Коминтерний мэдэлд орсон. Нарийн дээрээ 1930-аад оны хэлмэгдүүлэлт хийгдэхдээ Манж Хятадын тагнуулын мэдээгээр Коминтерн манай сэхээтнүүдийг устгахад чиглэсэн бодлого явуулж байсан. Энэ тухай сүүлийн үед бас яригдаж, судалгаагаар тогтоогдож байгаа. 1930-аад оны хавтгай хэлмэгдүүлэлт бол мөн л сэхээтэн давхаргыг аймаглан устгах үйл явдал байжээ. Өөрөөр хэлбэл үндэстэнг устгахад сэхээтнийг нь л устгадаг юм байна.

Тэгвэл сэхээтэн гэж хэн бэ гэдэг асуудал гарч ирнэ. Гринфелд зохиол дээр “Сэхээтэн гэдэг бол өөрийнхөө үндэсний эрх ашгийг мэдэрсэн, мэдсэн, гэгээрсэн, сэхээрсэн хүнийг хэлнэ” гэж бичсэн байдаг. Би үүнийг их зөв юм байна гэж хараад байгаа. Түүнээс биш нэг дээд сургууль төгссөн, диплом өвөртөлсөн, өөрийгөө боловсролтой гэж бодож байгаа хүнийг сэхээтэн гэж хэлдэггүй юм байна. Бид энэ дээр маш том төөрөгдөлд явж байгаа юм байна шүү. Өөрийнхөө үндэснийхээ юмыг, мэдрэмжийг цогцоор нь мэдэрсэн хүнийг л сэхээтэн гэнэ. Тийм учраас сэхээрсэн гэж хэлж байгаа юм. Үндэстэнг устгахын тулд сэхээтэн рүү нь довтолдог. Заримдаа миний дотроос түлхээд, хэлмээр байгаа юм юу байдаг гэхээр Монголын сэхээтэн хаана байна? Өнөөдөр дээр үеийнх шиг биднийг устгаад байгаа юм байхгүй ч Монголын сэхээтнүүдийг оюун санааных нь хувьд устгачихсан байна. Бид өөрөө өөрсдийнхөө үндэсний эрх ашгийг мэдэхээ больсон. Тэгэхээр биднийг сэхээтэн гэж хэлж болох уу?.

Хэрвээ сэхээтэн нь өөрөө устаад байвал үндэстэн нь өөрөө устаад байна гэсэн үг.

Бид ардчилал руу орлоо, олон намын тогтолцоотой боллоо. Монгол үндэстний оюун ухаан намуудаар л дамжиж илэрч гарах ёстой. Уг нь хуучин цагт нам гэдэг бол эрин зууны оюун ухаан, нэр төр, алдар гэсэн үг байсан. Өнөөдөр намууд нь оюун ухаан, нэр төр, алдар гэдэг тэр үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон байна. Хэлбэрийг нь харахаар олон намтай юм шиг. Ямар ч оюун ухааны эрүүл өрсөлдөөн байхгүй болсон. Оюун ухааны эрүүл өрсөлдөөн байхгүй байна гэдэг чинь нөгөө сэхээтэн давхарга устчихжээ гэдгийг хэлээд байгаа юм. Оюунлаг хэсэг нь устаад, үлбийгээд ирэхээр үндэстэн өөрөө устана. Бид нар өнөөдөр яг энэ зам дээр зогсож байна. Тийм учраас бидний уриалан дуудаад байгаа юм бол үндэснийхээ эрх ашиг гэдгийг мэдээч, үндэсний үзэл гэдгээ мэдээч, өөрсдөө үндэстнийхээ сэхээтэн болж босч ирээд үндэстнээ дагуулаач гээд байгаа юм. Өнөөгийн олон намын тогтолцоо хэлбэр боловч ажиллахгүй байна. Ажиллагаанд оруулахын тулд улс төрийн намуудыг шинэ төлөв байдал руу шахсан ажиллагаанууд хийгдэх хэрэгтэй байгаа учраас бид үүнийг хийх гэж оролдож байгаа юм.

Үндэсний үзэл гэж юу вэ. Үндэсний үзлийг маш товчхон хэлэхэд монгол төрийг бэхжүүлж хөгжүүлэх тухай л үзэл юм. Үндэсний үзлийг бидний ой, маханд ортол хэлсэн Эзэн Чингисийн үг байгаа.

Алд бие минь алжааваас алжаатугай

Ахуй төр минь бүү алдартугай

Монголчууд төрөөрөө дамжин байж үндэстэн болсон. Төрөөрөө дамжин байж үндэстнээ бэхжүүлж, өөрсдийгөө авч явах ёстой улсууд. Гэтэл ардчиллын гэх 20 жилд бид төрөө муулж чаддаг л болж. Сайн байна уу, муу байна уу, юм хийж чадаж байна уу, үгүй юу гэдэг нь хамаагүй зүгээр л төрөө новшилдог болсон. Төрөө новшилж, төртэйгээ тэмцсэн хүн ер нь бараг баатрын дүртэй болж. Энэ чинь үндсэндээ бид нар өөрөө өөрсдийгөө алж, дуусч байна гэсэн үг. Энэ бол ардчилал завхарч дампуурсан байна гэдгийг хэлээд байгаа юм.

Төрийн эрх мэдлийг хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх гээд хуваахыг гадныхан хүрч ирээд бидэнд зааж өгсөн. Манайх түүнийгээ яаж хэрэгжүүлсэн бэ гэхээр хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл нь хоорондоо бантан, шүүх нь нөгөө хоёр эрх мэдлээсээ хараат ийм байдалтай байгаа. Дэлхийн олон орнуудыг хараад байхад төрийн эрх мэдлийг гурав хуваана гэсэн юм ч яг байхгүй. Тав, зургаа хуваасан орнууд зөндөө байна. Үндсэн хуулийн хувьд манайд өөр хоёр эрх мэдэл нэмэгдэх ёстой гэж би боддог. Нэг нь шалгаруулах эрх мэдэл буюу монгол төрийн албанд ямар хүн ажиллах вэ гэдгийг намаас хараат биш, засгаас хараат биш, их хурлаас хараат биш, төрийн албаны зөвлөл өөрөө шууд шийддэг байх ёстой. Шалгаруулах эрх мэдэл нь аль намд харьяатай хүн бэ гэдгээр биш ямар ёс суртахуунтай юм, ямар хүмүүжилтэй юм, ямар эрх гэрийн орчинд өссөн юм, ямар боловсролтой юм гэдгийг нь харж төрийн албанд сонгодог байх хэрэгтэй. Энэ өнөөдөр байхгүй. Тийм ч учраас манай төр дээд зэргээр бохирдчихсон байна. Өөрөөр хэлбэл бие даасан үндсэн хуулийн эрх мэдэл бүхий засаглал алга байна. Өөр нэг нь хянах эрх мэдэл гэж бие даасан эрх мэдэл байх ёстой. Хянах эрх мэдэл гэж юуг хэлээд байна гэхээр шалгалтын байгууллагууд. Ямар нэг байгууллага дээр очоод санхүүг нь шалгахад алдаа байвал хариуцлага тооцдог чадвартай. Одоо Засгийн газар луу

хэлнэ, Их Хурал руу хэлнэ, нөгөөдүүл нь хариуцлага тооцохгүй. Авлигатай тэмцэх газар гээд нэг газар байгуулчихсан. Авлигын асуудал ийм байна, тийм байна гээд ярьдаг. Үнэхээр тийм асуудал нь тогтоогдсон бол шууд төрийн албанаас авилгачдыг хөөж байх хэрэгтэй. Хэнээс ч асуухгүйгээр тэр хүнийг хөөгөөд дараагийнх нь хүнийг тавьж байх хэрэгтэй. Шалгаад л байдаг, авлигын хэрэг байна гээд яриад байдаг, тэгсэн хэрнээ нөгөө хүн нь авлигаа авсан хэвээрээ, төрийн албанд байсан хэвээрээ л байдаг. Манай төрийн онол бол импортын хуулбар онол.

Монгол бодлого гэдэг дээр бид хамгийн том алдаж байгаа зүйл бол баялаг гэдэг ойлголтыг ойлгоогүй явна. Адам Смитийн “Үндэсний баялаг ба түүний шалтгааныг шинжлэхүй” гэдэг ном байдаг. Тэр номыг энэ бол чөлөөт зах зээлийг номлосон мундаг классик зохиол гээд дэлхий ертөнц сурталчилсан.. Гринфелд гэж хүн номон дээрээ юу гэж бичээд байна гэхээр Адам Смит шиг хамгийн их хэлмэгдсэн хүн байхгүй. Адам Смит тэр чөлөөт зах зээл гэдгийг номлоогүй, үл үзэгдэгч гар гэдгийг номлоогүй. Харин Адам Смит нийгмийг харахдаа үндэстэн гэж харсан учраас үндэстний баялаг гэж хэлсэн. Яагаад гэхээр Адам Смит 17-р зуунд номоо бичиж байхдаа Английг үндэстэн гэж харж, үндэстний баялаг гэж бичиж байсан гэжээ. Бидний хувьд үндэстний гэдэг үг одоо л нэг хэллэгэнд орж байх шиг байна. Нийгмийн баялаг гээд туугаад байхынхаа оронд үндэстний баялаг гэж босч ирэх ёстой. Баялаг гэдгийг юу гэж буруугаар ойлгож байгаа вэ гэхээр хамгийн энгийнээр хэлэхэд ногоон долларыг, улаан юанийг, манай муу бор төгрөгийг баялаг гэж бодож байгаа. Эд бүгдээрээ маш сайн хэвлэх үйлдвэрт хэвлэсэн цааснууд. Хэрвээ долларын массыг авч үзвэл

100 долларын 5 нь л ардаа баталгаатай, бусад нь ямар ч баталгаагүй зүгээр цааснууд. Юанийг авч үзвэл 100 юаний 1 юань нь л баталгаатай, 99 юань нь баталгаагүй зүгээр л хэвлэсэн цаас. Төгрөгийг ярих юм бүүр алга болж өгнө биз. Үүгээр юу хэлэх гээд байна гэхээр хэрвээ мөнгийг баялаг гэж хараад байвал цаадуул чинь мөнгөө хэвлээд, авчраад, цаасаар цутгаад баялгийг чинь өөрөө зөөдөг. Одоо бид яг тийм юманд оролцоод зөөлгүүлж байна. Монголд үндэсний баялаг гэж юу вэ гэвэл монгол хүн, бид нарын ус, агаар, байгалийн баялаг, монгол шинжлэх ухаан, технологи, монголчуудын хөдөлмөр гэж томъёологдох ёстой. Үүнийгээ хэрвээ зөв томъёолоод төрийн бодлого болгоё гэвэл цоо шинэ төрийн бодлогыг босгож болно. Яг энэ нүдээр харж гадаадын хөрөнгө оруулалтын хуулиа өөрчлөх хэрэгтэй. Стратегийн ордууд дээр хийж байгаа хэлэлцээрийг яг энэ концепцээр харж хэлэлцээрт орох ёстой. Гадныхантай хэлэлцээрийн ширээний ард сууж байхдаа хөгжлийн төлөвлөгөө, багц өөдөөс нь тавьдаг байх ёстой. Жишээлбэл, хуучин ЗХУ-тай Эрдэнэт үйлдвэрийн талаар хэлэлцээр хийж байхад Эрдэнэт хот барья, Эрдэнэтэд хивсний үйлдвэр байгуулж эмэгтэйчүүдийг ажилтай болгоё, хүнсний үйлдвэр байгуулъя гээд бүх л юмыг нь шийдэж байж олборлох асуудлыг шийдэж байсан. Өнөөдөр Монголын стратегийн баялагт гадныхан яаж хандаж байна гэхээр ерөөсөө л хэдэн гэр хороолол бариад, хэдэн ажилчид суулгаад, өөрийнхөө баялгийг зөөлгөхийн төлөө зам тавьсан ийм л хэлбэртэй байна. Бид өөдөөс нь багц саналаа сөргүүлж тавьж чадахгүй, мэдэхгүй байна. Ингэж ажиллах ёстой гэдгээ ч ойлгохгүй байна.

Эдийн засаг дээр төлөвлөлтөнд орох хэрэгтэй байна. Төлөвлөлт бол гарцаагүй тавигдана. 10,15 жилээр хөгжлөө баримжаалдаг, 5 жилийн төлөвлөгөөнд ордог.

Ялангуяа дэд бүтцийн хөгжлийг 5 жилээр төлөвлөдөг байх ёстой. Тэгэхгүй бол орж ирж

байгаа мөнгөө өнөө маргаашаар нь цацаад л байгаа. Цацаад байгаа нь одоохондоо болоод байгаа юм шиг хэрнээ болохоо байчихдаг юм. Болоод байгаа юм шиг хэрнээ дунд, урт хугацаанд асуудал үүсгэдэг, буруу зуршилд сургадаг. Дэлхий маш эмзэг байгаа. Жаахан сэгсрэхэд л бид хамт дуусна. Өчигдөрхөн Олон Улсын Валютын сангаас дэлхийн эдийн засаг хамгийн аюултай үедээ орлоо гэж анхааруулга өгч байна. Валютын сан зүгээр анхааруулга өгнө гэж байхгүй шүү. Бид тэр анхааруулгыг маш дутуу ойлгож байна. Ер нь цаана чинь их эвгүй юм болох гэж байгаа шүү гэж хэлэх гээд байгаа юм. Нөгөө баялаг гэж ойлгож байсан мөнгөнүүд чинь бүгд унах гээд байна. Би та бүхэнд эдийн засагт болж байгаа үйл явцын мөн чанарыг ойлгуулахын тулд сонирхолтой байж магадгүй гэдэг үүднээс нэг юм асууя. Жишээлбэл, Есүс Христос 1 доллар банкинд хадгалуулсан бол 2000 жилийн дараа хэдэн доллартай байх бол? Та нар төсөөлж байна уу? Сая биш, миллиард биш, триллион биш, квадрилион биш бидний аманд багтахгүй тоо гарна. Ерөнхийдөө эдийн засагт мөнгөний масс тэгтлээ нэмэгддэг юм. Монголын банкны зээлийн жилийн дундаж хүү 12-15% байгаа. Банкны өгч байгаа мөнгө нь жилд 12%-иар өсч байна. Манай эдийн засаг жилд 12%-иар өсч байна уу? Үгүй. Тэгэхээр бодит эдийн засаг нь өчүүхэн, энд мөнгөний масс нь асар их өсөөд байхаар бодит эдийн засагтаа нийцэхийн тулд юмны үнэ өсөхөөс өөр арга байхгүй. Дэлхийн хэмжээнд аваад үзэх юм бол Валютын сангаас яагаад анхааруулаад байна гэхээр мөнгөний масс нь хэт их, бүүр дэндүү их явчихаар энэ мөнгөний масс, бодит эдийн засаг хоёрынхоо хоорондын зохицолдлогоог олохын тулд дайн тулаан хэрэгтэй болдог. Дэлхий дээр болж байгаа өчнөөн олон дайн тулааны ард ерөөсөө л эдийн засгийн энэ балансаа л олох гэж байгаа юм. Тийм учраас өнөөдөр дайн болно гэхэд ерөөсөө эргэлзэх юм байхгүй. Яагаад улс орон болгон цэргийн хүчээ зузаатгадаг юм, яагаад үргэлж дайнд бэлдэж байдаг юм бэ? Яагаад гэвэл эдийн засгийн механизм, энэ зах зээл гэдэг механизм өөрөө дандаа балансаа алдаж байдаг учраас үүний зохицуулалтыг хүчээр, дайнаар хийдэг. Нэг хэсгийг устгаж, нэг хэсгийг дарж, нэг хэсэг улсыг алж байгаа, одоо ч байгаа энэ үзэгдлийг харах юм бол нөгөө илүү гарсан цаасан мөнгийг жинхэнэ баялгаар баталгаажуулахын тулд тэр баялгийн төлөө дайрч байгаа юм.

Манайхыг эзэлж авахын тулд тархиар нь дайраад, халаасаар нь дайраад, авилгалаар дайраад баялаг руу нь шуналдаж байгаа. Үүнийг ойлгох хэрэгтэй. Ойлгочихоод үүнийг сөрж зогсох бодлого төрд байх хэрэгтэй. Чухам түүнийг л үндэсний үзэл гэж би хэлэх гээд байна. Үүнийг хийж чадахгүй бол бид өөрсдөө үндэстнийхээ хувьд устаж байгаа улс. Ер нь стратегийн ордуудын энэ алдаатай гэрээ хэлэлцээрийг хийдэг эрх зүйн орчнуудаа Үндсэн хуулиасаа авахуулаад бүгдийг нь өөрчлөх хэрэгтэй. 20 жил явахад зөөлхөн орж ирээд бид нарын тархийг угаасаар угаасаар, янз янзын төсөл хэрэгжүүлж байна гэсээр байгаад дандаа өөрсдөдөө хэрэгтэй хуулиудыг бүгдийг нь монголчуудаар өөрсдөөр нь гаргуулчихсан. Энэ хуулиудыг бүгдийг нь цогцоор нь өөрчлөх хэрэгтэй. Гадныхантай байгуулсан бүх гэрээг цогцоор нь харах хэрэгтэй. Давхар татвараас чөлөөлөх гэрээг 1989 онд Нидерландтай байгуулж байсан. Тэр үед бид ордтой гэдгээ мэдэхгүй, юм авна гэдгээ мэдэхгүй байсан. Нидерландынхан манайд чөлөөт хэвлэлийнхнийг хөгжүүлэх төсөл өгчихөөд түүнийх нь хариуд давхар татварын гэрээнд гарын үсэг зураад л тууж байсан. 20 жилийн дараа өнөөдөр Оюу толгой дээр орж ирж байгаа гадны хөрөнгө оруулагчид нь Нидерландад бүртгэлтэй компани байна. Энэ компани Нидерландад бүртгэгдээд давхар татвараас чөлөөлөгдөх гээд ороод ирлээ гээд Нидерландын талд хэлэхээр бид ингэхийн төлөө л 20 жилийн турш та нарт янз янзын төсөл, тусламж өгсөн гэж хэлдэг. Өөрөөр хэлбэл биднийг зөөлөн колоничилсон.

Зөөлөн колоницлол гэдэг нь тархиа алдаж байгааг хэлдэг юм. Бид нар ийм зөөлөн колоницлол дотор орчихсон. Энэ үгийг хэлэхээр одоохондоо зарим нь цочоод байгаа. Жаахан цочиж байгаад сүүлдээ ойлгодог болно. Хатуухан хэлэхэд манай Үндсэн хуулийг 1992 онд гадныхан хийж өгсөн. Үүнийгээ өөрчлөх хэрэгтэй. Илт тод байгаа учраас юмыг сүүлд эргээд харахад бас их сонин юм. Азийн сангийнхан манайд анх үндсэн хууль хийж байхад хүний эрх гэж юу юм гэдгийг 40,50 хуудсанд бичиж өгсөн. Бид өнөөдөр 20 жил мөрдсөн үндсэн хуулиа харахаар түүнийг нь сайхан монголчилсон л байгаа юм. Ингэж алсаас ажиллаж байна. Би юу гэж хэлэх гээд байна гэхээр 20 жилийн өмнө улс төрийн алуурчид нь орж ирсэн юм байна шүү. Одоо 20 жилийн дараа эдийн засгийн алуурчид орж ирж байна. Сэхээрээч ээ, манай үндэсний сэхээтнүүд хаана байна аа гэж уриалаад байгаа юм. Тэгж байж юмаа өөрчилнө.

Нийгмийн бодлогын хувьд бид 20 жилийн турш хүний эрх, хүний эрх гэсээр байгаад одоо хүний хөгжлийн сантай сууж байгаа улс. Нийгмийн бодлого өрх гэрт төвлөрөх ёстой. Ер нь өрх гэрийн эрх гэж байна уу? Хүний эрх нь чухал юм уу, өрх гэрийн эрх нь чухал юм уу? Үр ашиг талаас нь харсан ч гэсэн монгол төр 2,8 сая хүнтэйгээ ажиллах юм уу, эсвэл 700-800 мянган өрхтэй ажилласан нь дээр үү? Нийгмийн бодлогын бүгдийнх нь фокусыг өрх гэр дээр төвлөрүүлэх хэрэгтэй. Өрх гэр дээр энэ бодлогоо төвлөрүүлээгүй цагт өрх нь задраад, нэг нэгээрээ хүний эрх гэж гүйж байсан цагт бүгдээрээ тэр том капиталист системийн тэр том үндэстэн дамнасан корпорациудын ажиллах хүч, боол л болно. Тийм учраас энэ нийгмийн бодлого гэдэг юмыг цоо шинээр ахин эргэж харах хэрэгтэй. Ингэж харах бололцоог надад юу өгөөд байна гэхээр үндэсний үзэл дээрээ босч зогсож байж л энэ бүгдийг харж байгаа. Үндэсний үзлээ харж, үндэстнийхээ эрх ашгийг мэдэж, сэхээрсэн, гэгээрсэн сэхээтэн болж чадахгүй бол үүнийг бүгдийг нь цогцоор нь харж чадахгүй. Ингэж чадахгүй бол энд тэнд, хэсэг бусаг, алаг цоог л юм ярисаар л байх болно.

Манайх уул уурхайн орон болж байгаа нь үнэн. Газар доорх баялгаа хүнд ашиглуулахгүй гээд дээр нь дараад хэвтээд байж бас л чадахгүй. Цэргийн хүчээр ч хамаагүй авч магадгүй. Дээрээс нь дараад хэвтэж байгаа хүмүүсийг эхнээс нь далавчит пуужингаар харваад байгаа. Угаасаа дээр нь дарж мордоно гэдэг бол бодлого биш. Баялгийн тухай ойлгохдоо газрын доор үндэстний баялаг байна. Газрын дээр яаж үндэстний баялаг болгож хувиргах уу гэж бодох хэрэгтэй. Манайд газар доорх баялаг газар дээр дээшээ гараад ирэхээрээ үндэстний баялаг болж чадахгүй байна. Одоо тэр том гүрэн, том компаниуд чинь заналхийлээд байна. Рио Тинтогийн захирал “улс төрчид өө, шуналаа хязгаарлаарай” гэж монголчуудад анхааруулаад байна. Рио Тинтогийн захирал бол өөрөө хамгийн дээд зэргийн шуналтай, тэр өөрийнхөө юмыг хамгаалж тэгж ярьж байна. Бид нар яаж өөрийнхөө үндэсний эрх ашгаа ойлгодог, яаж үндэснийхээ эрх ашгаа хамгаалдаг төрийн тогтолцоонд орж, яаж тэдний өөдөөс сөрж зогсох вэ гэдэг асуудал Монголын өмнө тулгамдсан асуудал болж байна. Ингээд бодохоор бид арчаагүй, үлбэгэр, сул бодлогоосоо идэвхтэй, давшингүй бодлого руу орохоос нааш монгол үндэстэн босч ирж чадахгүй.

Бид жижигхэн орон боловч том санаархалтай. Манай цэргүүд хаа хамаагүй газар оччихсон давшиж явна. Тэнд монгол цэрэг эрсдэнэ. Цэрэг эрсдэх байтугай өнөөдөр олон улсын терроризм өртөж болох дэлхийн орнуудын эхний 20 дотор Монгол орж байгаа. Яагаад гэхээр бид өөрсдийнхөө хэмжээнд таараагүй бодлого явуулснаас бид нар хариу цохилт авахад бололцоотой ийм орон болчихоод байна. Манайх маш задгай, ганц шугам дээр ганц юм

дэлбэрэхэд Улаанбаатар тэр чигээрээ хөлдөнө. Улаанбаатар будаа болоход үндэстэн яах бол гэдэг асуудал хэцүү шүү. Тийм учраас жижиг гэдгээ мэдэж, өөртөө таарсан гадаад бодлоготой байх ёстой. Би Америкийн элчинтэй монгол цэрэг Афганистанд явж байгаа тухай маргалдаж байсан юм. Манай монгол цэрэг тэнд үхвэл яах юм гэсэн чинь Америкийн элчин надад монгол цэрэг үхэх ёстой гэж хэлж билээ. Тэр бол зүгээр л Америкийн бодлого. Бид их гүрний тоглоомонд ороод байна.. Өөрийн гэсэн Монгол бодлоготой хэзээ болох вэ гэдэг асуудлыг л би хэлээд байна.

Уг нь өөрийн бодлоготой болох бололцоог ардчиллын 20 жил өгөөд байгаа юм. Цагийг алдаад байна. Монгол монголоороо байхын төлөө төлөө бүгдээрээ хамтарч ажиллая. Баярлалаа.



Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч, МАХН-ын дарга Н.ЭНХБАЯР:

“Хүн ном судар уншиж бурханыг эрж хайдаг, харин бясалгал хийж бурханыг олдог”

“Ном судар уншиж Бурханыг эрж хайдаг, харин бясалгал хийж Бурханыг олдог” хэмээн Христийн шашины лам, ариун Падрэ Пио нэгэнтээ айлдсан байдаг. Буддын шашины уламжлалд бясалгагч нь бясалгал хийж амьсгалаа авахдаа бусдын зовлонг өөртөө шингээж, харин амьсгалаа гаргахдаа нарны илч туяа түгдэг лүгээ адил бусдад жаргал баясгалан түгээдэг хэмээн үздэг. Энэ үнэн бол бусдын зовлонг өөртөө шингээж, бусдад жаргал түгээдэг “бясалгал” хэмээх их эрдмийн тухай өгүүлэе.

Сүүлийн жилүүдэд “бясалгал” хэмээх үг та бидний амьдралд гүн гүнзгий нэвтэрч, бясалгал заалгадаг хүмүүсийн тоо ч олширч, хамгийн сонин нь заадаг багш нарын тоо ч түүнээс дутуугүй олон болсон мэт санагдана.

Бясалгал бол тодорхой зорилго бүхий, хүний бие, оюун ухаан, сэтгэл санаагаа нэгэн зэрэг бүрэн дайчилж хийдэг нэг ёсны цогц дасгал юм.

Өрнийн орнуудад бясалгал хэмээх үг нь латины *meditatum* буюу махчлан орчуулвал “эргэцүүлэх” гэдэг үгнээс гаралтай. Дорнын орнуудад бясалгал нь санскрит “*dhyai*” буюу “ажиглах”, “бясалгах” гэсэн үгнээс үүдэлтэй. Монголчууд бурханы шашинаар дамжуулан “даяан” хийх хэмээх ойлголттой болж, бясалгалыг хөгжүүлсэн уламжлалтай ард түмний нэг.

Бясалгал нь анхнаасаа шашин, шашины зан үйлтэй холбоотой байсан нь ойлгомжтой. Христийн шашин, Исламын шашин, Буддын шашины аль аль нь бясалгалын их, бага уламжлалтай. Христийн шашин дотроо Өрнийн ба Дорнын хэмээх хоёр том урсгалтай байсан бөгөөд Өрнийн уламжлалд нь бясалгалыг ариун Библи судрыг тодорхой аргаар унших замаар үйлддэг бол (унших, бодох, залбирах, эргэцүүлэх хэмээх дөрвөн үйлдлийг нарийн дэс дараалалтайгаар хийнэ гэсэн үг), түүний Дорнын уламжлал нь “эсихазм” хэмээх урсгал бясалгалын өвөрмөц аргыг хөгжүүлсэн аж (Есүсийн нэрийг олон дахин давтаж бясалгал хийнэ).

Исламын шашинд бясалгалыг “дикр” хэмээх залбиралын арга төлөөлдөг гэж үздэг бөгөөд энэ нь товчхон тайлбарлавал “Коран сударт буй Аллахын 99 ариун нэрийг олон дахин давтана” гэсэн үг. Хожим Исламын шашинд “суфизм”-ын уламжлал хөгжихөд бясалгалын арга нь нарийсч боловсронгуй болсон байна. Энэ уламжлалд гол нь бясалгагч Аллах бурхантай шууд холбоо тогтоохыг зорино.

Буддын шашиныг бясалгалгүйгээр төсөөлөхийн аргагүй. Бурхан багш өөрөө бодь модны доор бясалгал хийж нирванд хүрсэн бөгөөд түүнийг сэргээж, шавь нартаа болон зовлонгийн хүрднээс гарахыг эрмэлзсэн хүн бүрт зааж, захиж үлдээсэн бясалгалын арга нь өнөөдөр хүртэл хадгалагдан иржээ.

Энэ бол Випассана бясалгалын арга юм. Випассана хэмээх үгийг махчлан орчуулвал аливаа юм үзэгдлийг бодитойгоор харна гэсэн үг.

Сонирхуулахад санскрит хэлний dhyai хэмээх бясалгахыг илэрхийлсэн үг монгол хэлэнд даяан хэмээн хувирч орж ирсэн бол хятад хэлэнд чань, япон хэлэнд зэн хэмээн хувиран орж ирсэн гэж үздэг. Зүгээр нэг үг зээлэх хэмжээнд бус бүр бясалгалыг эрхэмлэдэг, эрхэмлээд зогсохгүй өвөрмөц бясалгалын аргыг хөгжүүлж бурханы хутагийг олж болох тухай сургасан бүхэл бүтэн томоохон уламжлал болж хөгжсөн байна.

Бясалгалыг ерөнхийд нь хоёр төрөл, хэлбэрт хуваана. Нэг нь “төвлөрөх бясалгал”. Бясалгагч анхаарлаа нэг юм, үйлдэл, эсхүл дүрс дээр тогтоож төвлөрүүлнэ гэсэн үг. Тухайлбал, уруулын дээд хэсэг болон хамрын үзүүр, нүхээр орж, гарч буй амьсгалын урсгалыг мэдрэхэд төвлөрүүлэх /ингэхийг “анапанасати” хэмээн нэрлэх нь бий/, эсхүл ямар нэгэн бурхан, сахиус, багшийнхаа дүрийг төсөөлж, түүнд анхаарлаа төвлөрүүлнэ. Ерөөсөө анхаарлаа төвлөрүүлж чаддаг болно гэдэг их чухал эрдэм, чадвар.

Хоёрдох нь “Оюун ухааны бясалгал”. Бясалгагч анхаарлаа төвлөрүүлж, аливаа нэгэн юм, эсхүл үйлдлийг бүхэлд нь ажиглана. Ийм нөхцөлд ямар нэгэн мэдрэмж мэдрэгдэхэд түүнийг таалах, эсхүл үл таалах маягаар хүлээж авч үл болно. Түүнийг эргэцүүлэхгүй, түүний тухай бодол санаа хөгжүүлэхгүй зүгээр л ажиглана. Энэ бол зүгээр л анхаарал төвлөрүүлэхээр хязгаарлагдахгүй гэсэн үг. Оюун ухааны бясалгал хийснээр аливаа юм, мэдрэмжийг хуурамч, мөнх бус учир таалж шунах, эсхүл үзэн ядаж дургүйцэх зэрэг аль ч алдааг гаргахгүй байхыг сурна. Энэ нь цаанаа ямар утга учиртай вэ гэдгийг хойно тайлбарлах болно.

Дашрамд хэлэхэд Буддын шашины бясалгалын уламжлал Исламын шашины “Суфизм”-ын бясалгалын уламжлалд, мөн түүгээр дамжин Христийн шашины бясалгалын уламжлал хөгжихөд нөлөөлсөн хэмээн үзэх нь бий. Энэ талаар шашин, шашины төлөөлөгчид, судлаачид нэгдсэн нэг ойлголтонд хүрээгүй ч бясалгалыг томоохон шашин бүр мэддэг, эрхэмлэдэг, хэрэглэдэг гэдэг нь сонирхол татаж байгаа юм.

Ер нь сүүлийн үед шашин хоорондын харилцаа, тэдний нэг нэгэндээ үзүүлж буй нөлөөлөл олны анхаарлыг татаж, зарим үед шүүмжлэл маргаан өрнүүлж байгаа билээ. Ялангуяа 20-р зуунд хүмүүсийн, тэдгээрээр дамжин соёл, шашин хоорондын харилцаа онцгой идэвхжиж, дээр нь мэдээллийн хэрэгсэл асар хурдтай хөгжиж, мэдээллийн урсгал хил хязгаарт захирагдахгүй орон орон, тив тивээр чөлөөтэй нэвтрэх болсон нөхцөлд шашинууд болон шашины зүтгэлтнүүд, сүсэгтнүүдийн хоорондын харилцаа мэдэгдэхүйц идэвхжсэн юм.

Энэ нь нэг нэгнийгээ судлах, нэг нэгнээсээ сурах, нэг нэгэндээ нөлөөлөх эерэг харилцаа үүсэх маягаар ч илэрнэ. Мөн үүний хажуугаар нэг нэгэнтэй сүсэгтнүүдээ булаацалдан өрсөлдөх замаар, нэг нэгнийгээ муулах, улмаар дайсагналцах сөрөг маягаар ч илэрдэг.

Энэ тухай Америкийн алдарт эрдэмтэн Сэмюэль Хантингтон “Соёл иргэншлийн мөргөлдөөн” (Clash of Civilizations) хэмээх 90-ээд оны эхээр хэвлэгдсэн алдарт номондоо өгүүлсэн нь тухайн үедээ багагүй шуугиан дэгдээсэн билээ. Миний бие 1994 онд АНУ-ын Мэдээллийн агентлагийн урилгаар Хавайд байдаг Дорно Өрнө төвд зочилж, соёл иргэншил судлаачидтай уулзаж энэхүү ном, түүнд дэвшүүлсэн болон анхааруулсан санааны тухай ярилцаж байхад тус төвийн эрдэмтэд соёл иргэншлүүдийн хооронд Хантингтоны хэлсэн шиг тийм хурц мөргөлдөөн болохгүй гэж байсныг санаж байна.

Гэтэл ийм сөргөлдөөн мөргөлдөөн сүүлийн үед байнга болж байгаа нь үнэн билээ. Гэхдээ тэдгээрийг голдуу соёл иргэншил хоорондын мөргөлдөөн бус, харин ядуу зүдүү амьдрал, ардчилсан ба ардчилсан бус тогтолцооны нөлөө гэх зэргээр тайлбарлахыг оролддог. Хэдийгээр энэ нь бодууштай тайлбар мөн ч гэсэн соёл иргэншлийн үнэт зүйлсийн ялгаа, нэг нэгнийхээ соёлыг үл мэдэх, үл хүндэтгэх байдал нь зөрчлийн суурь болж, улмаар зөрчлийг улам хурцатгаж, “дарин дээр давс” гэдгийн үлгэрээр тэр бүхнийг өдөөн турхирсаар мөргөлдөөнийг төрүүлдэг тухай Хантингтоны номд өгүүлдэгийг анхаарахаас өөр аргагүй.

Ер нь зөрчил мөргөлдөөн үүсэх шалтаг, шалтгаан олон байдаг. зүйрлэвэл хүний биенд олон төрлийн нян байдаг, гэхдээ хүн ядрах, даарах, халууцах зэрэг хэвийн бус байдалд ороход аль нэгэн төрлийн нян идэвхжиж, улмаар хүн өвддөг. Үүнтэй адил улс үндэстнүүд хоорондоо, эсхүл нэг улс дотор олон үндэстэн хоорондоо эвтэй найртай байдаг ч, газар нутаг, үүх түүх, шашин соёлын ялгаатай байдал, эдийн засгийн тэнцвэргүй нөхцөл зэрэг нь ямар нэгэн гэнэтийн үйл явдал болоход хурцадмал байдлыг үүсгэх аюул заналыг дотроо агуулж байдаг. Тийм учир улс хоорондын болон улс доторх үндэстэн хоорондын харилцааны эмзэг байдлыг аль болохоор хурцатгаж, зөрчил болгож өдөөхгүй байхыг зорьж байх нь чухал. Харамсалтай нь сүүлийн үед санаатай болон санамсаргүй хэлсэн үг, хийсэн үйлдлийн улмаас, мөн соёл шашины (олон шашин сүсэгтнүүдээ булаацалдан нэг нэгнийхээ орон зай руу халдаж тэмцэлдэнэ гэсэн үг.) болон нийгэм-эдийн засгийн (хэт баян ба хэт ядуугийн ялгаа хурдан нэмэгдэж байгаа явдал) ялгаа, зөрүү улам гүнзгийрснээс шалтгаалан нийгэм доторх үндэстнүүд болон давхаргуудын харилцаа сөргөлдөөн, мөргөлдөөний хэлбэр рүү шилжих, хямарч өвдөх явдал үе үе гарч байна.

Ийм нөхцөл байдлыг гол өдөөгчид, хамгийн овжин ашиглагч этгээдүүд нь нэг талаас үндсэрхэх үзэлтнүүд буюу өөрсдийгөө бусдаас дээгүүр тавигчид, нөгөө талаас бусдыг шүтэгчид буюу өөрсдийгөө бусдаас доогуур тавигчид юм. Ер нь үндэсний үзэл, үндсэрхэх үзэл болоход нэг л алхам, бүр сөөмхөн төдий зай байдаг. Харин сонирхолтой нь үндсэрхэх үзэл хоёр туйлширсан байдлаар илэрдэг гэж хэлж болно. Нэг бол өөрийнхөө соёл, эрх ашгийг хэт дөвийлгөж бусдыг басамжлах, эсхүл өөрийнхийг бүр үгүйсгэж, бусдын соёлд бууж өгөх. Тодруулбал, хэт үндсэрхэх үзэлтэн буюу сөргөлдөөн мөргөлдөөнийг өдөөгч нэгэн нэг бол бусдын дээр гарах гэж зүтгэнэ, эсхүл аль хэдийн бусдын дор орчихсон явж байж мэднэ. Аль аль нь буруу бөгөөд энэ хоёр замын алинаар нь ч явсан мухардал, зөрчил сөргөлдөөнд орно. Өөрийгөө хэт дөвийлгөх, бусдыг хэт шүтэх хоёр яахаараа адилхан байдаг билээ гэж асууж болно. Нэг нь нөгөөдхөөсөө том, эсхүл жижиг шашин соёл, үндэстэн ястан гэж байдаггүй тул дээрх хоёр туйлширсан байдал хоёулаа буруу гэж энгийнээр тайлбарлаж болох юм. Тодруулбал, өөрийн соёлыг бусдынхаас дээгүүр тавьж, эрх ашгаа хэт дөвийлгөн бусдад тулгаж, үндэстэн ястнаа аврагч этгээдийн дүрд хувилах нь өөрөө юу ч хийж бүтээгээгүй

мөртлөө өөр хүмүүсийн урьд өмнө хийж бүтээснийг өөртөө хамаатуулж шууд томорно гэсэн үг. Эсхүл бусдын соёл, эрх ашигт бууж өгч, түүнийг шүтсэнээр, тэр соёл, эрх ашгийг илэрхийлэгч болж, түүнд өөрийгөө хамаатуулах замаар бас томорно. Аль аль нь амархан томрох арга, гэхдээ даанч явцгүй. Аль аль нь нэг шашин соёлыг нөгөөгийнх нь дээгүүр тавих гэсэн туйлшрал мөн бөгөөд ингэх нь ойлголцлыг буй болгох бус харин зөрчлийг өдөөсөн оролдлого болно. Уг нь өөрийн соёл, эрх ашгийг бусдын соёл, эрх ашгийн дээр нь ч биш, доор нь ч биш, эн тэнцүүлэн зэрэгцүүлэн тавьж, хооронд нь уялдуулан зохицуулж, тэнцвэртэйгээр гүйцэлдүүлэх нь хамгийн зөв зам болно. Гэхдээ ингэхийн тулд өөрийнхөө болон бусдын соёл, эрх ашгийг судалж мэдэх хэрэгтэй, улмаар хүндэтгэх шаардлагатай. Ийм амьд, эерэг харилцааг бий болгож тогтоон төлөвшүүлэхэд буруугаар ашиглавал шашинууд ихээхэн саад учруулна, харин зөв ухаарвал хамгийн их тус хүргэнэ. Юуны түрүүнд бусдыг биш, эхлээд өөрийгөө ялахын тухай хамгийн ил тод номлодог Буддын шашин үүнд их үүрэг гүйцэтгэх бололцоотой. Магадгүй тийм ч учир өнгөрсөн зуунд Дорнын соёл, шашины уламжлал, түүний дотор Буддын шашин Барууны сэхээтнүүд, соёл урлагийн томоохон зүтгэлтнүүд, эрдэмтдийн дунд ихээхэн сонирхол татаж, дэлгэрсэн байдаг. Эл шашины нэгэн өвөрмөц урсгал, том давалгаа Өрнө, Дорнын соёл, шашины харилцаанд хүчтэй нөлөө үзүүлсэн билээ. Энэ бол та бидний сонирхож буй бясалгал буюу даяан хийх хэмээх ойлголттой үгийн үүсэл гарал, нэр томъёо, үйл ажиллагааны арга хэлбэрээрээ нягт холбоотой “зэн буддизм” юм.

Зэн буддизмын нэгэн алдартай “коан” сургаалийг энд жишээ болгоё. Нэг удаа шавь нь багш дээрээ “Би Буддаг олчихлоо, Бурханы хутагийг олчихлоо” хэмээн хашгирсаар гүйж иржээ. Нэг ёсны багшдаа гайхуулах, амжилтаа хуваалцах, өөрөөрөө бахархахыг бодсон биз. Багш нь хариуд нь “Наад Буддагаа хая” гэжээ. Шавь нь ч дээд зэргийн гайхаж “Буддагаа хая гэнээ? Би ингэж удаан бясалгаж, ийм их хичээл зүтгэл гаргаж олсон Буддаг минь хая гэнэ үү? Ямар сонин багш вэ?” хэмээн багшдаа дургүйцжээ. Тэгээд багшийнхаа хэлснийг үл тоож, өнөөх “олсон Буддагаа” эрхэмлэн өөрийгөө нирваанд хүрсэн хэмээн боджээ. Гэхдээ “зэн буддизм”-ын шашины лам байсан тул багшийнхаа хэлснийг өөрийн эрхгүй бодож эргэцүүлдэг, бас бясалгадаг байлаа. Нэг удаа бясалгаж байгаад “Буддагаа хая” гэж багшийнхаа хэлсний дагуу “Буддагаа хаяж”, сая жинхэнэ ёсоор Бурханы хутагийг олсон байна. Багш нь яагаад “Буддагаа хая” гэж хэлсэн бэ гэвэл шавь нь Буддаг оллоо гээд санаандаа “хиймэл Будда” зохиосныг багш нь олж харсан байна. Хиймэл Будда жинхэнэ бурханы хутагийг олоход нь саад болох учир шавьдаа “Буддагаа хая” гэж хэлжээ. Ер нь Бурханы хутагийг олно гэдэг өөрөө өөртөө зохиож олсон “хиймэл дүрүүд (бурхад)-ийг хаяна” гэсэн үг.

Энэ утгаараа хүмүүс бид сайн, муу хиймэл дүрүүдийг өөрсдөө зохиож, тэднийгээ шүтэж, тэдэндээ итгэж, эсхүл тэднээсээ айж, үзэн ядаж амьдардаг. Өөрөөр хэлбэл тэдэнд ухаан санаагаа мэдүүлж, эрхэнд нь ордог гэсэн үг. Олон хиймэл дүр зохиож, тэднийгээ эрхэнд орох тусам хүн өөртөө болон өнөөдөртөө эзэн болж чаддаггүй. Тийм учир зэн буддизмын багш шиг тэдэнд өөрсдийнхөө зохиосон “хиймэл дүрүүдээ хая” гэж хэлэх хэрэгтэй.

Хүн голдуу нэг юм, хүнийг хэт шунаж хүсэхдээ, эсхүл зовж зүдрэхдээ “хиймэл дүр буюу бурхан” зохиож бүтээдэг. Уг нь хэн нэгнийг шүтлээ гээд тэр хүн хэзээ ч таны шүтэж хүссэн шиг тийм сайн хүн болохгүй, мөн хэт үзэн ядсан хүн чинь ч тийм муу хүн болохгүй. Гэхдээ хиймэл дүрүүд буюу сайн муу бурханууд гэж зөвхөн хүн бус бас байгууллага, үзэгдэл ойлголт ч байж болно.

Хүн бүрт, мөн тухайн улс орны ард түмэнд өөр өөрийн хиймэл дүр олон бий. Ихэнх тохиолдолд хүмүүс, эсхүл ард түмэн хиймэл дүрүүдийг өөрсдөө зохиож, тэднийхээ эрхэнд орж амьдардаг, харамсалтай нь тэгж буйгаа ухаардаггүй. Хиймэл дүрүүд таны амьдралд ихээхэн саад болох тул тэднээс салах хэрэгтэй. Салахдаа заримыг нь засаж, заримыг нь бүүр орхиж сална. Таныг хиймэл дүрүүдтэй байх, тэдэнд итгэж эзэмдүүлсэн, тэднээр бүслүүлсэн, тэдний эрхэнд орсон байхыг намууд, Засгийн газар, хэвлэл мэдээлэл, бүр таны найз нөхөд, дайснууд бүгд хүснэ. Та хэдий чинээ хиймэл дүрд итгэсэн байна, төдийчинээ таны итгэлийг барьж таныг хуурах, төөрөлдүүлэхэд амар болно. Намууд сонгуульд хуурна, Засгийн газар амлалтаа одоо л биелүүлэх гээд байгаа юм шиг хуурна, хэвлэл мэдээлэл худлаа мэдээ түгээсэн мөртлөө танд үнэн хэмээн итгүүлнэ, найз нөхөд чинь ашиглах гэж хуурна, дайснууд чинь таныг буг чөтгөр болгож, бусдад итгүүлж, явах суух газаргүй болгохыг оролдоно.

Өндөр боловсрол, эргэцүүлж бодох чадвар, аливаа үйлдлийг дангаар нь бус бусад үйлдлийн шүтэлцээн дунд олж харах, ойлгох оюун ухаан, өөртөө болон өнөөдөртөө эзэн болох эр зориг танд хиймэл дүрүүдээс салах, эргэн тойрноо харж амьдрахад тус болно. Өөх бол хэтрүүлсэн хоол, залхуу зан хоёроос гаралтай байдаг лугаа адил таны төөрөгдөл буюу хиймэл дүрүүд таны хүсэл шунал, эсхүл үзэн ядалтаас үүдэлтэй.

Тэгвэл бясалгалаас өөр хүсэл шунал, үзэн ядахаас салгах чадвартай эрхэм эрдэм байхгүй гэж хэлж болно.

Одоо Випассанагийн бясалгал чухам ямар бясалгал болохын тухай товч өгүүлэе. Шуудхан хэлэхэд бясалгал хийх амаргүй. Гэхдээ бас л шулуухан хэлэхэд үнэхээр хэрэгтэй. Хэрэгтэй юм хэзээ амархан байлаа? Хүнд хэцүү л байдаг шүү дээ.

Випассана бясалгалд нэг удаа ороход доод тал нь арав хоног сууна. Хорь, гуч хоногийн бясалгалууд байдаг, хамгийн урт нь 90 хоног. Ер нь бясалгал хүний насан туршдаа салшгүй хамт байх ёстой амин чухал зүйл юм. Энэ утгаараа тасралтгүй үйл явц бөгөөд бясалгалаас бясалгалд бид гэгээрэл рүү алхам алхамаар ойртоно гэсэн үг.

Бясалгалын үед ярьж болохгүй, дохио зангаагаар ч харьцаж үл болно. Зөвхөн багшаасаа мэдэхгүй, ойлгохгүй байгаа зүйлээ асууж болно. Цагаан хоол иднэ. Орой цай л ууна. Гар утас, компьютер, ном, сонин бүгдийг тушаана. Санаа бодлыг чинь сарниулахгүйн тулд ийнхүү түр хурааж байгаа юм.

Эхний гурав хоног анхаарлаа төвлөрүүлэх дасгал хийнэ. Амьсгал орж, гарах тэр хэсэг газар буюу хамрын хоёр нүх, дээд уруул дээр анхаарлаа төвлөрүүлнэ. Хүний анхаарал сармагчин лугаа адил тул байнга ийш тийш үсчинэ, нэг л мэдэхэд хаа хамаагүй тэнэж явна. Тэглээ гээд сандрах, гутрах хэрэггүй. Дахин өнөөх газраа анхаарлаа төвлөрүүлнэ. Ингэж гурав хоногийн турш анхаарал төвлөрүүлэх дасгал хийнэ. Дөрөв дэх өдрөөс эхлэн төвлөрүүлсэн анхаарлаа толгойныхоо орой дээрээс хөлийнхөө хуруу хүртэл явуулна. Ингэж байхад биеийн гадаргуун дээр илэрч байгаа мэдрэмжийг ажиглана. Тааламжтай мэдрэмж байж болно, тааламжгүй мэдрэмж ч байж болно. Удаан завилж суухад бие чилж өвдөнө. Тэгсэн ч анхаарлаа төвлөрүүлж зүгээр л ажиглана. Тааламжтайд нь сэтгэл татагдан шунаж, тааламжгүйг нь тээршаан үзэн ядаж үл болно. Тайван амгалан ажиглана.

Зургаа дахь өдрөөс эхлэн анхаарлаа төвлөрүүлж, толгойны оройноос хөлийн үзүүр хүртэл явуулдаг байсан дээрээ нэмээд эргээд хөлийн хурууны үзүүрээс толгойн орой хүртэл явуулдаг болно. Мэдээж хэрэг анхаарал хаа хамаагүй тэнэхийг завдана, эсхүл тэнэнэ. Төвлөрүүлж дээрх дасгалыг үргэлжлүүлэн хийнэ. Мөн л тааламжтай болон тааламжгүй мэдрэмжүүдийг анхаарлаа төвлөрүүлэн шунаж хүсэлгүй, тээршааж үзэн ядалгүй тайван амгалан ажиглана. Гол утга нь ингэж дасгал хийснээр та шунах болон үзэн ядах сэтгэлд автахгүй байх их эрдмийг сурна. Энэ нь үйлийн үрээ нимгэлэх, арилгахтай шууд холбоотой.

Хүн үйлийн үрээсээ салж чадвал Бурханы хутагийг олно гэдэг. Харин үйлийн үр нь шунал тачаал, үзэн ядалтын, мунхаг харанхуйн аль нэгээс, эсхүл аль алинаас нь тэжээгдэнэ.

Хүн өөрөө ч сайн мэдэлгүйгээр өдөр бүр юманд шунаж, эсхүл үзэн ядаж үйлийн үрээ нэмэгдүүлнэ. Тэгэхээр тааламжтай, тааламжгүй мэдрэмжийг тайван амгалан ажиглаж хянаж чаддаг болсноор шунал тачаал болон үзэн ядах сэтгэлд автагдахгүй байж чаддаг болно гэсэн үг. Улмаар үйлийн үрийг тэтгэж зузааруулдаг шуналын болон үзэн ядалтын үндсийг тасална. Үйлийн үр өөх лүгээ адил бөгөөд хүсэх шунах болон зэвүүцэн үзэн ядах хэмээх хоолноосоо салвал нэмэгдэхээ болино, улмаар багассаар арилна. Ийм нарийн бясалгалын цогц аргыг Бурхан багш сэргээж, та бидэнд өвлүүлэн үлдээсэн байна. Энэ бясалгалын арга Бирмад хадгалагдан үлдэж, У Ба Кин хэмээх багшаас Гоенка багш сурч, одоо Випассана бясалгалын төвүүдийг олноор байгуулж олон мянган хүнд бясалгалыг үнэ төлбөргүй зааж буян үйлдэж байна.

Товчхон тайлбарлахад ердөө л энэ. Гэхдээ тайлбарлахад амархан. Хийхэд хэцүү. Харин хэцүү гээд байлгүй бясалгал хийж байж л үйлийн үрээсээ сална шүү дээ. Миний мэдэрч ойлгосноор бясалгал хийхэд хүний оюун ухаан гэхээс илүү далд ухамсар буюу оросоор “подсознание”, англиар “subconscious” ажилладаг. Бясалгал шинжлэх ухааны үндэстэй. Тэр утгаараа бясалгал нь алдарт Фрейдийн онолтой ихээхэн ойрхон гэж хэлбэл хэтрүүлсэн болохгүй биз ээ.

20-р зууны эхэнд Фрейд хэмээх сэтгэл зүйч хүний сэтгэлийг судалж шинэ онол гаргасан нь сэтгэл зүйн хөгжлийг ихээхэн хурдасгасан билээ. Фрейдийн онолыг хялбаршуулвал хүнд оюун ухаанаас гадна далд ухамсар гэж байдаг бөгөөд тэнд хүний бага балчир наснаасаа туулж өнгөрүүлсэн амьдралын айдас, баясал, бусад дурсамж хадгалагддаг. Тэр бүхний нийлбэр нь үйлийн үр ч гэж хэлж болно. Хүн насан туршдаа далд ухамсарт буй сайн, муу дурсамжаа хүчээр дарна, нууна, мартана, эсхүл мартахыг хичээнэ. Гэхдээ тэр хүчээр дарагдсан айдас хүйдэс, баяр баясгалан үе үе гарч ирэн хүний ухамсар, оюун ухаанд хүчтэй нөлөөлнө. Далд ухамсар, хүний төлөвшил, амьдрал, сэтгэл санааны өөрчлөлтөнд хүчтэй нөлөөлдөг тул түүнийг судалж, хүний сэтгэл санааг засаж хэвийн байдалд оруулна, хадгална.

Тэгвэл бясалгал бас л хүний далд ухамсрыг нээж, тэнд хуримтлагдсан үйлийн үрийг нимгэлж, улмаар арилгана. Далд ухамсарт нууцлагдсан юмс эмх замбараагүй байдаг. Үлгэрлэвэл нэг өрөөнд эд бараа, ном судар, хоол унд, хог новш гээд бүх юм зэрэг байна гэсэн үг. Бясалгал нь эхлээд тэр бүхнийг цэгцэлнэ, дараа нь цэвэрлэнэ.

Бясалгал хийснээр та шуналын сэтгэлээ дарж, үзэн ядалтанд автахаа болино. Аливаа юм, үзэгдлийг бодитойгоор харах чадвартай болно. Өөртөө эзэн болж байна гэсэн үг. Мөн

өнгөрсний болон ирээдүйн хиймэл дүрүүдэд татагдаж, тэдний эрхэнд орохоо болино өнөөдөртөө эзэн болно.

Энэтхэгийн алдарт гуру Ошогийн зэн буддизмын тухай эргэцүүлэхдээ өнөөдрийн тухай болон өөртөө эзэн болох тухай хэлснийг саная. Тэрээр зэн буддизм бол өнгөрсний тухай эсхүл ирээдүйн тухайн сургаал биш хэмээн үздэг байсан. Харин өнөөгийн буюу одоо цагийн тухай цогц сургаал юм. Өнөөдөр буюу одоо цаг хэзээ эхэлж, хэзээ дуусч буйг хэн ч баттай хэлж үл чадна. Өчигдөр буюу өнгөрсөн хэзээ дууссаныг, эсхүл маргааш буюу ирээдүй хэзээнээс эхлэх гэж буйг баримжаалж болно. Харин одоо цаг чухам яг хэзээ эхэлж, хэзээ дуусч буйг хэлэхэд хэцүү. Хэзээ ч дуусахгүй байгаа мэт санагдана. Тэр утгаараа одоо цаг бол үнэн хэрэг дээрээ мөнх үргэлжилнэ. Чухамхүү үүний тухай л зэн буддизм номлодог. Өөрөөр хэлбэл зэн буддизм бол өнгөрсний, эсхүл ирээдүйн тухай сургаал номлол биш, харин өнөөдөр буюу яг одоо цагийн тухай, тэр утгаараа хэзээ ч дуусдаггүй мөнхийн тухай цогц сургаал мөн билээ.

Өнгөрсөн цаг хугацаа, эсхүл ирээдүйн тухай ойлголт төсөөлөл нь хиймэл дүрүүдийг буй болгоно, бид тэднээс айж эмээж, эсхүл тэднийг шүтэж, тэдгээрт шунаж амьдарна. Тэдний эрхшээлд орно. Өөрөө хэн ч биш болно. Өнөөдөр маань, одоо хэмээх үнэт цаг хугацаа юу ч биш мэт санагдана. Ингэснээр мөнх юм, нирвааны тухай хэзээ ч ухаарахгүй. Зэн буддизмд өнөөдрийг мөнх болгохдоо бясалгал хийж байж л болгохын тухай номлодог. Ингэсний ачаар та өөрөө өөртөө эзэн болно, өнөөдөртөө буюу одоодоо эзэн болно. Хэн ч таны бие, сэтгэлийг эзэмдэж чадахаа болино. Хиймэл дүрүүдээсээ салж, тэдний эрхшээлээс гарна. Чухамхүү тийм учраас би бясалгал хийх хэрэгтэй гэж хэлж байгаа юм. Гэхдээ энэ бол хэцүү зүтгэл. Амьдрал сонин шүү дээ. Муухай юм хийхэд амархан, аяндаа болчихдог, хялбаршуулан хэлбэл юу ч хийхгүй байхад муу юм аяндаа болчихдог.

Харин сайн юманд садаа мундахгүй. Сайн юмыг заавал зүтгэж байж бүтээнэ. Сайн юм аяндаа болдоггүй. Тийм ч учраас сайн юм хийхийг зорьдог, тэгэхийн тулд бусдыг бус, хамгийн түрүүнд өөрийгөө засахыг шаарддаг юм. Зүгээр суувал муу юм хийнэ гэсэн үг. Сайн юмыг хийж бүтээнэ гэвэл заавал хичээл зүтгэл гаргах хэрэгтэй хэмээн номлодог. Буддын шашин хамгийн идэвхтэй, хамгийн шинжлэх ухаанч шашин гэж хэлэх нь зөв буйзаа. Бясалгалтай холбогдуулж мухар сүжиг, сайн багшийн тухай зарим санаа бодол төрснөө хуваалцаа. Өнөөдөр хүмүүс амиа бодож, өөрийнхөө сайн муу хэрэг зоригийг бүтээхийн тулд юу ч хийж болно хэмээн боддог, тийм бодлоо гүйцэлдүүлэхийн тулд ямар ч хэрэг хийхээсээ үл айдаг болсныг прагматик хандлага гэж зөвтгөж тайлбарладаг билээ. Энэ нь үнэн хэрэг дээрээ нөгөөх л үйлийн үр хэмээх гинж гавлыг улам урт, бат бэх болгож байна гэсэн үг. Олон хүн шашинд сайнаар яривал их прагматик, муугаар яривал явцуу эрх ашигтаа нийцүүлж ханддаг болжээ. Муу муухай юм хийчихээд алдаагаа өөрөө засахын оронд түүнийгээ өөр хүнээр цайруулахын тулд нэг лам дээр очиж, хандив өгч ном уншуулан, засал хийлгэнэ. Бүр байтлаа хараал хийлгүүлнэ. Тэгээд бас болчихлоо гэж бодно. Лам нар маань энэ хүсэлд нь хөтлөгдөн хандивыг нь авч, туслах гэж оролдоно. Тэр байтугай ном уншуулахад тусгай тариф тогтоож үйлчилнэ. Өөр хүнээр ном уншуулснаар тухайн хүний нүгэл алга болж, үйлийн үр нь арилдагсан бол өнөөдөр та бид огт нүгэлгүй ертөнц, улс орон, гэр бүлд амьдрах байсан бизээ. Хүн үйлийн үрээ чухамхүү өөрөө л хүсвэл, хүсээд зогсохгүй зүтгэвэл арилгана. Хүсэхгүй бол эсхүл хүсээд байгаа мөртлөө зүтгэхгүй бол үл арилна.

Бясалгал хийнэ гэдэг хүн өөрөө нүглээ арилгаж, үйлийн үрээ устгахын тулд зүтгэж байгаа цогц үйл ажиллагаа. Хийхэд хэцүү, гэхдээ зайлшгүй хэрэгтэй. Сайн юм амархан бүтдэггүй.

Нөгөө талаар хүн хэлэхээс нааш ухаарахгүй, цаас чичихээс нааш цоорохгүй гэж ярьдаг. Сайн багш таарвал том аз. Миний бие 1982 онд шавь орсон анхны багшаа халуун дотноор дурсаж явдаг. Сайн багшийг ялгаж таньдаг байхад тус болох болов уу хэмээн миний учирсан багш, ариун явалднуудын заримыг нь дурсъя. Монгол улсад Энэтхэгийн элчин сайдаар ажиллаж байсан Кушок Бакула Ринбүүчий, Христийн шашины алдарт гэлэнмаа Тереза эх, Випассана бясалгалын их багш Гоенка нарын тухайн хэдэн үг хэлье. Сайн багш өөрийгөө шүтүүлэх дургүй байдаг. Миний санахад Бакула Ринбүүчий хэзээ ч өөрийгөө шүтүүлэхийг эрхэмлэж байгаагүй. Харин дэндүү энгийн гэмээр юм уу байдаг байж билээ. Том хүн энгийн байсан ч томоороо, жижиг хүн хичнээн сүртэй дүр эсгэвч жижгээрээ л үлдэнэ.

Би 1992 онд Энэтхэгийн Калькутта хотод очихдоо аз болж алдарт Тереза эхтэй уулзаж билээ. Уулзах хүсэлт тавихад саяхан өөрөө өвдөөд боссон ч Хатанбаатар эмч бид нарыг уриалгахан хүлээж авсан. Жижигхэн биетэй, агуу энэрэнгүй сэтгэлтэй, зөөлөн гартай, хүнийг нэвг шувт хардаг хурц нүдтэй, үргэлж инээмсэглэсэн нигуур царайтай Тереза эхтэй уулзаж ярихад ертөнцийн хамгийн энгийн хүнтэй учирсан мэт сэтгэгдэл төрсөн. Дэргэд нь байсан гэлэнмаа нарын гаднах төрх байдлыг харахад бараг бүгдээрээ Тереза эхээс илүү том, чухал дарга нар шиг харагдаж байж билээ. Харин Тереза эхийн зургийг өмнө нь харсан учир түүнийг амархан таньсан. Хамгийн энгийн яриа өрнүүлсэн ч амьдралын хамгийн хүнд хэцүү асуултуудад хариу авсан юм шиг санагдсан.

Энэ зун Энэтхэгийн Мумбай хотод Випассана бясалгалд суусны дараа бясалгалын багш Ширэндэв нарын хамт Гоенкатай багштай уулзсан. Гоенка багшийн зургийг өмнө нь үзэж хараагүй байсан бол зүгээр нэг тэтгэврийн өвгөн байна гэж бодно. Би Гоенка багшид хандан ажигласнаа наргиан болгож “ Энэтхэгийн гуру буюу их багш нар голдуу урт үстэй, том сахалтай, ширүүн харцтай, нүүрэндээ оо энгэсэг тавьсан, сүрдмээр нэртэй байдаг. Тэгтэл та жирийн халимагтай, сахалгүй, нигуурандаа будаггүй, зөөлөн харцтай, жирийн нэртэй байх юм” гэж хэлэхэд инээж “Нээрэн тийм шүү. Анх Бирмаас Энэтхэгт ирж Випассана бясалгал зааж эхлэхэд хүмүүс та үсээ ургуул, сахал тавь, нэрээ соль, манай Энэтхэгт гуру буюу их багш нар гаднаа тийм дүр төрхтэй байвал түүнийг шүтэж, олон хүн шавь ордог юм гэж хэлж зөвлөж байсан. Тэгэхэд хариуд нь Би өөрийгөө шүтүүлэх гээгүй. Харин Бурхан Буддагийн та бидэнд захиж үлдээсэн Випассана бясалгалын техникийг зааж өгөх зорилготой. Энэ бясалгалыг хийхэд урт үс, том сахал, сүржин нэр, ширүүн харц хэрэггүй. Намайг шүтэх хэрэггүй. Ер нь хүн шүтэх гэдэг өөрөө өөртөө эзэн болохгүй байна. Бясалгалыг ёсоор нь хийж чадахгүй байна гэсэн үг” гэж хэлж байсан. Түүнээс хойш олон арван жил өнгөрчээ. Одоо хүртэл том сахалгүй, урт үсгүй, сүртэй нэргүй л байна, болж л байна.

Випассана бясалгалыг олон арван мянган хүн сурч, үйлийн үрээ арилгахын тулд хичээл зүтгэл гаргаж байна. Олон арван оронд дэлгэрч байна гэсэн юм. Нээрээ ч Випассана бясалгалын буюу аливааг бодитоор харах чадварыг хөгжүүлдэг бясалгалын багш хэмээх хиймэл дүр бүтээх шаардлагагүй нь ойлгомжтой. Сайн багшийн шинж бол энгийн байх чадвар. Мөн өөрийгөө шүтүүлэхийг үл зорино. Мөн сайн багшийн эрхэм шинж бол яг хэлснээрээ байх чадвар. Бакула Ринбүүчий, Тереза эх, Гоенка багш аль аль нь бусдад зааж

сургаснаараа байж чаддаг. Тийм учир бага ярьдаг ч байж болно. Үг, санаа, үйл гурав нь нэг цул байж ийнхүү байдаг бизээ. Та бид уран донгоддог мөртлөө явдал нь задгай, ярьсандаа хүрдэггүй олон хүнийг мэднэ дээ. Бид өөрсдөө ч бас тиймэрхүү улс мөн гэвэл хэтрүүлсэн болохгүй.

Үгээрээ бус үйлээрээ үлгэр жишээ болно гэдэг жинхэнэ сайн багшийн чадвар. Үгээр сургах үнэхээр амархан. Тийм багш нар, албан тушаалтнууд бараг өдөр бүр телевизээр гарч байна. Харин үг, үйл нь нийлдэг, үйлээрээ үлгэр жишээ болох нь туйлын хэцүү тул тийм багш ховор таардаг. Тийм багштай учирсан хүн өөрийгөө азтайд тооцож болно. Ингээд Випассана бясалгал буюу аливааг бодитойгоор олж харах чадвар суулгадаг бясалгалын тухай санал бодлоо хуваалцлаа. Бясалгал хийнэ гэдэг мундаг болно гэсэн үг биш. Бурханы хутагийг олчихсон гэсэн ч үг биш. Гэхдээ ямар ч байсан бусдын эрхшээлд орохгүйгээр, өөртөө, өнөөдөртөө эзэн болж амьдрахыг зорино гэсэн үг. Бүгдээрээ ядахдаа тийм зорилготой болцгооё.

Бясалгал буюу түүний зарчмууд хамгийн түрүүн манай өнөөгийн өөрсдийгөө нүгэлгүй гээд байгаа төр засаг, өндөр албан тушаалтнуудад хэрэгтэй, бас тэдэнд шууд хамаатай. Тэд эргэн тойрноо, байгаль орчноо, улс орноо, ард түмнийхээ амьдралыг бодитойгоор олж харж сурах хэрэгтэй. Нүгэлтэй хэмээн тэдний үздэг ард түмнийхээ, сэхээтнүүд, эрдэмтдийнхээ дуу хоолойг битгий боймло, харин жаргалынх нь хуурамч биш, зовлонгийнх нь үнэн дууг сонсдог бол. Сэтгэлийн чих буюу “совесть”-той болцгоох хэрэгтэй. Энгийн даруу бай. Эрх тушаалаа ашиглаж, өөрсдөдөө зориулж эд хөрөнгө хуваарилах аливаа ажиллагаагаа таслан зогсоох хэрэгтэй.

Энэ бүхнийг хийхэд хэцүү. Гэхдээ хийхгүй бол шударга нийгэм тогтохгүй, улс орон хөгжихгүй, ард түмэн жаргахгүй. Хэцүү ч гэсэн хийхээс өөр арга байхгүй. Эс хийвээс хийх чин хүсэл эрмэлзэлтэй, эрдэм чадалтай, бас эр зориг, зүрх сэтгэлтэй нь ард түмнийхээ шаардлага, дэмжлэгээр хэзээ нэгэн цагт зайлшгүй хийх болно. Эдгээр алдаа завхралыг аль болохоор эрт таслан зогсоох тусмаа хаа хаанаа гарз хохирол багатай байна. Удах тусам хор хохирол нь нэмэгдэж улам их болно. Бодитой үнэн ийм байна.



Чанадаас халих бясалгалын төвийн тэргүүн Г.БАТ-ЭРДЭНЭ:

Хүний физиологи бол веда болон ведын утга зохиолын илэрхийлэл

Манай Чанадаас халих бясалгалын багш нар бясалгагч нартаа л шинжлэх ухааны эриний энэ гайхамшигтай нээлтийн тухай ярилцдаг, энэ тухай лекц ордог байсан. Анх удаа гадагшаа лекц тавихдаа “Эртэч монгол” уулзалтанд уригдсандаа баяртай байна.

“Хүний физиологи бол веда ба ведын утга зохиолын илэрхийлэл мөн” гэсэн гайхамшигтай нээлтийг зууны зааг дээр физиологич эрдэмтэн Тони Нейдер хийсэн билээ. Энэ хүн физиологийн ухааны докторын зэргийг энэ ажлаараа хамгаалсан.

Чанадаас халих бясалгал маань маш энгийн, сурахад их амархан, байгалийн жам ёсны бясалгал байгаа. Чанадаас халих бясалгалыг сурахад хүний оюун ухаан тэлж, хурц тунгалаг болж, бүтээлч оюун нь сэргэж ирдэг. Хүний эрүүл мэнд сайжирдаг. Тэр байтугай хүний биеэ авч явах байдал, ёс суртахуун ч сайжирдаг. Орчин тойрондоо дулаан сайхан уур амьсгал бий болгодог ийм гайхамшигтай энгийн техник байгаа. Энэ техникийг сураад оюун ухаан нь хөгжиж байгаа гайхамшигтай хүмүүс Махариши багшийн удирдлага дор энэ нээлтийг хийсэн байдаг. Юуны өмнө энэ нээлтийг ярихын тулд орчлон ертөнц маань ямар зохион байгуулалттай вэ гэдгийг товчхон дурдмаар байна.

Амьдрал гэж юу вэ, амьдралын зорилго юу вэ гэсэн асуултыг хүн болгон өөрийн эрхгүй эрт орой хэзээ нэгэн цагт өөртөө тавьдаг билээ. Тэгвэл амьдрал маань өөрөө ямар зохион байгуулалттай юм бэ, юу юм бэ гэдгийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гаргаж ирсэн байдаг. Мөн ведын ухаанаар үүнийг баталгаажуулан орчин үеийн шинжлэх ухаан, эртний ведын ухаан хоёрыг хослуулан нэгтгэж Махариши багш маань “Бүтээлч оюуны ухаан”-ыг үндэслэсэн ухамсрын ухааны суут багш билээ.

Физикийн шинжлэх ухаан хөгжлийн явцад саяхан хүртэл матери анхдагч гэж үздэг байсан. Барьж байгаа, тэмтэрч байгаа, хүртэж байгаа бүх юм бодитой, бусад нь байхгүй учраас бодитой биш гэдэг учраас материаллаг амьдралыг эрхэмлэн нилээн удаан жил хөгжиж ирсэн түүхтэй. Шинжлэх ухаан илүү хөгжихийн хэрээр микроскоп бий болж нүдэнд үзэгддэггүй илүү нарийн зүйлийг хардаг болсон, юм бүхэн атом молекулаас тогтдог юм байна гэдгийг тогтоосон билээ. Ингээд илүү нарийн хэсэг байдаг юм байна, түүний цөм нь атом, атом бол задрашгүй гэсэн үзэл бас нилээд удаан хугацаанд ноёрхсон. Ингээд сонгодог физик сүүлийн 400-аад жил эрчимтэй хөгжин оргилдоо хүрэн, атомыг цааш нь задлаад энэ атом гэдэг чинь өөрөө эгэл бөөмсөөс тогтдог юм байна, электрон, нейтрон, протоноос бүрддэг юм байна гэдгийг тогтоосон. Улмаар сонгодог физикийн хууль маань эгэл бөөмсийн нарийн түвшинд

үйлчилдэггүй, энэ түвшинд өөр хууль журам үйлчилдэг болохыг тогтоосон байдаг. Сонгодог физикийн Термодинамикийн хууль, Ньютоны хууль энд үйлчлэхгүй байлаа. Энд шал ондоо хууль үйлчилдэг болохыг тогтоосон. Илүү нарийн түвшин-Планкийн шаталбарын түвшнийг судлан Квантын механик гэж нэрлэсэн бүхэл бүтэн шинэ онол гарч ирсэн билээ. Квантын механикийн онол сүүлийн 30, 40-өөд жилд үсрэнгүй хөгжин, нано технологиуд гарч ирээд байна.

Ийнхүү орчин үеийн шинжлэх ухаан нь байгаль ертөнц бол янз бүрийн энергийн түвшнээс тогтсон үе давхаргуудтай болохыг нээсэн байдаг.

Квантын механикийг судалж байгаад байгалийн бүх хууль, хүчнүүд нь суурь 4 хүчнээс буюу Цахилгаан соронзон орон, сул үйлчлэлийн орон, хүчтэй үйлчлэлийн орон, хүндийн хүчний орноос бүрддэг гэдгийг физикчид тогтоосон. Үүнийг дахиад судлахад цахилгаан соронзон орон маань сул үйлчлэлийн оронтой нэгдэн нэгэн нэгдмэл орон үүсгэжээ. Тэр нь хүчтэй үйлчлэлийн оронтой нэгдэн суурь нэгдэл болоод хамгийн сүүлд хүндийн хүчний оронтой нэгдэхэд бүх юм түүн дотор алга болсон байдаг. Ингээд физикчид онолын хувьд орчлон ертөнцийн суурь нь нэгэн нэгдмэл бүрэн бүтэн зүйл байдаг болохыг тогтоосон байна. Түүнийг шинжлэх ухаанд “Нэгдмэл Орон” гэж нэрлэсэн байдаг. Монголчууд бид үүнийг “Хоосон чанар”, “Үлэмжийн чанар” гэж нэрлэж, мэддэг гүн баялаг мэдлэгтэй ард түмэн билээ.

Бидний амьдарч байгаа амьдрал маань илэрхийлэгдсэн нэг хэсэг, илэрхийлэгдээгүй байгаа чанадын нөгөө хэсэг гэсэн хоёр зүйлээс бүрддэг юм байна. Илэрхийлэгдсэн хэсэг нь янз бүрийн энергийн түвшин, янз бүрийн илэрхийллийн түвшнээс тогтоно. Түвшин нарийсах тусам энерги нь улам ихсэж байдгийг бид нар мэднэ. Илэрхийлэгдээгүй түвшин маань бүх орчлон ертөнцийн хязгааргүй өөрчлөгдөж байгаа олон талт энэ бүх үзэгдэл, юмсыг бий болгон суурьд нь байдаг огт өөрчлөгддөггүй, өнө мөнхийн орон байдаг. Ялангуяа сүүлийн 30, 40 жилд шинжлэх ухаан маань өөрийнхөө оргилд хүрч, үүнийг шинжлэх ухааны түвшинд олж тогтоочихоод байна.

Тэгвэл хүмүүс бид амьдралынхаа энэ хугацааг зөвхөн идэвхитэй, өөрийнхөө ухамсарт ухааныхаа түвшинд, хамгийн гадаргуун өнгөц, бүдүүлэг гэж хэлж болох түвшинд л юмыг бодон сэтгэж үйлдэж байдаг байна. Ухамсарлахгүй байгаа, ашиглахгүй байгаа уураг тархиныхаа нөөцийг бид далд ухамсар гэж нэрлэдэг. Бүр чанадын хэсгийг нь хоосны чанар гэх мэтээр янз бүрээр нэрлэж байгаа. Сүнс, жинхэнэ бие, хоосны чанар зэргээр яаж нэрлэх нь хамаагүй. Ерөөсөө л нэгэн орон, нэгэн зүйл энд байдаг. Чанадаас халих бясалгалаар бид нар юу хийдэг вэ гэхээр ухамсарт ухааныхаа энэ гадаргуун түвшнээс энэхүү тодорхой их амархан оюуны арга техникийн тусламжтайгаар ухаанаа дотогш нь чиглүүлдэг. Ингээд бидний ухаан маш гүнзгий дотогшоогоо шумбан орж, бодлын гадаргуун түвшнээс бодлын илүү нарийн түвшнийг туулан туулсаар бодлынхоо хамгийн нарийн түвшнийг туулан бодлын чанадаас халин бүх бодол урган гарч байдаг бодлын эх үүсвэрт хүрдэг. Үүнийг чанадын ухамсар буюу цэвэр ухамсар гэж нэрлэдэг.

Чанадаас халих бясалгалаар хүрч байгаа энэ бүх хувь хүний туршлага мэдрэмж нь орчин үеийн шинжлэх ухаанаар баталгаажсан. Чанадаас халих бясалгал хийдэг хүмүүс цэвэр ухамсар буюу нэгдмэл орны түвшнийг хүртэл туулж дотоод хязгааргүй нөөц бололцоогоо

байгалийн жам ёсоор өөр дотроо сэргээж байдаг. Өөрөөр хэлбэл бид энэ дэлхийд хүн болж төрөхөд бидэнд угаас заяасан сансарлаг мөн чанар маань, бодлын чанадад, бодлын эх үүсвэрт оршдог энэ зүйлийг маань физикийн шинжлэх ухаан нэгдмэл орон гэж тогтоочихсон гэсэн үг.

Ийнхүү Чанадаас халих бясалгал маань хамгийн шулуун, хамгийн богинохон, хамгийн энгийн аргаар өөрийнхөө хязгааргүй мөн чанарыг өөртөө сэргээж өгдөг энгийн техник болохыг ойлголоо. Тийм ч учраас маш их судлагдсан, бодитой, оюун ухааны техник учраас маш их үр дүнтэй байдаг. Үр дүн гарч байгаа учраас шинжлэх ухаанаар судлах боломжтой байдаг. Чанадаас халих бясалгалын ач тус, үр нөлөө нь дэлхийн 300 гаруй их дээд сургууль, хүрээлэнд хийсэн 600 гаруй судалгаагаар судлагдан баталгаажсан байдаг. Чанадаас халих бясалгал нь хүний оюун ухааныг бүх талаар хөгжүүлдэг, хүний ухааныг хурцалдаг, хүний сэтгэн бодох чадварыг сайжруулдаг, оюун ухааныг тэлж тархины бүрэн үйл ажиллагааг нээж болдог гэх зэргийг эдгээр судалгаагаар тогтоочихоод байна. Мөн хүнийг залуужуулдаг, эрүүлжүүлдэг, бүх талаар хөгжүүлдэг. Өөрөөр хэлбэл мод ургамлыг ургуулахын тулд үндсийг нь усалдагтай адил хүмүүс бид ч өөрсдийгөө хөгжүүлэхийн тулд бүх үйлдлийн эх үүсвэр болсон сэтгэн бодох чадвараа тэтгэдэг. Сэтгэн бодох хүч хаана байдаг вэ гэвэл бидний өөрийн дотоод, жинхэнэ БИ-д байдаг гэдэг. Эртний Ведын ухаан ийнхүү орчин үеийн шинжлэх ухаанаар баталгаажсан, энэ ухааныг Махариши багш “Бүтээлч оюуны ухаан” гэж нэрлэсэн.

Веда бол байгалийн хуулийн бүрэн мэдлэг юм. Энэ бүрэн мэдлэг нь чанадад, ухамсарт оршиж байдаг. Бид чанадаас халих бясалгалаар бодлын нарийн түвшнүүдийг туулан туулсаар бодлын чанадаас гаран бодлынхоо эх үүсвэртээ хүрдэг. Энэ цэвэр ухамсарт

бүрэн мэдлэг, байгалийн бүх хуулиуд оршин байдаг болохыг орчин үеийн шинжлэх ухаан тогтоосон болохыг дээр дурдсан билээ. Тэгэхээр хүний ухамсар хэр зэрэг хөгжсөн байна, ямар түвшинд байна гэдгээсээ хамааран хүний мэдлэгийн цар хүрээ илэрхийлэгдэж байдаг юм байна. Тийм ч учраас хүмүүс сайн сайханд, гэгээрэл өөд тэмүүлж байдаг. Ингээд ухамсарт бүрэн мэдлэг суурилдаг юм байна, ухамсарт бүрэн мэдлэг бүтэцвэржин оршин байдаг тухай бид ярилцлаа.

Хүн тархиныхаа боломж чадавхийн багахан хувийг буюу 3-5%-ийг л ашигладаг болохыг сэтгэл судлаачид тогтоосон байдаг. Энэ нь бидний ухамсарт ухаан буюу сэтгэхүйн их орны гадаргууны энэ өнгөц түвшинд, далайтай жишвэл далайн давалгаа мэт эсвэл оволзож байдаг, эсвэл тайван байж янз бүрээр өөрчлөгдөн хувьсаж байдаг. Орчин үеийн шинжлэх ухаантай зүйрлэх юм бол энэ маань нөгөө материаллаг түвшин билээ. Жишээ нь бид нүдээ нээгээд аливааг хардаг. Харж байгаа хараагаа 100% гэж бодвол нэг нүдээ тас анин, өрөөсөн нүдээ онийлгож байгаад 5%-ийн завсар үлдээгээд харж байгаатай адил ингэж бид орчин тойрноо хүлээн авдаг гэж хэлж болно. Тэгэхээр бид ямар өрөвдөлтэй амьдарч байна вэ? Гэтэл хүн болгонд 100% сэтгэх энэ нөөц бололцоог байгалиас олгосон байдаг. Яагаад үүнийгээ ашигладаггүй юм бэ, энэ ямар учиртай юм бэ гэдэг тухай бид ер нь боддоггүй. 3-5%-аараа сэтгэсэн мөртлөө юу нь зөв, юу нь буруу гэдэг дээр л маргаад байдаг болохоос биш яагаад би амьдралыг гуравхан хувиар харж байна гэдгээ боддоггүй. Тэгэхээр Чанадаас халих бясалгал нь энэ 3-5%-аар сэтгэж байгаа энэ гадаргуун өнгөц хэсгээс, таван мэдрэхүйгээр гадагш чиглэсэн байгаа ухааныг маш энгийн амархан арга техник ашиглан дотогш нь чиглүүлдэг.

Гэхдээ ухааны өөрийнх нь байгалийн жам ёсоор нь шүү. Тэгээд дотогшоогоо шумбаад орохоороо ухаан маань энэ бүх цар хүрээг туулан тэлж ирдэг. Ингээд бид физикийн шинжлэх ухааныг хүний чадавхитай жишиж яривал гадаргуун материаллаг түвшин болох хэл ярианы түвшнээс атом молекулын түвшин болох сэтгэн бодох түвшнээ туулан, цаашлаад квантын механикийн түвшин болох зөн билгийнхээ түвшнийг туулан бүх бодол санааны эх үүсвэрээс халин гарч, бүх орчлон ертөнцийн хязгааргүй нэгдмэл орон болсон цэвэр ухамсрынхаа түвшнийг туулдаг.

Чанадаас халих бясалгал хийснээр амьдралын янз бүрийн түвшний илэрхийлэгдсэн бүх хүрээг, мөн түүний эх үүсвэр болсон илэрхийлэгдээгүй хүрээг зүгээр л өөрийнхөө дотор сэргээгээд өгчихдөг. Ингээд ирэхээрээ хүн хүний байгалийн бүх хууль оршин байгаа, өөрийн чинь бүх авьяас чадвар оршин байгаа, бүтээлч оюун оршин байгаа түүнийгээ өөрийнхөө дотор сэргээгээд өгдөг. Энэ нь бодь мөрийн зэрэг дээр туссан байдаг, энэ маань гэгээнтнүүдийн сайн сайхан яриад байгаа жинхэнэ БИ гэдэг тодорхойлолтонд бүгдээрээ байдаг. Энэ тодорхойлолтууд бүгдээрээ ижилхэн нэг л зүйлийн тухай байдаг ч хэрхэн түүндээ хүрэх вэ гэдэг аргууд нь л ондоо байдаг.

Веда, Ведын утга зохиол нь 4 Веда болон 36 Ведын утга зохиолоос тогтдог. Веда гэдэг нь бүрэн мэдлэгийг, Ведын гэдэг нь Ведатай холбоотой зүйлийг хэлдэг. Веда гэж ярихдаа Махариши багш маш сайхан тайлбар өгсөн байдаг: “Ямарваа нэгэн зүйлийн хамгийн эхнийхэд нь бүх л юм нь оршиж байдаг юм аа.” гэж. Энэ бол ведын өөрийнх нь зохион байгуулалт, бүтэц. Бүх цагаан толгой А үсгээр эхэлдэг. Яагаад А үсгээр эхэлдэг юм бэ гэдгийг ерөөсөө тайлбарладаггүй байсан. Хамгийн эхний Ведын (Рк Веда) хамгийн эхний үсэг нь “А” үсэг байдаг. “А” нь юу юм бэ гэхээр бидний дотоод цэвэр ухамсар өөрөө маш аниргүй тайван, сэргэг соргог, эрч хүчтэй жинхэнэ БИ маань, Аатмаа маань гадагш илэрхийлэгдэн бидний дотроос урсан гарч байгаа байдлын илэрхийлэл юм. “А-ааа” гэж хэлэхэд бидний дотоод мөн чанар жинхэнэ БИ маань гадагшаагаа ямар ч саадгүйгээр урсан гарч байгаа явц юм. Энэ бол цэвэр ухамсар - байгалийн бүх хууль оршин байдаг Нэгдмэл Орон маань гадагшаагаа урсан гарч байгаа үйл явц гэсэн үг. Харин хамгийн эхний Веда болох Рк Ведын эхний “Р-ррр” гэсэн үсгийг хэлэхэд динамизм, үелзлийг мэдэрч байдаг. “Р-ррррр” гэж хэлэхэд үелзсэн хөдөлгөөн багассаар багассаар аниргүй, туйлдаа хүрч хөдөлгөөнгүй болж байна.

Бид үйлдэхийн тулд эхлээд боддог. Сэтгэн бодох чадвар хэр зэрэг сайн байгаа нь бид өөрсдийгөө хэр зэрэг хөгжсөн бэ, хязгааргүй, сансарлаг мөн чанараа хэр зэрэг сэргээсэн бэ гэдгийн хэмжүүр болдог. Өөрөөр хэлбэл ухамсарт бүрэн мэдлэг маань суурилж байдаг. Үйлдэл хийхийн тулд өөрийнхөө мөн чанарыг өөр дотроо сэргээж бий болгох хэрэгтэй. Үйлдэл хийхийн тулд ухаанаа өөрийнх нь эх үүсвэр хүртэл татах хэрэгтэй. Энэ бол Рк Веда, Ведын хамгийн эхний Ведын нэр. Өөрийнхөө цэвэр ухамсар, цэвэр мөн чанарыг дотроо сэргээгээд дараа нь үйлдэл хийх юм бол хамгийн богинохон хугацаанд хамгийн үр дүнтэй шийдвэрийг зөнгөөрөө, аяндаа гаргадаг. Яг нум сум харвах урлаг адил. Бид өөрийнхөө дотор 100% сэтгэх нөөц бололцоогоо сэргээгээд, өөрийгөө засаад, хязгааргүй бүтээлч оюунаа, өөрийнхөө хязгааргүй эрүүл мэндийг, хязгааргүй тэр сайхан мөн чанараа өөр дотроо сэргээдэг. Ингэснийхээ дараа үйлдэл хийх хэрэгтэй. “Йогастах куру кармани” – йогт тогтноод, өөрийнхөө ахуйдаа тогтноод үйлдэл хий гэсэн үг.

Юу ч үгүй хоосон тэр орчинд бүх юм бий болох орчин бас байдаг. Тэгээд тэндээс дараагийн шинэ зүйл нь урган гардаг. Эхний Веда болох Рк Веда нь үр хөврөл хэрхэн бүрэлдэхээс эхлээд цаашид хөгжих бүхий л явцтай шууд холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл Рк гэдэг хамгийн эхнийхээ энэ нэрэнд “Р-ррр” гэдэг хөдөлгөөн, эрчим маань багассаар багассаар хөдөлгөөнгүй, аниргүй “К” цэгт нуран унадаг. Энэ маань юу гэсэн үг вэ гэхээр эр эс эм (өндгөн) эстэй нийлэн үр хөврөл үүсгэж байгаа явцтай дүйцдэгийг гарамгай эрдэмтэн Тони Нейдер нээсэн байдаг. Эр эс хөдөлгөөнтэй (“ррррр”-хөдөлгөөн). Хөдөлгөөнтэй эс маань хөдөлгөөнгүй өндгөн эс рүүгээ (К цэг) ороод хоёулаа нэгдэж нэгэн зүйл болоод хоосон болж байгаа мэт (К-д нурна). Ингээд энэ дотор хоосон чанар бий болж байна. Үр маань бүрэлдэн тогтчихоод зөвхөн өөрөө өөрийгөө л хувилдаг (2, 4, 8, 16 гэх мэт). Тэгэхээр бидний бодлын эх үүсвэр, хязгааргүй энэ цэвэр ухамсар маань, Аатмаа маань өөрөө тийм хоосон чанартай. Энэ дотор та өөрөө ганцаархнаа байна. Танин мэдэх явц бол та өөрөө цор ганцаараа оршиж байгаад өөрөө өөрийгөө таньж мэднэ, таньж мэдэх арга нь үйл явц нь ч та өөрөө. Ийм учраас Нэг, Хоёр биш, шууд Гурвалсан чанартай болоод ирдэг. Өөрөө өөрийгөө таньж мэдэх явц нь өөр дотроо явагддаг учраас хүн болгон үүнийг хийж чадна. Хүн болгоны мөн чанар энэ юм.

Өөрөөр хэлбэл өөрөө өөртөө хандсан чанартай. Өөрөө л байгаа юм чинь өөрөө өөрийгөө таньж мэднэ, өөрөө объект нь, өөрөө субъект нь, өөрөө арга нь -танин мэдэх үйл явц нь буюу субъект объект хоёрын холбоо нь. Ингээд нэгд гурав гэсэн зохион байгуулалтын учир нь үүнд оршино. 4 Веда гэж ярихад энэ 4 веда маань нэгд гурав гэсэн зохион байгуулалттай гэсэн бүтцийг Махариши багш бидэнд тайлбарлаж өгсөн билээ. Хамгийн эхний Веда болох Рк Веда нь бүх юмыг хамарсан, 3 веда, 36 ведын утга зохиолоо бүгдийг нь өөртөө агуулах нэгдмэл мөн чанартай (самхитаа чанатай) байдаг. Яг үр мэт, өндөг мэт. Рк Веда нь хүний физиологитой харьцуулахад бидний мэдрэлийн тогтолцоотой дүйцдэг болохыг Тони Нейдер тогтоосон байдаг. Рк Веда 10 Мандалаас тогтдог. Эхний Мандал нь 192 сутратай. Энэ нь хүний мэдрэлийн тогтолцооны 192 тогтоцтой дүйцэж байдаг гэх мэтчилэнгээр гүйцэтгэх үүрэг, зохион байгуулалтаараараа 1:1-ээр дүйцдэг. Нэгд гурав гэсэн зохион байгуулалт нь Риши, Дээвата, Чхандас гэсэн гурван чанараар илэрхийлэгддэг. Риши гэдэг нь субъект – мэдэгч, Дээвата гэдэг нь мэдэх арга, Чхандас гэдэг нь объект – мэдэгдэхүүн. Ингээд танин мэдэх явц маань өөрөө юу юм бэ гэхээр мэдэгч, мэдэх гэж буй объект болон энэ хоёрын хоорондын холбоо юм. Энэ гурав гурвуулаа нийлж байж бүрэн мэдлэг болж ирдэг, цогц боловсрол болдог.

Тэгвэл орчин үед боловсрол маань зөвхөн гадагшаагаа юмыг таньж мэддэг, мэдээлэл цуглуулдаг болсон. Өөрийгөө орхигдуулсан байдаг. Тэгвэл хүн өөрийгөө хэрхэн хөгжүүлэх юм бэ? Өмнө хэлсэнчлэн бүрэн мэдлэг цэвэр ухамсарт суурилагдсан байдаг. Тэгвэл чанадаас халих бясалгалаар бид цэвэр ухамсраа өөр дотроо сэргээн тогтворжуулдаг, тиймээс цэвэр ухамсарт суурилагдсан бүрэн мэдлэг ч бас жамаараа сэргэж ирдэг. Тийм учраас хүний ухаан тунгалаг болоод саруулхан, маш их эрч хүчтэй, үр дүнтэйгээр ажиллан бүтээлч сэтгэлгээ нь сайжирч ирдэг. Ведын 36 салбар маань бас Риши чанартай 12, Дээвата чанартай 12, Чхандас чанартай 12 гэсэн зохион байгуулалттай байдаг. Ингэхдээ бас риши дээвата чхандас, чхандас дээвата риши гэсэн эргэн гогцоорсон зургаа зургаан хэсгээс тогтсон зохион байгуулалттай байдаг. Хүн яагаад төрсөн нутагтаа татагдан эргэн очдогийн шалтгаан нь энэ. Хүмүүс тахиа анхдагч уу, өндөг анхдагч уу гэж мэтгэлцдэг. Тэгвэл эхлээд ямар байсан яг л тийм байдаг аж. Энэ бол Шрути, Смрити, Пураан ч гэсэн Ведын утга зохиолын 3 нэрээр илэрхийлэгддэг.

Шрути гэдэг нь туйлын үнэн гэсэн утгатай. Туйлын үнэн үргэлж байж байдаг. Пураан нь эртний гэсэн утгатай. Тэгвэл энэ эртний зүйл Пураан маань юунаас бүрддэг юм бэ, ямар материалаар хийгдсэн юм бэ гэхээр Смрити-гээс тогтдог. Смрити гэдгийн яг оносон орчуулгагүй, гэхдээ ой ухаан, ой санамж гэсэн үгтэй утгын хувьд илүү ойр. Ийнхүү Үнэмлэхүй үнэн (Сат Чит Ананда) байсан тухай Пураанад түүхчлэн өгүүлсэн байдаг байна. Харин энэ тухай бид эргэн санах Смрити - ой санамждаа сэргээн авчрах чадвар үргэлж оршин байдаг.

Ведын эхний 6 гогцоорсон утга зохиол бол хязгааргүй аниргүй хэрхэн илэрхийлэгдэж гадагш дэлгэрээд буцаад өөр лүүгээ эргэн ирж мэргэн ухаан болж буйг харуулдаг. Эхний гурван утга зохиол нь бидний хязгааргүй аниргүй сансарлаг БИ, Аатмаа, цэвэр ухамсар маань хэрхэн гадагшаага илэрхийлэгдэн хувьсан дэлгэгдэн гардагийг харуулдаг. Шикшаа - ведын утга зохиолын нэг, оюуны илэрхийлэгдэх чанарыг илтгэнэ. Физиологид бол бидний дотоод эрхтэнүүдийн үйл ажиллагаатай дүйцэж байдаг. Хязгааргүй Аниргүйгээс – Би-гээс бодит орчлон руу илэрхийлэгдэж байгаа чанар юм. Илэрхийлэгдээд цаашаа юу болж байна гэхээр илэрхийлэл нь хөгжин хувьсдаг (Ведын утга зохиолын нэг болох Калп). Тэгээд дараа нь улам тэлж тархдаг (Ведын утга зохиолын нэг болох Вяакаран). Ингэж тэлэгдчихээд гадагшаага хэдий хэмжээтэй юм бий болсон байна төдий хэмжээтэй юм заавал эсрэг чиглэлд үүсэж байдаг жамтай. Энэ бол байгалийн хууль. Атомыг цэнэггүй гэж ярьдаг. Гэтэл энэ цэнэггүй мэт байдал нь хэдэн электрон бий болно, төчнөөн протон үүсдэг учир тэнцвэржин байдаг учиртай. Өөрөөр хэлбэл хэдий хэмжээний юм гадагшаага илэрхийлэгдэж байна, төчнөөн юм эсрэг талдаа бас л үүсэж байдаг. Иймээс Ведын гадагш илэрхийлэгдэх явц маань буцаж эргэж өөрөө өөр лүүгээ хандаж ирдэг (Ведын утга зохиолын нэг болох Нирукт). Буцаж эргэн өөрөө өөртөө хандахдаа хэдий хэмжээний юм илэрхийлэгдсэн байна тэр бүгдийгээ бүгдийг хэмжиж тоолдог (Ведын утга зохиолын нэг болох Чханд). Гадагш илэрхийлэгдэн гарсан бүхий л илэрхийллээ нэгд нэгэнгүй хэмжиж тоолсны үр дүнд бүхнийг мэдэх чанар бүрэлддэг. Энэ бол Ведын утга зохиолын нэг болох Жётиш буюу зурхайн ухаан юм. Бүгдийг тольдох мэргэн ухаан маань гадагш илэрхийлэгдсэн орчлон эргэн өөр лүүгээ хандан илэрхийлэгдсэн бүхнийг хэмжин тоолж нэгтгэсэн чанар болохнээ. Зурхайн ухаан маань ийм мөн чанартай байхнээ.

Шикшаа, Калп, Вяакаран, Нирукт, Чханд, Жётиш гэсэн энэ зургаа гогцоог Ведаанга гэж нэрлэдэг (Ведын “анга” буюу бие).

Няая, Вайшнэшика, Саамхья, Йога, Карма Миимаамсаа, Ведаант гэсэн зургаалыг Упаанга гэдэг.

Гандхарваведа, Дханур Веда, Стхапаатъя Веда, Хааритаа Самхитаа, Бхээл Самхитаа, Каашьяп Самхитаа гэсэн зургаал болон мөн Чарак Самхитаа, Суушрут Самхитаа, Вагбхатт Самхитаа, Мадхав Нидаан Самхитаа, Шарьягадхар Самхитаа, Бхаава-Пракааш Самхитаа зургаал хоёуланг нэгтгэн Упа-Веда гэдэг. Ведын энэхүү 12 утга зохиол нийлээд Ааюур Веда буюу ведын анагаах ухааныг бүрдүүлдэг.

Дараагийн зургаан Ведын утга зохиолыг Браахмана, хамгийн сүүлийн зургаалыг Праатишаакхья гэж тус тусад нэрлэдэг. Бүгд маш гүн учир утгатай.

Гэх мэтчилэн Ведын тухай яриад байвал тасралтгүй их үргэлжилнэ. Та бүхнийг энэ нандин мэдлэгийг дотроо сэргээн ашиглах арга болох Чанадаас Халих Бясалгалын (ЧХБ) танилцуулганд (Утас:99095401, 99661778) урья.

Анхаарал тавьсанд баярлалаа.



Хүний эрхийн Хуульч М.ИЧИННОРОВ:

Хувь хүний үнэ цэнэ

Монгол бол хамгийн сайхан орон гэж миний хувьд боддог. Монголчууд сэтгэл зүйн гутралд ордоггүй гэнээ. Яагаад гэвэл бид байнгын тэмцэл дунд амьдарч байдаг. Зарим улс орнуудад өвчин зовлонтой хүмүүсээс гадна эрүүл хүмүүс нь сэтгэл зүйн маш их гутралд ордог. Миний хувьд гэхэд дэлхийн 40 гаруй улс оронд аялж үзсэн. Карибын арал дээр байдаг Ямайкагийн тэнгэрт татсан хөх уулсад хүртэл очиж үзэж байлаа. Аль ч улс орны гоё газруудыг үзсэн. Монголыг гүйцэх сайхан газар хэзээ ч миний зүрх сэтгэлд байгаагүй. Монголдоо ирэхэд Монголын минь тал нутаг ямар ч улс орны ямар ч гайхамшигтай зүйлтэй зүйрлэшгүй агуу санагддаг. Монголын малчин айлын аргалын утаанаас үнэртэж байгаа тэр үнэр, гал дээр чанаж байгаа сүүтэй цайны тэр ааг зэрэг бол жинхэнэ бидний гайхамшиг, жинхэнэ бидний бахархал. Өөрөөр хэлбэл үүнээс илүү сайхан мэдрэмжийг би өөр хаана ч авч байгаагүй. Бид бол ийм сайхан Монгол орны иргэд.

Хувь Хүний үнэ цэнийн тухай “Үнэ цэнэ” гэдэг ном би гаргасан. Би эхлээд номоо “Мишээл охин” гэж нэрлэе гэж бодож байсан л даа. Яагаад гэхээр энэ номны хамгийн эхний нүүрэнд нь Мишээл охин гэдэг нийтлэл байгаа. 2008 онд Дарханд сонгуульд ялагдчихаад ерөнхийдөө их том цохилт аваад амьдралынхаа нилээн хүнд үеийг туулж байсан. 2009 оны өвөл нэг цас орсон өдөр МТҮП-ийн урдуур найзтайгаа явж байтал 40 гаран настай эрэгтэй ой гаран насны нэг охин тэвэрчихсэн сууж байсан. Тэгээд тэр охин нь чарлаад уйлж байсан. Маш хүйтэн өдөр цементэн дээр дороо юм дэвсэлгүй суугаад охин нь уйлаад байсан. Мэдээж тэр хоёрыг анзаарахгүй өнгөрөх хэн ч байхгүй. Ерөнхийдөө эмэгтэйчүүд тойрч зогсоод мөнгө өгч байсан. Тэр охин надад үнэхээр аймар харагдсан. Шээс, баасандаа хутгалдчихсан, хэдэн ч хоног суусан юм бүү мэд. Тэгээд тэр хүн миний охиныг авах хүн байна уу, ээж нь нас барчихсан юм гээд уйлаад байсан. Би үнэхээр итгээд их өрөвдсөн. Надад ямар нэгэн эргэлзээ байхгүйгээр би тэр охиныг шууд л тэвэрч авсан. Би охиныг чинь авъя гэсэн чинь тэр ах охиноо өгсөн. Тэгээд охиныг тэврээд такси барих гэсэн чинь такси олдоогүй. Яг тэр үед аймар уйлж байсан охин над дээр ирээд уйлахаа больсон. Тэр охиноос муухай үнэр үнэртээд үнэхээр өрөвдөлтэй байсан. Надад юу бодогдсон бэ гэхээр охин мэдээж өвчтэй байгаа, хамгийн түрүүнд усанд оруулаад эмнэлэг авч явна гэхээс өөр ямар ч бодол байгаагүй. Тэгээд арай гэж такси баригдаад яг суух гэтэл нөгөө аав нь араас ирж уйлаад охиноо өгөхгүй гээд надтай булаацалдаад, маш олон хүн тойроод зогсчихсон сүүлдээ би хүүхэд хулгайлсан хэрэгт орж магадгүй гэж санаа зовоод охиныг өгсөн.

Тэгээд явж байсан чинь харамсаад болдоггүй. Манай найз яасан азгүй юм бэ, нэгхэн

минутын дотор тэр охины хувь заяа бүрэн эргэх байлаа гэсэн. Би өөрөө нэг хүүтэй, хүү маань нилээн том болсон. Би охинтой болно гэж боддог байсан болохоор тэр охиныг тэгээд авчихна л гэж бодсон. Би ЦЕГ-ын хүүхдийн Алтанцэцэг гэдэг ахмадтай холбоо бариад та энэ хүүхдийг үнэхээр анхааралдаа аваарай, та нар авахгүй байж болохгүй шүү гээд яагаад ч юм би найдаад явчихсан. Би тэр үеэр Америк яваад тэндээ бараг жил болохоор билетээ аваад төлөвлөчихсөн байсан. Тэгээд Америкт байж байсан чинь манай найзаас и-мэйл ирээд 7 хоногийн дараа явахад нөгөө хүн чинь хүүхэдтэйгээ л сууж байна гэж хэлсэн. Жилийн дараа би Мишээл охин гэж нийтлэл бичээд www.news.mn сайтад тавьсан юм. 24 цаг миний нийтлэл тэнд байрлахад онцлох нийтлэлээр шалгараад дахиад 7 хоног байрлаад их олон хүн уншсан л даа. Яагаад би энэ нийтлэлийг бичсэн бэ гэхээр жилийн дараа ирэхэд тэр хүн яг тэр газраа хүүхдээ тэврээд зараад сууж байгаа юм л даа. Өөрөөр хэлбэл өөрөө архины мөнгөө олоод сууж байгааг нь л мэдсэн. Америкт жишээ нь хүүхдээ ганцааранг нь орхиод ажилдаа явсан байх юм бол хөрш нь утасдаж цагдаад мэдэгдээд эцэг эх нь хэрэгт ордог. Өөрөөр хэлбэл хүүхдийг хараа хяналтгүй орхихоос сэргийлдэг. Нэг талаасаа харгис сонсогдож байгаа боловч тэр хүүхдийг хамгаалах үүднээс тийм хатуу хууль үйлчилдэг. Мишээл охины тухай гол нь юу бичсэн гэхээр манайд хүүхдээ гудамжинд зараад сууж байхад тэр хүмүүсийн эцэг эх байх эрхийг нь ч хасахгүй, тэр хүүхдийг хамгаалалтанд ч авахгүй байгаа тэр системийг шүүмжилж бичсэн. Тэгээд тэр утгаар нь номоо Мишээл охин гэж нэрлэе гэж бодож байсан чинь манай нэг найз миний номыг уншаад чи энэ номоо “Үнэ цэнэ” гэж нэрлэ. Яагаад гэвэл энэ номон дотор маш үнэ цэнэтэй мэдээллүүд байна, чи өөрөө үнэ цэнэтэй хүн, энэ мэдээллүүд хүмүүст үнэ цэнэ болж очих ёстой, энэ үг маш олон утгатай байна гэсэн.

Олон жил Монголын ардчилал, эрхзүйн системийн шинэтгэл, ардчиллын хөгжилд хувь нэмрээ оруулан амьдарч явахдаа нэг зүйлийг сайн ойлгосон. Юу гэхээр, ардчилал гэдэг бол дураараа аашлахын нэр биш. Ардчилал гэдэг бол хариуцлагагүй байхын нэр биш. Ардчилал гэдэг хуулиас, системээс, тогтолцооноос, бусдаас бүхнийг үзчихээд өөрөө хариуцлагагүй байхын нэр биш. Бүр том агуулгаар нь аваад үзэх юм бол ерөөсөө хүн болгон өнөөдөр ямар нэгэн болохгүй байгаа зүйлийг энэ бол хуулийн цоорхой, системийн буруу, тогтолцооны гажиг гэж ярьдаг. Гэтэл тогтолцоог хүн бүрдүүлдэг, системийг хүн хийдэг, хуулийг хүн бичдэг, хуулийг бас хүн зөрчдөг. Хариуцлагыг бас хүн зөрчдөг. Тэгэхээр хувь хүний үнэ цэнэ, хувь хүний үнэлэмж, хувь хүний хөгжил дэвшил, хувь хүний хариуцлага, хувь хүний сэтгэлгээний өөрчлөлт ардчиллын, ардчилсан нийгмийг бүтээх хамгийн гол цөм нь юм байна гэдгийг ойлгосон.

Өнөөдөр хувь хүний үнэ цэнийн талаар долоон зүйл хэлье гэж бодлоо. Нэг алдартай профессор лектор 200 хүний өмнө гараад 20 доллар гаргаж ирээд үүнийг авах хүн байна уу гэсэн. Тэгэхэд бүх хүн авахыг хүсч гараа өргөсөн. Нөгөө 20 доллараа үрчийлгэж үрчийлгэж дахиад үүнийг авах хүн байна уу гэсэн чинь бүгдээрээ л гараа өргөсөн. Тэгээд нөгөө 20 доллараа газар хаяад, дэвслээд, бүүр муухай болгож байгаад одоо үүнийг авах хүн байна уу гэсэн чинь бүгд л авья гэсэн. Тэр профессор хэлэхдээ үүнээс та бүхэн нэг л зүйлийг сурах ёстой. Энэ бол үнэ цэнэ. 20 доллар хичнээн шинэ цэвэрхэн байсан ч үнэ цэнэ нь 20 доллар хэвээрээ, хичнээн үрчийлгэж муухай болгосон ч үнэ цэнэ нь 20 доллар хэвээрээ л байна. Тэгэхээр хувь хүний үнэ цэнэ гэдэг бол ерөөсөө л энэ. Бид бүгдээрээ бурханаас заяахдаа, төрөхдөө, энэ дэлхий дээр амьдрахдаа хүн болгон өөр өөрийн гэсэн үнэ цэнэтэй, өөрийн гэсэн авьяас чадвартай, шинж чанартай. Өөр хэзээ ч, хэнд ч давтагдахгүй шинж чанар хүн

болгонд байдаг. Энэ л бид нарын үнэ цэнэ. Харамсалтай нь амьдрал биднийг тэр 20 долларыг үрчийлгэсэнтэй адилхан чи ийм үнэ цэнэгүй гэж мэдрүүлэхийг хүсч байдаг. Амьдрал тэр чигээрээ тийм байдаг. Харин би өөрөө үнэ цэнэтэй гэдгээ мэдэж байх нь хамгийн чухал. Ийм л авьяас чадвартай, хүсэл эрмэлзэлтэй хүн гэдгээ өөрөө мэдэх нь чухал. Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа гэдэг. Өөрийнхөө үнэ цэнэ үнэлэмжийг мэддэг байх тэр амьдралд хүүхдийг хэн сургадаг юм бэ? Эцэг эх, багш байдаг. Хамгийн ойрын, тэдэнд тэр үнэлэмжийг суулгах хамгийн чухал хүмүүс бол мэдээж тэд нар. Мөн мэдээж найз нөхөд, нийгэм байна.

Бас нэг түүх ярьж өгье. Энэ бол хайрын үнэ цэнэ. АНУ-ын нэг сургуулийн профессор судалгаа хийсэн байгаа юм. Эдиморг гээд хотын хамгийн ядуу, хар арьстай, гэмт хэрэг нүүрлэсэн тийм дүүргийн хүүхдүүдийн дунд судалгаа хийсэн. Оюутнуудаар 100 гаруй хүүхдийн дунд судалгаа хийлгээд энэ хүүхдүүдийн ирээдүй найдваргүй гэсэн дүгнэлт гаргасан. Тэгээд 20 жилийн дараа тэр багш яг нөгөө газраа дахин судалгаа хийсэн. Тэгэхэд тэдгээр хүүхдүүдийн ихэнх нь хуульч, багш, улс төрч, хотын дарга, эмч, инженер гээд хүүхэд байх үеийнх нь тэр судалгаанаас ирээдүй нь шал өөр болсон байсан. Тэр профессор маш их гайхсан. Яагаад гэвэл тэр гэмт хэрэг, хар тамхи, хэрүүл зодоон, ядууралтай орчинд амьдарсан хүүхдүүдийн бараг хагас нь үхдэг, гэмт хэргийн золиос болдог, шоронд явдаг, охидууд нь хүүхэд төрүүлдэг, нийгмийн халамжинд амьдардаг. Тэгвэл үүний нууц нь юундаа байна гээд судлахад бүгдээрээ нэг харилут өгсөн, тэр нь юу гэхээр “манай багш” гэж. Тэгээд багшийг нь хайж олоод уулзсан чинь нилээн өндөр настай эмэгтэй байсан. Та энэ хүүхдүүдийг яаж ийм гайхамшигтай ирээдүй рүү хүргэсэн нууцаасаа хэлээч гэсэн чинь ерөөсөө энэ бүхний хариулт нь маш энгийн, би зүгээр л энэ хүүхдүүдийг хайрласан юмаа гэж хэлсэн. Энэ бол хайрын үнэ цэнэ. Ер нь манайд ч биш, олон тохиолдолд хүүхдийг багаас нь ямар ч үнэ цэнэгүй амьтан гэж мэдрүүлж өсгөх хамгийн аюултай. Эцэг эхчүүд хүүхдүүддээ багаас нь яг том хүн шиг юмыг тайлбарлаж өгдөг байх хэрэгтэй. Хүүхдийг дандаа хараана. Хүүхэд чинь нэг буруу юм хийнэ, тэгэхэд нь муу хүнийг зар, зарсан хойноо өр гэж загнадаг. Тэгэхээр шууд хүүхэд өөртөө муу хүн гэсэн ойлголтыг авдаг. Бид нар багаас нь хүүхдүүдээ чи бол үнэхээр гайхамшигтай, чи бол үнэхээр үнэ цэнэтэй, чи бол миний хамгийн гайхамшигтай бэлэг ч гэдэг юм уу, дандаа сайхан үгнүүдийг хэлж, чи чадна, чамд гайхамшигтай ирээдүй байгаа гэдгийг дандаа мэдрүүлж байх юм бол хүүхэд түүнд итгэнэ. Тэгж итгэснээр л тэр хүний амьдрал тодорхойлогдоно. Хүүхдэд багаас хайрын үнэ цэнийг мэдрүүлж, өөрийг нь үнэ цэнэтэй хүн гэдгийг мэдрүүлж амьдарна гэдэг бол, тийм амьдралыг өгнө гэдэг бол хамгийн чухал.

Өөр нэг түүх ярья. 2006 онд над дээр нэг сэтгүүлч бүсгүй ирээд баахан ном үзүүлээд надад юм тайлбарлаад ярьж зөндөө суусан. Би тэр хүний ярианаас нь их сайхан сэтгэлтэй эмэгтэй байна, маш их юм хийсэн байна гэдгийг нь ойлгосон. Тэгээд яг юу хүсч байгаа юм бол гэж бодсон. Тэгсэн чинь манай нөхөр бид 2 урлагийн

Виртуас гээд наадмыг санаачилсан юм. Энэ нь юу гэхээр тухайн үед ардчилал гараад нийгэм солигдоход бид нарын хамгийн их сайн мэддэг байсан дуу, балет гээд сонгодог урлаг бол маш хүнд байдалд орсон. Нөхөр нь сонгодог урлагийн мэргэжилтэй, хөгжмийн зохиолч, багш хүн. Өөрөө сэтгүүлч эмэгтэй. Тэр хоёр Виртуас гэдэг наадмаар залуу уран бүтээлчдийг дэмжих санаачилга гаргаад, энэ салбарыг үхүүлчихгүйн тулд тэмцье гэсэн зорилготой байсан.

Хүүхдийн сонгодог урлагийн боловсролд зориулж гаргасан Суут хөгжмийн зохиолчид гэдэг цуврал номнууд байдаг. Түүнийг үзээд үнэхээр биширсэн, хорвоо дэлхий дээр гайхамшигтай хүмүүс олон байдаг юм байна. Тухайн үед тэр хоёр энэ наадмын төлөө хадам ээж болон өөрийнхөө ээжийн өгсөн алтан ээмэг бөгжийг, 9919-тэй дугаараа зарж байсан. Виртуас наадам их амжилттай болсон. Гэхдээ тэр хоёр том том компаниуд дээр очиж хөрөнгө мөнгө босгох ажил ерөөсөө хийгээгүй, урлагийг дэмждэг сайхан сэтгэлтэй хүмүүс дээр очоод уулзаад явж байсан гэсэн. Над дээр ирсэн шалтгаан нь дэмжиж 10 билет худалдаж аваач гэсэн, би тухайн үед худалдаж авч байсан. Жил болгон энэ наадам зохиогдоод хүүхдүүд тэндээс урам авч олон улсын тэмцээнүүдээс шагнал аваад явсан. Одоо энэ Виртуас наадам нилээн өндөр түвшинд болдог болчихсон. Морин хуурын удирдаач багш Түвшинтөр гээд залуу тэр хоёрт зориулаад “Хос ятга” гэдэг хөгжим бичсэн байгаа. Би бас тэр хоёрын тухай Хос ятга гэдэг нийтлэл бичсэн. Яагаад гэхээр Оюунаа маань өнөөдөр ч чихэндээ ээмэггүй, түүний нөхөр Цогоо нь өнөөдөр ч унах машингүй. Гэхдээ тэр хоёр маш баяр баясгалантай сайхан амьдарч байна. Бусдад өгч байгаа тэр тусламжаасаа, бусдад өгч байгаа тэр хайр энэрэлээсээ өөрсдөө кайф авч амьдардаг. Түүгээрээ аз жаргалтай байдаг. Магадгүй тэр хоёрт маань хэзээ ч гавьяат цол өгөхгүй байх гэж би боддог юм. Манайд ер нь хамгийн гавьяатай хүнд гавьяат цол өгдөггүй. Төр засаг тэр хоёрын чармайлтыг үнэлэхгүй ч байж магадгүй. Гэхдээ тэр хоёр хөгжмийн зохиолч, бас ч гэж Монголын цуутай хөгжмийн зохиолчийн хөгжмийн аянд тэр хоёр маань мөнхөрч үлдэх нь ээ гэж би бэлэгшээж бодсон.

Амьдралын бас нэг хамгийн үнэ цэнэтэй зүйл бол миний хувьд хүсэл мөрөөдөл, тэмүүлэл. Гол нь би тэнд хүрнэ, миний амьдралын зорилго тийм гэдгээ харсан зорьсон тэр амьдрал. Яагаад гэхээр хүсэл мөрөөдөлгүй амьдрал жигүүргүй шувуутай адилхан, зорилгогүй хүн сэлүүргүй завиар далайд аялж байгаатай адилхан гэж ярьдаг. Би эдгээр үгтэй санал нэг байдаг. Учир нь хүн хүсэл мөрөөдөлтэй, тэнд хүрнэ гэсэн өндөрлөгөө тодорхойлсон бол, хаана хүрэхээ харж байгаа бол түүндээ хүрэх зорилготой амьдардаг. Зорилгоо тодорхойлсон хүн түүндээ хүрэх төлөвлөгөө боловсруулдаг. Төлөвлөгөөтэй байгаа хүн түүнийхээ төлөө үйлс хийдэг. Үйлстэй амьдарч байгаа хүн тэмцэлтэй байдаг, амьдрал нь утга учиртай байдаг. Бүдэрч болно. Хүн хажуунаас дэгээдээд унагаачихаж ч магадгүй, өөрөө ч бүдэрч унаж магадгүй. Тэгсэн ч зорилгынхоо төлөө л явах хэрэгтэй. Би залуучуудад хэр зэрэг том мөрөөднө тэр хэмжээгээрээ илүү том юм хийж, илүү амжилтанд хүрдэг гэж хэлдэг юм.

Ерөөсөө хүний амьдралд итгэл үнэмшил маш чухал. Хүн ер нь юунд итгэнэ, тэр хэмжээгээрээ хүний амьдрал урагшилна, аль эсвэл хойшилно. Та нарын сайн мэдэх дэлхийн хамгийн баян эмэгтэй Опра Уинфригийн түүх бол үнэхээр байлдан дагуулагчийн түүх. Опраг таван настай байхад эмээ нь гадаа юм угаагаад хатааж байсан. Тэгээд эмээ нь чи миний хийж байгааг сайн харж ав. Энэ ажлыг бидний өвөг дээдэс ч хийж байсан, би хийж байна, чи ч бас хийнэ гэж хэлсэн. Тэгэхэд нь үгүй ээ, би үүнийг хийхгүй, надад үүнээс агуу хувь заяа байгаа, яагаад гэхээр би 1950 онд төрсөн, (1950 онд хар арьстан, цагаан арьстан хүүхдүүдийг тусгаарлаж сургадаг байсан системийг халсан жил) тэгэхээр би ирээдүйн он жилүүдэд төрсөн гэж таван настай охин итгэж байсан учраас өнөөдрийн энэ өндөрлөгт хүрсэн. Юунд итгэнэ тэр бол хамгийн чухал. Ямар нэгэн итгэл үнэмшилтэй хүн үнэ цэнэтэй сонголтуудыг хийдэг. Амьдралаа үрэн таран хийхгүй байх сонголтуудыг хийдэг. Итгэл үнэмшилтэй хүн өөртөө итгэдэг. Өөртөө итгэх итгэлийг бардамнал гэж ойлгож болохгүй, өөртөө итгэх итгэл бол өөрийнхөө ирээдүйд итгэж байгаа, өөрийнхөө амьдралд итгэж байгаа итгэлийг хэлнэ гэж

боддог. Энэ бол бас л нэг чухал үнэ цэнэ. Хүн өөрийгөө яг юу гэж бодно, тэгж л байх болно. Өөрийгөө хүчгүй, сул дорой гэж бодох юм бол хүчгүй, сул дорой л байна. Өөрийгөө царай муутай гэж бодвол царай муутай л байна. Өөрийгөө хүн яг юу гэж бодно, тийм л байна. Үүний жишээ бол “Тахиа болсон бүргэд” гэдэг өгүүллэг байдаг. Бид хүүхдүүддээ тахиа биш бүргэд гэдгийг нь ойлгуулж өсгөх хэрэгтэй, энэ бол эцэг эх бидний маш чухал үүрэг. Хүүхэд өөрийнхөө үнэ цэнийг мэдэрч амьдрах тэр амьдралыг эцэг эх бид нар өгөх үүрэгтэй.

Үгийн үнэ цэнэ байна. Бид нарын амнаас гарч байгаа үг зүгээр гардаггүй. Амнаас гарч байгаа үг ямар нэгэн үр тарьдаг. Энгийн жишээ хэлэхэд л би хүүгээ чи хамгийн сайхан ханхүү, гайхамшигтай хүн шүү гэж хэлээд тэр хүнийг бүтээж байгаа бол тэр амнаас гарч байгаа үг маань тийм гайхамшигтай үр тариад ургац авч байна гэсэн үг. Амнаасаа хараалын, бусдыг доромжилсон үгийг тийм ч амархан гаргаж болохгүй байх нь. Тодорхой хэмжээнд олны танил болсон хүмүүс байнгын хараал, доромжлол, муу муухайгаар хэлүүлэх тийм ертөнцөд амьдарч байна. Хүнийг яаж доромжилж байна, ямар муу муухай үгээр хэлж байна тэр нь өөрт нь, эсвэл үр садад нь ямар нэгэн байдлаар эргэж ирдэг. Үг гэдэг бол үнэхээр аймар хүчтэй зэвсэг. Үгээр хүнийг алж болно, үгээр хүнийг амьдруулж, босгож, зоригжуулж болно. Монголчууд бурмаар тэтгэхээр урмаар тэтгэ гэж ярьдаг. Хүнд маш их урам хэрэгтэй байдаг, зоригжуулалт магтаал сайшаал хэрэгтэй байдаг.

Үнэ цэнийг нь мартаж болохгүй зүйл бол хүний алдаа, оноо, бүтэлгүйтэл, зовлон бэрхшээл. Эргээд харахад бидний хамгийн их зовж байсан, шаналж байсан, зовлон туулж байсан тэр үе бол хамгийн үнэ цэнэтэй хугацаа байдаг. Тухайн үедээ хамгийн хэцүү боловч түүнийг туулж байгаа цаг мөч бүр эргээд харахад хамгийн үнэ цэнэтэй, хүний амьдралын хамгийн онцлог хугацаа байдаг. Тэндээс би ийм юм сурсан, тэндээс би ийм хүчирхэг болсон, тэр бэрхшээл дундаас өнөөдрийн би бий болсон.

Эцэст нь хэлэхэд бидний амьдралд бүхнээс үнэ цэнэтэй зүйл бол бид нарын эрх чөлөө. Өнөөдөр монголчууд шиг эрх чөлөөтэй ард түмэн бараг алга. Хаана ч очсон хөдөлвөл хөлс, зогсвол зоос гэсэн тийм л системтэй. Монгол бол үнэхээр эрх чөлөөтэй, хүмүүс нь үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь байна. Нүүдэлчин соёл иргэншлээсээ болоод тэр юм уу хүмүүс нь эрх чөлөөтэй сэтгэдэг, боддог, ярьдаг. Өнөөдөр төрийнхөө тэргүүнүүдийг хэн дуртай нь гараад шүүмжилж болно. Эрх чөлөөний үнэ цэнийг ойлгоход тусалсан зохиол бол “Цорын ганц” гээд зохиол байдаг. Тэр бол боолчлолоос чөлөөлөгдөж байгаа эмэгтэйн түүх. Боол байна гэдэг бол байнга хүний хараа хяналтанд байдаг. Тэр эмэгтэй ой дотор нэг аюулгүй газраас нөгөө аюулгүй газар луу явж байхдаа юу ойлгосон бэ гэхээр эрх чөлөө гэдэг бол эзэнгүй байхын нэр биш юм байна. Эрх чөлөө гэдэг бол сонголт хийх боломжтой байхыг хэлдэг юм байна. Энэ бол үнэхээр агуу үг. Өөрөөр хэлбэл эрх чөлөө гэдэг нь эзэнгүй байхын нэр биш юм байна гэдэг нь юу гэсэн үг вэ гэхээр замбараагүй, хууль дүрэмгүй, ёс жудаггүй байхыг хэлдэггүй юм байна. Өөрийнхөө хийх юмыг сонгоно гэдэг бол хамгийн том эрх чөлөө. Бид нар энэ эрх чөлөөт оронд, эрх чөлөөт нийгмийн орон зайнд амьдарч байгаа учраас, тэр тусмаа Монгол бол өнөөдөр дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж байгаа орны тоонд орж байна, бид нарт хийж бүтээх орон зай маш их байна. Та бүхэн өөрсдийн үнэ цэнийг мэдэж, мэдэрч, үнэ цэнээ үнэлж, үр хүүхдүүдийнхээ үнэ цэнийг өсгөж амьдраарай. Нийгэмдээ үнэ цэнэ болж яваарай.



Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба, гавж Д.ЧОЙЖАМЦ:

Зүрх тархиа хослуулан хөгжүүлэх нь

Би та бүхэнтэй гэртээ байдаг шиг энгийнээр ярилцъя. Асуух юмаа бодоод, үнэн хэлж байна уу, худал байна уу ажиглаад, авах юмаа авч, хаях юмыг нь мартаарай. 1990-ээд оноос хойш бид шинэ нийгэмд орсноор 20-иод жил өнгөрчээ. Энэ хугацаанд хүмүүсийн сэтгэл санаа нийгэмдээ дасаж, нийгмийнхээ ололт амжилттай, алдаа гажилттай талыг мэдэрдэг болсон. Миний ажигласан нэг зүйл бол хүмүүсээ соён гэгээрүүлэх ажлыг их хиймээр байгаа юм. Хүмүүст сайхан зөв мэдлэг алга. Хүүхэд, залуучууд шинэ юмыг шууд өөр дээрээ тусгаж аваад тэр дор нь хэрэгжүүлдэг сайн талууд их харагдаж байна. Гэхдээ өнөө үед авмаар юм ч байна, хаямаар юм ч их байгаа. Эхнээс нь сайн бодолтой хандахгүй бол амьдралын замдаа алдаа гаргаад, ирээдүйгээ баллах асуудал их гарч байна. Тиймээс хүүхдүүдээ багаас нь хашир суулгах хэрэгтэй. Хүн болоход гурван үүд гэж байдаг. Тэр нь бие, хэл, сэтгэл гурав. Хүн энэ гурваас зайлна гэж байхгүй. Ямар нэг үйл явдал, жаргал зовлон аль нь ч гэсэн энэ гурван үүдээр дамжиж ирдэг. Хамгийн түрүүнд бид сайхан, өв тэгш хүмүүжилтэй, мэдлэг боловсролтой хүнийг бий болгоход энэ гуравтай нь ажиллах хэрэгтэй. Бие, хэл, сэтгэлийг нь ямар болгох вэ гэдэг асуудал юм. Энэ гурвын хамгийн чухал, эзэн хааны байр сууринд нь сэтгэл байдаг. Сэтгэлд юу бодогдоно хэл тэгж хэлдэг, бие дагаж хөдөлдөг. Тиймээс сэтгэлийг сайн судалж, сонсож, мэдэрч тайван сууж байгаад бодох хэрэгтэй. Сэтгэлийг боловсруулж хөгжүүлэхэд хоёр арга байдаг. Далай багш “Зүрхээ тархитайгаа хамт хөгжүүлээрэй” гэж хэлсэн. Энэ бол их ухаантай үг. Тархи бол боловсрол мэдлэг, зүрх нь хайр, энэрэл нигүүлсэл зэрэг хүнийг хүн болгодог хэмжүүр. Хичнээн өндөр мэдлэг боловсролтой болсон ч цаад аргын талын боловсролгүй бол адгуусан шинж рүүгээ ойртоно. Сэтгэл сайтай, гэр бүлээ сайхан авч явлаа ч мэдлэг дутвал орчин үеийн нийгмээс хоцрогдоно. Шинжлэх ухаан техник, янз бүрийн мэдээ, мэдээллээс хоцрохоор, нэг л сайн хүн яваад дуусахаас биш бүтээн байгуулж, улс орондоо хэрэгтэй зүйл хийхэд зовлонтой. Тиймээс энэ хоёрыг зэрэг хөгжүүлэх ёстой. Тэгвэл хэлэн дээр аятайхан өөрчлөлт гарна, биен дээр ч гэсэн сайхан илрэл гардаг. Бидний амьдарч байгаа нийгэмд гарч байгаа сэтгэлийн завхрал нь бие, хэлэн дээр илэрдэг юм байна. Үүнээс болж эрх чөлөөгөө буруугаар ойлгосон, биеэ яаж авч явахыг америк, солонгос киногоор ойлгодог болсноос хойш монголчуудын соёл, уламжлал сүүлийн жилүүдэд их өөрчлөгдсөн. Энэ өөрчлөлт эмэгтэйчүүдийн хувцаслаж байгаа биен дээр нь илэрдэг. Яаж илэрч байна гэхээр банзал нь улам богиносоод, дээгүүрх хувцас нь улам доошлоод хөх нь гарчих гээд байх маягтай болсон. Тийм хувцас өмсдөг өдөр, цаг байж болно, очдог газар байж болно. Гэхдээ цаг хугацаагүй, сэтгэлтэйгээ харьцаагүй дуурайлт байж болохгүй. Нэг охин хүчиндүүлчихээд амиа хорлоно гээд байхаар эцэг эх нь зовоод над дээр авчирсан. Гэтэл тэр шөнийн нэг цагийн үед ахындаа очно гээд мини юбкатай гарч явсан гэсэн. Тэр цаг чинь

бааранд орсон хүмүүс цөмөөрөө согтчихсон, тийм л юм эрээд явахад нь энд байна гэж хэлсэнтэй ялгаагүй юм болсон. Тиймээс цаг хугацаагүй, хий дэмий бусдыг даган дуурайж байж багаасаа өөрийн биед амьдралын хар толбо суулгачихаад амиа хорлоно гэж давчдаад байгаа нь тэр. Өөрөөс нь хамаарах зүйл их байгаа биз. Бурханы шашинд гадагшаа харахаас илүү өөрийгөө хар гэж заадаг. Өөрийгөө сайн харах ёстой, бие рүүгээ харах хэрэгтэй юм байна. Хөвгүүдийг харахаар нэг л хачин, бие нь өөрчлөгдөөд хуруу гар нь савх шиг, компьютер тоглосоор байгаад, биеийн хүчний ажил хийхгүй үлбийсэн, булчин шөрмөсгүй болчихсон. Бидний үед биеийн тамир хийгээд цээжээрээ мундаг бадируун болчихсон, түүгээрээ гайхуулдаг байлаа. Одооны залуучуудын өмдний салтаа нь баачихсан юм шиг тээр дор, урт ханцуйтай юм өмсөөд бүр үлбийлгээд хаячихна. Биен дээр гарч байгаа тэр өөрчлөлт бол толгой дотор хоосон байгаагийн илрэл, юу ч бодохгүй урсгалаар явдаг болсны шинж. Тийм учраас сэтгэл рүүгээ харах хэрэгтэй. Хэлээ ажиглах юм бол бас л нийгмийн будлианыг өгүүлж байна. Зурагтаар гарч байгаа хүмүүсийн хэлж, ярьж байгаа зүйлийг ухамсарлахгүйгээр хуулан, дуурайж байна. Ахмад настны найран дээр очсон нэг их хурлын гишүүн “Таныг урт удаан наслаарай гэж хэлмээр байна” гэсэн. Хэлчихгүй яасан юм бэ? Хэлмээр байна гэдэг чинь арай хэлээгүй байгааг илэрхийлсэн үг шүү дээ. Манайхан бүгдээрээ л ингэж ярьдаг болчихсон.

Гадаад хэл сурч ирээд хүүхдүүдэд хэл заах гэхээр монгол хэл нь пад. Киноны орчуулга хүртэл хангалтгүй болсон. Сэтгэл бузартахаар хэл ингэж бузартаж, бие ч бузартаж байгаа юм.

Өөрийгөө магтаж, дандаа худал ярьсаар байгаад сүүлдээ хэн ч итгэхээ больдог. Чалчаа яриа яагаад нүгэлд орсон бэ гэхээр хүн 70 наслая гэж бодоход өөртөө сайн юм хийхэд дэндүү бага хугацаа. Талыг нь шахуу унтаад өнгөрөөчихдөг, идэж уух, бие засах хугацаа зэргийг тооцоод үзэхээр зөндөө хугацаа ордог. Маш сайн хөдөлмөрлөж чадвал тавхан жилийн дотор асар их сайн юм хийж чаддаг. Эрдэнэт хүний бие их эрдэм, чадалтай, юу ч бүтээж чадах тэр сайхан бие, хэл, сэтгэл гурвыг завгүй байлгаад хамаг цагийг нь алдуулчихдаг. Түүнээс илүү эрх чөлөөг алдуулна гэж байхгүй л дээ. Эхийнхээ гэдсэнд бүрэлдээд, эхийгээ зовоон байж гарч ирчихээд, арай гэж хүн болгож авч байхад өсвөр нас руугаа ороод ирэнгүүт би өөрийнхөөрөө амьдарна, та дуугүй байж бай гээд л эхлэвэл түүнээс илүү нүгэл гэж хаа байх вэ? Юуны өмнө маш сайн сонголттой байх ёстой. Улс орон бол хүнээс л бүрддэг. Хүнээ төгөлдөр болгож чадвал гэр бүл төгөлдөр болно. Гэр бүл амгалан төгөлдөр болоод ирэхээр улс орон түвшин, тайван болдог. Уламжлалт зан заншлаа дээдэлж суралцан, аав ээжийгээ асарч, ах эгчээ хүндэлдэг, дүү нараа энхрийлж, ахмад настнаа ачилж энэрдэг, бие биенийхээ өмнө шударга, үлгэр жишээ үзүүлдэг байх нь чухал. Үүгээр хүн болох хэмжээс тавигдана. Бид эхлээд зөв хүн болох ёстой. Хамтын амьдралд нэг хүн зовох юм бол бусад нь жаргаж чаддаггүй. Нэг нь л архинд орчих юм бол бусдыгаа хөнөөгөөд эхэлдэг.

Зүрх тархи хоёрын зүрх их гол. Хайр гэдгийг сайн ухаарч дадлагажуулах хэрэгтэй. Монгол бол их олон янзын хайр байдаг. Нигүүлслийн хайр, асралын хайр, эцэг эхийн хайр, хайр дурлалын гээд их олон янз байна. Эдгээр нь бүгдээрээ амьдралд хэрэгжиж байж бат бөх гэр бүл болно. Хайр дурлал нь өөрийн эрх ашигтай учраас амархан шантардаг. Эхийн хайр бол хэзээ ч өөрчлөгдөхгүй. Эх хүн үрээ цэцэг, цэврүү шиг байхад нь ч хайрлаж, архинд ороод арвайсан хар юм болсон ч хайрласаар л байдаг. Үүнийг сайн бодох хэрэгтэй. Англи, америк кино гээд хошуурах хэрэггүй. Дотоод сэтгэл рүүгээ, монгол уламжлал, зан заншил руугаа

эргэж харах ёстой. Мэдлэг, соёл, боловсрол эзэмшиж эдгээр гурван зүйлээ төгс төгөлдөржүүлж байж жинхэнэ хүн болдог. Үүнийг бурханы шашинд “Эрх чөлөөг олох цагт нь энхэрлэн бариарай” гэж гайхамшигтайгаар номлосон. Чи эрх чөлөөгөө хамгаалж явахгүй бол бусдын эрхэнд алдагддаг юм гэсэн үг. Бид эрх чөлөөг юугаар дамжуулж мэдэрдэг вэ? Биеэрээ, хэл, сэтгэлээрээ дамжуулж эдэлдэг. Салшгүй гурван эрх чөлөө бол бие, хэл, сэтгэлийн эрх чөлөө. Нүгэлт үйл нь эрх чөлөөг устгаж, зовлонд унагадаг. Бие, хэл, сэтгэл гурав нэгдэхэд хүн болж төлөвшин, бусдад үнэлэгдэнэ. Хичнээн мэдлэгтэй байсан ч дотор талд нь юу ч байхгүй бол өрөвдөлтэй. Бие, хэл, сэтгэлийн эрх чөлөөний эсрэг талд нь нүгэл, эерэг талд нь буян байдаг. Буян хийх тусам эрх чөлөөг авчирч, жаргалтай сайхан амьдрал бий болдог. Өөрийнхөө эрх чөлөөг алдуулж, зовлонд унагах зүйл хийж байгаа бол тэр нь нүгэл юм. Биеэр хийдэг нүгэлд хүн алах, гэр бүлээсээ гадуур явах, хулгай хийх зэрэг орно. Хэлээр хийдэг нүгэлд дэмий донгосох, өөрийгөө магтах, бусдыг муулах, худал хэлэх зэрэг багтдаг.

Хоёрдугаарт сайхан гэр бүл болоод нийгэмд амьдрахад эв зохицлын сургаал хэрэгтэй. Эв зохицлыг бурханы шашинд өөр рүүгээ харахаас өмнө нөгөө хүнээ хар гэж сургасан. Бидний араншин бол өөрсдийнхөө сэтгэлийг урладаг. Сэтгэлийн урлал гэдэг их чухал юм. Түүнийгээ мэдэрч, захирч байхгүй бол хүн хяналтаа алдаад өөртөө дайсныг бий болгоно. Дайсан болох уу, нөхөр болох уу гэдэг нь алга эргэхийн төдий зүйл шүү дээ. Өнөөдөр миний дайсан байлаа ч маргааш миний нөхөр болж болно. Тиймээс магадлал байхгүй энэ хорвоод амьдарч байж өөрийн бодлоор магадлаж дайсан үүсгэх хэрэггүй. Бидний хамгийн том алдаа бол бүх юмыг өөртөө зохицуулах гээд байдаг. 2,8 сая монголыг өөртөө зохицуулах нь зөв үү, өөрийгөө бусдад зохицуулсан нь дээр үү гэдгийг бодох хэрэгтэй. Бид аав ээжийгээ, багшийгаа хүртэл өөртөө зохицуулж амьдрах гээд байгаа нь харилцаанаас ил харагддаг. Далд харагдахгүй зүйл ч олон байгаа нь ойлгомжтой. Мунхагийн харанхуй, хүсэл тачаал, уур омог нь муу сэтгэлийн суурь. Энэ бүхний цаана мэдлэггүй, мунхаг сэтгэл байж, түүний зарц болдог. Хүсэл тачаал, уур хоёр хамгийн түрүүнд зарцлагддаг. Өөрийнхөө дуртай юманд тачааж, дургүй юманд уур хүрдэг. Эрүүл мэнд, нийгмийн харилцаа зэрэг хамаг юмыг зохицуулж өгдөг асуудал энд байгаа. Яаж зохицуулдаг вэ гэхээр мунхаг сэтгэл ихсээд ирэхээр толгой тархи, ходоод зэргээ гэмтээж эхэлдэг. Уур ихсээд ирэх юм бол элэг, цөс тэргүүтнээ гэмтээдэг. Хүний дотоод сэтгэхүй нь бие махбодь, хэлээ захирч төлөвшүүлдэг. Нийгмийн урсгал дунд хөгжиж боловсрохдоо ухамсартай байхгүй бол нэг мэдэхэд хамгийн хөгжилтэй орны юмыг авлаа гэсэн чинь хамгийн хогийн юман дотор орчихсон байх аюултай. Үүнийг маш сайн анхаараарай. Би та нарт ойлгуулахын тулд их энгийнээр ярилаа. Бид хоосон улс биш, бидэнд их боломж бий шүү гэдгийг мэдүүлэхийн тулд хамба гэдгээ мартаад яг танай аав ээж болж хамаагүй юм ярилаа. Та нар энэ бүхнийг сайн бодоорой.



**VIP клуб ТББ-ын тэргүүн, Монголын лектор төвийн жинхэнэ гишүүн, “Соёолж”
зохимжит хоолны газрын зөвлөх Б.ГЭРЭЛМАА:**

Амжилтыг цааш нь түлхэгч хүчийг хэрхэн багасгах вэ?

Өнөөдөр энд эрт босдог, өөдрөг тэмүүлэлтэй, өөрийгөө хөгжүүлэх зорилготой хүмүүс байгаа нь ойлгомжтой. Бид бүгдээрээ амжилтаар дүүрэн байхыг хүсдэг. Хүссэндээ хүрсэн хүнийг амжилттай явна гэдэг. Хүний хүсэл – аз жаргал. Хүн жаргахын тулд төрдөг.

Аз жаргал гэдэг нь эрүүл байх, мөн хангалттай мөнгөтэй байх үед төрдөг мэдрэмж. Мөнгөний тухайд бол зөвхөн өөрийн материаллаг хүслийг хангах хэрэгцээ юу, эсвэл бусдын тусын тулд хийх үйлэнд зориулах хэрэгцээ юу гэдгээрээ зарчмын ялгаатай тэс өөр хоёр сэдэл байдаг тул аз жаргалын мэдрэмж нь бас хоёр өөр байдаг байна.

Бид амжилтыг татах хүчний тухай сүүлийн үед сүрхий сайн мэддэг боллоо. “Нууц” гэдэг номыг уншаагүй хүн энэ танхимд байхгүй бизээ. Гэхдээ татах хүчний нууцыг олж мэдээд, зааврын дагуу маш их хичээгээд ч хүсэл биелэхгүй байх нь их түгээмэл.

Таталцлын хууль үйлчлэхгүй байна гэж бодмоор. Зарим хүн “энэ бүх яриа худал юм байна” гэсэн дүгнэлтэд хүрсэн ч байдаг. Тийм бүтэлгүйтэл ч гэсэн хууль үйлчилж байгааг нотолж байгааг ойлгох хэрэгтэй.

Үүний учир нь түлхэх хүчинд оршиж байгаа юм. Татах хүч сул, түлхэх хүч их учраас амжилт ирэхгүй байна гэсэн үг. Орчлонгийн бүх юмс, үзэгдэл нь арга, билгийн тэнцвэрт төлөвт л жам ёсоороо зөв бүтдэг бөгөөд энэхүү тэнцвэр алдагдсаны нотолгоо нь бидний өнөөдрийн аз жаргалын түвшин юм.

Түлхэх хүч их байхад татах хүч бага байна. Түлхэх хүчийг багасгахгүйгээр татах хүч нэмэгдэхгүй. Арга, билгийн нэгдлийг илэрхийлдэг хос загастай дүрс дээр авч үзвэл хар тал нь их байхад цагаан тал бага байна. Ертөнцийн бүх юмс нэг бүхэл бөгөөд эсрэг тэсрэг хоёр хэсгээс бүрддэгийг арга билиг гэдэг шүү дээ. Аль тал нь давамгайлж байна гэдгийг тухайн цаг үеийн үр дүнг гэрчилнэ.

Тэгвэл түлхэх хүч яагаад их байдаг вэ?

Түүнийг яаж багасгах вэ?

Юуны түрүүнд түлхэх хүч гэж юу болохыг ойлгох хэрэг гарна. Хамгийн энгийнээр тайлбарлах гэж оролдвол энэ нь тухайн хүний сэтгэлийн сөрөг тал юм.

Хүнд махбодь буюу физик бие, хийбодь буюу сэтгэл, оюун ухаан гэсэн гурван гол бүрдэл байдаг. Өнөөдөр олонхи хүн үндсэндээ физик биеийнхээ тухайд их санаа тавьдаг. Оюун ухаанаа хөгжүүлэхийг их анхаардаг. Харин сэтгэлийн боловсролд санаа тавих нь тун бага.

Жаргал, зовлон гэдэг нь зөвхөн мэдрэмж бөгөөд сэтгэлийн төлөв юм. Гадны нөхцөл байдлаас шууд хамаарч мэдрэмж үүсдэг гэж бодох нь эндүүрэл юм байна. Сөрөг мэдрэмж нь түлхэх хүч болдог. Тиймээс хүний сэтгэлд айдас түгшүүр, уур бухимдал, үзэн ядалт, хорсол гомдол, аминч үзэл, атаархал, бардамнал, дээрэнгүй байдал оршиж байвал тэр хүн хичнээн ч амжилтын мөрөөдөл, зорилготой байгаад аз жаргалыг үздэггүй. Ийм хүнийг харанхуй хэмээн тодорхойлж, хатуу, хүйтэн, хурц иртэй юмтай зүйрлэдэг.

Харин хайрын эх булгаа нээж, асрал энэрэл, өршөөл нигүүсэл, талархал, хариу нэхдэггүй өглөгийн эзэн болсон хүн татах хүчийг эзэмшдэг бөгөөд ийм хүнийг гэрэл хэмээн тодорхойлж, зөөлөн, халуун бүлээн, урсгал юмтай адилтгадаг.

Мэдрэмж гэдэг бол сэтгэлийн илрэл юм. Энэхүү сэтгэлийг боловсруулах ажил нь оюуны боловсрол олж авахаас зарчмын ялгаатай.

Хүний мөн чанар болох сэтгэлийн тухай гүнзгий мэдлэгтэй болсноор ажил бүтдэг байсан бол бүх лам, бясалгагч нар татах хүчийг бүрэн эзэмшсэн хүчирхэг гэрэлнүүд байх байсан. Гэтэл байдал арай өөр байдаг нь үүний цаана нарийн учир байгааг гэрчилнэ.

Цагаан талыг мэдлэгээр шууд ихэсгэж болдоггүй бөгөөд хар талыг багасгахад л нэмэгдэнэ. Энэ зүйрлэл нэн хийсвэр бөгөөд төсөөлөл төрүүлэхэд л туслах зорилгоор хэрэглэгддэг. Хар, цагаанаараа ялгараад оршиж байх юм байхгүй. Холилдож сүлэлдсэн хэлбэр л байна. Час халуун, цэв хүйтэн хоёр янзын усыг хольж, бүлээн болгож чадвал уух, угаахад таарна. Савтай усны нэг талд нь халуун нь, нөгөө талд хүйтэн нь ялгаралгүй холилдоод байгааг л хүйтэн бүлээн, халуун бүлээн гэх мэтээр мэдэрдэг шиг.

Хар талыг нэмж улам түнэр харанхуй болгохгүй байх, сэтгэлийн хир буртгийг цэвэрлэж ариусгах нь амаргүй ч гэсэн хийж болох ажил. Гагцхүү аргыг эзэмшиж, дадлагыг тасралтгүй хийснээр харанхуйд гэрэл нэвтрэх нүх сүв үүсч, сэтгэл гэгээтэй болох ажил урагшилдаг. Амжилт аяндаа ирдэг. Эргэж буцахгүйгээр.

Түлхэх хүч яаж үүсдэг вэ?

Гадаад ертөнцтэй мэдрэхүйн таван сувгаар харилцах агшин бүрт төрдөг мэдрэмж нь гаднын юмс, үзэгдлээс биш сэтгэлд өмнө нь суусан ул мөрөөс хамаардаг гэдгийг 2500 гаруй жилийн өмнө нэгэн суут хүн олж мэдсэн байдаг.

Ямар нэг үйл явдал болж байхад хүмүүс янз бүрээр хүлээж авдаг нь ийм учиртай юм байна. Үүнийг тайлбарлахад ихээхэн цаг орох бөгөөд миний чадвар ч мөхөсдөх бизээ. Тиймээс энэ тухай маш ойлгомжтойгоор энгийн хялбар тайлбарлаж чаддаг олон хүмүүсийн, жишээ нь

Майкл Роач багшийн “Очир огтлогч”, П.Бадрал багшийн эрхлэн гаргадаг Агнистийн гэгээ цуврал гэх мэт олон сайхан номноос уншиж судлах нь дээр.

Өнгөрсөн цагт болоод өнгөрснийг өөрчилж чадахгүй юм чинь одоо цагт илэрч байгаа үр дүнг нэгдүгээрт, ажиглаж, өмнөх үйлдээ дүгнэлт хийгээд, хоёрдугаарт, тухайн агшинд тохиолдож байгаа явдлыг сэтгэлээ номхотгох дадлагад ашиглах нь хамгийн зөв ажил болдог. Энэ нь хэлэхэд амархан ч хийхэд нэн түвэгтэй дасгал юм. Гэхдээ ийм дасгалыг л уйгагүй хийж чадвал өнөөх түлхэх хүчийг чимх чимхээр ч гэсэн багасгаж болдог.

Ямар нэгэн зүйлд уур хүрлээ гэхэд тэр зүйл нь уур хүргэх ямар ч мөн чанаргүй, хоосон чанартай нейтрал саармаг зүйл атал түүнийг хараад, сонсоод, амтлаад, үнэрлээд, хүрээд уур хүрч байгаа нь сэтгэлийн асуудал бөгөөд түлхэх хүчийг үүсгэн арвижуулж байгаа үйлдэл. Уур хүрч байгаагийн жинхэнэ шалтгаан нь урьд өмнө хэзээ нэгэн цагт сэтгэлдээ үүсгэн цацруулмагц мөнөөх л сэтгэлд “бичигдэн” үлдсэн сөрөг долгион юм. Хэзээ ч шамшигдан устдаггүй тэр “бичлэг” буюу ул мөр сэтгэлд хадгалагдан байхдаа үржиж арвижих хуультай учир “боловсорч” гүйцсэн нь тэрхүү зүйлээр өдөөгдөн илэрч, тэр зүйлийг уур хүрмээр гэж санагдуулдаг. Үүний учрыг олохыг хичээх нь маш их ашиг тустай ажил байдаг.

“Харагдуулах”, “санагдуулах”, “хоосон чанар”, “үйлийн үр” гэх зэрэг нэр томъёоны утга нь аль ч цагт маш их ач холбогдолтой. Яагаад гэвэл үүнийг ойлгоогүй бол таталцлын хуулийг ашиглаж, амжилтанд хүрч, аз жаргалтай амьдрах боломжгүй.

Энэ цагийн агуу хүмүүсийн нэг яруу найрагч Мэнд-Ооёогийн “Хүний гэрлийн дууль” гэдэг шүлэг татах, түлхэх хүчний тухай гэж би боддог.

Орчлон төрхөө олоогүй байхад

Огторгуйн наран мандаагүй байхад Эртний хүмүүс өөрийн биеэсээ Эрдэнийн гэрэл цацраадаг байжээ.

Салаа модод гэрэлт жимстэй

Санаа сэтгэл гэрэлт бодолтой Гэрэлт хүмүүс харанхуйг сүлж Гэм зэмгүй амьдарч байжээ.

Өөрийн модных нь гэрэлт жимс

Өдий төдийгээр сагсайж байхад Бусдын жимс зарим нэгэнд нь Бузгай амттай санагдах болжээ.

Гэрлээ унтраагаад тийм хүмүүс

Гэтэж мярайж явах болжээ. Хаяа бөөрөө хадран хумсалж Харанхуй царайлан суух болжээ.

Нэг нэгээрээ гэрлээ бөхөөсөөр Нэлэнхүй даяараа харанхуйд живжээ.

Галав эрин юүлэн өнгөрч

Ганцхан домог хорвоод үлджээ. Буман жилийн харанхуйн дараа Бурханы авралаар наран гийжээ

Бичин баларын зуун улирч

Бидний эрин дэлхийд манджээ. Гэрэл гэдэг улам л хэрэгтэй Гэгээн наран ч багадах болжээ.

Орон дэлхийгээ гэрлээр сондорлож

Одон мичидийн гижигийг хүргэжээ. Цацрах туяатай чимэг юугаар Царай зүсээ ч гоодох болж

Ондоо бусдын гэрэлд шүтэж

Одоогийн хүмүүс явах болж Өөрт нь байсан өнийн гэрлийн Өнгө нь улам буурах болжээ.

Сэвгүй царай нь гэрэлтэгч хүмүүсийн

Сэтгэлийн гэрлийг л үгүйлэх боллоо Өмнөх галав руу дахиад өнгийж Өнөөх домгоо дурсах боллоо Энэ бүхнийг ойлгож мэдэрч, өөрсдийнхөө гэрлийг асааж явдаг хүмүүс бидний дунд олон байдаг. Тэр хүмүүсийн ачаар орчлон ертөнц өдий зэрэгтэй сайхан байдаг гэж би ойлгодог. Бидний татах хүч ерөөсөө л гэрэлд байдаг. Зовлон гэдэг бол гаднын ямар нэгэн нөлөөнөөс хамааралгүй биднээс л хамаарч байдаг юм.

Үүнийг бид харсаар, мэдсээр, сонссоор байгаад дасаад, “за, нэг тийм нэг яриа байдаг, жаахан амьдралаас тасархай” гээд ойшоодоггүй. Өнөөдөр бидний дунд маш өндөр боловсролтой, олон сургууль төгссөн, эрдмийн зэрэг цол хамгаалсан, мөнгө төгрөгтэй баян чинээлэг боловч таг харанхуй хүн байх тохиолдол зөндөө. Материаллаг хэрэгцээ хангагдаад аз жаргалтай болдоггүй.

Аз жаргалыг таашаалтай мэдрэмж гэж болох боловч хоёр өөр таашаал байдгийг “Тогмар ложон” хэмээх сударт маш тодорхой тайлбарлажээ.

Харанхуй хүний мэдэрдэг таашаал бол шуналын таашаал, гэрэлтэй хүнийх ариуслын таашаал.

Энэ хоёр таашаал хоорондоо чухам ямар ялгаатай, яагаад тийм ялгаатай болдгийг ойлгоход татах, түлхэх хүчний учир олдоно.

Хүн өөрийнхөө жаргалын ч, зовлонгийн ч шалтгаан гэдгийг ухаанаар ойлговч, мэдсэнээ ажил болгож чаддаггүйгээс л бид утга төгс амьдарч чаддаггүй.

Өөрөөс гадна орших зүйлийг танин мэдэх гэж асар их хүч хөдөлмөр, хөрөнгө, цаг зарцуулж, жаргаж чадахгүй байгаадаа бусдыг буруутгасаар энэ насыг барахын оронд өөрийгөө таних ажлыг хойш тавилгүй эхэлж, эмнэг догшин адгуус, эсвэл нялх балчир хүүхэдтэй адилтган зүйрлэж дүрсэлдэг сэтгэл гээч мөн чанараа таньж, номхотгон эрхэндээ хурааж сурвал амьдрал үнэхээр гайхамшигтай сайхан, яруу тансаг гэдгийг агшин бүрт мэдэрч, хүн болж төрсөн боломж завшааныг үр бүтээлтэй ашиглан, сэтгэлийн боловсролоо шаг ахиулах

байтугай “сургуулиа төгсөх” ч энүүхэнд ажээ.

Та бүхэнд амжилт, аз жаргалыг хүсье.

Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хэл бичгийн шинжлэх ухааны доктор,
МУИС-ийн тэргүүлэх



ШУТИС, КТМС-ийн профессор, доктор(ScD), профессор Л.Оюунцэцэг

“Инноваци -монгол улсын хөгжлийн шинэ гарц”

“American dream” гэсэн ойлголт байдгийг олон хүн мэдэх байгаа. Энэ бол америкчуудын хүсэл мөрөөдлийн биелэлийн илэрхийлэл. Энэ нь америк маягийн амьдралын идеал төсөөлөл, түүнд хүрэх хүсэл тэмүүллийн нэгдлээр илэрдэг. Энэхүү идеал нь олон америкчуудын ирээдүйн зүг чигийг зааж, ажил, амьдралынх нь зорилго болж байдаг. Уг идеал нь элбэг дэлбэг, баян тансаг эд хөрөнгөтэй байх төдий биш, сэтгэл амгалан, эрүүл саруул зөв ухаалаг, ёс суртахуунтай аж төрөх, бүтээлчээр ажиллаж хөдөлмөрлөх, нийгэмд тодорхой байр суурь эзлэх зэргээр хувь хүн өөрийн амьдралын зорилгоо тодорхойлж, түүнд хүрэх эрмэлзлэлийг бүхэлд нь агуулдаг.

Гэтэл бидэнд үүн шиг “Mongolian dream” гэж байна уу? Мэдээж хүн бүрт хүсэл мөрөөдөл бий. Харин улс үндэстэнээрээ, монголчууд нийтээрээ мэддэг, эрхэмлэн дээдэлдэг, эрмэлзэж явдаг тийм мөрөөдөл байна уу? Тодорхой хэлэх зүйл олдохгүй байгаа биз? Энэ юу гэсэн үг вэ гэвэл бидний нийтлэг хүсэл мөрөөдөл “American dream” гэдэг шиг тийм тодорхой болоогүй байгааг харуулж байна. Тэгвэл “Mongolian dream” буюу монгол мөрөөдөл гэдгийн талаар бодитой төсөөлөл бий болгох, түүнийг хэрэгжүүлэхэд монголчууд бид яах ёстой вэ? Бид бүгд энэ талаар бодох ёстой, ярилцах хэрэгтэй, нэгдмэл үзэл бодол, ойлголттой болох шаардлагатай болж байна.

Энэ асуудлын нэг гол чиглэл бол манай эх орны ирээдүйн хөгжлийн чиг хандлагын тухай асуудал юм. Монгол улс хаашаа явах ёстой вэ? Ямар арга замаар хөгжилд хүрэх бол? Бид ирээдүйд улс орноо ямар байгаасай гэж хүсч мөрөөдөж байна вэ? Энэ бүх асуултууд хариугаа хүлээж байна.

Миний хувьд энэ сэдвээр 2003 оноос эхлэн оюутнуудтай хичээл сургалт, уулзалт, семинараар санал солилцож, хурал семинар дээр илтгэл тавьж ирлээ. Миний ингэж бодож явдаг, зорьдог зүйлтэй Монгол тэмүүлэл-Сайхан Монгол орон ТББ-ын үйл ажиллагаа нийцэж байгаад би их баяртай байна.

Энэ удаагийн лекцээр өнөөдөр дэлхий дахины орчин үеийн хөгжлийн чиг хандлага хаашаа явж байгаа болон үүнтэй манай Монгол улс хэрхэн яаж хөл нийлүүлэх вэ гэдэг талаар ярья.

Эдүгээ хүн төрөлхтөн хөгжил дэвшлийн цоо шинэ эрин үед шилжин орж байна. Мэдлэг оюуны үнэ цэнэ улам бүр нэмэгдэж, хөгжлийн тулгуур хүний хүчин зүйлд шилжих үйл явц

эрчимтэй өрнөж байна. Мэдлэгийн үүрэг шинэчлэгдэж, эдийн засаг, үйлдвэрлэлийн нэг чухал хүчин зүйлд тооцогдох болов. Мэдлэгийн менежмент, мэдлэгт түшиглэсэн эдийн засаг, мэдлэгт суурилсан нийгэм гэсэн ойлголтууд бий болж, амьдрал практикт бодитойгоор хэрэгжих шатандаа оржээ. Энэ нөхцөлд аливаа улс орны нийгэм- эдийн засгийн хөгжилд шинжлэх ухаан технологийн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай болж байна. Улс орнуудын өрсөлдөх чадвар хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, байгалийн баялгаар бус, харин мэдлэг оюунд түшиглэн нөөцөө хэрхэн үр өгөөжтэй ашиглаж байгаагаас ихээхэн хамаарч, үүнд инноваци шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боллоо. Үүнтэй холбоотойгоор шинжлэх ухааны мэдлэгийг үр ашигтай хэрэглээ болгон хувиргахад чиглэсэн инновацийн үйл ажиллагаа ихээхэн эрчимжиж, түүнийг баримжаалах явдал улс орнуудын эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн цоо шинэ хандлагыг тодорхойлж байна. Энэ нь өндөр хөгжилтэй орнуудын хувьд аж үйлдвэржилтийн дараах нийгэм, мэдлэгт түшиглэсэн эдийн засгийг хөгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгаа төдийгүй, хөгжиж буй орнуудын тухайд хөгжлийн хурдацаа нэмэгдүүлэх, хоцрогдлоо богино хугацаанд даван туулах чухал арга зам болж байна.

Дээр өгүүлсэнтэй холбогдон гарч ирж байгаа мэдлэгийн менежмент (knowledge management), мэдлэгт түшиглэсэн эдийн засаг (knowledge based economy), инноваци гэх мэт ойлголтуудын талаар товч тайлбар хэлье. Мэдлэгийн менежмент (knowledge management) бол мэдлэгийг олж авч, эзэмшиж, түгээж, хэрэглэж, хөгжүүлэх үйл ажиллагааг хамарсан ойлголт. Зарим хандлагаар мэдлэгийн менежментийг оюуны капиталыг удирдах үйл ажиллагаа гэж үзэж байна.

Харин мэдлэгт түшиглэсэн эдийн засаг (knowledge based economy) гэсэн ойлголтыг “мэдлэгийг олж авч, эзэмших, түгээж, хэрэглэх, хөгжүүлэх нөхцөл боломж, чадавхийг бүрдүүлж чадсан эдийн засаг” хэмээн тодорхойлж байна. Мэдлэгийн менежмент, мэдлэгт түшиглэсэн эдийн засаг нь инновацитай шууд холбоотой. Инноваци (innovation) гэсэн ойлголт нь шинжлэх ухааны мэдлэг, шинэ, үр ашигтай зүйлсийг нэвтрүүлж, хэрэглээний эргэлтэнд оруулахтай шууд холбоотой. 2006 онд шинэчлэгдэн батлагдсан Монгол улсын Шинжлэх ухаан технологийн тухай хуульд инновацийн агуулгыг үйл явцын хандлагаар тодорхойлж “Инноваци гэж эрдэм шинжилгээний ажлын үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээл, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх цогц үйл ажиллагаа” хэмээн заажээ.

Ерөнхийдөө инновацийг шинжлэх ухаан технологийн хувьд шинэлэг, практикт хэрэгжүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой, арилжаалагдахуйц, өөрөөр хэлбэл, зах зээлд борлогдон, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангах чадвартай байх гэсэн гурван үндсэн шалгуурт нийцсэн байх ёстой гэж үздэг. Энэ талаас авч үзвэл, “эдийн засгийн хувьд үр өгөөжтэй хэрэглээ болон үйлдвэрлэл, практикт нэвтэрсэн шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүн, технологи, түүнчлэн борлуулалт, удирдлага- зохион байгуулалт, санхүү-эдийн засгийн болон бусад дэвшилтэт шийдлийг инноваци гэнэ” хэмээн тодорхойлж болно.

Мэдлэгт суурилсан эдийн засаг, нийгмийн гол хөдөлгөгч хүч нь өндөр мэдлэг, чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй хүн юм. Иймээс бид бүхний өмнө тасралтгүй суралцаж, хөгжих, хувийн зорилго, амьдралд эзлэх байр сууриа тодорхой болгох, юу чаддаг, ямар арга барилаар ажилладгаа цаг алдалгүй тогтоох, байгууллагын үйл хэрэгт оруулж буй өөрийн хувь нэмрээ

зөв үнэлэх, хүмүүсийн хооронд харилцаа холбоо тогтооход хариуцлага хүлээх зэрэг шинэ шаардлагууд тавигдаж байна. Эдгээрээс үүдэн бид өөрсдийн мөн чанарыг гүнзгий танин мэдэх шаардлага урган гарлаа.

Хүний мөн чанар, түүнийг ажил, амьдралд чухам юу өдөөн идэвхжүүлдэг тухай асуудал эрт дээр үеэс хүн төрөлхтөний сонирхолыг татсаар иржээ. Хүний мөн чанарыг ухаж ойлгох, судалж тайлбарлах оролдлого тасралтгүй хийгдэж, олон тооны бүтээл туурвилууд бий болсон ч эцсийн хариулт бүрэн тодорхой болоогүй байна. Энэ талаар олон арван үзэл баримтлал, онолын хандлага, загварууд бий болсон ба энэ байдал цаашид ч үргэлжлэх хандлагатай байгаа юм. Хүн бүрт тохирох амьдралын нийтлэг загвар байхгүй. Ер нь хүний мөн чанартай холбоотой, хүний амьдралын загварт хандах хэд хэдэн хандлага байна гэж үзэж болно. Үүнд:

1. Хувь тавилангийн

2. Заяа төөргийн

3. Эрэл хайгуулын

4. Идэвхтэй нөлөөллийн

Эдгээрээс эхний хоёр нь гадаад хүчин зүйлсээс хамааралтай бол сүүлийн хоёр нь хүний дотоод хүчин зүйл- мотивтай холбоотой.

“Бие хүн” гэсэн ойлголтыг оросоор “личность”, англиар “personality” гэж тодорхойлж байна. “Personal-ity” нь “persona”- “жүжгийн баг” гэсэн утгатай латин үгнээс гаралтай гэж үздэг бөгөөд энэ нь хүний гадаад, нийгмийн дүр төрхийг илэрхийлдэг. К. Маркс “хүний мөн чанар нь тухайлсан тодорхой нэг хувь хүнд байдаг хийсвэр зүйл биш. Бие хүн бол өөрөө буй байдлын, нийгмийн бүхий л харилцааны цогцолбор юм” гэж тодорхойлжээ .

Ерөнхийдөө хүнийг “бие” + “сэтгэл” + “оюун”-ны нэгдэл хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл, хүн бол бие махбодь-физик “Би”, оюуны “Би”, энергийн “Би” гэсэн гурван “БИ”-ээс тогтоно хэмээдэг. Бие махбодь буюу физик биеийн хувьд статистикийн дундаж хүн нь 70-80 кг орчим жинтэй, 165 см орчим өндөр, бүтцийн хувьд химийн төдийлөн ховор бус элементүүдийн нэгдлээс тогтох ба дийлэнх(70-80 %) хувийг ус бүрдүүлдэг гэдэг. Иймээс үнэ өртөг багатай. Гэвч бие махбодийн хувьд хүн эрүүл саруул байж ажиллаж, амьдарна. Хүний оюуны биеийг сэтгэл санаа, оюун ухаан бүрдүүлдэг гэж үздэг. Хүн янз бүрийн сэтгэлийн хөдөлгөөн(баярлаж хөөрөх, уурлах, уйтгарлах, гомдох цөхрөх г.м.)-тэй, зан төрх(меланхолик, холерик, флегматик, сангвиник г.м.)-тэй. Оюуны чадварын хувьд хэд хэдэн дээд сургууль төгсөж, олон арван гадаад хэл сурч, олон мянган боть ном тогтоох оюуны чадамж (IQ)-тай хэмээдэг. Түүнээс гадна хүнд “дээд оюун ухаан” буюу “сүнс” бий гэж үзэх хандлага ихээхэн түгээмэл болж байгаа бөгөөд дээд оюуны чадвараараа хүн өөрийгөө бие, сэтгэл, оюун ухааны хувьд хөгжүүлэх, өөрийгөө удирдан чиглүүлэх, анагаах эрүүлжүүлэх чадвартай бөгөөд далдыг харах, ирээдүйг зөгнөх зэрэг зөн билэгтэй гэж үздэг .

Иймээс хүний бодол санаа өөрийн гэсэн хүч энергитэй гэдэг ба үүнийг нотлох туршилтууд цөөнгүй хийсэн байдаг. Жишээлбэл, Японы эрдэмтэд хүний сэтгэл зүйн энергийн хүчийг

тогтоох зорилгоор нэгэн сонирхолтой туршилтыг хийжээ. Тэд хэсэг хүмүүсийг хоёр бүлэгт хуваан, нэг хэсгийг биеийн тамирын дасгал бодитойгоор хийлгэсэн бол нөгөө бүлгийг бясалгалаар буюу сэтгэл санаагаар нь биеийн тамирын дасгалууд хийлгэжээ. Ингээд хэсэг хугацааны дараа тэдгээр хүмүүсийн булчин бие махбодь хир зэрэг хөгжсөнийг хэмжиж үзэхэд биет байдлаар дасгал хийсэн хүмүүсийн булчин 30%-иар, бодлоороо дасгал хийсэн хүмүүсийнх 20%-иар хөгжсөн байжээ. Эндээс хүний бодол хүчтэй, хүч энерги бий болгодог гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна. Хүний бодол санаа сайн, зөв байвал эерэг энерги ялгаруулах бөгөөд муу, буруу бодол санаа бол сөрөг энерги ялгаруулж, орчин тойрондоо нөлөөлж байдаг гэж үздэг. Иймээс орчин үед хүнд тавигдах ерөнхий шаардлагуудыг шинээр тодорхойлох хандлага бий болоод байна. Үүнийг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

1. Бие махбодийн чадавхи / BQ- эрүүл мэндээ анхаарах, эрүүл байх;
2. Оюуны чадавхи/ IQ- уураг тархины боломжийг бүрэн дүүрэн ашиглах;
3. Сэтгэлийн тэнхээ/ EQ-бэрхшээлийг даван туулах;
4. Өв тэгш чадавхи/ DQ- эрүүл, мэдлэгтэй ухаалаг, зөв хандлага, эерэг сэтгэлгээ, сэтгэлийн хагтай, оюунлаг-харилцааны үр чадвартай байх ;

Хүний мөн чанар, чадварыг өөрөөр үнэлж, тодорхойлох болсон өнөөгийн нөхцөлд боловсролын салбарын хувьд суралцагчдад ямар мэдлэг, чадвар олгож, хэнийг бэтгэн гаргах ёстой вэ гэдэг асуудлыг ул суурьтай авч үзэх шаардлагатай болжээ.

Нөгөө талаас эдийн засгийн чухал нөөц болж буй мэдлэгийг бүтээх, дамжуулах, түгээх, хэрэглэхтэй холбоотой мэдлэгийн менежментийг судлах, хөгжүүлэх асуудалд ул суурьтай хандах нь зүйтэй юм. Мэдлэг амархан хуучирдаг, хоцрогддог тул хүн бүр байнга, тасралтгүй суралцаж, мэдлэгээ шинэчилж байх шаардлага тулгарч байна. Тэр ч бүү хэл хүн бүр төдийгүй байгууллагаараа суралцах, улс үндэстнээрээ суралцах тухай яригдах болов. Эдгээрийг илтгэсэн “суралцагч

-байгууллага”(learning organization), “суралцагч -үндэстэн”(learning nation) гэсэн ойлголтууд бий болоод байна.

Нэгэнт дэлхий дахины хөгжлийн гол чиг хандлага мэдлэгт тулгуурласан, инновацийн чиг баримжаатай болсон өнөөгийн нөхцөлд манай орны хувьд энэхүү нийтлэг хандлагатай “хөл нийлүүлэх” шаардлагатай болж байна. Иймээс манай орны хувьд мэдлэгийн буюу инновацийн эдийн засгийн үндэс суурийг цаг алдалгүй тавьж, түргэн хугацаанд бэхжүүлэн хөгжүүлэх хэрэгтэй юм. Үүнийг хэрхэн шийдвэрлэх талаар бид судалгаа явуулсан бөгөөд тодорхой шийдлийг санал болгож байгаа болно.

Энэ талаар товч авч үзье.

Улс оронд мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх гол арга механиз нь Үндэсний Инновацийн Тогтолцоо (National Innovation System) бүрдүүлэх явдал болохыг олон улс орны туршлага харуулж байна. “Үндэсний инновацийн тогтолцоо бол шинэ, эдийн засгийн хувьд үр ашигтай

мэдлэгийг бий болгон нэвтрүүлж, хэрэглээний эргэлтэд оруулан ашиглахад тодорхой үүрэг гүйцэтгэн, хувь нэмэр оруулдаг, өөр хоорондоо харилцан уялдаатайгаар инновацийн хүрээнд хамтран ажилладаг төр, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллага, субъектүүдийн цогц нэгдэл” юм. Үндэсний Инновацийн Тогтолцоо (ҮИТ)-г бүтцийн хувьд авч үзвэл:

- Мэдлэг бий болгох дэд систем: шинжлэх ухаан, боловсрол
- Инновацийн үйлдвэрлэлийн дэд систем: том үйлдвэрүүд, инновацийн жижиг, дунд үйлдвэрүүд
- Инновацийн арилжааны дэд систем: инновацийн бүтээгдэхүүний зах зээл, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн зах зээл
- Инновацийг дэмжих дэд систем: мэдээллийн дэмжлэг, хууль эрх зүйн дэмжлэг, удирдлага-зохицуулалтын дэмжлэг, санхүүгийн дэмжлэг, инновацийн дэд бүтэц зэргээс бүрдэнэ.

Өнөөгийн байдлаар манай орны эдийн засгийн хөгжил мөчлөгийн идэвхитэй үедээ байна гэж үзэж болохоор байна. Ерөнхийдөө манай улсын эдийн засаг нь түүхий эдэд тулгуурласан, гадаад орчны болон байгаль цаг уурын хүчин зүйлсийн нөлөөнд мэдрэмтгий шинжтэй юм. Тодруулбал, Монгол улс нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, аж үйлдвэр- ХАА-н орон. Гол онцлогуудыг дурьдвал: хоёр том гүрний дунд орших, далайд гарцгүй, эх газрын орон бөгөөд эдийн засгийн цар хүрээ багатай, харьцангуй хүн ам цөөн, газар нутгийн хэмжээ томтойгоос хүн ам сийрэг суурьшсан, эрс тэс уур амьсгалтай, жилийн дөрвөн улиралтай тул байгаль цаг уурын нөхцөл байдал харьцангуй хүнд, байгалийн нөөц, ашигт малтмалаар баялаг боловч олборлолт, ашиглалтын нөхцөл хүнд, нутаг дэвсгэрийн дийлэнх хувьд геологи хайгуул хийгдээгүй, хүн амын хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн их, хүн амын 30% орчим нь нүүдлийн хэв маягийн аж ахуй эрхэлж, аж төрдөг, хүн амын бүтцэд хүүхэд залуусын эзлэх хувь хэмжээ өндөр байгаагаас, нэг ажиллагчид хөдөлмөрийн бус насны 3 хүн ногддог, аж үйлдвэрт ашигт малтмал олборлох болон эрдэс байлаг, МАА-н түүхий эд боловсруулах үйлдвэрлэл давамгайлдаг, ХАА-н голлох салбар нь нүүдлийн МАА, улс орны нийгэм- эдийн засгийн хөгжилд гадаадын зээл тусламж ихээхэн үүрэг, нөлөөтэй байгаа нь гадаад орчноос хамааралтай байдалд хүргэдэг зэргээр тодорхойлогдож байна.

Инновацийн хүрээнд явуулсан судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл, өнөөгийн байдлаар Монгол улс нь инновацийн хөгжлөөр дэлхийн түвшний 20-30% -д байна. Инновацийн потенциалын хувьд дэлхийн дундаж болон Шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, мөн ҮИТ хөгжүүлэх хөтөлбөрт тусгагдсан 2015 онд хүрэх бодлогын зорилтот түвшний 35%-д байна гэсэн үнэлгээ гарлаа. ҮИТ-ны ерөнхий төлөв, үр ашгийн үнэлгээ 0.361 гэсэн интеграль үзүүлэлтээр үнэлэгдсэн нь дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан 2015 онд хүрэх зорилтот түвшний 36% орчимд байна гэж үзэж болно. Харин Дэлхий банкны институтийн мэдлэгийн эдийн засгийн түвшинг тодорхойлох судалгаагаар 45% (үнэлгээ 4.50 оноо, Зүүн Азийн дундаж түвшин -6.59 оноо)-тай гарчээ. ШУТ-ийн аюулгүй байдлын үнэлгээгээр критик түвшний дөнгөж 16%-д байгаа нь ноцтой нөхцөл байдал мөн.

Аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварын түвшин үлэмж доогуур байгаа нь үйлдвэр аж

ахуйн газрууд техник- технологийн хувьд ихээхэн хоцрогдонгүй байгааг илтгэж байна. Аж үйлдвэрийн дийлэнх салбарууд технологийн хувьд I ба II дахь хэвшлийн түвшинд байна. Салбарын бүтцийн шинжилгээнээс үзэхэд дийлэнх дэд салбарууд капитал ба хөдөлмөр эзлэмж ихтэй (60%), бага болон бага-дунд ур чадвар шаардагдах (70%) үйлдвэрлэлд хамрагдаж байна. Үйлдвэрлэлийн 85% нь шинжлэх ухааны багтаамж багатай байна. Экспортын ихэнх хувь (97.7%)-ийг технологигүй (No-tech) ба нам технологийн (Low-tech) бүтээгдэхүүн эзэлж, импортын бүтээгдэхүүний 25 % нь нам технологийн, 73%-дундаж технологийн, дөнгөж 2%-өндөр технологийн бүтээгдэхүүн тус тус эзэлж байна.

Улс орны инновацийн хөгжлийн өнөөгийн байдлыг нэгтгэн дүгнэвэл: инновацийн далайцтай бодлого байхгүй; үндэсний инновацийн оновчтой тогтолцоо, механизм бүрдээгүй; инновацийн хэрэгжилтийн үр дүн хангалтгүй; хувийн хэвшлийн инновацийн потенциал, идэвхжил сул, сонирхол бага; шинжлэх ухаан- боловсрол- бизнесийн үйл ажиллагааны уялдаа холбоо сул, хамтын ажиллагаа хангалтгүй; инновацийн санхүүжилтын эх үүсвэр, хөрөнгө дутмаг зэргээр тодорхойлогдож байна. Гэсэн хэдий ч улс орны хувьд инновацийн чиг баримжаагаар хөгжихөд шаардагдах багагүй нөөцтэй гэж үзэж болно. Түүнээс гадна манай үндэсний эдийн засгийн гол онцлог нь юуны өмнө “жижиг” эдийн засаг байгаатай холбоотой. Ийм эдийн засагтай улс орны хувьд дотоод зах зээлийн хэмжээ багтаамж бага, дэлхий эдийн засаг болон олон улсын хөдөлмөрийн хуваарьт хамрагдах оролцоо бага, үзүүлэх нөлөө сул, эдийн засгийн хүч чадал багатай зэрэг сул талуудтай боловч бэсрэг эдийн засгийн хувьд юуны өмнө уян хатан, түргэн өөрчлөлт хийх боломжтой, инерци багатай, динамик шинжтэй, манервлах чадвар өндөр зэрэг давуу талуудтай. Иймээс өөрийн давуу тал дээрээ түшиглэн ҮИГ үр ашигтай тогтолцоо бүрдүүлж, шинжлэх ухаан, аж үйлдвэрийн баазаа шинэчлэн, нөөц, потенциалын ашиглалтын үр өгөөжийг эрс дээшлүүлэх замаар богино хугацаанд технологийн хоцрогдлоо давах туулах боломжтойн дээр, үүнийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол хүн бүрийн итгэл сэтгэл, хичээл зүтгэл, хөдөлмөр бүтээл чухал үүрэгтэй юм. Энэ бүгдийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь нийгмийн эрүүл сэтгэхүй, зөв, эерэг хандлага, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх явдал мөн.

Нийгмийн сэтгэхүй, түүнийг зөв төлөвшүүлэх талаар олон асуудал хөндөж болох ч манай өнөөгийн нийгмийн сэтгэхүйд төлөвшүүлэх ёстой нэг зүйл бол, өмнө өгүүлсэнчлэн, монголчуудын амьдралын зөв хэв маягийн талаарх нийтлэг идеал төсөөлөл бий болгох явдал юм. Хэдийгээр хүн бүр ирээдүйн амьдралаа өөр өөрөөр төсөөлж болох боловч монголчуудын хувьд нийтээр эрхэмлэн, түүнд хүрэхээр эрмэлзэн тэмүүлдэг тийм хэв маяг зайлшгүй байх ёстой гэж үзэж байна. Энэ нь хүмүүс хэрэглээгээ ухаалаг болгох, орлого зарлагаа зөв зохицуулах замаар хуримтлал бий болгон ирээдүйд хүрэхээр төсөөлж, зорьж буй амьдралын таатай орчноо бүрдүүлэхэд түлхэц болох бөгөөд ингэснээр улс орны ирээдүйн хөгжил дэвшилд эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй. Манай судлаачдын явуулсан зарим судалгаагаар монголчуудын 41 орчим хувь нь “үрэлгэн”, 30 гаруй хувь нь “гэнэн”, 15 орчим хувь нь “жоорломтгой”, дөнгөж 8 хувь “ухаалаг” хэрэглэгч байдаг ажээ .

Амьдралын идеалыг бүрдүүлэх үндэс суурь нь тухайн улс орны үндэсний соёл, зан заншил, нийгмийн үнэт зүйлс юм.

Тэгвэл монголчуудын нийтлэг үнэт зүйлс юу вэ? Үүнд эх орон, үндэсний өв уламжлал, соёл, зан заншил, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн тэгш байдал, шударга ёс гэх мэтээр олон зүйлсийг хамруулж болно. Манай улсын Үндсэн хуульд: “Монголын ард түмэн улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн заасан байдаг. Эдгээр нь монголчууд бидний зорих ёстой үнэт зүйлсийн шалгуур болно гэж үзэх үндэстэй.

Ингээд үзэхэд манай нийгмийн эрхэмлэн үзэх үнэт зүйлсийг бүгд мэддэг мэт боловч тухайлан тодорхойлж тунхагласан зүйл одоогоор алга байна. Иймээс нийгмийн үнэт зүйлсээ тодотгон томъёолж, нийтэд түгээн хүртээл болгох нь зүйтэй юм.

Монголчуудын амьдралын идеалын социализмийн үеийн дүр төрхийг тодорхойлбол нэг иймэрхүү байсан байж болох талтай: Улсын орон сууцтай (2 өрөө байр, хөргөгч,

телевизор г.м.); 1-2 хүүхэдтэй; Гадаад(ах дүү социалист орнуудад)-д боловсрол эзэмшсэн; Улсад ажил хөдөлмөр эрхэлдэг; МАХН-ын гишүүн байх; Төрийн дээд цол, одон медаль, гавьяа шагналтай;

Тэгвэл зах зээлийн харилцааны нөхцөлд өнөөгийн монголчуудын амьдралын нийтлэг дүр төрх, эрмэлзлэл дараах байдлаар төсөөлөгдөж байна: Хувийн орон сууцтай(хотын, зуслангийн г.м.); Машин, гар утас, электрон хэрэгслүүдээр бүрэн хангагдсан; 1-2 хүүхэдтэй; Хувийн бизнес эрхэлдэг; Төрийн өндөр албан тушаалд ажилладаг; Өндөр цалин хөлстэй ажил эрхэлдэг; Гадаадад суралцаж, боловсрол эзэмшсэн, үр хүүхдээ сургадаг; Гадаадад ажилладаг; Эрүүл мэнддээ анхаарал хандуулдаг;

Ирээдүйн амьдралын идеал дүр төрхийг бүрдүүлэх гол хүчин зүйлсэд доорхийг хамруулж болох болов уу.

Үүнд:

шалгуур гэж үзэж болох ба эдгээрийг харгалзан түүний бодит дүр төрхийн төсөөллийг бий болгох шаардлагатай байна. Үүний тулд монголын оюуны элитүүд, шашны зүтгэлтнүүд, эрдэмтэд, сэхээтнүүд, зохиолч, яруу найрагч, сэтгүүлч, зураач, дизайнер, архитекторууд нэгдэж ажиллах шаардлагатай байна. Ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэн, кино урлагийнхан энэ тал дээр онцгой анхаарал хандуулах нь зүйтэй юм.

Энэхүү идеалыг бий болгон, хүмүүсийн ухамсарт шингээж, итгэл үнэмшил болгоход төр, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагуудын ухаалаг, бодлого, үйл ажиллагаа мөн ихээхэн үүрэг гүйцэтгэнэ.

Эцэст нь тэмдэглэхэд дээр өгүүлсэн зүйлс нь ард иргэд, оюутан залуус, мэргэжилтнүүд, эрдэмтэд судлаачдад санаа өгөх төдий бөгөөд эрхэм уншигчид энэ асуудлыг цаашид оюун ухаандаа тунгаан, баяжуулан сайжруулж, бодит үр дүнд хүргэх тал дээр ухаан бодлоо

уралдуулна хэмээн найдаж байна.



“Монгол тэмүүлэл-Сайхан Монгол орон” ТББ-ын Гүйцэтгэх захирал Н.Цэндмаа

“Монгол тэмүүлэл- монгол хүний хөгжил”

Сүүлийн үед хүний хөгжлийн тухай их ярих болжээ. Дэлхийн түвшинд хүний хөгжлийг тодорхойлох аргачлал байдаг. Энэ аргачлалаар хүний хөгжлийн индексийг тодорхойлохдоо 3 үзүүлэлтийг харгалзан үздэг.

НЭГ. ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ИНДЭКС - Тухайн орны хүн амын боловсролын түвшин нь хөгжлийн чухал үзүүлэлт юм. Боловсрол нь эдүгээ эд баялагаас илүүтэйгээр улс орны хөгжилд хүчтэй нөлөөлж, хөгжлийг хурдасгагч бие даасан хүчин зүйл болсон.

ХОЁР. НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН -

ГУРАВ. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ

2011 онд хүний хөгжлийн индексээр дэлхийн 187 орноос Монгол улс 110-т жагсжээ. Энэхүү аргачлал нь

хүний хөгжлийн гадаад хүчин зүйлийг тооцоолон гаргаж байна. Өөрөөр хэлбэл хүний эрүүл, аюулгүй, баталгаатай орчинд амьдарч байгаа эсэх талаархи тооцоолбор гэж хэлж болох байна. Хүний хөгжлийн индексээр дэлхийд дээгүүрт орж байгаа хөгжингүй гүрнүүдийн хувьд нийгэмд нь гэмт хэрэг, авилгал, гэр бүл салалт, садар самуун, алан хядлага, амиа хорлолт нэлээд газар авсан дүр зурагтай байгаа. Үүнээс үзэхэд хүний хөгжлийн дотоод хүчин зүйл болох хүмүүжил төлөвшлийн асуудал нэн чухал билээ. Хүний хүмүүжил төлөвшилд олон хүчин зүйл хамаарах боловч ёс суртахуун, хувь хүний мөн чанар, жудаг ёсны асуудал багтана. Байшин барихад эхлээд суурийг нь гүн бат тавьж гэмээн урт настай, чанартай барилга бүтээн босгодгийн адил хүнийг хөгжүүлэхэд хүмүүжил төлөвшлийн суурийг нь гүн бат суулгаж гэмээн нийгэмд хэрэгтэй, үнэ цэнтэй хүнийг бий болгож чадна.

Нийгэмд хэрэгтэй, үнэ цэнтэй хүн болох нь хүний амьдралын зорилго, утга учрыг ухааран ойлгохоос эхэлнэ.

Хийж байгаа ажлаар минь дамжуулаад бусад хүмүүс хэр аз жаргалтай, сайхан болж чадав? гэдэгт хүний амьдралын утга учир оршино. Утга учиртай амьдрахын тулд хүн өөрийгөө танин мэдэх хэрэгтэй.

Хувь хүн өөрийгөө дараахь зургаан хүрээнд таньж, хөгжүүлэх нь зохистой юм.

1. Сүнсэн болон Ёс зүйн (Spiritual, Ethical) –Энэ нь хүний итгэл үнэмшил дээр суурилсан хүмүүжил төлөвшилийг багтаана. Хүний хөгжлийн хамгийн суурь, чухал чанар юм.

2.Оюун ухаан болон Боловсрол (Intellect, Education) –Хүний мэдлэг боловсролыг агуулна.

3.Нийгэм болон Соёлын (Social, Culture) –Нийгэмдээ идэвхтэй оролцож, бусдад сайн талаараа үлгэр загвар болох чанар.

4.Санхүү болон Мэргэжил (Financial, Occupation)

– Эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж, амьжиргааны зайлшгүй зардлаа бусдаас хараат бусаар санхүүжүүлдэг байх чадвар

5.Гэрлэлт болон Гэр бүл (Marriage, Family) – Гэрлэлтээ үнэнч сэтгэл, ариун ёсоор үүсгэж, гэр бүлээ бат тогтвортой авч явах.

6.Бие бялдар болон Эрүүл мэнд (Physical, Health)

– Энэ насанд ганцхан заяасан эрдэнэт биеийнхээ эрүүл мэндэд анхаарах

Дээрх зургаан хүрээнд хувь хүн өөрийгөө хөгжүүлбэл хүний хөгжил жинхэнэ утгаараа, иж бүрэн, цогцоор хангагдах юм. Өөрийгөө иж бүрнээр хөгжүүлж үсрэнгүй амжилт гаргаж, чанартай амьдарсан хүний тод жишээ бол даруй бидний хайрлаж хүндлэн, бахархдаг Их эзэн богд Чингис хаан билээ. Ингээд Чингис хааны өөрийгөө хөгжүүлж, онцгой амжилтанд хүрсэн нууцыг тайлбарлан ярья.

ЧИНГИС ХААН бол 1162-1227 онд 65 жил агуу ихээр амьдрахдаа өөр хэний ч хүрэх бололцоогүй амжилтыг гаргажээ. Иймээс Аргын тооллын 1001-1999 оны Мянганы манлай хүн юм. Чингис хааны хүрсэн амжилт, хийсэн ажлынх нь бодит үр дүнг харахад:

Чингис хаан 7,770,000км.кв (Монгол улсаа төвшитгөн гадаад улсыг зорив).

Александр 3,480,000км.кв

Гитлер 2,190,000км.кв

Наполеон 1,150,000км.кв байна.

Амжилтын энэ бодит үзүүлэлтээрээ мянган жилийн суут хүн болж байгаа юм.

“Вашингтон пост” сонин аргын тооллын 1101-2000 он хүртэлх түүхэн хүмүүс дотроос хамгийн алдартай хүнээр Чингис хааныг тодруулсныхаа үндэслэлийг :

“Өнгөрсөн мянган жилд гарсан хамгийн том үйл явдал бол цэвэр нэг л үндэстэн дэлхий даяар сүр хүчээ бүрэн төгс илтгэж чадсан явдал бөлгөө... Чингис хаан болон түүний залгамжлагчид Европ-Ази тивийг хамарсан чөлөөт худалдааны асар өргөн уудам бүс бүрэлдүүлж, дорно-өрнийн соёл иргэншлийн хэлхээ холбоог бэхжүүлж өгсөн юм. Үүнийг

дундад зууны үеийн GATT(General Agreement Tariffs and Trade)-WTO(World trade organization)-ын тогтолцоо байсан гэж хэлж болно... Тэд интернэт бүтээгдэхээс аль тэртээх 700 жилийн өмнө дэлхийг холбосон харилцаа холбооны сүлжээг анх бий болгосон байна. Чингис хаан бол хүн хүч, шинэ арга технологийг сүлжилдүүлэн дэлхий ертөнцийг ойртуулж нягтруулсан хүн...” хэмээн тодорхойлжээ.

Англи, Америкийн маркетингийн эрдэмтэд Чингис хааныг “эзлэн түрэмгийлэгч” гэхээсээ “гарамгай удирдагч” эсвэл “дээд зэрэглэлийн менежер” хэмээн нэрлэж байна. Чингис хааны мэргэн ухаан, арга үйл ажиллагааг үнэлэн ийнхүү хэлсэн байж ч болох юм.

Чингис хааны амжилтын нууцыг 3 зүйл дээр төвлөрөн тайлж болох юм.

1.Аугаа тэмүүлэл –Монгол тэмүүлэл

2.Зөв үзэл баримтлал –Мөнх Тэнгэрийн үзэл

3.Арга зам

1. Аугаа тэмүүлэл-Монгол тэмүүлэл. Чингис хаан болон монголчууд бидний бүх үеийн өндөр дээд өвөг дээдэс маань “Мөнх тэнгэрийн хүчин дор наран мандахаас шингэх хүртэлх бүх ертөнц эв баясалд нэгдэхийн цагт бидний зорилго илт болно“ хэмээн амьдралынхаа зорилго тэмүүллийг тодорхойлж,

түүнийгээ биелүүлэн гүйцэлдүүлэхийн төлөө сэтгэл, биеэ чилээн зориулж иржээ. Тэрээр “Хэтийн зорилго үгүй хүнд ойрын зовлон мундахгүй”, “Хаашаа явж буйгаа мэдэж буй хүнд хорвоо ертөнц зам тавьж өгдөг” гэсэн зарчмаар ажиллаж, амьдарч байлаа. Хүнд хүсэл тэмүүлэл байсан цагт л хөдөлж, хөгжинө, амжилтанд хүрнэ.

2.Зөв үзэл баримтлал-Мөнх тэнгэрийн үзлийн цөм санаа нь хорвоо ертөнцийн оройн дээд, төгс оршихуйг Бурхан, Аллах, Яахова, Ертөнцийн эзэн, Мөнх тэнгэр хэмээн олон янзаар нэрлэх нь чухал биш харин түүний оршихуйн мөн чанарыг нээгээд, хүн хүсэл тэмүүлээ биелүүлж, амжилтанд хүрэхэд Түүнтэй түншлэн харилцах нь чухал юм. Хүний эзэн бол сэтгэл. Бие, хэл, хөл гурав нь сэтгэлийн зарц байдаг. Сэтгэл хаашаа даялана хөл тийшээ алхана, сэтгэл юу бодно хэл түүнийг илэрхийлнэ. Миний эзэн сэтгэл, сэтгэлийн эзэн бол Мөнх тэнгэр гэсэн үзлийг монголчууд бий болгожээ. Чингис хаан Мөнх тэнгэрийн тухай айлдахдаа:

Эрэмгий сайнаар

Эзэн эс болов би

Эрхт Тэнгэр Эцгийн хайраар

Эзэн боллоо би

Хамрагч сайнаар

Хаан эс боллоо би

Хан Тэнгэр Эцгийн хайраар

Эзэн боллоо би гэсэн байдаг. Эндээс харахад Мөнх тэнгэр бол бидний сэтгэлийн эцэг юм байна. Түүний хайр ивээлд багтаж гэмээнэ хүн хүршгүй оргилд хүрч, бүтэшгүй ажлыг гүйцэлдүүлнэ гэсэн санааг гаргаж ирсэн байна. Тэрээр хүний сэтгэл гэдэг ямар чухал болохыг үргэлж онцлон үздэг байсан. Үүнтэй холбоотой Чингис хааны хэд хэдэн чухал сургаалыг энд дурдъя.

“...Дэлхий дахиныг эзлэхүй нь

Хүмүүнийг эзлэхүй дор буй

Хүмүүнийг эзлэхүй нь

Хүмүүний сэтгэлийг эзлэхүй дор буй

Хүмүүний сэтгэлийг олбоос даруй

Дэлхий дахиныг олов хэмээмүй

Хүмүүний сэтгэлийг алдваас даруй

Дэлхий дахиныг алдав хэмээвүй”

...“Хаан хүний 35 эрдэм дотроос ХАЙРЛАХ эрдэм охь нь юм”

...Сэтгэлийг хураахын тулд дурыг нь хураа. Дурыг нь хураахын тулд шударгуу үнэн бай.

Сэтгэлийн ертөнц нь Бурханы бүрэлбаа байвал цагаан сайхан үйл гарна. Сэтгэлийн ертөнц муухай хүнээс сайн юм гардаггүй. Дотоод ертөнцөө таниагүй цагт цааш явах зам харагдахгүй.

...Тархи нь хоосорвол чөмөг нь хоосорно

Тархи, чөмөг хоёулаа хоосорвол үхэж мөхнө шүү

Бодох шинжих бодлого ухаанаа нарийвчлаарай

Нэг сэтгэлтэй, нэг тэргүүнтэй яваарай

Улсаа аварья гэвэл үндсээ авраарай

Үндсээ аварья гэвэл сэтгэлийг нь авраарай

Сэтгэл гэдэг биеийн эзэн бөгөөтөл

Сэтгэл мунхарвал бие даруй хэвтэнэ шүү

Дээрх мэргэн сургаал, үнэт үзэл санааг бид сайтар ухан ойлгож, ажил амьдралдаа хэрэгжүүлэх аваас Чингис хаан лугаа адил их хэргийг гүйцэлдүүлж, үнэ цэнээ харуулах суут хүмүүс байж чадах юм.

3. Арга зам

Өөртөө итгэх итгэл- Ямар ч ажлыг хийж чадна , би чадна гэж үздэг. Бэрхшээлийг боломж гэж харан хүчээ сорьж даван гарснаараа өөрийгөө хөгжүүлдэг байсан.

Итгэлцэл-Аугаа үйлийг би ганцаараа хийхгүй, бусадтай хамтарч байж хийнэ. Тиймээс над руу ирж байгаа бусад хүмүүст итгэ. Халуун сэтгэл шингэсэн

итгэлээр дайснаа ч нөхөр болгон өөртөө зүтгүүлж чадна. Итгэл үзүүлснээрээ тухайн хүнийг шалган сорьж, танин мэдсэнээрээ тохирох албанд томилдог байсан.

Хурд – Хурдыг шүтдэг байсан. Монголчууд морь унасан хурдаа сааруулбал бусдын ард сугарч хоцорно. Их үйлийг бүтээхэд хүний хурд гүйцэхгүй учир хүлгийн хурдаар ургахуйгаас шингэхүй хүртэл морины нуруунаас буухгүйгээр шүдний махаар хооллож, шүлсний хөөсөөр ундаалж, мацан чармайж байж Монгол гэдэг улсыг төвшитгөжээ. Өнөөгийн монголчууд бид үдээс хойш, урагш гэсэн хоёрхон цагтай хэвээрээ шахуу, удаан, цалгар наазгай байна. Цаг бүртгүүлж цалин авахын төлөө ширээний ард суудаг болсондоо дүгнэлт хийх хэрэгтэй.

Манлайлал – Чингис хаан өөрөө хийж үзээгүй, туулж мэдрээгүй зүйлийг бусдаас шаардах боломжгүй гэж үздэг байсан. Дайны талбарт цагаан морио унаж, хар тугаа бариад цэргүүдийнхээ урд давхин ордог байв. Хамгийн хэцүү, зүрхшээмээр бүхний өмнө өөрөө түрүүнд нь зогсдог. Ингэснээрээ бусдын өмнө бүх талаараа үлгэр үзүүлэхийг хичээдэг манлайлагч боловч цэргүүд жанждуудынхаа дунд хамгийн энгийн байдаг байлаа.

Багийн ажиллагаа – Цомхон, чадварлаг, бие биеэ нөхөн орлох чадвартай, итгэл даасан хүмүүсээр цөм багаа бүрдүүлдэг.

Зохион байгуулалт- Аравт, зуут, мянгат, түмтийн зохион байгуулалтаар хуваарилж, гүйцэтгэх ажил үүргийг тов тодорхой тохоон томилдог. Хүлээсэн үүргээ хамгийн дээд зэргийн чанартай сайн гүйцэтгэх шаардлага тавьдаг.

Урамшуулал – Бурмаар тэтгэхээр урмаар тэтгэ. Газар, мал хөрөнгө, эд баялгаар шагнан урамшуулахаас

гавьяа байгуулсан нэгнийг олны өмнө магтан сайшаахыг эрхэмд үздэг байв.

Аугаа тэмүүлэл, зөв үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлэх мэргэн арга зам гэсэн гурван зүйлээр зэвсэглэн мянганы манлай хүн болж амжилтын оргилд хүрсэн Их эзэн Чингис хаан өнөөдрийн бидэнд ийнхүү захин сургаж байна:

Гэр орон муу гэж бүү хэл Есөн насандаа ааваасаа хагацаж, нутгаасаа хөөгдөн гарч байлаа

Ядуу зүдүү гэж бүү хэл Талын хулгана барьж амиа зогоож явлаа Дорой буурай оронд төрсөн гэж бүү хэл Сүүдрээсээ өөр нөхөргүй байсан ч зуун мянган цэрэг эрстэй болж чадсан юм Сурсан мэдсэн зүйл бага, хүч чадал дорой гэж бүү хэл Өөрийнхөө нэрийг бичиж мэддэггүй байсан ч Бусдын үгэнд чихээ хандуулан амьдралын ухаан сурч байлаа Хүнд хэцүү байна, шантарч сөхөрлөө гэж бүү хэл Хүзүүндээ дөнгөтөй оргон зайлж байлаа Хацартаа сум зоолгон үхээд сэхэж ч явлаа Амьд явж буйгаа аз ивээл гэж бодон Өнгөрөн одсонтой зууралдан хоргодолгүй, ирээдүйгээ бүтээн явдаг байлаа Мэдэж ухаартал Дайсан гэгч гадаа байх бус харин миний дотор байдаг юм байна Тиймээс тэрхүү төвөгтөй зүйлсийг хуу шүүрдэн хаяад Би өөрийгөө ялж гарах тэр агшинд Чингис хаан болсон билээ.

Бусдын алдаа бурууг олж харан чичлэн шүүмжлэх маш амархан бөгөөд өнөөдөр бид үүнд маш дадамгай суралцжээ. Ёстой л нөгөө өөрийн толгой дээрх эврээ харахгүй байж, бусдын толгой дээрх өвсийг харна гэдэг биелэлээ олж байх шиг. Их хааны туршлагаас харахад хүн өөрийгөө хөгжүүлж, амжилтанд хүрье гэвэл бусдыг шинжиж шүүмжлэхээс урьд өөрийгөө сорьж ялах хэрэгтэй юм. Өөрийгөө ялна гэдэг бол сул тал, гутранги бодол, айдас, муу зуршлаасаа зоригтой салан ангижрана гэсэн үг. Өөрийгөө ялах эрдэмд суралцахад тань манай Монгол тэмүүлэл тусална.

“Монгол ухаанаар дархлаажсан, дэлхийд байр сууриа эзэлсэн, үлгэр жишээ, манлайлагч иргэн болох нь МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ юм” гэж бид тодорхойлсон. Монгол ухаанаар дархлаажна гэдэг нь монгол их ухаан, өвгөдийн амжилтанд хүрсэн эрдэм чадлаас суралцан өөрийгөө хүмүүжүүлж төлөвшүүлнэ гэсэн үг. Хүнийг хүн болгон хүмүүжүүлэн төлөвшүүлэх их ухаан монгол уламжлалд бий. Дэлхийд байр сууриа эзэлнэ гэдэг нь дэлхийн цартай сэтгэн тэмүүлж, түүндээ хүрэхэд дэлхийн их эрдмээс суралцан өөрийгөө хөгжүүлнэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл зүрхний эрдэм буюу хүмүүжил төлөвшлөө монгол ухаанаасаа олж аваад тархины эрдэм буюу боловсрол мэдлэгээ дэлхийн өв сангаас цэнэглэвэл та хаана ч үлгэр жишээ, манлай иргэн болох юм.

“Миний үр удам цайз бариад суурьшвал мөхнө” гэж Чингис хаан хэлсэн байдаг. Энэ нь шууд утгаараа өндөр байшин, тансаг хаусанд суухыг хэлж буй хэрэг бус бид сэтгэлгээгээрээ, сэтгэлээрээ хөшүүн хойрго, цалгар назгай, залхуу хойрго, хүйтэн цэвдэг байвал мөхнө гэсэн санаа юм. Иймээс байнга хөдөлж, өөрчлөгдөн хөгжиж байх ёстой.

Хөгжил гэдэг бол өөрчлөгдөж, ахиц дэвшил гарч буй үйл явц юм. Самсунг корпораци амжилтанд хүрсэн шалтгаан нь “өөрчлөлт “ юм. Өөрийн эхнэр болон хүүхдээсээ бусдыг нь бүгдийг өөрчил гэсэн уриатай ажиллаад өнөөдрийн хөгжилд хүрсэн. Бусдаас өөр, өчигдрөөс өөр байцгаая, хүйтэн хандлага хэнэггүй байдлаа өөрчилье. Гавьяаг хэзээ ч байгуулж болно. Өөрийгөө өөрчлөх л хэцүү. Иймээс гавьяа байгуулахын тулд биш өөрийгөө өөрчлөхийн төлөө бололцоотой бүхий л зүйлийг хийцгээе.

“Үндэс язгуураа бүү мартсугай хэмээн Үр хөвгүүддээ сургасугай Манай үндэстний шаргуу замыг Мартуулж үл болмой”



Монгол Улсын гавьяат багш Ц.ТҮВШИНТӨГС

Ардын мэдлэг

Намайг багад хөгшчүүд маань хүнд гурван эрдэм байдаг гэж хэлдэгсэн. Тэр нь сонсохын эрдэм, харахын эрдэм, уншихын эрдэм. Энэ нь хүнээс их юм сонсож байгаарай, олон газар орноор явж юм үзэж байгаарай, ном хэвлэл их уншиж байгаарай гэсэн захиас. Энэ гурван эрдэмд тэгширсэн хүнийг ухаантай хүн гэдэг юм шүү гэж буурлууд маань сургана. Мэргэдийн айлдвараас сонсвол “Хүний ном”, “Номын ном” гэж хоёр янзын ном байдаг. “Хүний ном” гэдэг нь хүнээс сонссон, хүний хийснийг харсан, түүнээс ухаарал авсан, өөрөө хийснийг хэлдэг. “Номын ном” гэдэг нь нүдээр үзээгүй ч эрт урьдын болон харь орны тэр олон эрдэмтэн мэргэдийн бүтээлийг уншаад, түүнээс санаа аваад ертөнцийг танин мэдэж байгаа ном юм. Номын ном бол итгэл үнэмшил муутай байж болох ч хүний ном бол нүдэн дээр ил тод итгэлтэй байдаг. Яагаад гэвэл өөрөө тэр бүгдийг биеэр мэдэрч байдаг. Өнөөдрийн сэдвийг “Ардын мэдлэг” гэж нэрлэе гэж бодлоо. Яагаад гэвэл үзсэн, харсан, сонссон юмнаасаа жишээ татаж ярья.

Утга зохиол, урлаг сонинд Хүннү гүрний тухай 2-3 ном хэвлүүлээд байгаа Я.Ганбаатар докторын ярилцлага хэвлэгджээ. Чанчин бумбад Чингис хаан захидал бичихдээ хоёр асуудал тавьсан гэдэг. Нэгдүгээрт төрийг засахад иргэн хүн хэрхэн оролцох, нөгөө нь биеийг засахад хүн өөрөө яах вэ гэдэг дээр голлож асуужээ. Өнөөдөр төрийг засахад хүн бүхэн улсын хэрэгт оролцох, биеийг засахад хүн бүр өөрөө хичээх хэрэгтэй боллоо. Төрийг засахад иргэн хүн оролцоно гэдэг нь ерөөсөө ёс заншлыг дагаж, нийгмийн амьтан байх үүргээ биелүүлэх, биеийг засах гэдэг нь өөрийн биеийг эрүүл байлгаж биологийнхоо амьтны амин хэрэгцээг хангахыг хэлнэ.

Хүнд гурван гол баяр тохиолддог. 1. Даахь үргээх,

2. Хурим, 3. 85 насны ой. Одоотой адилхан жил бүхэн төрсөн өдөр тэмдэглээд байдаггүй байжээ. Нэг нь хүн болсны баяр, нөгөө нь хүний ертөнцөд эр бие тэгширч амьдрах, сүүлчийнх нь хүний ертөнцөд амьдарсан тайлангаа тавих баяр. Ж.Жамъян генерал тэр жил таалал болохынхоо өмнөхөн 85 насныхаа найрыг хийхдээ “Надад бэлэг сэлт, янз бүрийн юм хэрэг байхгүй. Миний 85 насны ойг ёсолж хүндэтгэе гэвэл цагтай, завгайхан шиг ирээд миний амьдралдаа сонссон мэдсэн зүйлийг сайн сонсож, бичиж аваарай. Энэ бол миний 85 насны найр юмаа” гэж хэлж байсан.

Эхтэй хүн үхдэггүй гэсэн монгол үг байдаг. Өөрөөр хэлбэл эхийн ус гэдэг эрхэм хүндтэй

амин чухал рашаан юм. Одоо бол зүгээр л нэг эхийн шээс гэж ойлгоод байгаа. Гэтэл энэ бол уг нь эхийн шээс биш ургийн ус юм билээ. Хүүхдийн ургийн усыг арвайн гурил, эд юманд шингээж авдаг байсан. Энэ ургийн ус бол хүүхдийн өөрийнх нь “шээс” шүү дээ.

Овоон дээр эмэгтэй хүн гардаггүй гэж хэлдэг. Энэ бол эмэгтэй хүний эрх чөлөөг хасаж, гадуурхсан хэрэг биш юм. Яагаад гэвэл овоон дээр сансрын уудмаас, газрын гүнээс их энерги төвлөрч хуримтлагддаг. Эмэгтэй хүнд, урагт нь нөлөөлж магадгүй гэсэн сэрэмжээс үүдэлтэй юм билээ. Тийм учраас бие давхар бүсгүй хүн овооны наадамд очдоггүй. Шашны номоор бол бас л ярьдаг юм бий. Хий биетэн нь янз бүрийн тансаг үнэрт шунамхай, тийм учраас түүнээс сэргийлсэн юм гэдгийг бид сайн ойлгож байх ёстой. Даахь үргээх, үс засуулах өдөр байдаг. Гурван нас хүртэл хүүхдийн сэвлэг үргээдэггүй. Сансрын эрчим хүч авах олон мянган антен нь хүний үс юм. Шинийн 15-ны тэргэл сартай өдөр, эсвэл сарыг харагддаггүй 30-ны битүүний өдөр гэх мэтээр эрчим хүч нөлөөлдөг байдлаар үс авахуулах нь зүгээр нэг өдрийг сайн муугаар нь ялгасан биш, од эрхсийн хөдөлгөөнтэй холбоотойгоор эрчим хүч авах хийгээд алдахтай холбоотой юм.

Мах идэх ёс байна. Жишээ нь: Казак айлд ороод сүүжний махыг ам хүрээд хамгийн бага эрэгтэй хүүхдэд нь өгвөл таныг ёс мэдэж байна гээд ихэд хүндлэх болно. Дал, сүүж хоёр нь хаа гуаыг орлодог. Далыг бол манай баруун аймгийнхан “хавтгай яс” гэдэг, сүүжийг бас буяны хавтгай ясанд тооцож оруулдаг. 1996 онд би Английн Хүүхдийг ивээх сангийн суурин төлөөлөгч Жон Беклертэй хамт Өмнөговьд явж байгаад хээр өдрийн хоол идэв. Жон Беклер маань далны яс, сүүжний яс хоёр барьчихсан явж байхаар нь “Яах гэж байгаа юм бэ” гэсэн чинь үүнийг сэвтээж хаяна. Далны ясыг манай Англичууд ихэд хүндэлдэг. Бас сүүжний ясны нүхэнд чөтгөр хоргодвол муу. Энэ хоёрыг сэтэлж, сэвтээж хаях ёстой гэж хэлсэн. Үүнээс үзэхэд англичууд болон монголчуудын ёс заншилд адилхан юм бас байна шүү. Л.Түдэв гуай “Дал” сониныхоо дугаар бүрт эртний Английн яруу найргийн дөрвөн мөрт бичдэг. Монголчууд том үйл хэргээ далаар мэргэлээд, жижиг үйл хэргээ дөрвөн бэрхээр сонжоод аж амьдралынхаа хожмын юмыг таамагладаг байсан.

Дал сүүжний ясанд хандах ганцхан жишээ гэхэд энэ.

Монголчууд мэсийг хүнд бэлэглэдэггүй. Монголчууд хутга, сэлмийг үр хүүхэддээ өгөхдөө ганц хоёр төгрөг ч болов аваад худалдаж байгаа маягаар өгч дамжуулдаг. Бэлгэдлийг монголчууд сайн мэддэг, өөрийн далд ухамсарт сайны үрийг байнга тариад, дараа тэр нь ил ухамсарт нөлөөлж цаанаас нь өдөөж тэтгэдэг гэдгийг сайн ойлгох учиртай юм л даа. Айлд ороод мах буцалж байхаар нь хамгийн дээд талаас нь уушигт ам хүрдэг. Уушиг бүх махны дээр хөвж байгаа юм гэж Х.Баянмөнх аварга тэр жил ярьж байсан. Тавагтай идээний дээрх өрөмд эхлээд гар хүрдэг, жигнэмэг, боовны хээтэй талыг дээш нь харуулж тавагладаг. Жижиг гэлтгүй энэ бэлгэдлүүдийг залуу хүмүүс өөрийн амьдрал ахуйдаа сахиж мөрдөхөд илүүдэхгүй болов уу.

Яагаад ядам хуруугаар сэржим өргөдөг вэ? Ядам хуруундаа монголчууд мөнгөн бөгж зүүдэг байжээ. Тэгээд дарс сархадын дээж өргөхдөө ядам хуруугаараа “томоохон балгуулж” дүрээд дээшлүүлэхээр уг сэржим доошоо урсахдаа мөнгөн бөгжийг харлуулсан эсэх буюу хортой, хоргүйг нь мэдэж болдог. Та бүхэн эмнэлэгт шинжилгээ өгөхдөө ядам хуруунаас цусаа өгдөг. Ядам хуруунд холбогдох өөр олон бэлгэдэл бий.

Тоглоомын бэлгэдлийг хөндөж болно. Даалуу бол Манжийн засаглалаас гаралтай, монголчуудын хишиг буяныг дундруулах бэлгэдэлтэй тоглоом. Үүний эсрэг “Хорол” гэдэг тоглоомыг монголчууд зохиосон. 12 жилээр нэрлэсэн газрын модон дээр хорол, жанцан, арслан, хас зэрэг гарын дээд модыг нэмж хийсэн. Монгол тоглоом болгон бэлгэдлийг агуулж байдаг. Буга гэдэг тоглоом хүүхдийн оюун ухааныг задалдаг. Хаана бол хаана хөлөг нь явж байдаг 1960-1970-аад оноос хэрэглэгдэхээ больсон байна билээ.

Бүсийг хүндэтгэх ёсоо бодохгүй нэг гажуу юм харагдаад байдаг. Бүсийг нар зөв ороож бүслэх ёстой байтал одоо зарим настай хүн ч гэсэн нар буруу ороож бүсэлж байх юм. Охин хүүхдийг мордуулахад охины бүсийг хүний хишиг буян болгон авч үлддэг байсан. Эрчүүд очир зангилаагаар бүсээ зангидаж дэрлэж унтдаг. Хүний хийморь бүсэндээ байдаг учир бүс дээгүүр алхдаггүй гэх зэргээр бүстэй харьцах нь олон нарийн дэгтэй.

Бие давхар бүсгүйчүүд золгодоггүй гэсэн нэг үг байдаг. Хэвлий дэх ургийн хүйсийн эрчим хүч солигдчихож магадгүй гэж болгоомжлохдоо хүйс нь солигдоно гэж ярьдаг юм билээ.

Өнөө үед эрүүл аж төрөх талаар их ярих болжээ. Эртний ном сударт “Хаш булаг” гэдэг эмийн тухай өгүүлдэг. Энэ нь гадна талд төдийгүй дотор талаасаа хэрэглэдэг эм гэж бичжээ. Гэтэл энэ нь эм биш ердөө өлөн элэгний шүлс байсан. Өөрөөр хэлбэл ходоод өвдөх, улайх, ходоодны хүчил ихдэх, багадахад өлөн элэгнийхээ шүлсийг аман дотроо сайн хурааж байгаад балгаж өглөөгүүр залгахад ходоод хэзээ ч өвдөхгүй, шархлахгүй, шархалсныг эдгээдэг ид шидтэй юм байна. Биеийн гадна, арьсан дээр гарсан зүйлд өлөн элэгнийхээ шүлс түрхчихээр гайгүй болчихдогтой адилхан.

Эрчүүд аяга таваг угаах их сайн гэнэ. Эмэгтэй хүн байнга аяга таваг угаагаад хоёр гарын бүх хурууныхаа өндгөөр халуун хүйтэн үед өөхтэй тостой зүйлээр шим тэжээл аваад эрчүүдээс илүү насалдаг бололтой. Эрэгтэйчүүд урт наслая гэвэл аяга тавгаа сайн угааж байгууштай. Дундад ба Бага Азийн эрчүүд гал зууханд ойрхон, хоол унд их хийдэг болохоор урт настай. Эндээс санаа авууштай юм гэж бодогдоно. Нас ахиад ирэхээр хүний хөл сайртаж, эвэр ургаад ирдэг. Хөлөнд маш олон мэдрэлийн цэг байгаа. Тиймээс хөлөө сайн угааж, тэжээл сайтай, тухайлбал сүүлний тосоор тосолж хөлний арьсыг сайн хамгаалж байвал эрүүл, урт наслах боломжтой. Энд байгаа залуучууд аав ээжийгээ урт наслуулъя, хишиг буяныг нь эдэлье гэвэл хөлийг нь сайн угааж тосолж өгөөрэй. Ер нь Дорны улсууд хөлөө угаамтгай.

Залуу хүн хөгшин хүнтэй хамт байгаад байвал сурах юм их байдаг, харин жаахан нас ахиж яваа хүн залуу хүнтэй үерхэж дотносоод байвал цаг үеэ мэдрээд, ирээдүйдээ итгэлтэй болж, залуучуудаас, цаг үеэсээ хоцрохгүй явна. Хөгшин хүн хөгшин хүнтэйгээ байнга хамт байвал хуучин цагийнхаа дурсамжийг хөөрөлддөг учир залуу үеэ голомтгой, орчин үеэ мэдрэхээ больчихдог. Залуучууд хоорондоо их нийлээд байвал зарим үед дарвиад алдчихаж магадгүй, онож ч магадгүй ийм нэг амьдралын ухааны нэг жанжин шугам байгаа юм.

Сүүлийн үед эрүүл эхээс эрүүл хүүхэд гарна гэж шинжлэх ухаан, эмнэлэг, эмч нар хэлээд байна л даа. Энэ бол зөвхөн биеийн эрүүлийг төдий биш, бас сэтгэлийн эрүүл мэндийг хамт хэлж байгаа хэрэг юм. Бие давхар бүсгүй хүн бол асар их эмзэг. Яагаад гэвэл биеийн хувьд ч эмзэг, сэтгэлийн хувьд ч эмзэг, хоёр хүн хамт амьдарч, шинэ хүн бүрэлдэж байгаа учир сахивал зохих журам, цээр ёс их байдаг. Жишээлбэл: Бие давхар бүсгүй хүн хажуулдаж

хэвгэхгүй, дальжийж зогсохгүй, сүүжилдэж суухгүй, нүдэндээ улай үзэхгүй, чихэндээ муу үг сонсохгүй, амандаа элдэв юм идэхгүй гэж хэлдэг. Дээр үеэс л бие давхар хүн хонь муулахыг хардаггүй байсан бол одоо аймшгийн кино үзээд байгаа шүү дээ. Тэр алаан хядаан, чөтгөр шулмыг харж байгаа бүсгүй хүний тархинд мэдээлэл буудаг, тэр мэдээлэл урагт нөлөөлнө. Хожим шоргоолж дэвсдэг хүүхэд, хүн амьтан хайрладаггүй хүн гарч ирнэ. Бие давхар бүсгүй хүн рок хөгжим, тас няс гэсэн юм сонсоод байвал хэл ярианд нөлөөлнө, хэл ярианаас оюун ухаанд, тэгээд бие эрхтэнд нөлөөлнө. Бие давхар эмэгтэйг битгий уурлуул, хүүхэд нь ууртай болчихно, битгий уйлуул эхийнх нь нулимсны хир хүүхдэд нь суучихна, битгий айлгаж цочоо, хүүхэд нь зүрх зориггүй, аймхай хулчгар хүн болчихно, бие давхар эмэгтэйг оршуулганы газарт битгий очуул, зайлшгүй очихоор бол нүцгэн бие дээрээ суран чөдөр бүсэлж цээр гарга гэх мэт аман хууль байдаг. Энэ бүхэн нь нөгөө бие давхар бүсгүйг ариглахтай холбоотой төдийгүй шинэ хүний төрмөл шинжийг үүсгэхэд нөлөөтэй байжээ. Бие давхар болохын өмнө нөхөр, эхнэр хоёул биеэ бэлтгэх ёстой. Тиймээс сарны гэрэлд энгэр битгий зөрүүл гэдэг юмуу, салхитай бороотой тэнгэр хуйсгануур байвал энгэр битгий зөрүүл ч гэдэг юмуу, үр заяахад эрсдэлтэй гэж энгэр зөрүүлэх хүртэл учиртай байв. 15-ны өдөр сар тэргэл байхад, 30-ны өдөр сар битүү байхад хүний сүнс бүх биед, 28-ны өдөр бэлигсийн оронд сүнс оршино, тэр үед энгэр битгий зөрүүл гэх мэт үгийн цаана их нарийн учир бий шүү дээ. Хүний таван хөндий байгаа. Нармайн, цээжний, хэвлийн, аарцгийн хөндий байдгийн аарцгийн хөндийг бэлигсийн орон, тэр нь их эмзэг гэж хэлдэг. Ийм олон зүйл байдаг учраас гэр бүл төлөвлөлт гэдэг бол нэг хоёр хүүхэдтэй төдий байх өнгөц асуудал огт биш юм. Хэдийд үр хүүхэдтэй болох вэ, үр хүүхэдтэй болохын тулд ямар бэлтгэл хийх вэ, нэгэнт ураг бий болчихвол юу анхаарах вэ, хэвлийд нь юу төлөвшүүлэх вэ, өлгийд нь яаж сурган хүмүүжүүлэх вэ, мөлхөж байхад нь яах вэ, балчир насанд нь хэрхэх вэ, бага насанд нь юу анхаарах вэ, өсвөр насанд яаж харилцах вэ, орь залуу насанд нь амьдралд яаж оруулах вэ гээд чухал олон асуудал ар араасаа цувран гарч ирнэ.



Монгол Улсын Ардын жүжигчин Ш.ЧИМЭДЦЭЭ:

Бүүвэйн дуу, марзай гийнгооны хүмүүжлийн ач холбогдол

Бүүвэй гэдэг бол хүнтэй хамт төрсөн аялгуу гэж ойлгож болно. Бүүвэйг хэн нэгэн алдартай хөгжмийн зохиолч эсвэл гайхамшигтай хүн зохиосонгүй, энэ бол эх хүн үрээ хэвлийдээ тээж төрүүлэхээс эхлээд бий болжээ. Бүүвэйн дууны гайхамшигтай чанар бол боловсрол олгох явдал юм. Боловсрол гэхээр бид ерөнхий боловсрол олох, ажил мэргэжлийн боловсрол олохыг л ойлгоод байдаг. Жинхэнэ хүн болох боловсрол нь бүүвэйн дуу гэж ойлгож болно. Бүүвэй аялж байгаа айлд янз бүрийн харгис хэрцгий үйлдэл болдоггүй. Миний ижий, эмэг эх ярихдаа жаахан сахилгагүй хөдөлгөөнтэй хүнийг энэ багадаа эхийн бүүвэй сонсож өсөөгүй юм байна гэж жаахан муу хэлдэг байсан. Өнөө үед бараг бүх ээжүүд бүүвэй аялахаа байсан учраас жаахан дутагдалтай хүмүүсийг бэлдээд өгч байх шиг санагддаг.

Би бүүвэйн дууны талаар зургаан жил гаран судалсан. Манай дээд үеийн монголчууд гайхалтай их ухаантай байж дээ. Хүнд долоон хүрд байдаг гэдэг. Долоон хүрдний дээрээсээ дөрөвдэх, доороосоо дөрөвдэх хүрд бол зүрхэн хүрд байгаа. Зүрхэн хүрдний өнгө нь ногоон байдаг. Ногоон өнгө бол хүнийг тайван, амирлангуй болгох увьдастай бол зүрхний хүрд бас хүнийг зүрхнээс зүрхэнд тайван амирлангуй болгож байх ач тустай. Тийм учраас манай монголчууд хүүхдээ зүрхэн дээрээ, элгэндээ наалдуулж найган бүүвэйлж байсан. Одоо манай ээжүүд яаж байна гэхээр давсаг хавьцаагаа аваачаад сэгсчээд байдаг. Айхтар түнтгэр шар шар хийсэн тоглоомыг нүд амыг нь эрээлжилтэл урдуур нь савлаад байдаг болсон. Хүний багадаа олсон хүмүүжил ямар л байна цаашдаа тийм л хүн болдог. Үнэхээр ээж нь бие сэтгэлээ зориулан бүүвэйлж дуулж өсгөсөн бол тэр хүн энэ дэлхийг бүүвэйлж, өөрийгөө бүүвэйлж, хайртай хань ижил, үр хүүхдээ бүгдийг нь бүүвэйлж байгаа юм шиг зөөлөн амьдрах нь гэж ойлгож болно. Миний элэнц эх Пил, түүний өвгөн нь Балжир гэж хүн байж. Тэднийх Дарьгангын айл байсан. Тэгээд Пил хөгшин манай эмэг ижийг 4-5 настай байхад нь тэмээний бөхөнд арганд суулгаад Алтан овооны хажуугаар нүүж нутгаасаа гарч явахдаа бүүвэй аялж явсан гэсэн. Тэгэхээр бүүвэй бол хүний сэтгэлийг ямар их зөөллөж, уяруулж, ямар хүн болгодог нь ойлгомжтой. Нарийвчлаад ярих юм бол бүүвэйн дууны аялгуу нь дандаа эм эгшигтэй байдаг. Ер нь хүний хүмүүжлийн доройтол, өнөөдрийн энэ хатуу ширүүн, харгис хэрцгий, юу ч хийхээс буцахгүй байгаа, жаахан ухаангүй мулгуу болж байгаа нь ерөөсөө л багаас нь бүүвэй аялж хүн болгож өгөөгүйгээс болж байгаа.

Миний эмэг ижий намайг бага байхад хүн ижийнхээ ачийг хариулна гэж байдаггүй юм гэнэ лээ. Шүүдрийн ус

цуглуулаад цай чанаж өгвөл нэг л удаа босч хөхүүлсэн ачийг нь хариулдаг юм гэнэ лээ гэж ярихаар би жаахан хүүхэд байхдаа тэгэх юмсан гээд л бодоод байдаг байсан. Тэгээд сүүлд дуучин болсон хойноо шүүдэр цохиж үзье гээд тавиур дээр байдаг ишгүй шанаганы толгойг аваад үүрээр гарна даа гэж бодоод хонолоо. Үүр ч бараг цайгаагүй байхад би сэмээрхэн гараад явлаа. Нар унины дунд ирж байхад би жаахан шүүдэр цуглуулж ирсэн. Би тэгээд бөөн баяр ирэхэд манай ижий ер нь баярлаагүй шүү. “Чи ингэж дэмийрч яваад яах вэ, ажлаа л сайн хий. Тэгвэл боллоо” гэж хэлсэн. Нээрээ л ажлаа сайн хийлгэхийн үндэс суурь нь бүүвэй юм шүү. Ингээд миний сэтгэл ханасангүй ээ, юун ач хариулах ээжийгээ ч жаахан уурлуулчих шиг боллоо. Тэгээд би тэр жилээ “Тэнгэр ээж минь өршөө” гэж дуу зохиосон. Би чөлөө л гарвал бараг 7 хоног бүр ижидээ очдог байсан. Тэгээд ижидээ очоод дуулж өгтөл ижий маань жигтэйхэн их баярласан. Ер нь баярласан хүний нүд, царай зүс андашгүй байдаг. Ижий маань жигтэйхэн их баярлаад “Одоо л нэг боллоо. Чи ээжийнхээ ачийг хариулна гэж дахиж битгий санаа зов. Бүх л өндийж хөхүүлсэнийх нь ачийг хариулсан гэж бодоорой” гэж хэлсэн. Би тэнд юу гэж оруулсан гэхээр

Шүүдрийн мөнгөн дуслын оронд

Сувдын мянган дууг хэлхээд

Аагтай шаргал цайны оронд

Амилуулж дуулсан дуугаа өгье

Аялгуу шингээсэн дууг минь

Ачит ээж минь уу даа

Аягалан аягалан уу даа

Амтлан амтлан уу даа гэж бичсэн.

Ижий маань бас чи зөвхөн өөрийнхөө ачийг хариулсан гэж бодолгүй, 13 хүүхдийн маань бүгдийнх нь

өмнөөс миний өндийж хөхүүлсэний ачийг хариулчихлаа гэж бодоорой гэж хэлэхэд нь би бүр их баярласан. Ер нь хүний уярамтгай болох, сайхан зан чанартай болох нь хамгийн түрүүнд бүүвэйн дуу л ийм болгодог. Бодох ёстой болгоныг бодуулж өгдөг ийм чанар бүүвэйн дууны аялгуунд байдаг. Эм аялгуугаар бүтсэн учраас хүний сэтгэлийн утсыг хөндөх чанар бүүвэйн дуунд байна. Би өмнө нь олон газар бүүвэйн дууны талаар лекц тавьдаг байсан. Тэгтэл нэг л юм болж өгсөнгүй. Сайхан илтгэл боллоо, баяр хүргэе гээд л боллоо. Тэгээд би бодсоор байгаад би дуучин болсны хэрэг юу билээ, ерөөсөө л үүнийг өөрийнхөө хоолойгоор дуулж, ард нь хөгжмийн найруулгыг нь сайхан хийлгээд CD гаргаад түмэнд түгээвэл энэ үед төрсөн монгол хүнийхээ хувьд хүнд хэрэг болох юм даа гэж бодоод би зориглоод хийсэн. Үүнийг хийхээр зургаан жил гаран хөөцөлдсөн. Би Дорнод аймгийн Баяндун сумаас эхлээд Их тайга хүртэл явсан. Тэгэхэд зарим үед шантармаар байсан шүү. Бүүвэйн дууг Монголын тасарсан соёлын өв гэж хэлж болно. Нөгөө үзүүр нь бүр ч тасарчихаагүй баригдахын төдий байсныг нь

нэг үзүүртэй нь залгаж өгсөн нь хүн болсны маань хэрэг бүтлээ дээ гэж боддог доо.

Марзай гийнгоо бол эр эгшгээс бүтдэг учраас хүүхдэд эрч хүч, урам зориг хайрладаг. Би 15 хүртлээ үрээ унасан. Манайх их шарга, бага шарга гээд хоёр шарга азаргатай айл байлаа. Аав маань моринд их дуртай, би 15 нас хүртлээ үрээ унаж байгаад хүнддээд үрээ унахаас чөлөөлөгдөж байсан. Тэр үед их маарзайлж байжээ. Манай нутагт марзайлна гэж ярина. Боржигонд умарзынгоо гэж ярина. Төв аймаг, Дорноговийн наад тал, Хэнтийн хойд талаар гоолно гэж ярина. Богд уулнаас хойшоо Баянхонгор, Өвөрхангай, Булган зүг рүү гийнгоо гэж ярина. Ер нь гийнгоолох бол ядахдаа л хоолой нь

задардаг. Надтай нэг сужиганы хүүхэд Лхагваа, Должин, Батсүх гээд байлаа. Бид нар их марзайлцгаадаг, тэгээд бүгдээрээ дуучин болсон. Ер нь гийнгоо марзай бүр өөр өөрийн дэг жаягтай, өөр өөрийн тарнитай. Эрт үедээ бөөгийн шашинаар байж л дээ. Сүүл рүүгээ бурханы шашин орж ирсэн. Шашин бүгд л адилхан сайн сайхны төлөө хүчтэй тарниудтай. Манай марзай бол нарны тарни. Нарандаа хүүхэд, морио даатгаад явуулдаг. Гийнгоо бол Дандинянсэн бурханы тарни гэх жишээтэй олон сайхан тарни аялгуу хоёрыг нийлүүлээд дуулдаг. Ер нь адуу бол их ухаантай амьтан учраас хэд сайхан марзайлж гийнгоолоод өгөхөд тэр амьтны хийморь нь сэргэж бие сэтгэлээ хөнгөлөөд, түрүүлж давхиж ирэхийн зөн совинд авгаж, бараг л хагас галзуурлын байдалтай болдог. Тэр тарни аялгууг сонсоод ямар ч гэсэн би түрүүлж ирэх ёстой гэдгийг ойлгоно. Яагаад гэхээр тэр аялгуу зүүн талынх нь тархины бор хальсанд очоод нөлөөлчихөж байгаа учраас адгуусныхаа шинж төрхөөр түүнийг ойлгоно. Адуу гэдэг өөрөө их хийморьтой амьтан. Би CD-нийхээ зурган дээр янцгааж байгаа адууны толгой, улиж байгаа чононы толгой, хүүхдийн толгойг сонгосон. Дэлхий дээр байдаг хамгийн хийморьтой амьтан бол энэ гурав. Энэ гурван амьтны хийморь бол их ойролцоо. Тийм их хийморьлог байдаг нь дэлхийн дэлгэрүүлэгч хийтэй л холбоотой юм даа. Адуу бол аялгууг ойлгох чадвар нь бусад амьтнаасаа илүү чанартай байдаг.

Одоо хүн бол дөрвөн хананы дунд орон дээр төрдөг болсон. Адгуус бол яг л газар дээр үр төлөө гаргадаг. Тэгэхэд дэлхийн дэлгэрүүлэгч хий дөнгөж төрсөн нялх амьтны биед шингэдэг. Дэлхийн дэлгэрүүлэгч хий гэдэг нь янз янз байдаг. Тухайлбал манай Дарьгангад 222 галт уул 15 сая жилийн өмнө дэлбэрсэн. Тэнд маш их энерги байгаа. Тал газрын дэлхийн дэлгэрүүлэгч хий бол богино

богино боловч үргэлж давгамжаараа гарч ирж байдаг. Өндөрлөг газрын дэлхийн дэлгэрүүлэгч хий бол урт урт боловч хааяа хааяа гарч ирж байдаг учраас Хангай зүгийн өндөрлөг газрын дуунууд дээшээ шовх шовх аятай байдаг. Манай аавын хамгийн том эгч Дулам гэж 100 шахаж яваа хөгшин байдаг. Манай тэр ажаа намайг дуучин болсон цагаас эхлээд л дарамталж эхэлсэн. “Чи сайндаа дуучин болчихож байгаа юм биш шүү. Цөс нь хавиргаа дэлсэх юм ердөө байхгүй. Чиний урд төрөл чинь Дуутай жинсрэг гэдэг номыг олныг уншуулчихсан болохоор чи дуучин болсон” гэдэг байсан. Ажаагийн хэлдгээр би сайндаа ч ингээд төрчихсөн юм биш шүү дээ. Тэр дэлхийн дэлгэрүүлэгч хий надад нэвт шувт шингэж, ээж маань сайхан бүүвэйлж, ус сайхан эргүүлж, тарни сайхан хэлж байсны ач гэж би боддог.

Өнөөдөр бид бүүвэй, гийнгоо марзайгаа мэдэхгүй болчихсон ч гэсэн хүний генэнд энэ аялгуу хэзээ нэгэн цагт байж байсан учраас түүнийгээ их хүсч байдаг. Хүмүүс ямар нэгэн юмыг

байнга эрж байдаг. Энэ нь бол өөрийнхөө генэнд байж байгаад алга болсон аль нэг юмаа л хайгаад байгаа хэрэг. Түүний нэг нь бүүвэй байжээ гэж би ойлгосон. Хүмүүс их завгүй гэж ярьдаг. Үнэхээр тийм завгүй юм уу гэхээр бас ч тийм биш, завгүй завгүй гээд худлаа хэлээд яваад байдаг. Аягүй бол миний аялсан бүүвэйг тавьчихаад л хүүхдээ бүүвэйлэхгүй дээ. Миний аялнаас сураад хүүхдээ элгэндээ наалдуулаад өөрийнхөө хоолойгоор сэтгэлээ шингээн бүүвэйлбэл жинхэнэ ээжийн бүүвэй болно. Манай ажаа надад “Чи одоо л нэг зөв юм хийж байна даа, бидний багад насных нь цөвийг арилтал бүүвэйл гэж ярьдаг байсан” гэж хэлсэн. Тэгэхээр ах нь, эгч нь гээд дайралдсан хүн болгон бүүвэйлдэг байж. Тэгээд тэр хүн 70,80 наслахад тааралдах бүхий л муу муухай

бүхнийг бүүвэй бүр жаахан байхад нь зайлуулаад өгдөг байна. Хурдан адуунд гутга сууна гэж байдаг. Тэр гутгыг нь арилтал гийнгоолж марзайл гэдэг байсан. Ийм л учиртай юм гэнэ лээ.

Ажлаа сайн хийдэг хүн болгохын тулд хүүхдэдээ багаас нь бүүвэй сонсгох хэрэгтэй. Тийм учраас бүгдээрээ бүүвэйн дуу, гийнгооны аялгууг бие биедээ түгээж сайн хүн болгохын төлөө, жинхэнэ хурдан адуу болгохын төлөө хичээцгээе. Та бүхэнд баярлалаа.



Олон улсын Равжаа судлалын тэргүүн, МУСГЗ Л.ОДОНЧИМЭД:

Юнеско-д бүртгэлтэй равжаа хутагтын тухай хүүрнэхүй

Та бүхэнтэй өглөө эрт уулзаж байгаадаа их баярлаж байна. Ийм учралыг бүрдүүлсэн “Монгол тэмүүлэл”-ийнхэндээ их баярлалаа. Би олны газарт хүмүүстэй уулзаж Хутагтынхаа тухай ярьж байсан. Гэхдээ ийм эрт уулзаж байсангүй. Өнөөдөр энд ирсэн хүмүүс дотор залуучууд олон байна. Залуучууд өглөө эрт боссон байгаа нь сайн хэрэг. Би “Үдэш унтдаггүй өглөө босдоггүй өнөө үеийнхэн” гэж шоолж нэг шүлэг бичсэн. Одоо харин “Эрт үүрээр босдог эрмэлзэлтэй залуучууд” гэж өөрчилдөг юм билүү. Миний ээж “Өглөө эрт хийсэн ажил өөрөө бүтсэн ажил” гэж хэлдэг байсан. Иймээс би эрт босохыг их чухалчилдаг, унтаж байгаа хүнийг хараад уур хүрдэг, хүүхдүүдээ өглөө унтуулахгүй байх гэж их мэрийдэг.

Өнөөдөр би Равжаа судлалын өнгөрсөн, ирээдүйн талаар товч ярья. Хутагт гэдэг ойлголтын тухай хоёр үг хэлье. Хутаг гэж их зүйлийг горилох гэсэн үг. Аугаа их хүсэл мөрөөдлийг өмнөө тавьж, түүнийгээ биелүүлсэн, аугаа их хувь зохиолыг олж, их буян хишгийг цуглуулсан, зол жаргал эдлэх нөхцлийг бүрдүүлсэн хүнийг монголчууд их хутаг олсон хүн, Хутагт хүн гэдэг байсан. Хутаг олсон, хутаг оршсон гэдгийг хүлээн зөвшөөрсөн хүндээ хутагт гэдэг цолыг олгож байсан. Энэ нь нэг талаасаа шашины цол. Манай Монголд шашин төрийг хослуулсан 13 тамгатай хутагт байсан гэж үздэг. Тэр үеийн хутагт бол нэгэнт Манжийн төр байсан учраас Монголын төр, Манжийн төрөөс хоёулангаас нь зөвшөөрөл авч тэр хоёрын тамгыг атгасан хүн болж гэмээнэ сая энэ нэрийг авдаг байсан. Хутагтууд хоёр замаар тодордог. Төрөхөөсөө авахуулаад хутагт болох нь олонд харагдаж, ажиглагдаж олон талаар тодордог үе залгасан хүн гэж байдаг. Хутагт тодруулах наад захын есөн болзол байдаг гэж үздэг. Нэгдүгээрт, хутагтын хойд дүр байж магадгүй гэж бодсон хүндээ тавих гурван асуулт, тэр хүн өөрөө үзээд таних ёстой гурван зүйл, санаачлагаараа гаргаж ирэх ёстой гурван зүйлээр хутагтын хойд дүрийг танина гэж ярьдаг.

Энэ жил Егүзэр хутагтын мэндэлсний 140 жилийн ой болно. Егүзэр хутагт бол бас л их соён гэгээрүүлэгч хүн байж. Энэ бол бодлогоор нэгнийгээ тодруулж, түүнийгээ тойрч соёл гэгээрлийг, оюуны мандалыг бий болгож амьдарч байсан монгол ухаан гэж бас хэлж болно. Үүнийг ухаантай ард түмний шинж гэж олон жил хутагт судлалын асуудлыг сонирхсон хүний хувьд бодож явдаг. Яагаад гэвэл тэнэг мулгуу хутагт байсан тухай сонсоогүй, уншаагүй. Шашин төрийг хослуулсан ийм дүрүүд гадаад орнуудад бас байдаг. Үүнийг теократ дүр гэдэг. Равжаа хутагт бол “Говийн догшин ноён хутагт”, төрийг ч шашинаа ч төлөөлнө. Говийн ард түмнийг төлөөлсөн хүн байж. Егүзэр хутагт бол зүүн хязгаарыг төвхнүүлэх төрийн сайд бөгөөд хутагт цолтой байсан. Аль ч хутагт байсан олон түмнийг араасаа дагуулах чадвартай

байж. Ямар ч байсан аймаг хошууныхаа нэрийг хугалхааргүй улсуудыг тодруулж байсан байна.

Зовлонгийн шалтгаан буй нь үнэн

Зовлон ирэх нь үнэн

Зовлонг эдлэх нь үнэн

Зовлонгоос ангижрах нь үнэн гэж “Хутагтын дөрвөн үнэн” байдаг. Үе үеийн хутагтуудын амьдрал заавал хүнд бэрхийг туулсан байдаг. Амьдрал тэднийг сорьдог. Ард түмнийхээ төлөө зовлон зүдгүүр үзэж, ямар нэг нэр хочийг олсон, ямар нэгэн тэмцлийг хийсэн байдаг. Равжаа хутагт 200 гаруй жилийн өмнө Монголын бөглүү говь нутагт төрөөд өнөөдөр ЮНЕСКО-гийн хэмжээнд үнэлэгдтэл энэ том үйл хэргийг бүтээхдээ 53-хан наслахдаа юу хийснийг тодруулах зорилготой бид ажилласан. Хутагт 50 гаруй сүм хийдийг бариулсан, өөрөө газар шинжээч, газраа сонгоод бариулдаг. Өөрөө уран барилгачин, уран зураач, архитектор хүн байсан. “Галбын гурван хийд” гээд Өмнөговийн Дэмчигийн хийд, Цагаантолгойн хийд, Ридийн хийд байна. “Онгийн голын гурван хийд”-эд Дундговийн Сайхан овоогийн Бари ламын хийд, Хутагт ламын хийд, Ноён ламын хийд, “Говийн гурван хийд”-эд Дорноговийн Хамарын хийд, Шарилын хийд, Чойлонгийн хийд байна. Хамгийн ойрхон, бидний мэддэг, сэргээгээд явж байгаа хийдүүдийг би ярьж байна. 1937 онд сүм хийдийг сөнөөж байх үеэр Хамарын хийдийг устгах үүрэгтэй улсууд Хутагтын сүр дуулианаас айгаад гар хүрч чадахгүй, орос цэргүүдээр устгуулсан түүхтэй. Тэр цэргүүд нь өдөр ажиллаад шөнө майхандаа очиж амрах хооронд Хамарын хийдийнхэн хамаг юмаа зөөгөөд тэмдэгт газруудад булаад, нийтдээ 1000 гаран авдар зүйлийг авч гарсан гэж үздэг. Хутагт бүхэнд ажил үйлсээ тэмдэглэдэг дэргэдийн дэвтэр гэж байсан. Тэр тэмдэглэл дээр бичсэн зүйлийг одоо судлаад үзэхээр төдийд тэгээрэй, гахай жилд ингээрэй, морь жилд ингээрэй гээд биччихсэн байдаг. Үүнийг зөвхөн тахилчид үе залгамжлаж гүйцэтгэнэ. Бичсэнийх нь дагуу тахилчийн удмынхан тэр авдартай юмыг гаргаж музейд нь залдаг. Хамгийн сүүлд хоёр жилийн өмнө бид хоёр авдар зүйлийг гаргасан. Тэгэхдээ НК, ВВС, Венийн телевиз гээд гадны хэдэн том телевизийг урьж байгаад монголчууд соёлын өв сангаа яаж хадгалдаг юм, яаж хамгаалдаг юм, яаж нээдэг юм, яаж гаргадаг юм гэдгийг үзүүлэх зорилгоор нэвтрүүлэг хийсэн. Тэгэхэд гадаадынхан “та нар ийм мундаг улс юм уу, архи уугаад зодоон хийгээд байдаг гэж бодсон чинь арай өөр юмаа” гэж хэлсэн гэсэн.

Бид 1992 оноос хойш Равжаа судлалын төв, зохиолчдын Хурмаст тэнгэр төв, Равжаа судлалын баг байгуулсан. Дорноговийн Саран хөхөө театр, тэдний уран бүтээлчид бол Равжаагийн уран бүтээлийг хийдэг. Улсын Драммын Эрдмийн Театр ч Равжаагаар нэрээ гаргаж байна. Монголын зохиолчдын дунд манай яруу найрагч хүүхдүүд Хутагтын “Хурмаст тэнгэр” гэдэг дуугаар нэрлэсэн төв байгуулаад яруу найрагч, уран бүтээлчдийг нэгтгэсэн. Равжаа судлалын төв бол дэлхийн арваад орны Равжаа судладаг эрдэмтдийг нэгтгэсэн төв юм. Анхны эрдэм шинжилгээний хурлаа 1993 онд хийж байлаа. Равжаа хутагтын 190, 195, 200 жилээр нь наадам болж, эрдэм шинжилгээний том хурлууд хийгээд түүгээр нь товхимол ном эмхтгэн, өнөөдөр хутагттай холбоотой 30 гаруй ном гараад байна.

Равжаа хутагт гурван зүйлийг шүтдэг байсан. Нэгдүгээрт нь, эх хүнийг шүтдэг байсан. Эх нь

дөнгөж өөрийг нь гаргаад талийгаач болсон учраас эмэгтэй хүний хайрыг ерөөсөө үзээгүй. Ийм учраас дэргэдээ байнга таван хандмаа буюу таван авьяастныг байлгаж тэдэнтэйгээ уран бүтээлээ хийдэг, дарь эх шүтээнтэй байсан. Хоёрдугаар шүтээн нь хун шувуу байсан. Хун шувууг үхэшгүй мөнхийн хайрын бэлгэдэл гэж үздэг. Хайр сэтгэлдээ хамгийн их үнэнч, харуусдаг амьтан бол хун юм гэж үзсэн. Мөн яруу найргийн онгодынхоо талаас хунг шүтдэг байсан. Гуравдугаарт нь, хилэнцэт хорхойг шүтдэг байсан. Дигбаранз буюу хилэнцэт хорхой бол 1200 гаруй төрөл байдаг. Манай говийн хилэнцэт хорхой хамгийн амь бөхтэй нь. Дөрвөн галав юүлэхэд амьд үлдсэн ганцхан амьтан нь хилэнцэт хорхой гэсэн домог бий. Энэ бол нэг талаасаа гүн ухааны бэлгэдэл, хилэнцэт хорхойг үхдэггүй гэж үздэг. Үхье гэж бодвол өөрөө өөрийнхөө амийг егүүтгэж, сүүлнийхээ хурц үзүүрээр өөрийгөө нугасалж алдаг гэсэн ийм домогтой. Хутагт маань талийгаач болохдоо үндсэндээ санаатайгаар хор ууж нас барсан. Хутагтыг шулам авгай гэж хүн хорлосон гэж түүхэнд гардаг. Шулам авгай гэдэг нь багаасаа Хутагтад дурласан бүсгүй, сүүлдээ том ноёны авгай болоод Хутагттай эр эмийн харьцаа үүсгэх гэснийг Хутагт ерөөсөө тоогоогүй. Тэгээд олон удаа хор өгөөд алах гээд байхаар нь хамгийн сүүлд явуулсан хорыг нь мэдсээр байгаад “Би энэ хүнийг их олон жил зовоолоо. Энэ хүний сэтгэлийг амирлуулах нь зүйтэй. Би наадахыг чинь ууя” гээд 53-хан насандаа уусан ийм домогтой юм. Ер нь бол хор өгсөн нь үнэн. Шулам авгай нь өгсөн юм уу хэн нь өгсөн бэ гэдгийг хэлэхэд хэцүү. Богдын талаас ч гэсэн хор өгч хороох гэсэн хэд хэдэн оролдлого гарсан. Яагаад Богдын талаас хороох гээд байсан бэ гэхээр манай Хутагт бол улааны шашиныг шүтдэг. Улаан залаатай Монгол хүнийг шүтдэг, Цогт хунтайжийн маань эрхэмлэж байсан шарын шашины эсрэг, улаан залаат малгайтай монгол хүний шүтээн. Ан хийнэ үү, авгай авна уу, архи ууна уу чөлөөтэй урсгал. Ганцхан улааны шашины айхтар хатуу юм нь гэвэл тэр хийсэн нүглээ өөрөө цайруулж чаддаг байх ёстой.

Би сонин болгож ганцхан жишээ хэлье, хүүхдүүд намайг битгий шоолоорой. Нөгөө Хамарын хийдийн банди нар чинь ийш тийшээ яваад гэр хороо руу гүйгээд байхаар нь Хутагт нэг өдөр бүгдийг нь цуглуулаад хоёр давхар театрынхаа дээр гарч байгаад “Та нар энд байж бай, та нар яагаад эмс охид эргүүлээд энэ тэрүүгээр яваад байна. Ямар эрдэм чадал байна” гэсэн чинь нөгөөдүүл нь дуугарахгүй байхаар нь Хутагт өөрөө нөгөө сүмийнхээ орой дээрээс шээсэн. Шээж байснаа шээсээ буцаагаад татчихсан гэж байгаа юм. Ингэж чадах хүн байвал гарч ирээд энэ дээр үзүүл гэсэн чинь нөгөөдүүл нь чадахгүй гэсэн гэдэг. Ингэж чадахгүй бол үүнээс хойш ийш тийшээ битгий ухна шиг гүйж байгаарай гээд болиулсан гэдэг. Ийм домог яриа байдаг.

Уран бүтээлийн хувьд Хутагт одоогийн бидэнд мэдэгдээд байгаа нь 500 гаруй зохиол бичжээ. Тухайн үед Равжааг доош нь хийхийн тулд согтуу Хутагт, догшин Хутагт, солиот гэж янз бүрээр Богдын зүгээс нэрлэдэг байсан. Хүрээнд ирээд Богдтой уулзъя гэхээр уулздаггүй. Туулын хөвөөнд Богдтой уулзах гэж байж байхдаа “Түвшин сайхан” гэж дуугаа зохиосон гэж ярьдаг. Хавийн олон тэнд цуглараад байсан. Тэгээд Богд хүн явж үзүүлсэн чинь Равжаа ирчихсэн найрлаж байсан гэдэг. Том бүтээлээс нь дурдвал “Саран хөхөө” жүжиг. “Үлэмжийн чанар” дуу байна.

Соён гэгээрүүлэгч талаас нь би хоёрхон жишээ хэлье.

Хутагт Монголд анхны сургуулийг байгуулсан. Таван эрдмийг үздэг сурах бичгийг өөрөө

зохиосон, тэдгээр нь бүгд музейд нь байж байгаа. 1924 онд сургууль байгуулсан гэж Монголын түүхэнд гардаг. Үнэндээ бол 1840-өөд онд Хутагт сургууль байгуулсан. Хутагтын онцолж хийсэн зүйлүүдийн эрхийг хамгаалах талаар бид одоо хөөцөлдөнө гэж бодож байгаа. Тухайлбал, Монголд сургууль хэзээ байгуулагдсан бэ гэдэг талаар албан ёсоор Хутагтаар хамгаалуулна. Халуун ус байгуулж байсан. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд бүгдээрээ ордог саун маягтай юм. Эмэгтэйчүүдийн эрхийг яг зиндаанд тавьсан. Сургууль, соёл, жүжиг бүх юманд нь эмэгтэйчүүд оролцдог, нэг ёсондоо жендерийн асуудлыг Хутагт өмнө нь шийдчихсэн байжээ.

Шашин талаасаа бол Аграмба цолтой, анагаах талдаа маарамба цолтой байж. Энэ бол бүгд судалгаагаар нотлогдож байгаа. Одоо Хутагтын эдэлж хэрэглэж байсан бүх юм нь манайхан авч үлдсэн тэр хэвээрээ байж байна. Гүн ухааны маш олон сургаалууд нь өнөөдөр байж байна.

Нарны гэрэл хурц болоход үүлгүй бол нэн сайн

Насны залууд эрдэм сурахад залхуугүй бол нэн сайн гээд та нарт зориулаад хэлчихсэн сургаалийг нь би Дорноговийн бүх сургуулийн гадаа үүдэнд бичүүлж хадуулсан. Амьдралын мөн чанарыг гаргаж тавьсан “Хоосон чанарын дуулал” гэдэг асар том бүтээлийг хийсэн хүн шүү дээ. Хутагт одоогийн бидэнд мэдэгдээд байгаагаар 18 төрлийн авьяасаар ул мөрөө үлдээсэн, мөнхийн бүтээлүүдийг хийсэн гэж ойлгож болно. 18 төрлийн авьяас тэр хүний биед цогцолсон байж. Хөгжмийн зохиолч, найруулагч, жүжигчин, яруу найрагч, уран барилгачин, зураач, хөөмөлч, наамалч, хатгамалч, бүтээлч гээд. “Саран хөхөө” жүжгийг найруулж, дэлхийд

анх нүүдэлчдийн театр байгуулсан. Дэлхийд алдартай Москвагийн их театрын ой 2011 онд болно. Жишээд үз дээ. Хутагтын бүтээлийн цагаан өргөө гэж одоо манайхаар бол академи шиг ийм зүйлийг байгуулж, бүтээлийн цагаан өргөөндөө бүх газрын хүмүүс, Түвдээс Энэтхэгээс хүмүүс ирээд ном хаялцдаг. Ном хаялцсан хүндээ Дүвчин гэдэг пайз олгодог. Хутагтын пайзтай хүн ямар ч сүм хийдэд орох эрхтэй бөгөөд сургалт явуулах багшлах эрхтэй байсан. Манай Хамарын хийдэд Хутагтын бүтээлийн цагаан суваргыг энэ жилээс барьж эхлэх гэж байгаа.

Бид Хутагтынхаа жанч халсны 150 жилийн ойгоор 2005 онд ЮНЕСКО-д илтгэл бичсэн. Монголд ийм хүн амьдарч байжээ, ийм юм хийжээ гэдгийг бүгдийг нь англи дээр орчуулж бичээд илгээсэн. Хутагтын жанч халсны 150 жилийн ойг 2006-2007 онд дэлхий нийтээр тэмдэглэх 66 арга хэмжээ гэдгийн дотор Буддын гүн ухаантан, дорнын их яруу найрагч, дэлхийд анх нүүдэлчдийн театрыг үндэслэгч, соён гэгээрүүлэгч, олон талын хосгүй авьяастан гэсэн таван номинациар тодорхойлсон ЮНЕСКО-гийн тогтоол ирсэн.

Равжаа хутагт Дорнын говь Монголыг гурав тэжээнэ гэж хэлсэн байдаг. Эхний ээлжийг Зүүн баян, төмөр зам гээд хэлж болох байх. Одоо Оюу толгой, Таван толгой, Цагаан суварга гээд хоёрдох үе рүүгээ орж байна. Тэгэхээр говь өөрөө их том юм, говьд ухаантай хүн ч байна, баялаг ч байна. Равжаа хутагт үүнийг ажиглаад, энд эрт далай байж, далайн ёроолд зөндөө юм байсан байх ёстой. Тийм учраас говь том гэжээ. Судлаачид, ийм авьяастныг төрүүлсэн Дорнын говь хосгүй гэдэг. Хоёр зуу гаруй жилийн өмнө тэр бөглүү говьд төрсөн Равжаа

хосгүй гэдэг. Тэгвэл Хутагтынхаа өв санг авч үлдэж чадсан говьчууд, дорнын говийн ард түмэн, тахилчийнхан агуу гэдэг. Равжааг судлаж нээсэн Ц.Дамдинсүрэн гуай тэргүүтэй Ишжамц, Цэрэнсодном, Цагаан, Л.Хүрэлбаатар дараатай эрдэмтэд судлаачдын үйлс ч бас том. 2013 онд Хутагтын 210 жилийн ой болно. Түүнийг угтсан үе шаттай ажил өрнүүлж байна. 2011 онд яруу найргийн номын 10.0 ам долларын шагналын сантай уралдаан зарласан. 2012 онд Шувууншандад 36м өндөр суварга босгоно. Гурван боть гаргана.

Равжааг төрүүлсэн говь ч, авьяас чадлаараа тодорсон Равжаа ч, Равжаагаа хадгалж чадсан говьчууд ч бүгд агуу гэж би боддог. Бахархдаг. Тэр хүний бий болгосон оюуны мандал руу тэмүүлж амьдардаг. Нутаг бүхэнд агуу хүмүүс байсан. Харин тэднийгээ судлаж тодруулах тэмүүлэл бас хэрэгтэй биз ээ.



**Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэнгийн Экологийн судалгааны
салбарын эрхлэгч, доктор Ч.ЖАВЗАН:**

Усны шинж чанар

Ийм сайхан тэнгэрлэг, бурханлаг хүмүүс хуран цуглараад өглөө эртлэн босож энэ сайхан сав шим ертөнцийн талаар, хүмүүн төрөлхтний талаар, төр засаг байгууллагын талаар, хувь хүмүүсийн талаар ярилцлага зохион байгуулдагийг сонсоод их баяртай байна. Нэг ийм сайхан үг байдаг.

-Хүн эд баялгаа алдвал багыг алддаг

-Нэр төрөө алдвал ихийг алддаг

-Эрүүл мэндээ алдвал бүхнийг алддаг

гэсэн мэргэдийн хэлсэн сайхан сургаал байдаг. Тийм учраас хүний эрүүл байх үндсийн үндэс нь яах аргагүй устай холбоотой гэж усны судалгаа хийж явдаг хүний хувьд би багтай хэлж чадна. Баян хүн ч бай, ядуу хүн ч бай, ноён ч бай, боол ч бай бүгд л усыг хэрэглэдэг.

Усыг хаа сайгүй байдаг жирийн л нэг зүйл гэж ихэнх хүмүүс ойлгож ирсэн. Гэтэл ус маань юун алт, эрдэнэс түүнээс ч маш үнэтэй зүйл. Усгүй бол амьдрал байхгүй нь ойлгомжтой болохоор түүний мөн чанарыг одооноос эхлээд хүмүүс танин мэдэхийн төлөө өөрийнхөө эрүүл мэнддээ усыг яаж зөв зохистой хэрэглэх тал дээр анхаарах цаг иржээ.

Монголчууд эрт дээр үеэс усны талаар маш сайн мэдлэгтэй байсан. Тийм ч учраас Рашаан усаа дээдлэн хүндэлж, үргэлж ариун байлгаж, энэ рашаан бол элэг цөсний рашаан, энэ нь бөөрөнд маш сайн гээд рашаануудаа ялгаад хэрэглэж ирсэн. Гэтэл яагаад энэ тархи нугасных болчихдог юм, яагаад энэ элгэнд сайн болчихдог юм гэдгийг химийн бүрэлдэхүүн талаас нь судлаад ирэхээр тодорхой ялгаа гарахгүй л байгаа. Манай мундаг мэргэд судалгаа шинжилгээ хийлгүйгээр үүнийг мэдэрч, хэрэглэж ирсэн нь юутай холбоотой вэ гэхээр:

I. Өөрийгөө индикатор болгон хэрэглээд ирсэн агуу туршлага байна.

II. Усанд өөрт нь дээр үеэсээ зөв энерги, код дамжуулчихжээ.

Кодлогдсон мэдээллийг дамжуулж байгаа тэр рашааныг хэзээ ч харааж зүхэхгүй, түүний

дэргэд хэрүүл маргаан хийхгүй, байшин барилга бариад ч юмуу сөрөг үйл ажиллагаа явуулаагүй байгаа учраас энэ нь тухайн эд эрхтэнийг анагааж иржээ. Японы эрдэмтэн Масару Эмото усны бүтцийг судалж, хөлдөөж талстынх нь дүрсээр усны шинж чанарыг дүрсээр тогтоожээ. Тэгвэл яагаад шугам сүлжээгээр ирж байгаа ус ямар нэгэн тодорхой дүрсгүй байгаа юм бэ, яагаад байгаль дээр байгаа ус бурханлаг, тэнгэрлэг сайхан дүрстэй байгаа юм бэ? Шугам сүлжээгээр ирж байгаа ус хэрэглэгчдэд хүрэхдээ чанарын шаардлага хангахгүй болох тохиолдол байдаг. Тэгвэл яагаад чанарын шаардлага хангахгүй ус хэрэглэгчдэд түгээгээд байгаа юм бэ гэсэн асуудал гарч ирнэ. Улаанбаатар хотын Туул голын хурдаст байгаа гүний уснууд бол маш сайхан цэнгэг, зөөлөн, эрдэс бодисууд нь зохимжтой ус байдаг. Гэтэл хэрэглэгчдэд түгээгдэж ирэхдээ зэв үүсэх, ямар нэгэн механик хольц, нян бактери илрэх тохиолдол байна. Тэр тохиолдолд хэрэглэгч хүн өөрийнхөө усны чанарт анхаарах, эрүүл мэндээ бодох цаг болсон гэдэг үүднээсээ усаа аль болох цэвэршүүлж, чанарыг нь сайжруулж хэрэглэх хэрэгтэй.

Манай орон цэвэр усныхаа нөөцөөр хомсхон орны тоонд ордог. Энэ бол сэтгэл түгшээсэн л асуудал. Усны тархалт, байрлал нь жигд бус, хангайн уулархаг мужид усан сүлжээний нягтралт ихтэй, Говь руугаа болохоор гол, горхи ховор учир бүх төрлийн хэрэглээнд ихэнхидээ газар доорхи усыг ашиглана. Говийн ус төдийлөн чанарын шаардлага хангахгүй байдаг учир нь хур тунадас бага унадаг, салхи ихтэй, дулаан хангамж сайтай учир ууршилт ихтэй, хөрс нь давсархаг зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж говийн ус нэлээд их эрдэслэг, хатуулаг, хэд хэдэн үзүүлэлтээрээ чанарын шаардлага хангадаггүй. Чанарын шаардлага хангахгүй ус хаана байна тэнд өвчлөл харьцангуй их байдаг. Үүний нэг жишээ нь хатуулаг ихтэй ус хэрэглэж байгаа газруудад хүмүүс нь орон нутгийн нутагшмал өвчлөл гэж яригдаад байгаа шээсний замын чулуужих өвчлөл, ходоод гэдэсний өвчлөл давамгайлах хандлагатай байдаг. Энэ нь усан дотор агуулагдаж байгаа эрдэс бодисын агууламжтай холбоотой.

Аливаа үйлдвэрлэлд хэрэглэсэн усыг тодорхой түвшинд хүртэл цэвэршүүлэх шаардлагатай. Уул уурхайн үйлдвэрүүд дотроос алтны үйлдвэрлэл байгаль орчныг, усыг маш ихээр бохирдуулж байна. Иймээс үйлдвэрлэлийг явуулахдаа алтыг нь авч болно гэхдээ тэнд байгаа байгаль экологи, усыг хэрхэн зөв зохистой ашиглах вэ, яаж анхных нь байдалд оруулах, ядаж дөхүүлж очуулах вэ гэдэг тал дээр маш их анхаарахгүй бол болохгүй нь ээ. Нэг голыг бохирдууллаа гэхэд тэр гол нь цутгал голдоо нөлөөлөх маягаар бүгд бохирдоно. Газар доорхи болон гадаргын ус хоорондоо гидравлик холбоотой учир мөн л нэг нь бохирдвол нөгөөдөө нөлөөлнө. Энэ утгаараа “Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино” гэсэн үг биелэлээ олно. Монгол орон усны хязгаарлагдмал нөөцтэй хэрнээ дээрээс нь бохирдуулаад байх юм бол бид мөдхөн л чанарын шаардлага хангасан ус уух нь хомс болох нь ээ. Магадгүй бид үргэлж гамгүй хандаад байх юм бол гаднаас худалдаж авах хүртэл асуудал гарна. Бид гаднаас ус худалдаж авч чадах уу? Чадахгүй шүү дээ. Иймээс бид усаа аль болох хайрлан хамгаалах хэрэгтэй. Гадаргын ус маань ихэнхи нь гадагшаа гараад явчихдаг. Харин газар доорхи ус маань маш удаан хугацаанд нөхөн сэргээгдэж байдаг. Сүүлийн үед хур тунадасны орох хэмжээ нь багсааж, орж байгаа хэлбэр нь өөрчлөгдсөнөөс усанд тэжээгдэл болох нь мууджээ.

Газрын гүний ус чанарын шаардлага хангах нь ч байна, хангахгүй нь ч байна. Яаж чанарыг сайжруулах вэ гэдэг тал дээр бараг ихэнхи дээр нь чанар сайжруулах тоног төхөөрөмж

суурьлуулаад тавьчихсан байгаа. Энэ суурилуулж байгаа тоног төхөөрөмж маань хатуулаг ихтэй усыг зөөлрүүлэх тал дээр ч юмуу эрдэслэг усан дээр цэнгэжүүлэх тал дээрээ тавигдсан байлаа гэхэд зайлшгүй шаардлагатай элементүүдийг нэмэгдүүлэх тал дээр их учир дутагдалтай. Нэг хэсэг элементүүдийг буурууллаа гэхэд нөгөө элементүүдийг нэмэгдүүлэх сөрөг талтай байдаг. Ийм технологийн харшилыг төгс шийдэж чадахгүй байгаа юм. Энэ мэтчилэн чанарын шаардлага хангахгүй ус хэрэглэж байгаа газар, орныхон мөнхийн асуудалтай байна гэсэн үг. Нэг аппарат тавьчихаад түүнийгээ төгс гэж бодоод насан туршдаа хэрэглэнэ гэсэн ойлголт байхгүй.

Савласан усны тухайд гэвэл манайд 30 гаруй үйлдвэр байдаг. Тэдний 90 гаруй хувь нь шугам сүлжээний усыг хэдэн шүүлтүүрээр дамжуулаад савладаг. Миний хувьд түүнийг зөв асуудал гэж хэлэхгүй байгаа. Яагаад гэвэл тэртээ тэргүй хэрэглэгчид шугам сүлжээгээр ирж байгаа усыг л хэрэглэж байхад түүнээс илүү давуу чанартай ус савлахыг эрмэлзэх хэрэгтэй. Зарим нэг зохимжтой элементүүдийг нэмэгдүүлээд ч хамаагүй гүний, байгалийн усыг савлах нь зүйтэй. Тэгвэл хэрэглэгчдэд хэрэгтэй шүү дээ. Зөвхөн бизнесийн талаасаа битгий хараач ээ гэдгийг бид хөндөж тавьдаг. Савласан ус яагаад эрдэсгүй болчихож байна гэхээр тодорхой хэмжээний хадгалалт даах ёстой гэдэг утгаараа мембрам филтрээр шүүчихдэг. Хүний бие усаар дамжуулаад тодорхой хэмжээний эрдэс давсыг байнга өдөр тутмаа авч байх ёстой. Ус нь хүний бусад эрдэс тэжээл, хоол тэжээлийг бодвол шингэн төдийгүй доторх элементүүд нь ионы байдлаар байдаг учир харьцангуй шингэц сайтай байдаг. Ус ямар байхаас хүний эрүүл мэнд шалтгаална.

Ус гэдэг зүйл маань байгаль дэлхийтэйгээ байнга харилцан холбоотой байж, нар сар, од мичид, орчны энергийг өөртөө шингээж авч энергижиж байдаг. Хүн байгалийн бүтээгдэхүүн учраас зөв энергитэй усыг хэрэглэснээр эрүүл байдаг. Тийм учраас усыг цэвэршүүлэх, энергижүүлэх тоног төхөөрөмж тавиагүй байлаа ч гэсэн намайг ундаалж байгаа энэ усандаа талархаж байна, баярлалаа гэж хэлээд увал ус зөв бүтэцтэй болоод хүн өөрөө эрүүлжих шалтгаан болдгийг одоо мэдэх болжээ. Иймээс хүн бүр устай зөв харьцаж, усаа хайрлан, зөв хэрэглэх хэрэгтэй. Хүний бие организм нь усаар дамжуулан тодорхой хэмжээний, тухайлбал зэс, цайр гэх мэт элементүүдийг авч байдаг. Зэс, цайр гэдэг элементүүд нь хүний бие организмд нойр булчирхайн, түрүү булчирхайн болон сахарын өвчин үүсгэхээс хамгаалдаг гэсэн судалгаа байдаг. Иймээс Монголчууд байнга мөнгөн аяганд цай хоолоо хийж уудаг, зэс гуулин данханд цайгаа савлаж, цайндаа хужир хийдэг байжээ.

Тодорхой нэгэн өвчлөлүүдийг үүсгэх эх үндэс нь усан дахь элементүүдийн агууламжаас шалтгаалдаг гэдгийг санаж, цэвэр, стандартын шаардлага хангасан усыг хэрэглэж байх нь чухал юм.



Гэр бүл судлаач, доктор профессор Т.НАМЖИЛ:

Монгол гэр бүлийн уламжлал, шинэчлэлийн асуудал

Дэлхий даяараа гэр бүлийн асуудалд сүүлийн 10-аад жил айхтар анхаарч байна. Ёс заншлаа ч сэргээхийг оролдож байна. Нөгөө талаар дэлхийн том нутгуудын гэр бүлд асар их өөрчлөлт гарч байна. Бид үүнийг ажиглахгүй байж болохгүй. Хэрвээ үүнийг ажиглахгүй бол монгол гэр бүл дөрвөн уулынхаа дунд задралд орох шинжтэй байна. Баруун Европ, Австрали тив зэрэг эртний хөгжилтэй том газруудад гэр бүл задралд орж байна. Эдгээр орнуудад гэр бүл гэдэг асуудал маш бүдэг болсон. Тэгэхээр төр засгаас гэр бүлийн асуудлыг зохицуулах боломжгүй болчихож байна. Харилцааны хүрээнд зохицуулах асуудлууд гарч ирж байна.

2015 онд 3,100,000 орчим хүнтэй болно гэсэн багцаа байгаа. Азийн нөлөөлөл, Азийн соёлын нөлөөлөл зүүнтэйгээс салхилж байна, Европ нөлөөлж байна, Америк гэр бүл ямар болж байгааг та нар гадарлаж л байгаа, Дундад Ази бараг л Лалын бүгд найрамдах улс байгуулаад уламжлалт шашин дээр тулгуурлаад гэр бүлийн асуудлыг айхтар анхаарч байна. Энэ дунд өндөрлөг газар байгаа Монгол орон, монгол гэр бүл яах вэ? Гадны нөлөөлөл интернэт, кино, драм гээд газар авлаа. За тэгээд гар утасны асуудал байна. Манай эцэг эхчүүд, эмээ өвөө нар хүүхдийнхээ гар утсыг өдөрт нэг шалгаад, юу бичсэнийг харчихаж байхад гэмгүй шүү. Интернэт тоглоомын газрууд түгжиж байгаад л шөнө дунд хүртэл тоглуулж байна. Хуучин шар хаданд ямар ч мэдрэлгүй болтлоо донтсон хүүхдүүд байна. Дээр нь мансууруулах бодис өсвөр үеийнхний дунд дэлгэрч байна. Орой үдшийн цагаар тагтан дээрээ гарчихсан л мансуураад сууж байгаа. Ийнхүү гэр бүлийн задралд гадаад нөлөөлөл их байна.

Дотоод нөлөөлөлд таван шалтгаан байна. Нэгдүгээрт, Монгол орон хөгжих нь ээ. Хөгжил бол гэр бүлд нөлөөлдөг жамтай юм. Өнөөдөр Монголын хүн амын 60 гаруй хувь нь хот суурин газар суурьшсан. 30 гаруй хувь нь хөдөө байна. Арваад жилийн өмнө энэ үзүүлэлт яг эсрэгээрээ байсан. Хөдөө амьдрах хүмүүс нь цөөрөхөөр амьдралын хэв маяг, гэр бүлийн харилцаа гээд бүх юманд өөрчлөлт орж байна. Гэр бүл үүснэ, сална, дахин гэрлэнэ, хүүхэд өнчирнө, эхнэр нөхөр хохирох зэрэг нарийн асуудлууд гарч ирж байна. Оюутолгой, Тавантолгой руу нөхөр нь ажиллахаар явахаар эргэж очсон чинь нөхрүүд нь эхнэрээ хөөж байна. Эхнэрүүд нь уйлаад бидэн дээр ирж байна. Нөгөөдөх нь тэнд нэг залуу бүсгүйтэй хүзүү толгой нийлчихсэн явж байдаг. Эхнэр нь гурван сарын дараа очиход тийм л болчихсон байдаг. Тэгэхээр улс орны хөгжил гэр бүлд өөрчлөлт авчирдаг байна. Хоёрдугаарт, бидний ахмад үеийн үүсгэсэн уламжлалт гэр бүлийн бүтэц, хэлбэр нүдэн дээр чинь өөрчлөгдлөө. Ялангуяа, нийслэл хотод гэр бүлийн олон хэлбэр үүссэн. Хос гэр бүлээс гадна хосолмол гэр бүл байна. Хос гэр бүлийг хойч үе маань авч явах ёстой гэр бүл шүү. Хос гэр бүл

социализмын үед намын бодлогын үрээр задраагүй орж ирсэн. Сүүлийн 20 жилд гэр бүлийн амьдралд ардчилал нэвтэрсэн. Чөлөөт сонголт, боломж бий болоод дангаараа хос гэр бүл тогтнохоо больчихсон. Гэр бүлийн олон хэлбэрүүд гараад ирсэн. Тэр хэлбэрүүд нь олон эхнэр нөхөртэй гэр бүлүүд. Бид хосолмол гэр бүл гэж нэрлэж байгаа. Хоёр эхнэртэй, гурван эхнэртэй, хоёр нөхөртэй, гурван нөхөртэй амьдрал хот хөдөөгүй байна. Санаа зовж байгаа нэг асуудал бол үр хүүхдийн хүмүүжлийн асуудал юм.

Гуравдахь асуудал бол хамтран амьдрах асуудал. Албан бус хүрээнд, албаны хүрээнд гэж хоёр янз байгаа. Ер нь үндсэндээ явалддаг л хэлбэр. Энэ асуудалд би их эмзэг хандаж байгаа. Их дээд сургуулийн оюутнуудын дунд сэлгээний найз гэдэг нэр томъёо үүсээд хэдэн жил болж байна. Олон хүүхэдтэй найзлаад дундаас нь сайныг нь сонгох юм уу гэтэл зүгээр л сонирхлын үүднээс хандаж байна. Энэ бол их аюултай үзэгдэл. Залгамж болсон оюутнууд төгсөөд сонирхлын гэр бүлүүд үүсгэх үү? Тогтворгүй гэр бүлүүд үүснэ. Амьдрал дөнгөж эхэллээ гэтэл алга болчихдог. Зургаа, долоон удаа гэрлэсэн иргэд явж байна. Би хүүхнүүдтэй нь уулзсан. Хүүхнүүд маань дэндүү итгэмтгий юм даа. Түрүүчийнхдээ сургамж авсан байх, гайгүй биз гээд суусан чинь нэг хүүхэд дурсгал болгоод баяртай. Ямар амьдрал гэж ийм байна аа? Нөгөө жинхэнэ хайр, дурлал, зүрхээ сугалахаас буцахгүй гэдэг чинь хаачих вэ? Алга л болчихсон байна. Энэ хэлбэр бол их аюултай хэлбэр. Үүн рүү түрүүчийн хэлсэн явалддаг хэлбэр орж ирнэ, эндээс үүснэ.

Гэрээгээр амьдрах асуудал нийслэл хотоос эхэлчихсэн. Хоёулаа хугацаа тогтооно. Хугацаа дууссан сунгах уу, яах уу гээд нотариат, шүүхээр явж байдаг. Ийм асуудал амьдралын хүрээнд, эдийн засгийн хүрээнд гарч ирж байна. Өөр нэг асуудал бол манай нийслэл хотод ижил хүйстний гэр бүл хэдийнээ гараад ирчихсэн. Ийм явдлыг 10-аад орон гэрлэлт гэж үзэн хуулиндаа заасан байгаа. Тэр нь Монголд стандарт болж байна даа. Манайхан хууль боловсруулчихаад байж байгаа. Манай эмэгтэйчүүд гадаадын хүнтэй сууж байна. Солонгост л гэхэд 4000 байна. Үүнийг Солонгост олон соёлт гэр бүл гэж нэрлэдэг. Гадаад эцэгтэй, эсвэл гадаад эхтэй байвал аль ёс заншлыг барих вэ, аль эх орны төлөө зүтгэх вэ гэдэг асуудал гарч ирнэ. Иймэрхүү өөрчлөлтүүд уламжлалт байдлыг эвдэж гарч ирж байна. Би хүний дотоод хэрэгт оролцож зааварлах гэж байгаа юм биш. Монгол сайхан орныг хэн авч явах вэ гэдгийн үүднээс л ярьж байна. Бидний үеийнхэн 200-аад мянга байгаа, 15 жилийн дараа баяртай болно. Тэгэхэд дунд насны гэр бүлүүд Монголыг авч явна. Залуу гэр бүлүүд 15 жилийн дараа дунд насны гэр бүл болно. Тийм учраас иргэдийн гэр бүлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхийн тулд цуцалтгүй ажиллах хэрэгтэй байна. Зүгээр нэг сургалт, семинар биш, маш системтэй сургалтыг Монгол улсын хэмжээнд онцгой байдал зарлаж байгаа юм шиг зэрэг хийх хэрэгтэй. Энэ бол амин чухал асуудал.

Өнөөдөр хүүхдийн асуудал ярихад эцэг эхтэй нь л ярина. Цагдаагийн байгууллагад нэг айлын хүүхэд хэрэг төвөгт орооцолдоод очиход цагдаагийн байгууллага ангийн багшийг нь дуудаж байна. Ийм л буруу хандлага байна. Ангийн багш ямар хамаатай юм, эцэг эхийг нь дуудах хэрэгтэй. Хүүхдийн төлөө дээр дооргүй дэндүү сайн анхаарал тавих хэрэгтэй. Монгол улс хүүхдийн орон болох нь ээ. Залуучууд нийгэмд байраа эзлээд эхэлчихлээ. Тэр залуучуудын доор далайн давалгаа шиг хүүхдүүд байна. Өлгийтэйгээс эхлээд сая шахуу хүүхэд байна. Энэ цаашдаа 1,600,000-д хүрч бараг Монголын тал хувийг эзэлнэ. Тэр хүүхдүүдийг 15,20 жил ноцолдож байж хэн зөв замд нь оруулах юм бэ? Дунд үеийнхэн, залуу үеийнхэн оруулах

хэрэгтэй. Хэрвээ дунд, залуу үеийнхэн үүнд анхаарахгүй бол Монголыг тавиад туулаа л гэсэн үг. Миний хүүхэд гайгүй дээ, миний хүүхдэд ямар хамаатай юм гэж бодож болохгүй. Таны хүүхэд нийгэмд ороод сайн, муу юманд хутгалдана. Учир мэдэхгүй бол тэгээд л буруу зам руу орно. Хүүхдийн асуудал бүх нийтийн үйлс болох ёстой л гэж бодож байна. Манайхан муу юмыг нилээн газар авахуулж байж гэнэт сэрдэг болчихоод байгаа юм. Уг нь яг одоо л хүүхдийн асуудлыг анхаарах цаг болчихоод байна. Энэ хэрэг байдлаас үзвэл та бид дээр дооргүй гэр бүлийн асуудалд санаа зовохоос өөр аргагүй. Бид үр хүүхдэдээ монгол гэр бүл гэж ярих хэрэгтэй. Бидний өвөг дээдсийн үүсгэсэн бидний гэр. Тийм учраас ойртуулахын тулд монгол гэдэг нэр хэрэглэж үр хүүхэдтэйгээ харилцахдаа бидний монгол гэр бүл гэж харилцаж байх хэрэгтэй. Тэгэхээр удам угсаагаа мэдэж, эрхэмлэцгээе гэдэг лоозонг би ард түмэнд дэвшүүлж байгаа.

Удам гэхээр урагшаа ярина, угсаа гэхээр хойшоо ярина. Манай өвөг дээдэс сургасан байгаа. Эхийн талдаа 3 үе, эцгийн талдаа 5 үе үрийн шингэндээ муу юм шингээж дамжуулж болохгүй шүү, эмгэгтэй болно гэж сургасан байгаа. Эх тал нь 4,5 үеэ, эцэг тал нь 6,7 үеэ мэдэх хэрэгтэй болж байна. Нэг үе 25 жил. Монголчууд үр хүүхдээ 25 хүрэхээр үр хүүхдээ хүн боллоо гэж ярьдаг, архины цээр тавьдаг байсан уламжлалтай. 20 хүрээгүй бол бие сэтгэлийн хувьд жигдрээгүй байдаг. Одоо залуучуудаас асуухад би 3 үеэ мэднэ гэж нилээн маадгар хариулж байгаа. 3 үе гэдэг чинь юу вэ? Та байна, аав ээж нь амьд байна, өвөө эмээ нь амьд байгаа. Тэрнээс цаадах төрөл саднаа хайхрахаа болино гэсэн үг. Ийм л байгаа шүү дээ. Тэгээд 4,5 дахь үеэ олох гэхээр тусалдаггүй. 1997 оны бүртгэлээр дийлэнх нь Боржигон овогтон болоод тууж байгаа. Монгол ёсоор бол овог дотроо гэрлэж болдоггүй. Миний хүү хэний охинтой суух гэж байна, би аль нутгийн бэртэй болох гэж байна? Энэ бол монгол язгуурыг авч явах арга хэрэгсэл байсан. Өнөөдөр гэнэтхэн палхийтэл нэг хүн авчраад л миний суух гэж байгаа хүн, миний хань гэдэг. Бид нар тэгээд хүлээж авалгүй яахав дээ. Болж байвал яахав дээ гээд царай өгөхийг л бодно. Биднээс юу ч асуухгүй. Асууна гэхээр манай залуучууд гайгүй байлгүй, энэ чинь хүний эрхийн асуудал гэж байгаа. Эцэг эхчүүд бол үр хүүхдийнхээ сайн сайхны төлөө л байдаг. Өвөр түрийдээ ороод, хүзүү толгойгоо нийлүүлээд амьдрал эхэллээ гэвэл худлаа. Дорхноо салчихдаг.

Ургийн тэмдэглэгээ, ургийн бичиг хөтлөх. Би угийн бичиг гээгүй шүү. Уг бол эцэг талаа, эр талаа түүчихэж байгаа юм. Тэгэхээр эцэг тал нь ураг тэмдэглэгээнд хүргэн бэртэйгээ бүгдээрээ ороод ирнэ. Тэгэхээр ургийн тэмдэглэгээг авга нагац гээд өөрөөсөө хойш урагш 5,7 үеэр нь гаргана гэсэн үг. Тэгээд энэ дотор ердөө гэрлэж болохгүй. Нэг сайхан хүүхэн охиныхоо 2 сартай хүүхдийг авахуулна гэсээр орж ирлээ. За яасан гэсэн чинь би эхээс хоёулаа. Би 3 охин төрүүлсэн. Ах нь охин, хүү, охин төрүүлсэн. Дунд охин дээр нэг залуу орж гардаг болсон. Орж гарна гэвэл ерөөсөө л унтаж хэвтсэн л гэсэн үг. Тэгсэн чинь охины сарын юм ирсэнгүй. Айгаад ээждээ хэлэхэд 2 сартай хүүхэдтэй болсон байгаа. Асуудал гарнаа. Энэ орж гарч байгаа залуу хаанахын хүн бэ, ямар хүргэнтэй болох гэж байна гээд асууж сураглана.

Тэгсэн чинь нөгөө ахын хүүтэй тэр охин нөхцсөн байгаа. Яагаад ийм асуудал гарав гэвэл ойлгомжтой. Дээгүүрээ ахмадууд бид нар өөрсдийгөө мэддэг. Тэгээд нөгөө хүүхдүүд нь аль нэг аймагт байж байгаад нийслэл хотод ирсэн. Сургуульд ороод нэг хөөрхөн охинтой хөөцөлдөөд тэгээд л асуудал үүссэн. Эндээс ямар сургамж гарч байна гэхээр ахмадууд

Өөрсдийгөө болж байна гэж мэдээд зогсохгүй тэр хүүхдүүдийн байранд өөрсдийгөө тавих хэрэгтэй. Мэдээ орсноос нь эхлээд л овгийг нь хэлж өгөх хэрэгтэй. Ургийн тэмдэглэгээг хөглөөрэй. Туулай жилдээ багтаад энэ зун хий. Тэгээд ургийн уулзалт хийнэ шүү. Архи дарс хэрэглэхгүй зардал багатай хийгээд гол асуудал нь хэдүүлээ байна, ямар ямар ажил төрөл эрхэлж байгаагаа л бие биедээ мэдүүлэх хэрэгтэй. Ураг төрөл, хамаатан учраас нуух юм байхгүй.

Уржнан жил хүнсний аюулгүй байдал гээд хоолой руу орох юмаа анхаарч эхэлсэн. Бид чинь удмынхаа асуудлыг чанар нь муудаад байхад анхаарахгүй явж байна шүү дээ. Яагаад чанар муудсан гэхээр нийгэм, гэр бүл хоёулантай нь холбоотой. Удам угсаагаа харахаа больсон, тааралдсантайгаа маш богино хугацаанд бие биенээ мэдэлцээд л сууж байна. Манай өвөг дээдэс 2-3 жил хүлээлгэдэг байсан. Удам угсаа анхаарахгүй болохоор чанартай үр хүүхэд төрүүлж чадахгүй. Хүүхдийн асуудалд анхаарахдаа зарим нь гарсан хойно нь гэдэг юм, зарим нь хүүхэд олох үед гэдэг юм. Үгүй ээ, ханиа сонгохоос эхэлнэ. Удам сайтай, сайн хүний үр садыг олох ёстой. Манай охидууд өврөө нээхгүй маш тэвчээртэй явах хэрэгтэй, өврөө нээж ердөө болохгүй. Өөрөө дур хүрсэн ч нээж болохгүй. Би нэг хүүхдийн дурсгалтай үлдэнэ болохгүй ээ гэж хэл. Эрчүүд нь хүүхдээ гаргах чинь чиний үүрэг, би амьдралын төлөө гадагшаа явлаа гэж болдоггүй юм. Төрөх эхчүүдийн нөхрийн гол гүйцэтгэх үүрэг бол сэтгэл тайван байлгах хэрэгтэй. Чанартай үр хүүхэд л Монголыг авч явна.

Гэр бүлийн харилцаа бол маш чухал. Энд ерөөсөө л хоёр зүйл байна. Нэгдүгээрт, эхнэр нөхрийн харилцаа.

1. Бие биенийхээ онцлогийг мэдэж харьцаж байгаарай. Тохой нийлүүлээд 10 жил суусан, итгээд ханилсан чинь араатан шиг байна гэж ярьж байгаа шүү. Эхнэр хүн нөхрөө эр хүн гэж бодож тэр байранд авачина. Эр нь миний эхнэр эмэгтэй хүн гэсэн байранд нь харьцах хэрэгтэй. Тэгээгүйгээс зөрчил гарч байна.

2. Үг оновчтой байх хэрэгтэй. Одооны нийгмийн үг нь олон болчихоод байна. Хүүхдүүд бид нарыг яншаа гэх гээд байна. Тийм учраас цөөн үг хэлэх хэрэгтэй. Нөхөртөө, эхнэртээ ч цөөн үг хэлэх хэрэгтэй.

3. Нөхөр хүн эхнэрээ хайрлах заяатай төрсөн, эхнэр хүн бол нөхрөө халамжлахаар төрсөн. Хайр, халамж хоёр нэгдэж байж сайхан явна. Тэгж байж итгэл, хайр, аз жаргал, сэтгэл дүүрэн явна. Эцэг эхийн хайр халамжийг холбож байдаг нандин зүйл бол хүүхэд шүү. Та хоёрыг уурласан байвал хүүхэд чинь инээлгэнэ. Үр хүүхэд гэдэг бол тийм сайхан. Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас гэдэг. Сэтгэлээ засаад гэрээ зас шүү. Би сургаж байгаа юм биш, манай мэргэдийн сургаал. Сэтгэлээ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас, төрөө засаад дэлхийг зас гэсэн байгаа шүү. Тийм учраас бидний гэр бүлийн харилцаа, монгол гэр бүлүүдийн харилцаа, дэлхийн улсуудын харилцаа эцсийн эцэст сэтгэл дээр очиж нэгдэнэ шүү. Аливаа зүйлд чин сэтгэлээрээ хандаж эвгэй байх хэрэгтэй, сэтгэл төвшин байх хэрэгтэй, сэтгэл эрүүл байх хэрэгтэй. Сэтгэл эрүүл байвал бие эрүүл байна. Бие эрүүл байвал ухаан саруул, ухаан саруул байвал юуг ч бүтээж чадна. Монголчуудын маань удам эрүүл, ухаан саруул, ажил үйлс нь өөдөлж явахын ерөөлийг та бүгдэд дэвшүүлье. Баярлалаа.

Table of Contents

Монгол Улсын гавьяат эмч М.ШАГДАРСҮРЭН:

Төрийн соёрхолт, МУГЖ Д.СОСОРБАРАМ:

МУСГЗ, ОУ-ын сэтгүүлч, философийн ухааны доктор, профессор Б.ДАШЗЭВЭГ:

Ай даа хүмүүс минь, амьдрах сайхаан! Амьдрахуй ухааны “Алтан дөл” ТББ-ын тэргүүн И.ЦЭРЭН:

Амьдрахуй ухаан бясалгалын төвийн тэргүүн Ц.САРАНЦЭЦЭГ:

Төрийн шагналт, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, ШУА-ийн Физик техникийн хүрээлэнгийн захирал, академич Б.ЧАДРАА

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, дархан аварга, УИХ-ын гишүүн Б.БАТ-ЭРДЭНЭ:

МҮЭХ-ны Ерөнхийлөгч С.ГАНБААТАР:

УИХ-ын гишүүн Д.ЭНХБАТ:

МҮАН-ын дарга М.ЭНХСАЙХАН:

Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч, МАХН-ын дарга Н.ЭНХБАЯР:

Чанадаас халих бясалгалын төвийн тэргүүн Г.БАТ-ЭРДЭНЭ:

Хүний эрхийн Хуульч М.ИЧИННОРОВ:

Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба, гавж Д.ЧОЙЖАМЦ:

VIP клуб ТББ-ын тэргүүн, Монголын лектор төвийн жинхэнэ гишүүн, “Соёолж” зохимжит хоолны газрын зөвлөх Б.ГЭРЭЛМАА:

ШУТИС, КтМС-ийн профессор, доктор(ScD), профессор Л.Оюунцэцэг

“Монгол тэмүүлэл-Сайхан Монгол орон” ТББ-ын Гүйцэтгэх захирал Н.Цэндмаа

Монгол Улсын гавьяат багш Ц.ТҮВШИНТӨГС

Монгол Улсын Ардын жүжигчин Ш.ЧИМЭДЦЭЭ:

Олон улсын Равжаа судлалын тэргүүн, МУСГЗ Л.ОДОНЧИМЭД:

Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэнгийн Экологийн судалгааны салбарын эрхлэгч, доктор Ч.ЖАВЗАН:

Гэр бүл судлаач, доктор профессор Т.НАМЖИЛ: